bağır, -ğrı *is.* 1. цээж, хэнхдэг. 2. *anat.* гэдэс дотор. 3. дотоод хэсэг, дунд хэсэг. **~ı yanmak** 1) зовох, шаналах. 2) ам хатах, ангах, их цангах. **bağrına basmak** 1) хүзүүдэх, тэврэх 2) халамжлах, санаа тавих, элбэрэх, арчлах. **bağrına taş basmak** тэсэх, хүлцэх, тэвчих, тэсэн енгерүүлэх, хүлцэн енгерүүлэх, тэвчин енгерүүлэх.

bağırgan *is.* хашхирамтгай, бахирамтгай, ярдаг, орилоо (хүн).

bağırış *is.* хашгирах дуун, хашгираан, орилоон, чарлаан.

bağırış çağırış *is. ve s.* 1. орилоон, чарлаан, хашгираан, чимээ шуугиан. 2. чимээтэй, шуугиантай, орилолдож бахиралдсан, хашгирсан.

bağırışma *is. bk. bağrışma.*

bağırışmak *(nsz) bk. bağrışmak.*

bağırma *is.* bağırmak үйлийн нэр.

bağırmak *(nsz)* 1. хашгирах, чарлах, орилох, бархирах. 2. *(-e)* зандрах, ендер дуугаар зандрах, зандах, хашгиран загнах. **bağırıp çağırmak** (уурлан) орилж хашгирах, бархирах, зандчих.

bağırsak, -ğı *is. anat.* гэдэс. "*Kalın bağırsak.*" Бүдүүн гэдэс, "*İnce bağırsak.*" Нарийн гэдэс.

bağırtı *is.* хашгирах дуун, орилоон, бархираан, хашгираан.

bağırtma *is.* bağırtmak үйлийн нэр.

bağırtmak *(-i)* 1. хашгируулах, орилуулах, бахируулах, чарлуулах. 2. (мэдээ, зар, хүсэлт) зарлуулах, мэдүүлэх, дамжуулах.

bağış *is.* 1. bağışlamak үйлийн нэр 2. хандив, ергел, барьц, бэлэг.

bağışık *s. hlk.* 1. сул, чөлөөтэй, чөлөөлөгдсөн, хэлтрүүлсэн. 2. *tıp.* халдашгүй, дархлалтай.

bağışıklık, -ğı *is.* 1. хенгелелт, челеелелт. "*Vergi bağışıklığı.*" Татварын хөнгелелт. 2. *tıp.* дархлал, дархлаа.

bağışlama *is.* 1. уучлах, хэлтрүүлэх, өршөөл. 2. хандив, ергөл, барьц, бэлэг.

bağışlamak *(-i, -e)* 1. уучлах, хэлтрүүлэх, өршөөх, ершөөл үзүүлэх. 2. хандивлах, өргөл ергех, еглөг егех, бэлэглэх.

bağışlanma *is.* bağışlanmak үйлийн нэр.

bağışlanmak *(nsz)* bağışlamak үйлийн үйлдэгдэх хэв.

bağıt, -dı *is. huk.* гэрээ, хэлцэл, хэлэлцээр.

bağlaç, -cı *is. gr.* холбоос үг.

bağlam *is.* 1. боолт, боодол, баглаа, хэлхээ, багц. 2. *ed.* бадаг. 3. бий болсон нехцел байдал.

bağlama *is.* 1. bağlamak үйлийн нэр. 2. нэгэн терлийн турк үндэсний хегжмийн зэмсэг. 3. холбоос, бэхлээс.

bağlamak *(-i, -e)* 1. уях, боох, залгах, хүлэх, баглах, хэлхэх. 2. зангилах, зангидах. 3. (шарх) боох. 4. боох, баглах, хайрцаглах, савлах. 5. гарах, үүсэх, тогтох, бий болох, бүрэлдэх. 6. зориулах, зориулан гаргах, гаргаж егех, холбох. "*Maaş bağlamak.*" Цалинтай болгох, цалин авдаг болгох. 7. (ажил) холбох, төгсгөх, дуусгах, шувтлах. 8. *mec.* (сэтгэл) татах, талдаа оруулах. 9. дагах, мөрдөх. 10. хаах, хаалт хийх. "*Bütün yolları bağlamışlar.*" Бүх замыг хаасан байна.

bağlanma *is.* bağlanmak үйлийн нэр.

bağlanmak *(nsz, -e)* 1. bağlamak үйлийн нэр. 2. дасах, хайртай болох. 3. зориулагдах, холбогдох, гаргаж егех, хангагдах. "*Maaş bağlanmak.*" Цалинтай болох.

bağlantı *is.* 1. харилцаа, холбоо, харилцаа холбоо. "*Kar yüzünden bağlantı kesildi.*" Цас их орсноос болж харилцаа холбоо тасарлаа. 2. сүлжээ, холбоос, холбох газар.

bağlantılı *s.* холбоотой, харилцаа холбоотой.

bağlantısız *is.* ve *s.* 1. холбоогүй, харилцаа холбоогүй. 2. холбоонд нэгдээгүй, эвсээгүй, нэгдээгүй (орон).

bağlaşık *s.* 1. санал нийлсэн, эв санал нэгтэй, хамтын, нэгдсэн, нэгдмэл. 2. холбооны, эвслийн, холбоо байгуулсан.

bağlaşım *is.* 1. хослох, хамтрах, нэгдэх. 2. холбоо, холбоотон (улс орон).

bağlaşma *is.* bağlaşmak үйлийн нэр.

bağlaşmak *(nsz, -le)* нэгдэх, хамтрах.

bağlatma *is.* bağlatmak үйлийн нэр.

bağlatmak *(-i)* bağlamak үйлийн үйлдүүлэх хэв.

bağlayıcı *is.* ve *s.* 1. холбогч, холбоос. 2. үүрэгтэй, мердех ёстой, дагах ёстой.

bağlı *s.* 1. уяатай, холбоотой, хүлээтэй, хэлхээтэй. 2. холбоотой, хамаатай, хамааралтай, шалтгаалах. 3. *mec.* хайртай, дуртай. 4. үнэнч, үнэнч шударга. 5. хаалттай, хаагдсан. 6. хязгаартай, хязгаарлагдмал. 7. харьяа, харьяалагдсан, хамааралтай. "*Üniversiteye bağlı.*" Их сургуулийн харьяа. **~ kalmak** дагах, мердех. **~ olmak** холбоотой байх, харьяалагдах, хамаарагдах.

bağlılık, -ğı *is.* 1. хэлхээ холбоо, харилцаа холбоо, холбоо сүлбээ. 2. үнэнч байх, хайртай байх. 3. харьяалагдал, хамаарал. 4. *biy.* харьцалдаа.

bağnaz *s.* хэт шүтлэгтэн, улайран итгэгч, бишрэгч, улайран итгэгч, сүжиглэн бишрэгч, фанатикч.

bağrış *is.* bağırmak үйлийн нэр.

bağrışma *is.* орилолдоон, хашгиралдаан, бархиралдаан.

bağrışmak *(nsz, -le)* орилолдоцгоох, хашгиралдацгаах, бархиралдах, дуу дуугаа аван орилох.

bahadır *s.* баатар, зоригтой, зүрхтэй, баатарлаг, эрэлхэг.

bahadırlık, -ğı *is.* зориг зүрх, аймшиггүй чин зориг, баатарлаг явдал.

bahane *is.* шалтаг, шалтгаан, нэрийдэл, далим. **~ aramak** шалтаг хайх. **~ bulmak** *is.* шалтаг олох, шалтаглах. **~ etmek** шалтаг заах, шалтаглах.

bahar *is.* 1. хавар, хаврын улирал. "*Bahar bayramı.*" Хаврын баяр. 2. энэ улиралд цэцэглэж буй цэцэг, навчис. 3. *mec.* залуу нас, залуу ye.

baharat *is.* хоол амтлагч, амт оруулагч.

baharatlandırmak *(-i)* амтлах, амт оруулах, амтлагч холих.

bahçe *is.* 1. жимсний цэцэрлэг, ногооны талбай. 2. парк, цэцэрлэг, хүрээлэн.

bahçeci *is.* цэцэрлэгжүүлэгч, ногооч, цэцэрлэгч.

bahçecilik, -ği *is.* 1. цэцэрлэгжүүлэх, цэцэрлэг тарих. 2. цэцэрлэгийн аж ахуй.

bahçıvan *is.* 1. цэцэрлэгч. 2. цэцэрлэгжүүлэгч, ногооч.

bahçıvanlık, -ğı *is.* 1. цэцэрлэгжүүлэх, цэцэрлэг тарих. 2. цэцэрлэгийн аж ахуй.

bahis, -hsi *is.* 1. яригдаж буй зүйл, сэдэв. 2. яриа. 3. (ном) анги, бүлэг, хэсэг. 4. бооцоо, мерий, барьцаа. **~ açmak** ярих, ярьж эхлэх. **~ mevzuu olmak** хэлэлцэгдэх, яригдах. **bahse girmek** мерийцөх, мерий тавих, бооцолдох, бооцоо тавих. **bahsi kaybetmek** гартах, мөрий алдах, бооцоо алдах. **~ konusu** яригдаж буй зүйл, сэдэв.

bahriye *is.* тэнгисийн цэргийн флот, тэнгисийн цэргийн хүчин.

bahriyeli *is.* 1. усан цэрэг, далайчин, тэнгисчин. 2. тэнгисийн цэргийн хүчний ангийн сонсогч/сурагч.

bahsetme *is.* bahsetmek үйлийн нэр.

bahsetmek, -der *(-den)* ярих, хэлэх, өгүүлэх.

bahşiş *is.* шан харамж, шан.

baht, -tı *is.* 1. тавилан, заяа. 2. аз, хийморь. **~ı açılmak** азтай байх, аз хийморь түших. **~ı kapanmak** аз нь харих, аз хийморгүй байх. **bahtı açık** азтай, хийморьтой, завшаантай, хувьтай, азтай байх. **~ı açık olmak** аз түших, аз хийморьтой байх, аз тохиох, аз таарах. **bahtı kara** азгүй, хувьгүй, заяа муутай, жаргалгүй.

bahtiyar *s.* азтай, жаргалтай, жаргалант, хувьтай, заяатай, хийморьтой.

bahtiyarlık, -ğı *is.* аз жаргал, аз хийморь, хувь, заяа.

bahtlı *s.* азтай, хийморьтой, завшаантай, хувьтай, заяатай, аз жаргалтай.

bahtsız *s.* азгүй, аз хийморьгүй, аз нь харьсан, аз жаргалгүй, баяр хөөргүй, заяагүй, хувьгүй.

bakaç, -cı *is. hlk.* дуран.

bakakalma *is.* bakakalmak үйлийн нэр.

bakakalmak *(nsz, -e)* амаа ангайн гөлрөх, алмайран хоцрох.

bakan *is.* сайд. "*Devlet bakanı.*" Терийн сайд. "*Bakanlar kurulu.*" Сайд нарын зөвлөл.

bakanlık, -ğı *is.* яам. "*Sanayi ve Ticaret bakanlığı.*" Үйлдвэр, Худалдааны Яам.

bakar *is. esk.* үхэр, бух.

bakıcı *is.* 1. асрагч. 2. мэргэч, телегч.

bakıcılık, -ğı *is.* 1. сувилах, асрах. 2. мэргэлэх, төлөгдөх, төлөг үзэх.

bakılma *is.* bakılmak үйлийн нэр.

bakılmak *(-e)* bakmak үйлийн үйлдэгдэх хэв.

bakım *is.* сувилгаа, арчилгаа, өргөмж, тордлого.

bakım evi *is.* 1. асрамжийн газар, асрах газар. 2. *ask.* засварын газар.

bakımından *zf.* ...ийн үүднээс, ...ийн үзлийн үүднээс, зүгээс.

bakımlı *s.* сайн халамжлагдсан, сайн харж хандсан.

bakımsız *s.* зөнд нь хаясан, арчилгаагүй, хаягдмал, орхигдсон.

bakınma *is.* bakınmak үйлийн нэр.

bakınmak *(nsz, -e)* 1. эргэн тойрон харах, ажиглан харах, ийш тийш харах. "*Etrafa bakınmak.*" Зүг зүг тийш харах, эргэн тойрноо харах. 2. *hlk.* эмчид үзүүлэх.

bakır *is.* 1. зэс. "*Bakır kaplama.*" Зэсээр бүрэх, зэсээр хучих. 2. *s.* зэс, зэсээр хийсэн, зэсэн. 3. зэс сав. **~ akçe** зэс мөнгө, зэс зоос. **~ devri** зэсийн үе.

bakırcı *is.* зэс эдлэлийн дархан.

bakırlaşma *is.* bakırlaşmak үйлийн нэр.

bakırlaşmak *(nsz)* зэсийн өнгөтэй болох, зэсийн өнгөтэй байх.

bakırlı *s. kim.* зэсийн агуулламжтай, зэс агуулсан.

bakır sülfat *is. kim.* зэсийн байван.

bakır taşı *is. kim.* ногоолин.

bakış *is.* bakmak үйлийн нэр, харц, харах. **~ atmak** хальт харах. **~ açısı** үзэл бодол.

bakışık *s. mat.* тэгш хэмийн, тэгш хэмтэй.

bakışım *is.* 1. хэсгийн адил тэнцүү байдал, шүтэлцээ. 2. *mat.* тэгш хэм, хэм тэгш, хосмолжин.

bakışımlı *s. mat.* тэгш хэмийн, тэгш хэмтэй.

bakışımsız *s. mat.* тэгш хэмгүй.

bakışma *is.* bakışmak үйлийн нэр.

bakışmak *(nsz, -le)* 1. бие бие рүүгээ харах, харалцах. 2. ширтэлцэх.

baki *s.* 1. өөрчлөгдөхгүй, үргэлж, байнга, дандаа. 2. *esk.* үлдсэн, үлдэгдэл. **~ kalmak** 1) үргэлж байх, байнга байх. 2) үлдэх.

bakir *s.* 1. зандан (эр). 2. хүний гар хүрээгүй, ашиглагдаагүй, хэрэглэгдээгүй. 3. (газар) атар, хендөгдөөгүй. 4. шинэ, хэрэглээгүй, хуучраагүй, гар хүрээгүй.

bakire *is.* онгон охин, онгон.

bakirelik, -ği *is.* онгон охин нас, онгон байдал.

bakiye *is.* 1. үлдэгдэл, үлдсэн хэсэг, үлдсэн юмс. 2. үлдэгдэл, ул мөр.

bakkal *is.* 1. хүнсний барааны худалдагч, мухлагийн худалдагч. 2. хуурай хүнсний мухлаг, мухлаг.

bakkaliye *is.* 1. хуурай хүнс, хуурай зууш. 2. хүнсний дэлгүүр.

bakla *is. bot.* шош. **~yı ağzından çıkarmak** 1) дуугүй байж байж эцэс сүүлд нь тэвчээр барагдан бодсон зүйлээ хэлж эхлэх. 2) нууц задлах.

baklava *is.* баклава (самар, бүйлс, цөцгий гэх мэт зүйлсийг нимгэн элдсэн гурилд ороосон турк үндэсний нэгэн төрлийн амттан).

bakma *is.* bakmak үйлийн нэр.

bakmak, -ar *(-e)* 1. харах. 2. хайх, эрэх. 3. (нэг зүг рүү) харах. "*Bahçeye bakan pencere.*"

Цэцэрлэг рүү харсан цонх. 4. оролдох, оролдоод үзэх, хичээх. 5. асрах, харж хандах, тэжээх, тэтгэх. 6. харах, болох, шалтгаалах, хамаарах. "*İş paraya bakar.*" Ажил мөнгөнөөс хамаарна. 7. (өвчтөнийг) үзэх, харах, эмчлэх, оношлох. 8. харах, үзэх, хянах, шалгах. 9. (хүүхэд) харах, хандах, эргэх, анхаарал тавих. 10. хийх, хариуцах, үүрэг хүлээх. 11. чухалчилж үзэх. 12. ойлгох, ухаарах, мэдэх. 13. урьдах ажлаа хийх, ажиллах. 14. завдах, санаатай байх, зорих. 15. (өнгө) адил байх, адилхан байх, төстэй байх, ойролцоо байх.

bakraç, -cı *is.* 1. зэс хувин. 2. нэг хувин, нэг хувингийн хэмжээтэй.

bakteri *is.* ин, ян, бактөр, нян.

bakterisit *s.* бактериофаг, бактери уусгагч, бактери устгагч.

bakteriyolog *is.* бактер судлагч, нян судлагч.

bakteriyoloji *is.* бактериологи, нян судлал, бактөр судлал.

baktırma *is.* baktırmak үйлийн нэр.

baktırmak *(-i, -e)* bakmak үйлийн үйлдүүлэх хэв.

bal *is.* бал, зөгийн бал.

balaban *s. hlk.* 1. аварга том, мундаг том. 2. мантгар, тэнтгэр, мяраатай (хүүхэд).

balalayka *is.* домбор, товшуур.

balans *is.* баланс, тэнцвэр, тохирол.

balat, -dı *is. ed.* тууль, домогт шүлэглэл.

balata *is.* 1. дамжуулгын сур, татуургын сур. 2. тоормосны шугам.

balayı *is.* бурман сар (гэрлэсэн сар).

balçık, -ğı *is.* шавар, балчиг, шавхай, наанги шороо.

baldır *is.* шилбэ, хөлийн булчин.

baldırı çıplak, -ğı *is.* тэнүүлч, зайгуулч, дэмий сэлгүүцэгч, золбин.

baldız *is.* хадам эгч, хүр охин дүү.

bale *is.* 1. балет, бүжгэн жүжиг. 2. мэргэжлийн бүжгийн жүжигчдийн баг, хэсэг.

balerin *is.* эмэгтэй бүжгэн жүжигчин, эмэгтэй балөтчин.

balet *is.* эрэгтэй бүжгэн жүжигчин, эрэгтэй балетчин.

balgam *is.* цэр, залхаг.

balgamlı *s.* цэртэй, залхагтай, цэр гарсан.

balık, -ğı (I) *is. zool.* загас. **~ adam** усанд шумбагч. **~ avlamak** загас барих, загас агнах. **~ yumurtası** түрс, загасны түрс. **balığa çıkmak** загасанд явах.

Balık, -ğı (II) *z. is. astr.* Загасны орд.

balıkçı *is.* 1. загасчин, загас агнаж амьдардаг хүн. 2. *s.* загасчны, загас агнуурын. "*Balıkçı kayağı*" Загас агнуурын завь.

balıkçıl *s.* 1. загасаар хооллогч. 2. *is. zool.* хех дэглий.

balıkçılık, -ğı *is.* 1.загас агнуур, загас барих. 2. загас үржүүлгийн аж ахуй, загасны худалдаа.

balıkhane *is.* загасны зоорь, загас хадгалах газар.

balıklama *zf.* 1. (усанд шумбах, үсрэх) толгойгоороо урагш, бие цэх, гар урагш байдалтай. 2. *mec.* бодлогогүй, хөнгөмсөг.

balıklamak *(nsz)* толгойгоороо урагш тэмүүлж, бие цэх, гараа өмнөө авч ус руу үсэрч орох, шумбах.

balıklı *s.* загастай.

baliğ *s.* бэлгийн бойжилтод хүрсэн. **~ olmak** 1) хүрэх, болох. "*Borç beş yüz bine baliğ oldu.*" Өр таван зуун мянгад хүрсэн байна. 2) бэлгийн бойжилтод хүрэх.

balina *is. zool.* халим загас. "*Balina yağı.*" Халимын өөх.

balistik, -ği *is. ask.* харвал зүй, сумны явцын судлал.

balkıma *is.* balkımak үйлийн нэр.

balkımak *(nsz) hlk.* 1. гялалзах, гялайх. 2. цахилгаан цахих. 3. ус давлагаалах. 4. үе үе өвдөх, дуншиж өвдөх.

balkır *is. hlk.* 1. хурц гэрэл, гялалзах, гялтганах. 2. цахилгаан, үүлний давхаргад гялсхийн үзэгдэх гэрэл.

balkon *is.* 1. тагт, балкон. 2. театрын дээд давхрын суудал.

ballandırma *is.* ballandırmak үйлийн нэр.

ballandırmak *(-i) mec.* ихэд магтах, тэнгэрт тултал магтах..

ballanma *is.* ballanmak үйлийн нэр

ballanmak *is.* 1. зегийн бал болох, зегийн бал түрхэх. 2. *mec.* амттай болох, болох, болов сорч гүйцэх.

ballı *s.* зегийн балтай, балтай. **~ börek** балтай боов.

bal mumu *is.* лав, цагаан лав, балуус шааг. **~ gibi erimek** их турах, яс арьс болтлоо турах.

balo *is.* бүжигт үдэшлэг, бүжигт найр, үдэшлэг цэнгээн. **~ vermek** үдэшлэг зохион байгуулах, үдэшлэг зохиох.

balon *is.* 1. агаарын бөмбөлөг (хүүхдийн тоглоом). 2. (нисдэг) агаарын бөмбөрцөг, агаарын бөмбөлөг. 3. баллон, шилэн бөмбөгөр сав.

bal özü *is. bot.* цэцгийн шүүс, бал.

balta *is.* сүх, балт. "*Balta değmemiş orman.*" Аглаг ой. **(birine) ~ olmak** *argo.* (хэн нэгнийг) хоргоох, шалах, гуйх. **~ vurmak** сүхээр цавчих, сүхдэх, хагалах. **~yı taşa vurmak** *mec.* санаандгүй эвгүй үг хэлэх.

baltalama *is.* 1. baltalamak үйлийн нэр. 2. *mec.* ажил санаатайгаар саатуулах, боогдуулах үйлдэл.

baltalamak *(-i)* 1. цавчих, хагалах, эвдэх. 2. ажил санаатайгаар саатуулах, зориуд саатуулах, хойш татах, боогдуулах, садаа болох.

baltalayıcı *is.* ажил санаатайгаар саатуулагч, үймээн дэгдээгч, хорлон сүйтгэгч.

balya *is.* баглаа, боодол, зүйл, хайрцаг, уут. "*İki balya pamuk.*" Хоёр боодол хевөн.

balyoz *is.* лантуу, дөш.

balyozlama *is.* balyozlamak үйлийн нэр.

balyozlamak *(-le)* лантуугаар нүдэх, алх дөшеер нүдэх, давтах.

bambaşka *s.* өөр, огт өөр, шал өөр, тэс ондоо.

bambu *is. bot.* 1. хулс. 2. *s.* хулсан, хулсаар хийсэн.

bana *zm.* надад, над.

banal, II *s.* улиг болсон, чихний чийр болсон.

bandaj *is.* 1. ороолт, ороох материал, боолт. 2. боох, ороох, ороолт тавих, боолт тавих.

bandajlama *is.* bandajlamak үйлийн нэр.

bandajlamak *(-i)* боох, ороох, ороолт тавих, боолт тавих.

bandıra *is.* 1. хөлөг онгоцны туг, далбаа. 2. улс орны туг далбаа.

bandıralı *s.* туг далбаатай.

bandırma *is.* bandırmak үйлийн нэр.

bandırmak *(-i, -e)* дүрэх.

bando *is.* үлээвэр найрал хөгжим.

bandrol, -lü *is.* шошго, шогшиго.

bandrollü *s.* шошготой, шогшиготой.

bangır bangır *zf.* чанга дуугаар, өндөр дуугаар, тэнхээ мэдэн, байдаг чадлаараа. **~ ~ bağırmak** тэнхээ мэдэн бархирах, өндөр дуугаар хашгирах, байдаг чадлаараа орилох.

banka *is.* банк. "*Banka cüzdanı.*" Хадгаламжийн дэвтэр, банкны баримт. **~ gibi** мөнгений тулам, нударган баян (хүн). **~dan çekmek** банкнаас мөнгө авах. **~ya yatırmak** банкинд мөнгө хийх, банкинд мөнгө хадгалуулах.

bankacı *is.* банкны ажилтан, албан хаагч.

bankacılık, -ğı *is.* 1. банкны үйл ажиллагаа. 2. банкны ажил.

bankamatik *is.* бэлэн мөнгөний машин.

banker *is.* 1. банкны эзэн. 2. банкны ажилтан. 3. херенгийн зуучлагч. 4. мөнгений тулам, нударган баян.

bankerzede *is.* банкны буруутай үйл ажиллагаанаас болж хохирсон хүн, хохирогч.

banknot *is.* менген дээсгэрт, мөнгөн тэмдэгт, цаасан менге.

banliyö *is.* хотын зах, хотын дэргэдэх гацаа, дүүрэг, хотын хаяа. **~ treni** хот хооронд явах галт тэрэг.

banma *is.* banmak үйлийн нэр.

banmak, -ar *(-i, -e)* дүрэх. "*Yemeğime ekmek banıp yerim.*" Би хоолондоо талх дүрж иддэг.

bant, -dı *is.* 1. тууз, тасам. 2. шархны лент, шархны тууз. 3. наалддаг тууз. 4. соронзон тууз, соронзон хальс. **~a almak** хальсанд бичих, хальсанд буулгах.

bantlama *is.* bantlamak үйлийн нэр.

bantlamak *(-i)* наалддаг тууз наах, наалддаг туузаар холбох.

ban yağı *is.* тосон туулга.

banyo *is.* 1. усны онгоц, ванн. 2. усанд орох ерөө, угаалгын ерөө. 3. усанд орох, биеэ угаах, угаал үйлдэх. 4. усан эмчилгээ, рашаанд орох. 5. эмчилгээний ванн, тэвш. "*Güneş banyosu.*" Нарны ванн. "*Çamur banyosu.*" Шаврын тэвш, шавар эмчилгээний бие угаах тэвш. **~ yapmak** (veya **almak**) усанд орох, угаал үйлдэх.

banyolu *s.* 1. угаалгын өрөөтэй, ваннтай. 2. усанд орсон, усанд ороод саяхан гарсан.

bar (I) *is.* бар, уушны газар, үдшийн цэнгээний газар.

bar (II) *is. fiz.* бар (агаарын даралтын хэмжих нэгж).

baraj *is.* 1. хаалт, далан. 2. (сургууль) шалгуур, давах оноо. 3. (хел бөмбөг) хаалт.

baraka *is.* урц, оромж, овоохой.

barbar *s.* 1. зэрлэг, бүдүүлэг омгийн, хүй нэгдлийн үеийн. 2. *is.* бүдүүлэг омог, зэрлэг омгууд, зэрлэгүүд, харийнхан. 3. зэрлэг, бүдүүлэг. 4. *mec.* харгис хэрцгий, зэрлэг догшин, балмад, энэрэлгүй.

barbarca *s.* зэрлэгээр, бүдүүлгээр, догшин ширүүн, хэрцгийгээр.

barbarlık, -ğı *is.* бүдүүлэг явдал, бүдүүлэг харанхуй байдал, соёлгүй байдал.

barbunya *is.* 1. *zool.* нэгэн төрлийн загас. 2. *bot.* буурцаг, вандуй.

barcı *is.* барны эзэн.

bardak, -ğı *is.* 1. шилэн аяга, стакан. 2. аяганы хэмжээ. "*Bir bardak su verir misiniz?*" Нэг аяга ус өгөөч? *(yağmur)* **~tan boşanırcasına yağmak** тэнгэр юүлсэн юм шиг бороо орох, бороо асгарах, бороо цутгах.

bardan *s.* цав цагаан.

barınak, -ğı *is.* оромж, овоохой, орогнох газар, толгой хоргодох газар, хоргодох байр.

barındırma *is.* barındırmak үйлийн нэр.

barındırmak *(-i, -e)* barınmak үйлийн үйлдүүлэх хэв.

barınma *is.* barınmak үйлийн нэр.

barınmak *(-de)* 1. орогнох, толгой хоргодох. 2. байрших, байршиж суух, суурьших. 3. *mec.* эв найртай амьдрах, таарах, таарч суух, зохицож амьдрах.

barış *is.* 1. энх тайван. 2. энх тайвны гэрээ. 3. амар амгалан байдал, энх амгалан байдал. **~ yapmak** энх тайвны гэрээнд гарын үсэг зурах.

barışçı *s.* энх тайвныг эрхэмлэсэн, энх тайвныг сахисан, энх тайвны, энх тайвныг хүсэгч, энх тайванч, энх тайвныг тогтоогч.

barışçıl *is. bk.* barışçı.

barışçılık, -ğı *is.* пацифизм, энх тайвныг эрхэмлэх, эв эеийг хичээх.

barışık *s.* эвтэй, эвсэг, эв нийцтэй, эв эетэй, найрсаг.

barışma *is.* barışmak үйлийн нэр.

barışmak *(nsz, -le)* эвлэх, эвлэрэх, эвтээ орох, найрамдах.

barışsever *s.* энх тайвныг хүсэгч, энх тайвныг эрхэмлэгч, эө эвийг хичээгч, энх тайвныг тогтоогч.

barıştırma *is.* barıştırmak үйлийн нэр.

barıştırmak *(-ı, -le)* эвлэрүүлэх, эвлүүлэх, найрамдуулах.

bari *e.* 1. хэдийвээр, боловч, ч атугай, үгүй ядаж, тэглээ ч гэсэн, ядахдаа. 2. *zf.* ....ч болоосой, ...сан/сэн бол.

barikat *is.* хаалт, бэхлэлт, бөглөө, бөглөрөлт, саад тотгор. **~ kurmak** хаалт барих, бэхлэлт хийх. **~ yapmak** хаах, саад тотгор хийх, бөглөрелт хийх.

barikatlama *is.* barikatlamak үйлийн нэр.

barikatlamak *(-ı)* хаалт барих, хаах, бэхлэлт хийх, бөглөрөлт хийх.

bariton *is. müz.* 1. баритон, баргил хоолой. 2. баргил бүрээ.

bariyer *is.* 1. замын хаалт. 2. хаалт, саад тотгор, бөглее. 3. *sp.* (морины уралдаан) саад.

bariz *s.* илт, илэрхий, харваас илэрхий, мэдээжийн.

bark *is.* "*Ev bark.*" Орон гэр, гэр орон.

barklanma *is.* barklanmak үйлийн нэр.

barklanmak *(nsz)* гэр оронтой болох.

barmen *is.* бармен, баарны үйлчлэгч, зөөгч, шөнийн цэнгээний газрын үйлчлэгч.

barmenlik, -ği *is.* баарны үйлчлэгчийн ажил.

baro *is.* емгеөлөх байгууллага.

barograf *is.* барограф.

barok *is.* барокко маяг.

barometre *is. fiz.* 1. барометр, агаарын даралтын хэмжүүр. 2. *mec.* заагч тэмдэг.

baron *is.* барон, феодалын дээд хэргэм.

baroskop, -bu *is. fiz.* бароскоп.

barsak, -ğı *is. anat.* гэдэс.

barut *is.* дарь. **~ gibi** 1) ууртай, дүрсхийсэн, омогтой, аагтай. 2) ташуун, исгэлэн. **~ kesilmek** (veya **olmak**) уурлах, хилэгнэх. **~ kokusu gelmek** дайн болж мэдэшгүй, дайн ойртох, дарийн үнэр үнэртэх.

baryum *is. kim.* бари.

bas *is. müz.* 1. басс, хамгийн бүдүүн хоолой. 2. басс хөгжим.

basak, -ğı *is.* гишгүүр, шат.

basamak, -ğı *is.* 1. гишгүүр, шат. 2. үе шат, алхам, шат, түвшин. 3. *is.* (дээш гарах, хөгжлийн) шат, алхам.

basamak basamak *zf.* 1. алхам алхмаар, аажмаар. 2. шат дараалан.

basamaklı *s.* шат дараалсан, үе шаттай.

basar *is. esk.* 1. нүд. 2. *mec.* холын хараа, алсын хараа, мэдрэмж.

basbayağı *s.* энгийн, жирийн, хүн бүхний мэддэг, дасал болсон, байдаг л (юм).

basa *is.* хэвлэх, барлах, дармаллах.

basıcı *is.* хэвлэлийн ажилтан, хэвлэгч.

basık *s.* 1. дорой, сул, шахсан, нам (дуу, хоолой). 2. нам, намхан. 3. шамшигар, навтгар, хавтайлгасан, шамшийлгасан.

basılma *is.* basılmak үйлийн нэр.

basılmak *(nsz)* basmak үйлийн үйлдэгдэх хэв.

basım *is.* хэвлэлт, хэвлэх.

basım evi *is.* хэвлэх үйлдвэр, хэвлэлийн газар.

basın *is.* хэвлэл, хэвлэл мэдээлэл. "*Basın özgürlüğü.*" Хэвлэлийн эрх чөлөө. "*Basın toplantısı.*" Хэвлэлийн бага хурал.

basınç, -cı *is. fiz.* даралт.

basınçölçer *is. fiz.* барометр.

basırgama *is.* basırgamak үйлийн нэр.

basırgamak *(-e)* 1. бие хүндрэх, бие хүнд оргих. 2. хар дарах.

basil *is.* савханцар нян.

basiret *is.* хэрсүү гярхай зан, нэвтэрхий ухаан, мен чанарт нэвтрэх чанар.

basiretsizlik, -ği *is.* холч бодлогогүй байх, холыг харахгүй байх, бодлого мөчид байх, алсын хараагүй, харалган байдал.

basit *s.* 1. энгийн, хялбар. 2. *mec.* энгийн, жирийн, ерийн, эгэл. "*Basit bir giysi.*" Энгийн хувцас. 3. түгээмэл, хэвийн, ердийн, гоц биш, онц биш. 4. амархан, хялбархан.

basitçe *zf.* амархан, хялбархан, зовлонгүй.

basitleşme *is.* basitleşmek үйлийн нэр.

basitleşmek *(nsz)* хялбар болох, хялбарших, эгэл болох.

basitleştirme *is.* basitleştirmek үйлийн нэр.

basitleştirmek *(-i)* хялбарчлах, хялбар болгох.

basketbol, -lu *is. sp.* сагсан бөмбөг.

basketbolcu *is.* сагсан бөмбөгч.

baskı *is.* 1. хэвлэл. 2. хэвлэсэн тоо, ширхэг, хувь. 3. хэвлэлт. "*Sözlüğün ikinci baskısı.*" Толь бичгийн хоёр дахь хэвлэлт. 4. даралт, шахалт, шахуурга. 5. дарамт, хавчлага, хавчих, шахах. 6. *psikol.* сэтгэлийн дарамт. 7. хүрээ, эмжээр. **~ altında tutmak** хавчих, шахах, дарамтлах, дарамт үзүүлэх. **~ yapmak** хүчлэх, хүчээр хийлгэх, дарамтлах, дарлах.

baskıcı *is.* 1. хэвлэгч. 2. дарамтлагч, дарамт үзүүлэгч.

baskın *is.* 1. нэгжлэг, нэгжилт, цагдаагийн илрүүлэлт. 2. довтлого, халдлага, гэнэтийн дайралт. 3. *s.* давуу, давуу талтай, давамгай. **~ çıkmak** (veya **gelmek**) давах, давж гарах, давуу байх. **~ yapmak** 1) нэгжлэг хийх, нэгжих. 2) дайрах, довтлох, халдах. **~a uğramak** 1) халдлагад өртех. 2) гэмт хэргийн газар дээр баригдах.

baskıncı *is.* дайрагч, довтлогч.

baskül *is.* жигнүүр, жин, дэнс.

basma *is.* 1. basmak үйлийн нэр. 2. эрээн даавуу, хээтэй даавуу. 3. *s.* эрээн даавуун, эрээн даавуугаар хийсэн. 4. хэвлэл сэтгүүл, ном хэвлэл. 5. *s.* хэвлэгдсэн. 6. *hlk.* бордоо.

basmak, -ar *(-e)* 1. гишгэх. "*Çimlere basmayınız!*" Зүлгэн дээр бүү гишгэ! 2. (нялх хүүхэд) хөл дээрээ зогсож чадах, гишгэлэх. 3. болох, ирэх. "*Karanlık bastı.*" Харанхуй болов.

4. хэвлэх, барлах. "*Kitap basmak.*" Ном хэвлэх. 5. гишгэх, гишгэлэх, дэвсэх, дэвслэх. 6. мөр гаргах, дарах, тамгалах. "*Buraya baş parmağını bas dediler.*" Энд эрхий хуруугаараа дар гэцгээв. 7. дайрах, довтлох, халдах. 8. насанд хүрэх, настай болох. "*O bugün yirmi yaşına basıyor.*" Тэр өнөөдөр хорин нас хүрч байна. 9. унах, буух, нөмрөх, бүрхэх. "*Şehri akşamüstü sis basmıştı.*" Үдшийн цагаар хотыг манан бүрхсэн байлаа. 10. шахах, шахаж хийх. "*Kaba peynir basmak.*" Саванд бяслаг шахаж хийх. **basıp geçmek** 1) гүйцэх, гүйцэж түрүүлэх. 2) дайрахгүй өнгөрөх, тоохгүй өнгөрөх. **basıp gitmek** гэнэт явж одох, зайлах.

basmakalıp, -bı *is.* ve *s.* энгийн, нэг хэвийн, нийтлэг, уламжлалт, улиг болсон, байдаг л нэг.

basso *is. müz.* 1. аргил хоолой, унзад хоолой. 2. аргил бүрээ.

bastıbacak *s.* 1. богино хөлтэй, майга хөлтэй. 2. *mec.* сахилгагүй, дэггүй (хүүхэд).

bastırılma *is.* bastırılmak үйлийн нэр.

bastırılmak *(nsz, -e)* bastırmak үйлийн үйлдэгдэх хэв.

bastırma *is.* **bastırmak үйлийн нэр**

bastırmak *(-i, -e)* 1. basmak үйлийн үйлдүүлэх хэв. 2. дарах, хүчээр дарах. "*İsyanı bastırmak.*" Бослого дарах 3. давуу байх, давуу талаа харуулах. 4. дарах. "*Heyecanını bir türlü bastıramıyordu.*" Сэтгэлийн хөдөлгеенее дарж чадахгүй л байлаа. 5. гэнэт ирэх. 6. гэнэт орох, гэнэт хүчтэй шуурах, гэнэт болох. "*Yağmur birdenbire bastırdı.*" Бороо гэнэт асгарав. 7. дарамт үзүүлэх, шахах, дарамтлах.

baston *is.* таяг.

basur *is. tıp.* геморрой, шамбарам, гортиг гөвдрүү.

baş *is.* 1. толгой. 2. удирдагч, тэргүүн. 3. эх, анх, түрүү, түрүүч, эхлэл, эхэн. "*Hafta başı.*" Долоо хоногийн эхэн. 4. орой, оргил. 5. үндэс, суурь, эхлэл. 6. толгой, тав (хадаасны). 7. үзүүр, толгой, эхлэл. 8. *den.* хөлгийн хошуу, завины хамар хитэг. 9. толгой, ширхэг. "*Üç baş koyun.*" Гурван хонь. 10. ойролцоо, ойр. **~ ağrıtmak** залхаах, яршиг болох. **~ aşağı düşmek** нэр муудах, муу нэртэй болох. **~ sağlığı dilemek** эмгэнэл илэрхийлэх. **~ ~a vermek** 1) хэлцэх, зөвшилцөх, тохирох. 2) ярилцах. **~ ~a kalmak** хоёул үлдэх. **~ ~a olmak** хамт амьдрах, хамт байх. **~ etmek** хүч хүрэх, амжилтанд хүрэх. **~ göstermek** үзэгдэх, тодрох, илрэх. **~ kaldırmak** босох, бослого гаргах, эсэргүүцэх. **~ sallamak** толгой дохих. **~a ~ gelmek** тэнцэх, адил байх. **~a çıkmak** давах, дийлэх, чадах, хүчрэх . **~a gelmek** (муу явдал) тохиолдох, тулгарах. **~ı belaya girmek** хэрэгт орох, хэрэгт ороцолдох, муу үйл тохиолдох, гай дайрах, аюул тохиолдох. **~ çatlamak** толгой их өвдөх. **~ı çekmek** тэргүүлэх, манлайлах. **~ı sıkışmak** хэцүү байдалд орох, хүнд байдалд орох. **~ı yukarıda** нэр төртэй, ихэмсэг. **~ına vurmak** 1) (архи) согтоох. 2) толгой евтгөх. **~ından geçmek** тохиолдох, болж өнгерех, болох, тохиох. **~ının etini yemek** залхаах, залхтал ярих. **~tan çıkarmak** толгой эргүүлэх, сэтгэлийг урвуулах, уруу татах. **~tan aşağı** дээрээс доош, бүхэлд нь, эхнээс нь дуустал.

başak, -ğı *is.* (тарианы) түрүү.

Başak, -ğı *is. astr.* Охины орд.

başarı *is.* амжилт. **~ göstermek** амжилтанд хүрэх.

başarısızlık, -ğı *is.* амжилтгүй байдал, бүтэлгүй байх.

başarma *is.* başarmak үйлийн нэр.

başarmak *(-i)* дуусгах, амжилттай хийж дуусгах, амжилт гаргах, амжилтанд хүрэх.

başat *s.* ноёлж байгаа, ноёрхлоо тогтоосон, давамгайлсан, гол, үндсэн ерөнхий, зонхилсон.

başatlık, -ğı *is.* ноёрхол, давамгай байдал, нөлөө ихтэй байдал.

başbakan *is.* ерөнхий сайд.

başbakanlık *is.* 1. ерөнхий сайдын албан тушаал. 2. засгийн газрын ордон, ерөнхий сайдын өргөө.

baş belası *is.* гай таригч, тевег учруулагч.

başçavuş *is. ask.* бага дарга, түрүүч.

baş dönmesi *is.* толгой эргэх.

başhekim *is.* ерөнхий эмч.

başıboş *s.* 1. чөлөөтэй, хамааралгүй, эрх чөлөөтэй, дураараа. 2. уяагүй, бэхлээгүй, бөхлөөгүй, сул тавьсан, сул. 3. *mec.* эзэнгүй, удирдлагагүй, ямар нэг дэг журамд боогдоогүй, хязгаарлаагүй. **~ bırakmak** зөнд нь орхих, зоргоор нь тавих. **~ kalmak** дураараа байх, зоргоороо байх, зенгеерее байх.

başıbozuk, -ğu *is.* 1. жинхэнэ бус цэрэг, түр цэрэг. 2. засаг захиргаагүй нийгэм. 3. эмх журамгүй, эмх замбараагүй, дэг журамгүй.

başıkabak, -ğı *s.* халзан.

başı yumuşak *s.* номхон, зөөлөн зантай, хүлцэнгүй, дуулгавартай.

başka *s.* **1**. өөр, ондоо. 2. гадна. 3. бусад. 4. үүнээс гадна.

başkahraman *is. ed.* гол дүр.

başkalaşım *is. jeol.* метаморфизм.

başkalaşma *is.* 1. başkalaşmak үйлийн нэр. 2. *biy.* метаморфоз, хувирах.

başkalaşmak *(nsz)* 1. өөрчлөгдөх, хувирах, хувьсах. 2. *mec.* эвдрэх, еөрчлөгдөх, муудах.

başkalaştırma *is.* başkalaştırmak үйлийн нэр.

başkalaştırmak *(-i)* başkalaşmak үйлийн үйлдүүлэх хэв.

başkaldırı *is.* бослого, эсэргүүцэх.

başkan *is.* **1**. ерөнхийлөгч. 2. дарга.

başkanlık, -ğı *is.* **1**. даргалах, удирдах. 2. даргын ажил, үүрэг, хариуцлага. **~ etmek** (хурал) даргалах, удирдах. **başkanlığında** удирдлагын дор. **~ makamı** захиргаа, удирдах газар.

başkarakter *is. sin.* ve *tiy.* гол дүр.

başkent *is.* нийслэл хот.

başkomutan *is. ask.* ерөнхий жанжин, ерөнхий командлагч.

başkomutanlık, -ğı *is.* жанжин штабын газар.

başkonsolos *is.* ерөнхий консул.

başkonsolosluk, -ğu *is.* 1. ерөнхий консулын үүрэг, ажил. 2. еренхий консулын газар.

başkumandan *is. ask.* еренхий жанжин, ерөнхий командлагч.

başkumandanlık, -ğı *is.* жанжин штабын газар.

başlama *is.* başlamak үйлийн нэр.

başlamak *(-e)* 1. эхлэх. 2. эхлэх, төрөх, үүсэх. 3. үзэгдэх, харагдах. 4. ирэх, болох, эхлэх. "*Kış başladı.*" Өвөл ирлээ.

başlangıç, -cı *is.* 1. эхлэл. 2. *ed.* емнех үг. **~ noktası** эхлэлийн цэг.

başlanma *is.* başlanmak үйлийн нэр.

başlanmak *is.* başlamak үйлийн үйлдэгдэх хэв.

başlatma *is.* başlatmak үйлийн нэр.

başlatmak *(-i, -e)* эхлүүлэх.

başlayış *is.* эхлэл.

başlı başına *zf.* данганараа, тусдаа, дан ганц, биеэ даасан.

başlıca *zf.* гол, үндсэн, хамгийн чухал, голлох, амин чухал.

başlık, -ğı *is.* 1. малгай, тоорцог. 2. гарчиг, нэр. 3. гэрлэх ёсонд хүргэн болох эр, охины талд төлөх мөнге. 4. (дугуйн) бул.

başlıklı *s.* 1. малгайтай, тоорцогтой. 2. албан бичгийн болон захидлын дугтуйн толгой.

başmüfettiş *is.* ахлах байцаагч.

başmühendis *is.* ерөнхий инженер.

başoyuncu *is. sin* ve *tiy.* гол дүрийн жүжигчин.

başörtü *is.* толгойн алчуур.

başpapaz *is.* хамба лам.

başparmak, -ğı *is.* эрхий хуруу.

başrejisör *is.* еренхий найруулагч.

başrol, -lü *is.* гол дүр.

baş sağlığı *is.* эмгэнэл.

başşehir, -hri *is.* нийслэл хот, улсын нийслэл.

baştan savma *s.* хэлбэр төдий, ёс тедий, оромдсон.

başucu *is. astr* ve *coğr.* дээд цэг, оргил, орой.

baş ucu *is.* хажуу, орны толгой.

baş ucu kitabı *is.* гарын доорх ном, байнга хэрэглэдэг ном, ширээний ном.

başvekalet *is.* bk. başbakanlık.

başvekil *is.* bk. başbakan.

başvurma *is.* хүсэлт, хандалт.

başvurmak *(-e)* 1. хүсэлт гаргах, хандах. 2. ашиглах, хэрэглэх.

başvuru *is.* хүсэлт, хандалт, гуйлт.

başyapıt *is.* гол бүтээл, гол зохиол.

başyazar *is.* ерөнхий редактор.

başyazı *is.* тэргүүн өгүүлэл.

başyemek нэгдүгээр хоол.

başyönetmen *is.* еренхий найруулагч.

batak *is.* **1.** намаг, шавар, бүрд, балчиг. 2. *s. mec.* горьдлогогүй, найдваргүй, баларсан, нурсан, бүтэлгүй. 3. хүнд байдал, хэцүү байдал.

bataklı *s.* балчигтай, намагтай, шавартай.

bataklık, -ğı *is.* намагтай газар, намгархаг хөрс.

batarya *is.* 1. *ask.* батарей, суман, хэсэг. 2. нэг төрлийн эд ангийн бүлэг, иж бүрдэл. 3. цахилгаан цэнэгт хайрцаг, зайн нэгдүүр.

bateri *is. müz.* бөмбөр.

baterist *is. müz.* бемберчин.

batı *is.* **1.** өрне, баруун, нар шингэх зүг. 2. ернедийн орнууд, барууны орнууд, ерне зүгийн орнууд, өрне орон. 3. *s.* ернийн, баруун зүгийн.

batık *s.* (усан онгоц) живсэн.

batılı *s.* ернийн, барууны (орнууд).

batılılaşma *is.* batılılaşmak үйлийн нэр.

batılılaşmak *(nsz)* баруунжих, европчилох, европ янзтай болох.

batıl *s.* 1. хоосон, дэмий, худал. 2. үндэслэлгүй, хоосон, улгүй.

batıl inanç, -cı *is.* мухар сүсэг.

batırma *is.* batırmak үйлийн нэр.

batırmak *is.* 1. живүүлэх. 2. бүлэх, шаах, хатгах, шигтгэх. 3. гутаах, муулах. 4. буртаглах, хиртээх, хир болгох, бохир болгох. 5. *is.* мехөөх, сөнөөх, сүйтгэх. 6. дампуууруулах,үгүйрүүлэх, хоосруулах.

batkı *is.* ve *s.* дампуурал, төлбөрийн чадв аргүй болох, сөнөл, сүйрэл.

batkın *is.* ve *s.* дампуурсан, телберийн чадв аргүй, сүйрсэн.

batma *is.* batmak үйлийн нэр.

batmak, -ar *(nsz)* 1. живэх. 2. (нар) жаргах, шингэх. 3. дампуурах, үгүйрэх, хоосрох. 4. бохиртох, хиртэх, хир болгох. 5. шаах, шигдэх, хатгах 6. зэвүүцэх, эгдүүцэх, дургүй хүрэх, уур хүргэх. 7. сөнөх, мехөх. 8. гомдох, (хэлсэн үг) хүндээр тусах.

battaniye *is.* ноосон хөнжил, хучлага бүтээлэг.

bavul *is.* аяны цүнх, чемодан.

bay (I) *s. esk.* баян, нударган баян (хүн).

bay (II) *is.* 1. эрхэм, нөхер, ноён. "*Bay Burak.*" Эрхэм Бурак. 2. эрэгтэй хүн. "*Bir bay sizi arıyor.*" Нэг эрэгтэй хүн таныг асууж байна.

bayağı *s.* 1. еедгүй, олиггүй, хүний үнэргүй, хуншгүй, жудаггүй. 2. бүдүүлэг, замбараагүй, ичгүүр сонжуургүй, бузар. 3. хэвийн, ердийн, жирийн. 4. *zf.* бараг, арай л, хариугүй, шахам. "*Bayağı kanacak gibi oldum.*" Хариугүй хуурташдах шахав. 5. *zf.* нэлээд, овоо, бузгай, сайн, дариун. 6. *zf.* чухамдаа, үнэндээ, үнэхээр, нэлээд, овоо, бузгай.

bayan *is.* 1. хатан, хатагтай, ноёгтой. 2. эмэгтэй хүний нэрийн оронд хэрэглэнэ. "*Bir bayan sizi aradı.*" Нэг эмэгтэй таныг асуусан. 3. эхнэр, гэргий.

bayat *s.* 1. хатсан, хатуу, хуучирсан. 2. *mec.* хуучирсан, хуучны, хоцрогдсон.

bayatlama *is.* bayatlamak үйлийн нэр.

bayatlamak *(nsz)* хатах, хатуу болох, хуучрах.

baygın *s.* 1. ухаан алдсан, ухаангүй, муужирсан. 2. ядранги, зүдрэнгэ, зовонги, гунигтай. 3. манаруулсан, ухаан балартуулсан, согтоосон. 4. янаг амраг, дурласан, хайртай. 5. хагдарсан, унасан. **~ düşmek** ихэд ядрах, сулдах, доройтох, тамирдах, тэнхээрхэх.

bayılma *is.* bayılmak үйлийн нэр.

bayılmak *(nsz)* 1. муужрах, муурч унах, ухаан алдах. 2. тахих, шүтэх, эрхэмлэх, эрхэмлэн дээдлэх, ихэд таалагдах, таалах. 3. *arg*o. төлех, өгөх. "*İki lira bayıldık.*" Хоёр лир төллөө шүү дээ.

bayıltma *is.* bayıltmak үйлийн нэр.

bayıltmak *(-e)* муужруулах, ухаан алдуулах.

bayındır *s.* цэцэглэн хөгжсөн, цэцэглэн мандсан, тохилог, тохинуун.

bayındırlaşma *is.* bayındırlaşmak үйлийн нэр.

bayındırlaşmak *(nsz)* цэцэглэн хегжих, цэцэглэн мандах, мандах.

bayındırlık, -ğı *is.* 1. мандах, цэцэглэн мандах, цэцэглэн хөгжих, хегжил, дэвшил. 2. мандуулах, цэцэглэн мандуулах, цэцэглэх хөгжүүлэх, хөгжилд хүргэх.

bayır *is.* дов, гүвээ, болдог, толгой.

bayi, -i *is.* салбар, цэг.

bayilik, -ği *is.* 1. худалдаалах, тараах, түгээх. 2. худалдах цэг, түгээх цэг, салбар.

baykuş *is. zool.* ууль.

bayrak, -ğı *is.* 1. туг, далбаа. 2. бэлгэ тэмдэг. **~ çekmek (**veya **asmak)** далбаа өлгөх. **~ indirmek** далбаа буулгах. **~ı yarıya indirmek** далбааг хагас буулгах, туг бехийлгех.

bayraklı *s.* тугтай, далбаатай.

bayraktar *is.* тугч, тугчин, туг баригч.

bayram *is.* 1. баяр, баяр ёслол. "*Bayram günü.*" Баярын өдөр. "*Bayram havası.*" Баярын уур амьсгал. 2. *mec.* баяр басгалан, цэнгэл. **~ etmek** баярлах, баясах. **~da seyranda** хаяа, хаяа нэг.

bayramlaşma *is.* bayramlaşmak үйлийн нэр.

bayramlaşmak *(nsz)* баярын мэнд хүргэх, ёслох, баяр тэмдэглэх.

bayramlık, -ğı *s.* 1. баярын, сайн өдрийн. "*Bayramlık elbise*" Баярын хувцас. 2. *is.* баярын бэлэг.

baytar *is.* малын эмч.

baytarlık, -ğı *is.* мал эмчийн мэргэжил.

baz *is.* 1. суурь, ул, үндэс. 2. *kim.* суурь.

bazal *s. kim.* суурьлаг, суурьлаг чанартай.

bazalt *is.* хүрмэн чулуу, хүрэм.

bazen *zf.* заримдаа, хаяа, үе үе

bazı *s.* 1. зарим, зарим нэг, зарим хүн. 2. *zf.* заримдаа, хаяа, хаяа нэг, зарим үед.

bazik *s. kim.* суурьлаг, суурьлаг чанартай.

bebe *is. hlk.* нялх хүүхэд, нярай хүүхэд.

bebek *is.* 1. хөхүүл хүүхэд, нялх хүүхэд, елгийтэй хүүхэд. 2. хүүхэлдэй, наадгай. 3. нүдний цөцгий.

bebeklik, -ği *is.* 1. балчир нас. 2. хүүхэд зан, хүүхдэрхүү ааш.

beceri *is.* 1. чадвар, чадал, чадах, дүй. 2. амжилт. 3. авьяас чадвар, арга дүй, чадамгай байх.

becerikli *s.* авьяастай, чадамгай, чадвартай, арга дүйтэй.

beceriksiz *s.* авьяасгүй, чадваргүй, дадлагагүй, эв дүйгүй.

becerme *is.* becermek үйлийн нэр.

becermek *(-i)* 1. амжилттай гүйцэтгэх, амжилттай биелүүлэх, чадах. 2. эвдэх, сүйтгэх, хугалах, хагалах. 3. *argo.* (эмэгтэй хүнийг) хүчирхэх, хүчирхийлэх, хүчирхэн явалдах. 4. *argo.* хүний аминд халдах, хүн алах.

bedahet *is. esk.* 1. тов тодорхой, илэрхий, илт (байдал). 2. бэлтгэлгүйгээр ярих чадвар.

bedava *s.* телеесгүй, үнэ телбөргүй, үнэгүй.

bedavacı *s.* бүх зүйлсийг телеесгүй авахыг хичээгч, бэлэн юманд дуртай, зүгээр сууж шимэгч, хүнийг мөлжигч.

bedavaya *zf.* үнэгүй шахам, зүгээр шахуу, их хямдхан.

bedbaht *s.* азгүй, хувьгүй, жаргалгүй, золгүй, заяа муутай. **~ etmek** гомдоох, гутраах. **~ olmak** гомдох, гутрах.

bedbahtlık, -ğı *is.* азгүйдэл, гай, үйл, тотгор, муу заяа, аз жаргалгүй байх.

bedbin *s.* гутрангуй, итгэл мөхөс. **~ etmek** гутраах, гутрангуй болгох, итгэл мөхөстүүлэх. **~ olmak** гутрах, гутрангуй болох, итгэл мехестех.

bedbinlik, -ği *is.* гутрангуй үзэл, итгэл мөхес үзэл, пессимизм.

beddua *is.* хараал. **~ etmek** хараах, хараал хийх. **~sı tutmak** хараал хүрэх. **~sını almak** хараалгах, хараал хийлгэх.

bedel *is.* 1. үнэ, үнэ өртег, үнэ цэнэ. 2. солио, арилжаа. 3. адил тэнцүү, тэнцүү. 4. телөөс (цэргийн алба хаахгүйн тулд, мөн цэргийн албаны хугацааг багасгахын тулд телөх телөөс).

beden *is.* 1. бие, бие махбод, организм. 2. цээжин биө, цээж. 3. цайзны хана.

bedenci *is.* биеийн тамирын багш.

beden eğitimi *is. sp.* биеийн тамир.

bedensel *s.* биеийн, биет, бие бялдрын.

bedevî *is.* 1. бедуин хүн, арабын нүүдэлчин, бядан явагч. 2. *s.* бедуин, арабын нүүдэлчин, бядан явагч.

bedir, -dri *is. esk.* тэргэл сар, дүүрэн сар, арван тавны сар.

begonya *is. bot.* хайтан цэцэг.

beğendirme *is.* beğendirmek үйлийн нэр.

beğendirmek *(-i, -e)* beğenmek үйлийн үйлдүүлэх хэв.

beğeni *is.* таалалж, таалах, таашаал, таашаах мэдрэмж.

beğenilme *is.* beğenilmek үйлийн нэр.

beğenilmek *(nsz)* таалагдах.

beğenme *is.* beğenmek үйлийн нэр.

beğenmek *(-i)* 1. таалах, таашаах, таалагдах. "*Ben bu tabloyu çok beğendim.*" Энэ зураг надад их таалагдлаа. 2. сонгох, шилэх, шилж авах, илүү гэж үзэх. 3. таалах, зөвшөөрөх, сайшаах, сайшаан батлах

beğenmemek *(-i)* 1. таалагдахгүй байх, таалахгүй байх. 2. дорд үзэх, үл ойшоох, үл тоомсорлох. 3. үгүйсгэх, үл зевшөөрөх, таалагдахгүй байх. 4. эргэлзэх, тээнэгэлзэх.

behavyorizm *is. psikol.* бихевиоризм.

beher *s.* бүр, бүхэн, тутам.

behişt *is.* диваажин, энхжин, сугаа вади.

bej *is.* хул, ухаа (өнге).

bek (I) *s. hlk.* хатуу, чанга, бат бөх.

bek (II) *is. sp.* хамгаалагч.

beka *is.* үүрд менх байх, үхэшгүй мөнх байдал. ~ **bulmak** менхжих, үүрд орших, үхэшгүй мөнх байх.

bekâr *s.* гэрлээгүй, гэр бүлгүй, ганц бие, гоонь.

bekârlık, -ğı *is.* ганц бие амьдрал, гэрлэхгүй байх.

bekçi *is.* харуул, манаач.

bekçilik, -ği *is.* харуул, манаа

bekleme *is.* 1. beklemek үйлийн нэр. 2. цаг нөгцөөх.

beklemek *(nsz)* 1. хүлээх. 2. сахих, манах, хамгаалах, харах. 3. найдах, горьдох, хүлээх.

bekleme salonu *is.* хүлээлтийн танхим.

beklenme *is.* beklenmek үйлийн нэр.

beklenmedik *s.* ve *zf.* санаандгүй, гэнэт, санамсаргүй.

beklenmek *is.* beklemek үйлийн үйлдэгдэх хэв.

beklenti *is.* 1. хүлээлт, итгэл найдвар, найдах. 2. магадлал.

bekletilme *is.* bekletilmek үйлийн нэр.

bekletilmek *(-)* bekletmek үйлийн үйлдэгдэх хэв.

bekletme *is.* bekletmek үйлийн нэр.

bekletmek *(-i, -e)* 1. хүлээлгэх. 2. сахиулах,мануулах, хамгаалуулах, харуулах. 3. найдвар төрүүлэх, горьдоох, хүлээлгэх.

bekleyiş *is.* хүлээлт, хүлээх.

bel (I) *is.* шинж, тэмдэг, дохио.

bel (II) *is.* 1. зоо, зоо нуруу. "*Bel ağrısı.*" Зоо нуруу евдех, зоогоор хатгах. "*Bel fıtığı.*" Уцны ясны гэмтэл, нуруу нугасны гэмтэл. "*Bel kemiği.*" Нуруу, сээр, нурууны яс. 2. бэлхүүс. 3. уулын жим. ~ **bağlamak** итгэх, найдах. ~**i bükülmek** хүч тамир доройтох, хөгшрех. ~**i çökmek** бөгтийх, бөхийх. ~**ini bükmek** бэрхшээлтэй байдалд оруулах, аргагүй байдалд оруулах. ~ **soğukluğu** *is. tıp.* хүйтэн евчин, заг.

bel (III) *is.* хүрз, савар, хамуур.

bel (IV) *is.* сперм, эр бэлгийн эс, үрийн шингэн.

belâ *is.* 1. гай, гай зовлон, хор, хорлол, муу юм. 2. гай таригч, хохирол учруулагч, аюул нүүрлэгч. 3. шийтгэл, гэсгээл. "*Allah belâsını versin!*" Бурхан шийтгэг/гэсгээг!. 4. (муу зүйлд татан оруулах) нелее, нөлөөлөх, донтох. "*O kumar belasına tutuldu.*" Тэр мөрийтэй тоглоомны донтой болчихсон байна. ~ **aramak** өдөх, едөөн хатгах. ~ **çıkarmak** хэрүүл зодоон гаргах. ~ **okumak** хараах, хараал хийх. ~**ya girmek** гай дайрах, муу юм тохиолдох. **(başını) ~ya sokmak** өөрөө өөртее гай удах, гай тарих.

belâgat, -ti *is.* 1. уран үг. 2. *esk.* яруу илтгэх зүй. 3. *ed.* уран илтгэл. 4. гүн утга, гүн санаа.

belâlı *s.* 1. хортой, муу нөлөөтэй, уршигтай, гай зовлонтой, гайтай. 2. танхай, үймээн дэгдээгч, зодоонч.

Belçikalı *öz. is. ve s.* бельги хүн, бельги гаралтай, бельгийн.

belde *is. esk.* хот.

belediye *is.* хотын захиргаа, нутгийн захиргаа. "*Belediye başkanı.*" Хотын дарга.

belek, -ği *is.* өлгий, хүүхдийн даавуу.

beleş *s.* төлөөсгүй, үнэ төлбергүй.

belge *is.* баримт, баримт бичиг, батлах хуудас, лавлах баримт.

belgeci *is.* баримтат киноны найруулагч.

belgeleme *is.* belgelemek үйлийн нэр.

belgelemek *(-i)* баримттай болгох, баримтжуулах.

belgelendirme *is.* belgelendirmek үйлийн нэр.

belgelendirmek *(-i)* баримтаар нотлох.

belgelik, -ği *is.* архив, хуучин данс бичгийн газар.

belgesel *s.* 1. баримттай, баримтат. 2. *is.* баримтат кино. "*Belgesel film.*" Баримтат кино зураг.

belgi *is.* онцлог, онц ялгаа.

belgileme *is.* belgilemek үйлийн нэр.

belgilemek *is.* тодорхойлох, тогтоох, онцлог чанарыг харуулах.

belgili *is.* онцлогтой, онц ялгаатай, тодорхой.

belgin *s.* тодорхой, илт, илэрхий.

belgit *is.* нотолгоо, нотлол, нотлох баримт.

beliklеme *is.* beliklemek үйлийн нэр.

beliklemek *(nsz)* үс сүлжих.

belirgin *s.* илт, илэрхий, тод, тодорхой, лавтай, маргаангүй.

belirginleşme *is.* belirginleşmek үйлийн нэр.

belirginleşmek *(nsz)* тодрох, илрэх, тод болох, тодорхой болох, илт болох.

belirginlik, -ği *is.* илт байдал, илэрхий байдал, тодорхой байх.

belirleme *is.* тодорхойлолт, тогтоол.

belirlemek *(-i)* 1. тодорхойлох, тогтоох. 2. *man.* тодотгох, тодорхойлох, тодорхойлолт өгөх, заах. 3. хязгаарлах, хэмжээлэх.

belirlenim *is.* тодорхойлолт, тодотгол.

belirlenme *is.* belirlenmek үйлийн нэр.

belirlenmek *(nsz)* тодорхойлогдох, тогтоогдох, тодотгуулах.

belirli *s.* тогтсон, тодорхой. **~ belirsiz** мэдэгдэхтэй үгүйтэй, үл мэдэгдэм, бүдэг бадаг, тод биш

belirme *is.* belirmek үйлийн нэр.

belirmek *(nsz)* 1. илэрхий болох, тодорхой болох. 2. үзэгдэх, харагдах, тодрох, илрэх, илрэн гарч ирэх. 3. илрэх, тодрох, учир нь олдох.

belirsiz *s.* 1. тодорхойгүй, тогтоогүй, тодорхой биш. 2. эргэлзмээр, дамжигтай, хоёрдмол утгатай, утга битүү, тээнэгэлзээтэй. 3. үл мэдэх, үл таних, мэдэхгүй, мэдэгдээгүй, учир битүүлэг .

belirsizlik, -ği *is.* тодорхой биш байдал, учир битүүлэг байдал, үл мэдэх.

belirteç, -ci *is. gr.* дайвар үг.

belirten *is. gr.* тодорхойлогч.

belirti *is.* шинж, тэмдэг, шинж тэмдэг.

belirtme *is.* үзэл бодол илэрхийлэх, илэрхийлэл, тодотгол.

belirtmek *(-i)* илэрхийлэх, тайлбарлах, тодотгох, мэдэгдэх.

belit *is. man.* аксиом, илт үнэн, нотлогогүй үнэ.

beliye *is.* гай гамшиг, гай зовлон, аюул.

belki *zf.* магадгүй, яаж ч мэднэ, ... мэднэ.

bellek, -ği *is.* **1**. ой, цээж, санаа. 2. компьютерийн санах ой, электрон тооцоолох машины санах байгууламж, санах төхөөрөмж. **~ kaybı** *is. tıp.* санах ой алдагдах, ой санамжаа алдах.

belleme *is.* bellemek үйлийн нэр.

bellemek *(-i)* 1. цээжлэх, тогтоох. 2. санах.

belleten *is.* мэдээллийн тогтмол хэвлэл, шинжлэх ухааны сэтгүүл.

belletme *is.* belletmek үйлийн нэр

belletmek *(-i, -e)* 1. цээжлүүлэх, тогтоолгох. 2. сануулах

belletmen *is.* (дунд сургуулийн) давтуулагч.

belli *s.* 1. илэрхий, мэдээжийн, гарцаагүй. 2. тодорхой, илт, илэрхий. **~ etmek** 1) илэрхийлэх, тайлбарлах, ойлгуулах. 2) гаргах, мэдэгдэх, мэдрүүлэх, харуулах, илэрхийлэх. **~ olmak** ойлгогдох, мэдэгдэх, харагдах.

belli başlı *s.* 1. тогтсон, тодорхой, илэрхий. 2. үндсэн, гол, чухал.

belli belirsiz *zf.* мэдэгдэхтэй үгүйтэй, үл мэдэгдэм, бүдэг бадаг, тод биш.

bembeyaz *s.* цав цагаан, цасан цагаан, дун цагаан.

ben (I) *is.* мэнгэ.

ben (II) *zm.* 1. би (нэгдүгээр биеийн төлөөний ганц тоо). 2. *is. psikol.* бие хүн, хувь хүн. 3. *is. fel.* бие хүний мөн чанар.

ben (III) *is.* хахуул, илбээс, өгөөш, өөш, хилбэ, мэн, өгьее. "*Balık beni.*" Загас барих илбээс.

benbenci *s.* өөрийгөө хэт их ергөмжилдөг, сэхүүн зантай, еерийгөө магтах дуртай, ихэрхэг, хамраа сехсөн.

bence *zf.* миний бодлоор бол, минийхээр бол, миний санахад.

benci *s.* бардам, их зантай, биеэ тоосон.

bencil *s.* аминч, аминчхан, хар амиа хөөгч, хувиа хичээгч, амиа бодогч.

bencillik, -ği *is.* хувиа хичээх үзэл, хар амиа хөөх, амиа бодох.

benek, -ği *is.* жижиг толбо, буудан, бидэр.

benekli *s.* толботой, цоохор.

bengi *s.* мөнхийн, үүрдийн.

benimseme *is.* benimsemek үйлийн нэр.

benimsemek *(-i)* 1. хүлээн зөвшөөрөх, эзэмших, өөрийн болгох. 2. *mec.* ижилсэх, дасах, дотносох, ээнэгших.

benimsenme *is.* benimsenmek үйлийн нэр.

benimsenmek *(nsz)* benimsemek үйлийн үйлдэгдэх хэв.

beniz, -nzi *is.* нүүрний енге. **benzi açmak** нүүр нь цонхийх, зэвхийрэх. **benzine kan gelmek** царай орох, енге орох.

benlenme *is.* benlenmek үйлийн нэр.

benlenmek *(nsz)* мэнгэ бий болох, мэнгэ үүсэх.

benli *s.* мэнгэтэй.

benlik, -ği *is.* 1. бие хүн, хувь хүн. 2. өөрийгөө өргөмжлөх явдал, их зан, биеэ тоох.

benlikçilik, -ği *is.* 1. өөрийгөө өргөмжлөх, өөрийгөө шүтэх явдал. 2. хувиа хичээх үзэл.

bent, -di *is. esk.* 1. (сэтгэлийн) холбоо, холбоос. 2. далан, хаалт, усны далан. 3. (хуулийн) зүйл анги, зүйл. 4. *esk.* сонины егүүлэл. 5. *ed.* бадаг.

benzeme *is.* benzemek үйлийн нэр.

benzemek *(-e)* 1. адилхан байх, ижил байх, төстэй байх. 2. ижил харагдах, адилхан харагдах, санагдуулах.

benzer *s.* 1. адил, адилхан, төстэй, төсөөтэй. 2. *is. mat.* адилтгал. 3. *is. sin.* орлон тоглогч.

benzerlik, -ği *is.* 1. адил төстэй байдал. 2. *mat.* харьцуулалт, адилтгал.

benzersiz *s.* зүйрлэшгүй, харьцуулшгүй, ижилгүй, хосгүй, цорын ганц.

benzeşme *is.* ижилсэх, адилсах, автагдан шингэх, төстэй болох, адил байх.

benzeşmek *(nsz)* ижилсэх, адилсах, автагдан шингэх, төстэй болох, адил байх.

benzetilme *is.* benzetilmek үйлийн нэр.

benzetilmek *(nsz)* benzetmek үйлийн үйлдэгдэх хэв.

benzetme *is.* benzetmek үйлийн нэр.

benzetmek *(-i, -e)* 1. адил төстөй болгох, адилтгах, ижил болгох. 2. андуурах, эндүүрэх, холих, хутгах, будлих. "*Sizi bir başkasına benzettim.*" Би таныг өөр хүнтэй андуурсан байна. 3. *мес.* эвдэх, сүйтгэх, хэсэг хэсэг болгох, бутлах. "*Çocuk oyuncağını benzetti.*" Хүүхэд тоглоомоо эвдчихсэн. 4. *мес.* зодох, жанчих, балбах, нүдэх.

benzeyiş *is.* адил байх, төсөө, төс.

benzin *is.* бензин (машины шингэн шатахуун). "*Benzin deposu.*" Түлшний сав. "*Benzin istasyonu.*" Шатахуун түгээх станц.

benzinci *is.* ve *s.* шатахуун түгээх станц, шатахуун түгээгч.

benzinlik, -ği *is.* шатахуун түгээх станц.

benzol, -lü *is. kim.* бензол.

beraat, -ti *is. huk.* цагаатгал. **~ etmek** цагаатгах.

beraber *zf.* 1. хамт, цуг, зэрэгцээ. 2. *мес.* адил, ижил, тэнцүү, чацуу. 3. боловч, ч гэсэн. **~e bitmek** хайнцах, хайнцаж дуусах. **~e kalmak** хайнцах, тэнцэх, хожилгүй болох. **~inde** хажуудаа, хамтдаа.

beraberce *zf.* хамтдаа, цугтаа, хамтран, хоршин.

beraberlik, -ği *is.* 1. хамт байх, нэгдэл, нэгдэх. 2. хайнцал, тэнцэл.

berat *is.* 1. патент, эрхийн бичиг, зохиогчийн эрхийн бичиг. 2. *tar.* хааны захирамж, тушаал (Оттоманы гүрэнт улсад тушаал дэвших, цалин олгох, шагнах, хүндэтгэлийн ёслол хийх гэх мэт үйл явдалд хааны гаргасан тушаал, захирамж).

berbat *s.* 1. муу, муухай, муусайн. 2. эвдэрхий, хэмхэрхий, муу. "*Berbat bir yolu.*" Муу зам. 3. муухай, олиггүй, онцгүй. 4. замбараагүй, эмх цэгцгүй, новширсон, хөглөрсөн, заваан. **~ etmek** 1) үгүй хийх, нураах, сүйтгэх, хэцүү байдалд оруулах. 2) эвдэх, эвдлэх, сүйтгэх, устгах. **~ olmak** 1) муухай болгох, бохир болгох, хир буртаг болгох, хиртээх. 2) эвдрэх, муудах. "*Onun karakteri iyice berbat olmuş.*" Түүний зан нь ихэд эвдэрсэн байна.

berber *is.* 1. үсчин. 2. үсчин, үсчний газар, үс засах газар

berduş *is.* ve *s.* 1. дэмий сэлгүүцэгч, танхай. 2. заваан, бохир, замбараагүй, хегдөрсөн.

bere (I) *is.* эсгий тоорцог, хилэн тоорцог, малгай.

bere (II) *is.* хөх няц, хөхрөх.

bereket *is.* 1. элбэг байдал, элбэг дэлбэг байдал, арвин байх. 2. *zf.* аз дайрахад, завшаанаар. 3. *hlk.* бороо, бороо хур.

bereketli *s.* элбэг, дэлбэг, арвин.

bereleme *is.* berelemek үйлийн нэр.

berelemek *(-i)* хөх няц болгох, хөхрүүлэх.

beri *is.* 1. ойр, ойрхон, хамгийн ойр (тал). 2. е. тэр үеэс хойш, ... хойш. "*Dünden beri.*" Өчигдрөөс хойш.

beriberi *is. tıp.* бери–бери, В витамины дутагдал.

berilyum *is. kim.* берилли, биндэр.

berk *s.* 1. хатуу, чанга. 2. бөх, бөх бат.

berkime *is.* berkimek үйлийн нэр.

berkimek *(nsz)* хүчирхэгжих, бэхжих, бат бөх болох, батжих.

berkitme *is.* berkitmek үйлийн нэр.

berkitmek *(-)* хүчжүүлэх, бэхжүүлэх, бат бөх болгох, батжуулах, хүч нэмэх.

berklik, -ği *is.* 1. хатуу чанар, хатуу чанга байдал. 2. бөх бат байдал.

berrak *s.* тунгалаг, цэвэр, саруул, цэлмэг. "*Berrak su.*" Тунгалаг ус, цэнгэг ус.

berraklaşma *is.* berraklaşmak үйлийн нэр.

berraklaşmak *(nsz)* 1. тунгалаг болох, цэвэр болох, саруул болох. 2. тодрох, илрэх, тодорхой болох.

berraklaştırma *is.* berraklaştırmak үйлийн нэр.

berraklaştırmak *(-i)* 1. тунгалаг болгох, цэвэр болгох, саруул болгох. 2. тодруулах, тод болгох, тодорхой болгох, ойлгомжтой болгох.

berraklık, -ğı *is.* тунгалаг байдал.

bertaraf *is.* зайлуулалт, арилгах, хураах. **~ etmek** зайлуулах, арилгах, хураах, нэг тийш болгох, үгүй хийх. **~ olmak** үгүй хийх, арилах, хураагдах.

bertilme *is.* bertilmek үйлийн нэр.

bertilmek *(nsz)* 1. булгарах, мултрах, гэмтэх, бэртэх. 2. хөх няц болох, хөхрөх. 3. шалбарах, шархтах.

bertme *is.* bertmek үйлийн нэр.

bertmek *is. bk.* bertilmek.

besbelli *s.* 1. тов тодорхой, ив илт, илэрхий. 2. *zf.* харваас, ойлгомжтой.

besi *is.* 1. тэжээх, хооллолт. 2. шимтэй зүйл, тэжээллэг зүйл. **~ye çekmek** (амьтныг) бордох, шахах, таргалуулах.

besili *s.* бордсон, шахсан, таргалуулсан.

besin *is.* хоол хүнс, хоол тэжээл.

besi suyu *is. bot.* (ургамлын) шүүс, шим, шүлт.

besleme *is.* 1. beslemek үйлийн нэр. 2. тэжээлгэгч охин, гэрийн үйлчлэгч. 3. *is.* дэмжигч, тэтгэгч.

beslemek *(-)* 1. хоол хүнсээр хангах, тэжээх. 2. хоол идүүлэх, хооллох, ундлах, тэжээх. 3. бордох, шахах, таргалуулах. 4. есгех, бойжуулах, тэжээх. "*Köpek beslemek.*" Нохой тэжээх. 5. санагалзах, бодох, сэтгэл зүрхэндээ тээх. 6. бэхлэх, бэхжүүлэх, бехлөх. 7. (гол) нийлэх, нэгдэх. 8. *мес.* менгөн туслалцаа үзүүлэх, туслах, дэмжих, тэжээх.

beslenen *s. fiz.* унтардаггүй, саардаггүй.

beslenme *is.* 1. beslemek үйлийн үйлдэгдэх хэв. 2. хооллолт, тэжээл.

beslenme eğitimi *is.* зөв хооллох арга зүй, хооллох ухаан.

beslenmek *(nsz)* 1. хооллох, хоол идэх, идэшлэх. 2. beslemek үйлийн нэр.

besleyici *s.* тэжээллэг, шимтэй

beste *is. müz.* ая. ~ **yapmak** ая зохиох.

besteci *is.* ая зохиогч, хөгжмийн зохиолч.

bestekâr *is.* ая зохиогч, хөгжмийн зохиолч.

besteleme *is.* bestelemek үйлийн нэр.

bestelemek *(-i)* ая зохиох.

beş *is.* тав, тавын тоо. ~ **para almamak** менгө авахгүй байх. ~ **para etmez** үнэ цэнэгүй, ямар ч хэрэггүй, юу ч биш, улаан мөнгений үнэгүй. ~ **parasız** хувхай хоосон, ядуу зүдүү.

beş duyu *is.* таван мэдрэх эрхтэн (харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрч мэдрэх).

beşer (I) *is.* хүн, хүн төрөлхтөн.

beşer (II) *s.* тав тавaар.

beşeriyet *is.* хүн төрөлхтөн, хүмүүс.

beşeriyetçi *is.* энэрэлт хүн, хүнлэг хүн.

beşeriyetçilik, -ği *is. esk.* хүнлэг ёс, энэрэнгүй үзэл, хүнийг дээд төрөлт амьтан болохыг хүлээн зевшөөрдөг шинжлэх ухаан.

beşgen *is. mat.* таван өнцөгт.

beşik, -ği *is.* 1. өлгийн ор. 2. өлгий нутаг, голомт.

beşik kertme *is.* хүүхдийг өлгийтэй байхад нь эцэг эх нь сүй тавих.

beşinci *s.* тавдугаар, тав дахь.

beşiz *is.* таван ихэр (хүүхэд).

beşli *s.* 1. тав, таван, таван хэсгээс бүрдсэн, таван ширхэг. 2. *is.* таван нүд, хезрийн тавт. 3. *ed.* таван мөрт шүлэг.

beşlik, -ği *is.* 1. тавтын бутархай менге, таван мөнге. 2. тавтын багц.

bet, -di *s.* муухай, хачин. ~ ~ **bakmak** муухай муухай харах.

beter *s.* хамгий муу, адгийн муу, адаг, зааз, маш муу.

beti *is.* дүрс, маяг, хэлбэр дүрс.

betimleme *is.* betimlemek үйлийн нэр, дүрслэл, дүрслэн бичих.

betimlemek *(-i)* дүрслэх, дүрслэн бичих, тодорхойлон бичих, тодорхойлон өгүүлэх.

beton *is.* бетон, хиймэл гуранз.

betonarme *is.* төмөр бетон.

bevliye *is.* бөөр судлал, бөөр суваг эмчлэх ухаан.

bevliyeci *is.* бөөрний эмч, бөөрний сувгийн эмч.

bey *is.* 1. гуай, ноён. 2. эрэгтэй хүний нэрийн оронд хэрэглэнэ. *"Bir bey sizi aradı."* Нэг эрэгтэй хүн таныг сураглаcан. 3. нөхөр, хань. 4. баян хүн, язгууртан. 5. *tar.* хөзрийн тамга. 6. командлагч, дарга.

beyan *is.* илтгэл, егүүлэл, заалт. ~ **etmek** мэдүүлэх, илтгэх, илэрхийлэх.

beyanat *is.* мэдэгдэл, мэдүүлэг. ~**ta bulunmak** (veya ~ **vermek**) мэдэгдэл гаргах, мэдүүлэг гаргах.

beyanname *is.* тунхаг, тунхаглал, тунхаг бичиг, мэдэгдэл.

beyaz *is.* 1. цагаан, цагаан өнгө. 2. *s.* цагаан, цагаан өнгөтэй. *"Beyaz kağıt."* Цагаан цаас. 3. *is.* цагаан арьстан. 4. сийрүүлэг бичиг. ~**a çekmek** (veya ~ **etmek** хуулан бичих, дахин хуулах, сийрүүлэх.

beyazımsı *s.* цэгээн, цагаавтар.

beyazımtırak *is.* цэгээн өнге, цагаавтар енгө.

beyazlanma *is.* beyazlanmak үйлийн нэр.

beyazlanmak *(nsz)* цайрах, цагаан болох.

beyazlaşma *is.* beyazlaşmak үйлийн нэр.

beyazlaşmak *(nsz)* цайрах, цайх, цагаарах.

beyazlatıcı *is.* цайруулагч.

beyazlatma *is.* beyazlatmak үйлийн нэр.

beyazlatmak *(-i)* цайруулах, цайлгах, цагаан болгох.

beyaz perde *is.* 1. дэлгэц. 2. *mec.* кино урлаг.

beyefendi *is.* ноён, ноёнтон.

bey erki *is. sos.* язгууртан ноён.

beygir *is.* 1. морь, агт. *"Beygir gücü."* Морины хүч. 2. уналганы морь, тэрэгний морь.

beyhude *zf.* 1. хий, дэмий, хоосон, талаар. 2. тусгүй, дэмий, үр ашиггүй, утгагүй.

beyin, -yni *is.* 1. (уураг) тархи. 2. *mec.* ухаантан, хосгүй ухаантан. 3. оюуны чадав х. ~ **yıkamak** *psikol.* үзэл суртлын аргаар хүнийг өөрчлөх. **beyni bulanmak** 1) мангуурах, дүйнгэрэх, толгой дүйрэх. 2) муу юм зөгнөх, муу ёрлох. **beyni sulanmak** зенөх. **beyninden vurulmuşa dönmek** цохигдох, тархинд цус харв ах шиг болох. **beynine vurmak** (архи) толгойд гарах, өөрийн ухаангүй болох. ~ **cerrahı** *is. tıp.* тархины мэс засалч. ~ **kanaması** *is. tıp.* тархинд цус харвах.

beyincik, -ği *is. anat.* бага тархи.

beyin göçü *is.* тархины урсгал, өндер мэдлэг боловсролтой, эрдэм чадалтай сэхээтэн хүмүүс гадаадад цагаачлах явдал.

beyin gücü *is.* сэтгэх хүч чадвар.

beyinli *s.* 1. тархитай. 2. *mec.* ухаантай, тархи сайтай, толгойтой.

beyinsel *s.* уураг тархины, тархи нугасны.

beyinsiz *s.* 1. тархигүй. 2. *mec.* тэнэг мулгуу, хоосон толгойт, усан тархит.

beyit, -yti *is. ed.* хоёр мөрт (шүлэг).

beylik, -ği *s.* 1. улсын. 2. улиг болсон, нэг хэвийн, байдаг л нэг. *"Beylik söz."* Улиг болсон үг. 3. чинээлэг, тансаг. 4. *tar.* эмират 5. *esk.* засаг төр.

beynelmilel *s.* олон улсын.

beysbol *is. sp.* бэйсбол.

beysbolcu *is.* бэйсболчин.

beytülmal, -li *is.* улсын сан хөрөнгө.

beyzi *s.* зууван, зууван хэлбэртэй, зуувгар.

bez (I) *is.* 1. даавуу, даавуун материал.

2. ямар нэгэн төрлийн бес материал, даав уу. "*Masa bezi.*" Ширээний бүтээлэг. "*Yelken bəzi.*" Усан онгоцны далбаа. 3. ямар нэгэн зориулалтаар ашиглах даавуу, бөс материал. "*Toz bezi*" Тоосны алчуур. "*Çocuk bezi.*" Хүүхдийн даавуу. 4. алчуур, даавуу. 5. *s.* даав уун, даавуугаар хийсэн.

bez (lI) *is. biy.* булчирхай.

bezdirici *is.* 1. залхаах, хашраах, улиглах. 2. *s.* залхаасан, улиг болсон.

bezdirme *is.* bezdirmek үйлийн нэр.

bezdirmek *(-i, -dən)* залхаах, хашраах, улиг болох.

bezek, -ği *is.* 1. гоёл чимэглэл, хээ угалз, чимэглэл. 2. гоёл засал, дотоод засал чимэглэл.

bezelye *is. bot.* буурцаг, вандуй.

bezeme *is.* гоёл, чимэглэл.

bezemek *(-i)* гоёх, чимэх, чимэглэх.

bezen *is.* чимэглэл, чимэг.

bezgi *is.* гоёл, чимэглэл.

bezgin *s.* залхсан, ядарсан, үлбэгэр, үлжгэр.

bezginleşme *is.* bezginleşmek үйлийн нэр.

bezginleşmek *(nsz)* залхах, ядрах, үлбийх, гөлийх.

bezginlik, -ği *is.* залхсан байдал, ядарсан байдал, үлбэгэр байдал.

bezik, -ği *is.* безиз, хөзрийн тоглоом.

bezir, -zrI *is.* 1. хөвенгийн үр. 2. хөвенгийн тос. "*Bezir yağı.*" Хөвенгийн тос.

bezme *is.* залхалт.

bezmek *(-den)* залхах.

bıcıl *is.* 1. тагалцаг, сагаг, шагай, шивнүүр. 2. шагайгаар тоглох.

bıcırgan *is.* бөөрөнхий хуурай.

bıçak, -ğı *is.* 1. хутга. "*Keskin bıçağı.*" Хурц хутга. 2. зүсэгч. 3. сахлын хутга. **~ altına yatmak** мэс засал хийлгэх. **~ atmak** 1) хутга шидэх. 2) хутгалах. 3) мэс засал хийх. **~ çekmek** хутга тулгах. **~ yemek** хутгалуулах.

bıçaklama *is.* bıçaklamak үйлийн нэр.

bıçaklamak *(-i)* 1. хутгаар зүсэх, хэрчих. 2. хутгалах, хутга дүрэх, хутгаар шархтуулах.

bıçaklanma *is.* bıçaklanmak үйлийн нэр.

bıçaklanmak *(nsz)* bıçaklamak үйлийн үйлдэгдэх хэв.

bıçaklı *s.* хутгатай.

bıçkı *is.* 1. хөрөө. 2. цахилгаан хөрөө.

bıkkın *s.* залхсан, уйдсан, тевегшөөсөн, хаширсан.

bıkkınlık, -ğı *is.* залхалт, залхаа. **~ gelmek** залхах. **~ vermek** залхаах.

bıkma *is.* bıkmak үйлийн нэр.

bıkmak, -ar *(-den)* 1. залхах, залхуу хүрэх, улиг болох, хашрих. 2. *mec.* тэсэхээ байх, тэвчээр барагдах, алдах.

bıktırma *is.* bıktırmak үйлийн нэр.

bıktırmak *(-i, -den)* залхаах, залхуу хүргэх, хашраах, улиг болгох.

bıldır *s.* ve *zf. hlk.* енгерсен жил, өнгөрөгч

bıldırcın *is. zool.* бөдне шувуу, хулжуухай.

bıllık bıllık *s.* тарган, бүдүүн, мяраатай.

bıngıldak, -ğı *is.* зулай.

bıngıldama *is.* bıngıldamak үйлийн нэр.

bıngıldamak *(nsz)* цулцганах, цулцга цулцга хөдлөх.

bırakıt *is.* өв, ев хөрөнгө.

bırakma *is.* **1.** bırakmak үйлийн нэр. 2. суллах, челөөлөх.

bırakmak *(-i)* 1. орхих, унагах, алдах. 2. тавих, орхих. "*Birisi masaya bu parayı bırakıp gitmiş.*" Хэн нэгэн хүн ширээн дээр энэ мөнгийг орхиод явчихсан байна. 3. хойшлуулах, хойш тавих. 4. орхих, хаях, гээх, мартах. 5. орхих, үлдээх, хоцроох. 6. хойш тавих, хадгалж үлдэх, орхих, үлдээх. "*Paranın bir kısmını bırak!*" Мөнгөний нэг хэсгийг нь орхи!. 7. (үүрэг ба хариуцлагыг өөр хүнд) шилжүүлэн егөх, орхих, үлдээх, даалгах, үүрэг болгох. 8. унжуулах, орхих. "*Saçlarını omzuna bırakmış.*" Үсээ мөрөө дагуулан унжуулсан байлаа. 9. өв хөрөнгө үлдээх, орхих. 10. болих, огоорох, хаях, орхих, гарах. "*Sigarayı bırakmak.*" Тамхинаас гарах. 11. орхих, болих, хийхээ болих. "*O tenis oynamayı bıraktı.*" Тэр теннис тоглохоо больсон. 12. суллах, суллан тавих, чөлөөлөх, тавих. 13. орхиж явах, хаях. 14. (**анги**) **улираах. 15. салах,** хагацах, хаях. 16. үлдээх, хоцроох, хажуудаа авахгүй байх. 17. наалт салах, ховхрох. 18. үүсгэх, бий болгох, болгох, орхих, үлдээх. "*İz bırakmak.*" Мөр үлдээх. "*Leke bırakmak.*" Толбо болгох. 19. (сахал) тавих, ургуулах.

bıraktırma *is.* bıraktırmak үйлийн нэр.

bıraktırmak *(-i, -e)* bırakmak үйлийн үйлдүүлэх хэв.

bıyık, -ğı *is.* живэр сахал, дээд сахал . **~ bırakmak** сахал тавих. **~ altından gülmek** мишилзэх, жуумалзах, маасалзах.

bıyıklı *s.* сахалтай, сахлаа хусаагүй.

bıyıksız *s.* сахалгүй, сахлаа хуссан.

bızır *is. anat.* клитор, хэлүү.

biber *is. bot.* чинжүү.

biberli *s.* 1. чинжүүтэй, халуун ногоотой. 2. хурц гашуун.

biberlik, -ği *is.* 1. чинжүүний сав. 2. чинжүүний талбай, чинжүү тариалдаг газар.

biberon *is.* үгж.

bibliyograf *is.* библиографич, ном зүйч, номын сангийн мэргэжилтэн.

bibliyografya *is.* ном зүй, номын жагсаалт.

bibliyotek, -ği *is.* номын сан.

bibliyotekçi *is.* номын санч.

biçare *s.* арга барагдсан, хеерхийлөлтэй, өревдмөөр. **~ olmak** арга барагдах, аргаа барах, мухардах.

biçarelik, -ği *is.* аргагүй байдал, хеерхийлөлтэй байдал.

biçerbağlar *is.* тариа юүлүүр, тариа боох машин.

biçerdöver *is.* комбайн.

biçilme *is.* biçilmek үйлийн нэр.

biçilmek *(nsz)*biçmek үйлийн үйлдэгдэх хэв.

biçim (I) *is.* 1. хэлбэр, гадаад байдал, дүрс. 2. төрөл, зүйл, анги. 3. аятай байдал, тохиромжтой хэлбэр. 4. адил байх, төсөө, ижил байдал. 5. төрөл, маяг, хэв загвар. **~ almak** тодорхой хэлбэр дүрстэй болох, хэлбэржих, хэлбэрт орох. **~e sokmak** (veya **~ vermek**) тодорхой хэлбэр дүрстэй болгох, хэлбэржүүлэх, хэлбэрт оруулах.

biçim (II) *is.* biçmek үйлийн нэр.

biçimlendirme *is.*biçimlendirmek үйлийн нэр.

biçimlendirmek *(-i)* тодорхой хэлбэр дүрстэй болгох, хэлбэржүүлэх, хэлбэрт оруулах.

biçimlenme *is.* biçimlenmek үйлийн нэр.

biçimlenmek *(nsz)* тодорхой хэлбэр дүрстэй болох, хэлбэржих, хэлбэрт орох.

biçimli *s.* 1. хэлбэр сайтай, галбир сайтай. 2. таарсан, тохирсон.

biçimsiz *s.* 1. хэлбэргүй, галбиргүй. 2. таарамжгүй, таарахгүй, тохирохгүй, зохисгүй. 3. *fiz.* хэлбэр дүрсгүй, аморф.

biçimsizleşme *is.* biçimsizleşmek үйлийн нэр.

biçimsizleşmek *(nsz)* хэлбэр дүрсээ алдах, хэлбэргүй болох.

biçkı *is.* эсгүүр.

biçkıcı *is.* эсгүүрчин.

biçme *is.* 1. biçmek үйлийн нэр. 2. зассан барилгын чулуу, өөлсен барилгын суурь чулуу. 3. *mat.* призм, олон талст, олон цамцаалт.

biçmek, -er *(-i)* **1**. (тодорхой хэлбэр гарган) зүсэх, хэрчих, огтлох. 2. эсгэх. 3. (өвс) хадах. 4. шүршүүр буугаар шүрших, хядах, хиартал устгах. 5. үнэлэх, үнэлж дүгнэх.

bidon *is.* бидон.

biftek, -ği *is.* бифштекс.

bîgünah *s.* нүгэлгүй, хилэнцгүй, гэмгүй.

bîhaber *s.* мэдэхгүй, мэдээгүй, дуулаагүй.

bikarbonat *is. kim.* хоёрч нүүрсхүчлийн давс.

bikes *s.* өнчин, өнчирсөн.

bikini *is.* усны хувцас.

bikir, -kri *is. esk.* онгон охин.

bilâhare *zf.* эцэст нь, тегсгөлд нь, дараа нь, хамгийн сүүлд нь.

bilâkis *zf.* эсрэгээр, үүний яг эсрэг, харин.

bilânço *is.* баланс, тэнцвэр, тохирол, тооцооны дүн.

bilârdo *is.* бильярд, ширээний бембег (тоглоом). *"Bilârdo masası."* Бильярдын ширээ.

bildik, -ği *is.* ve *s.* мэддэг, мэдэх.

bildirge *is.* 1. мэдэгдэл. 2. татварын мэдүүлэг.

bildiri *is.* 1. мэдэгдэл, мэдээлэл. *"Ortak bildiri yapmak."* Хамтарсан мэдэгдэл хийх. 2. илтгэл.

bildirim *is.* мэдэгдэл, мэдээлэл, мэдүүлэг.

bildirişim *is.* мэдээ, мэдээлэл, холбоо, харилцаа.

bildirme *is.* мэдэгдэл, мэдээлэл.

bildirmek *(-i, -e)* 1. мэдэгдэх, мэдээлэх. 2. мэдээлэх, айлтгах, илтгэх, мэдээлэл хийх, тайлбар хийх. 3. тайлбарлах, тайлбарлан таниулах.

bile *zf. esk.* 1. хамт, цуг. 2. *e.* ... ч гэсэн, ...ч, ...ч хүртэл, ...ч бас. 3. тэр ч байтугай, түүгээр ч үл барам, түүнээс гадна. **~ bile** *zf.* мэдсээр байж, албаар, зориудаар, зориуд, санаатайгаар.

bileği *is.* билүү, хайрга.

bilek, -ği *is.* 1. гарын бугуй, хөлийн шагай 2. *mec.* хүч, чадал, эр чадал. **bileğine güvenmek** хүч чадалдаа эрдэх, эр чадалдаа бардамнах. **bileğinin hakkı ile** зевхөн өөрийн хүч чадлаараа, гагцхүү өөрийн хөлс хөдөлмөрөөрөө.

bilek kuvveti *is.* гарын хүч, биеийн хүч.

bileklik, -ği *is.* бугуйн боолт.

bilek saati *is.* бугуйн цаг.

bileme *is.* bilemek үйлийн нэр.

bilemek *(-e)* 1. гуранздах, билүүдэх, ирлэх, хурцлах, үрэх. 2. *mec.* хүчирхэгжүүлэх, хүчирхэг болгох, хүчтэй болгох, нөлөөг нэмэгдүүлэх.

bilenme *is.* bilenmek үйлийн нэр.

bilenmek *(nsz)* 1. bilemek үйлийн үйлдэгдэх хэв. 2. *mec.* анхаарлаа төвлөрүүлэх, хүчин зүтгэл гаргах. 3. *mec.* улайрах, шар хөдлөх, ихэд хүсэх.

bileşik, -ği *is.* 1. нэгдэл, хольц, нийлэл. 2. *kim.* нийлмэл, нэгдсэн, холимог, хэд хэдэн хэсгээс бүрдсэн, нийлмэл бүтэцтэй (бодис).

bileşik faiz *is. ekon.* нарийн хувь хэмжээтэй хүү.

bileşim *is. kim.* 1. бүтэц, бүрэлдэхүүн. 2. холимог бодис, нийлмэл бодис. 3. нэгдэх, нийлэх.

bileşke *is. fiz.* тэнцүү хүч.

bileşme *is.* bileşmek үйлийн нэр.

bileşmek *(nsz, -le)* нэгдэх, нийлэх.

bilet *is.* билет, тасалбар. **~ kesmek** билет таслах, тасалбар / билет худалдах.

biletçi *is.* билет зарагч.

biletsiz *s.* билетгүй, тасалбаргүй.

bilezik, -ği *is.* 1. бугуйвч. 2. цагираг, хүрээ, цагирган холбоос. 3. *argo.* гав.

bilge *is. ve s.* ухаан билиг тегс, билигт, эрдэмтэй, эрдэмтэн, эрдэм ухаантай, мэргэн

bilgelik, -ği *is.* 1. эрдэм ухаан, билиг ухаан, мэргэн ухаан. 2. *fel.* гүн ухаан. 3. *fel.* (эртний гүн ухаанд) өөрийгөө танин мэдэхүйн ухаан.

bilgi *is.* 1. мэдлэг, эрдэм мэдлэг, танин мэдэхүй. 2. мэдээлэл, мэдээ баримт, мэдээ. 3. шинжлэх ухаан. 4. мэдэц, мэдлэг, боловсрол, ухвар. **~edinmek** 1) сурах, мэдэх, сурч мэдэх. 2) ойлгох, байдлыг мэдэх, ухвар мэдээтэй байх. **~ vermek** мэдээ өгөх, мэдээлэх, мэдэгдэх.

bilgici *is.* софист, софизмыг баримтлагч.

bilgicilik, -ği *is. fel.* 1. софизм (өнгецхэн үзэхэд зөв мэт боловч, үнэндээ зориуд хуурмаг баримт хэрэглэн хийсэн дүгнэлт). 2. хуурмаг баримт хэрэглэх.

bilgiç, -ci *is.* 1. эрдэмтэн, мэргэн, мэргэшсэн хүн. 2. *mec.* мэдэмхийрэгч, мэдэрхээч, мэдэхгүй мөртөө мэддэг юм шиг царай гаргагч.

bilgiçlik, -ği *is.* эрдэм мэдлэг төгс байдал, мэргэшил. **~ satmak** (veya **taslamak**) мэдэмхийрэх, мэдэрхэх, бага мэдэвч их мэдэх байдал гаргах.

bilgi kuramı *is. fel.* танин мэдэхүйн онол, мэдлэгийн онол.

bilgilendirme *is.* bilgilendirmek үйлийн нэр.

bilgilendirmek *(-i)* мэдээлэх, мэдэгдэх.

bilgilenme *is.* bilgilenmek үйлийн нэр.

bilgilenmek *(nsz)* мэдэх, мэдэж авах.

bilgili *s.* 1. мэдлэгтэй, боловсролтой, ою ун билиг төгс, эрдэм мэдлэгтэй. 2. *zf.* зориуд, санаатайгаар, албаар.

bilgin *is. ve s.* эрдэмтэн, эрдэмтэй, мэргэн.

bilgisayar *is.* компьютер.

bilgisayarcı *is.* компьютерийн техникч, мэргэжилтэн, компьютерийн инженер, компьютерийн программист.

bilgisiz *is.* мэдлэггүй, боловсролгүй, харанхуй бүдүүлэг, юм мэдэхгүй.

bilgisizlik, -ği *is.* мэдлэг боловсролгүй байдал, харанхуй бүдүүлэг байдал, юм мэдэхгүй байх.

bilhassa *zf.* ялангуяа, тухайлбал, онцгойлон, тусгайлан, голчлон, юуны өмнө.

bilim *is.* шинжлэх ухаан, эрдэм ухаан. **~ adamı** эрдэмтэн.

bilimci *is.* эрдэмтэн.

bilim dalı *is.* салбар ухаан, шинжилгээний тусгай ухаан, ухааны зүй.

bilim kurgu *is.* шинжлэх ухааны уран зөгнөл.

bilimsel *s.* шинжлэх ухааны, эрдэм шинжилгээний.

bilimselleştirme *is.* bilimselleş tirmek үйлийн нэр.

bilimselleştirmek *(-i)* шинжлэх ухааны шинжчанартай болгох, шинжлэх ухааны шинжтэй болгох.

bilimsellik, -ği *is.* шинжлэх ухааны шинжчанар, шинжлэх ухааны арга маяг.

bilinç, -ci *is.* 1. мэдээ, мэдрэл, ухаан, ухамсар. 2. *mec.* үндсэн мэдлэг, суурь мэдлэг, үндсэн санаа бодол. 3. ой ухаан, санаа, ой. 4. оюун санаа, сэтгэл санаа, сэтгэл зүй. **bilincine varmak** ойлгох, ухаарах, сэхээ орох. **bilincini yitirmek** ой ухаанаа алдах, ой санамжаа алдах.

bilinçaltı *is. psikol.* дотоод ухамсар, ой санамж, ой ухаан.

bilinç dışı *is. psikol.* ухаан мэдрэлгүй, өөрийн мэдэлгүй, санаатай биш.

bilinç kaybı *is.* ой ухаанаа алдах, ой санамжаа алдах.

bilinçlenme *is.* bilinçlenmek үйлийн нэр.

bilinçlenmek *(nsz)* 1. мэдэх, суурь мэдлэгтэй болох, мэдлэг авах. 2. ой ухаан орох, сэхээ орох.

bilinçli *s.* 1. ухамсартай, эрүүл ухаантай, еерийн ухаантай, зориуд, үйлдсэн, санаатайгаар хийсэн. 2. мэдлэгтэй, суурь мэдлэгтэй, мэдлэг боловсролтой.

bilinçsiz *s.* 1. өөрийн ухаангүй, еерийн мэдэлгүй, ухаан мэдрэлгүй, өөрийн эрхгүй, санаатайгаар хийгээгүй, зориуд бус үйлдсэн. 2. мэдлэггүй, суурь мэдлэггүй, юм мэдэхгүй, харанхуй бүдүүлэг.

bilinçsizlik, -ği *is.* 1. ухаан мэдрэлгүй байх, өөрийн ухаангүй байх, ой ухаангүй байх. 2. мэдлэггүй байх, суурь мэдлэггүй байх, харанхуй бүдүүлэг байдал.

bilindik, -ği *is.* ve *s. mat.* тодорхой, тогтмол.

bilinemez *is. fel.* мэдэж болшгүй зүйлс, мэдэх аргагүй юм.

bilinemezci *is. fel.* агностик үзэлтэн.

bilinemezcilik, -ği *is.* агностицизм, өртөнцийг ойлгошгүй гэдэг гүн ухаан, ойлгошгүйн онол.

bilinen *is.* ve *s.* тодорхой, тогтмол.

bilinme *is.* bilinmek үйлийн нэр.

bilinmedik *is.* ve *s. mat.* үл мэдэгдэх.

bilinmek *(nsz)* bilinmek үйлийн үйлдэгдэх хэв.

bilinmeyen *is. ve s. mat.* үл мэдэгдэх.

bilinmez *s.* 1. үл мэдэгдэх, үл мэдэх, мэдэгдэхгүй, ойлгомжгүй, төвөгтэй. 2. нууц, далд, учир битүү.

bilirkişi *is.* 1. мэргэжилтэн, эксперт, шинжээч, нарийн мэргэжилтэн. 2. *huk.* нарийн мэргэжилтэн, шинжээч.

bilirkişilik, -ği *is.* экспертиз гаргах, мэргэжилтний дүгнэлт гаргах, шинжээчийн дүгнэлт гаргах.

bilirkişi raporu *is.* экспертийн дүгнэлт, мэргэжилтний дүгнэлт, шинжээчийн дүгнэлт.

bilisiz *is.* ve *s.* боловсролгүй, харанхуй бүдүүлэг, бичиг үсэгт тайлагдаагүй, үл мэдэгч.

bilişim *is.* мэдээлэл зүй. "*Bilişim ağı.*" Мэдээллийн сүлжээ.

billûr *s.* 1. талст. 2. *is.* болор. 3. *s.* болороор хийгдсэн, болор (аяга).

billûr cisim, -smi *is. anat.* нүдний цэцгий.

billûrsu *s.* 1. талст, талст шиг. 2. *kim.* кристаллоид.

bilme *is.* bilmek үйлийн нэр.

bilmece *is.* **1**. оньсого, таавар. 2. *mec.* нууц зүйл. **~ çözmek** оньсого таах.

bilmek, -ir *(-i)* 1. мэдэх. 2. мэдэх, мэдлэг эзэмших. 3. чадах. "*İyi ütü bilir.*" Сайн индүүдэж чадна. 4. таних, мэдэх, таньж мэдэх, санах. "*Kapıyı aç. Ben geldim. Bilemedin mi?*" Хаалгаа тайл. Би ирлээ. Намайг таньсангүй юу, чи? 5. бодох, санах, тооцох, үзэх. 6. ойлгох, мэдэх. 7. итгэх, найдах. 8. *-a/-e* нөхцөл, үйл үгтэй нэгдэн ....чадах гэсэн утга бүхий үйл үг үүсгэнэ. "*Yazabilmek*" Бичиж чадах, "*Gidebilmek*" Явж чадах, "*Görebilmek*" Харж чадах. **bildiğini okumak** еерийнхөөрөө зүтгэх, еерийнхеерее байх. **bildim bileli** миний мэдэхийн. **bilerek** санаатайгаар, зориуд, мэдсээр байж.

bilmeden 1) мэдэлгүй, ерийн мэдэлгүй, санамсаргүйгээр. 2) юу болохыг/тохиолдохыг мэдэлгүй, эцэс нь ямар байхыг мэдэж чадалгүй..

bilmemezlik, -ği *is.* мэдэхгүй байх, юм мэдэхгүй байх, харанхуй бүдүүлэг байдал.

bilmezlik, -ği *is.* мэдэхгүй байх, юм мэдэхгүй байх, харанхуй бүдүүлэг байдал. **~ten gelmek** мэдэхгүй дүр эсгэх, мэдэхгүй царайлах.

bilmiş *s.* 1. мэдэмхийрэгч, мэдэрхээч, мэдэхгүй мөртлее мэддэг юм шиг царай гаргагч. 2. *is.* их мэдэгч.

bilmukabele *zf.* 1. харилцан. 2. танд, та нарт, танд ч гэсэн, танд бас.

bilvasıta *zf.* дамжуулан,тойруулан,шууд бус.

bilye *is.* 1. мөхлөг, үрэл, жинс. 2. бөөрөнхий холхивч, мөхлөгөн эргэвч, бөөрөнхий подшипник.

bilyon *is.* биллион, арван дүнчүүр.

bin *s.* 1. мянга. 2. *mec.* олон, тоо томшгүй, асар их, мянга мянган. **~ pişman olmak** маш их харамсах. **~ yaşa!** урт насал! **~de bir** хаяа нэг, ховорхон.

bina *is.* 1. байшин, барилга. "*Hükümet binası.*" Засгийн газрын ордон. 2. *gr. esk.* хэв. 3. *gr. esk.* араб хэлний үйл үгийн дүрмийн ном. **~ etmek** 1) барих, барьж босгох. 2) (ямар нэгэн үзэл бодлын системд) тулгуурлах, түшиглэх, үндэслэх, үндэс болгох.

binaen *zf.* 1. учир, учраас, иймд, иймийн тулд, тул. 2. үндэслэн, тулгуурлан, түшиглэн.

binaenaleyh *zf.* иймийн тул, иймээс, ийм учраас, тиймээс, ингэхлээр, учир иймд.

binbaşı, -yı *is. ask.* хошууч.

bin bir *s.* олон, маш олон, тоо томшгүй олон, их, мянга мянган.

bindi *is.* тулгуур.

bindirme *is.* **1.** bindirmek үйлийн нэр. 2. хагас давхцалт, давхралт.

bindirmek *(-i, -e)* 1. binmek үйлийн үйлдүүлэх хэв. 2. мөргөх, цохих. 3. нэмэх, нэмэгдүүлэх.

binek, -ği *is.* 1. уналга. 2. *s.* унах, уналгын. "*Binek atı.*" Уналгын морь.

biner *s.* мянга мянгаар, мянган.

binici *s.* **1**. унагч, унаач. 2. *is.* жигит, гавшгай морьтон, моринд чадамгай хүн.

binicilik, -ği *is.* 1. морин спорт. 2. моринд чадамгай байх, чадварлаг морь унахдаа.

binilme *is.* binilmek үйлийн нэр.

binilmek *(sz, -e)* binmek үйлийн үйлдэгдэх хэв.

bininci *s.* мянга дахь, мянгадугаар.

biniş *is.* 1. binmek үйлийн нэр. 2. *esk.* морин цэргийн хороо. 3. *esk.* морин цэргийн хувцас. 4. *tar.* (ихэс дээдэс болон цэргийн жанжны өмсдөг) жанч, немрөг.

binit *is. esk.* уналгын мал, уналгын морь.

bin kat *s.* мянга түм дахин, хэмжээлшгүй, хязгаарлашгүй.

binlerce *s.* олон мянган, хэдэн мянган, маш олон.

binlik, -ği *is.* 1. нэг мянгатын дэвсгэрт. 2. ойролцоогоор гурван литрийн лонх, том шил. 3. *s.* мянгатын, мянган ширхэг.

binme *is.* binmek үйлийн нэр.

binmek, -er *(-i)* 1. (унаанд) суух. 2. унах, мордох. 3. давхарлах, дээр дээрээс нь давхарлах. 4. (үнэ) нэмэгдэх, өсөх. 5. нэмэгдэх, нийлэх, нэгдэх. 6. (ажил) муугаар эргэх, хэрэг буруу тийш хандах.

binnetice *zf.* эцэст нь, төгсгөлд нь.

binyıl *is.* мянган жил.

bir *is.* 1. анхдагч тоо, эхний тоо. 2. нэг, нэгийн тоо. 3. *s.* нэг. "*Bir kalem.*" Нэг үзэг. 4. нэгэн, нэг. "*Bir adam sizi soruyor.*" Нэг хүн таныг асууж байна. 5. ганц, гагц. 6. хамт, хамтдаа, цуг. "*Hep biriz, ayrılmayız.*" Бид үргэлж хамтдаа, хэзээ ч хагацахгүй. 7. нийтийн, бүх, дундын, нэг. 8. *is.* адил, ижил. 9. тэмдэг нэр ба дайвар үг болон хэрэглэгдэх үедээ ерийнхөө дараа орсон үгэнд хүсэл илэрхийлэх, хүч нэмэгдүүлэх ба тодорхой бус утга нэмнэ. "*Bir güzel ki...*" Ямар сайхан гээч... "*Bir tuhaf bakıyor.*" Нэг жигтэй харна. "*Bir gidin bakalım.*" Нэг яваад үзээдэх дээ. 10. *zf.* дахин нэг, дахин дахин. 11. *zf.* зөвхөн, ганцхан. "*Her şey bitti. Bir bu kaldı.*" Бүх юм дууссан. Зөвхөн энэ л үлдлээ. 12. дан, дан ганц, гагцхүү. "*Bunu bir sen yapabilirsin.*" Үүнийг гагцхүү чи л хийж чадна. **~ varmış ~ yokmuş** эрт урьдын цагт. **~ an önce** аль болох хурдан, бушуухан шиг, шалавхан. **~ ara** нэг цагт, нэг үе. **~ araya gelmek** цугларах, бөөгнөрөх. **~ araya getirmek** цуглуулах. **~ arada** хамт, цуг, нэг доор. **~ avuç** 1) нэг атга, атга. "*Bir avuç buğday.*" Атга буудай. 2) цөөхөн, цөөн тооны, бага. **~ bakıma** нэг талаас, нөгөө талаас, нөгөөтэйгүүр. **~ başına** ганцаараа, цор ганцаараа. **~ bir** *zf.* 1) нэг нэгээрээ, тус тусдаа, дангаараа. 2) яг үнэнээр нь, байгаагаар нь, бүрэн гүйцэд. **~ çift** 1) хос. "*Bir çift ayakkabı.*" Нэг хос гутал. 2) бага зэрэг, ганц хоёр. **~ daha** *zf.* дахин, ахин, дахиад, дахин нэг.

bira *is.* шар айраг, пиво.

birader *is.* 1. ах, эрэгтэй дүү. 2. "Найзаа!" "Анд минь!" (дуудах үг). "*Biz bu sorumluluğu üzerimize alamayız, birader.*" Бид энэ хариуцлагыг хүлээж чадахгүй, анд минь. 3. масон нарын бие биенээ нэрлэдэг нэр.

birahane *is.* шар айргийн газар.

birahaneci *is.* пивоний газрын эзэн.

biraz *zf.* 1. бага, багахан хугацаа, хэдхэн минут. 2. бага зэрэг, бага сага, жаалхан. "*Bu konuyu biraz biliyor.*" Энэ сэдвийг бага зэрэг мэднэ. 3. *s.* бага хэмжээний, бага, бага зэрэг, жаахан, жаал зугаа, цөөхөн, цөөн тооны. "*Biraz yağmur yağdı mı, burada sel oluveriyor.*" Бага зэрэг бороо оров уу үгүй юу, энд үер болчих юм.

birazcık *s.* жаахан, маш бага, багахан.

birazdan *zf.* удахгүй, медхен, одоохон. "*Ben birazdan gelirim.*" Би удахгүй ирнэ.

birbiri *zm.* 1. нэг нэгэндээ, нэг нэгнийхээ, бие биендээ, бие биендээ, хэн хэнийгээ, аль **а**линыгаа. 2. хойно хойноосоо, уван цуван, **а**р араасаа. **~ne bakmak** харалцах, бие биөө харалцах. **~ne düşmek** нэг нэгнийгээ үзэн ядах. **~ne girmek** 1) нэг нэгэнтэйгээ зодолдох, өөр хоорондоо зодолдоцгоох. 2) холилдох, хутгалдах, зууралдах, хольцолдох. 3) орооцолдох, ширэлдэх, даахирах, орооцолдон барилдах. **~ne katmak** муудалцуулах, эвдрэлцүүлэх, үймүүлэх, хооронд нь яс хаях.

birci *is. fel.* монист үзэлтэн, монизмийг баримтлагч.

bircilik, -ği *is. fel.* монизм (ертөнцийн үндэс нь нэг гэсэн, идеалист ёсоор ойлгоход санаа, материалист ёсоор ойлгоход материи гэж үздэг, гүн ухааны үзэл).

birçoğu *zm.* ихэнх нь, дийлэнх нь, нэлээд.

birçok, -ğu *s.* их, олон, нэлээд олон, тоо томшгүй.

bir defa *zf.* нэг удаа.

bir defalık, -ğı *is. ve s.* 1. нэг удаагийн, ганц. 2. зөвхөн ганц удаа, зөвхөн нэг удаа.

birden *zf.* 1. гэнэт, гэнэтхэн. 2. нэг удаа, нэг мөсөн, нэг дор, шууд, нэг зэрэг, бүгдийг нь нэг дор.

birdenbire *zf.* гэнэт, гэнэтхэн.

birebir *s.* үйлдэлтэй, хүчтэй, нөлөөтэй, үртэй, ашигтай, тустай. "*Bu ilaç size birebir gelir.*" Энэ эм танд сайн нөлөө үзүүлнэ. **~ gelmek** нөлөөтэй байх, нөлөөлөх, тустай байх, ач тустай байх.

birer *s.* нэг нэг, нэгэн.

birer ikişer *zf.* ганц нэгээрээ, хоёр гурв аараа.

bireşim *is.* 1. нэгтгэх, нийлүүлэх 2. нийлэг. 3. *kim.* нийлэг, синтез.

bireşimli *s.* нийлэг, синтезлэж гаргасан.

birey *is.* 1. бодгаль (салангид хүн, ургамал, амьтан тус бүрдээ). 2. *psikol.* бие хүн. 3. *sos.* хувь хүн. **~ oluş** *is. biy.* онтогенез, хувийн хөгжил.

bireyci *s.* 1. бодгальч үзэлтэн, хувиа бодогч, индивидуалист. 2. хүний эрх ашгийг емгөөлөгч, хүний эрх ашгийг эрхэмлэгч.

bireycilik, -ği *is. sos.* бодгальч үзэл, хувьчлах үзэл.

bireyleştirme *is.* бодгальчлал, хүн тус бүрийн онцлогийг харгалзах.

bireyleştirmek *(-i) fel.* бодгальчлах, хүн тус бүрийн онцлогийг харгалзан үзэх, хүн тус бүрийг ялган онцгойлох.

bireylik, -ği *is. sos.* 1. хувийн онцлог, өөрийн онцлог. 2. салангид хүн, бодгаль.

bireysel *s.* бодгалийн, тухайн хүний.

bireysellik, -ği *is. fel.* 1. бодгаль болох байдал, хувь хүн болох чадвар. 2. бодгаль хүний онцлог, хувь хүний онцлог ялгаа, тухайн хүний онцлог шинж.

bir gözeli *s. biy.* нэг эст.

bir hayli *zf.* нэлээд, нэлээд их, овоо их, их хэмжээний.

bir hücreli *is. ve s.* нэг эст.

biri *zm.* 1. ...аас нэг нь. 2. хэн нэгэн, нэг хүн.

biricik, -ği *s.* гав ганц, цорын ганц, ганцхан.

bir iki *s.* хэдэн, хэсэг, ганц хоёр.

birikim *is.* 1. хуримтлал, цуглуулалт, нөөцлөлт, бөөгнөрөл. 2. олон жилийн хуримтлал, туршлага. 3. *ekon.* мөнгө хураах, мөнгө хуримтлуулах, өсгөх, нэмэх.

birikinti *is.* овоолсон юм, бөөн юм, овооролдоон, багшралдаан, бөөгнөрөл.

birikme *is.* хуримтлал, цугларалт, бөөгнөрөл, хуралдалт, овоорол.

birikmek *(nsz)* хуримтлагдах, цугларах, бөөгнөрөх, овоорох, хуралдах, бөөмнөрөх, өсөх, нэмэгдэх.

biriktirme *is.* biriktirmek үйлийн нэр, хуримтлал, хэмнэлт.

biriktirmek *(-i, -e)* 1. хураах, бөөгнөрүүлэх, овоолох. 2. хэмнэх, гамнах, арвилах, хуримтлах. 3. цуглуулах, түүх, хураах.

birim *is.* 1. нэгж, нэгж хэсэг. 2. хэмжих нэгж. 3. анги, бүлэг, хэсэг, салбар.

birinci *s.* 1. нэгдүгээр, нэг дэх, нэг дэх тоо. 2. анхдугаар, тэргүүн. 3. анх, эх, эхний, анхны, түрүүчийн, нэг дэх. 4. *is.* тэргүүн, манлайлагч, шилдэг, нэгдүгээр байрны шагналтан, аварга, ялагч (хүн). 5. нэгдүгээр зэрэглэлийн, нэгдүгээр ангиллалын, дээд чанарын. **~ gelmek** түрүүлэх, нэгдүгээр байрыг эзлэх. **~ olmak** тэргүүн болох, нэгдүгээр байранд орох.

birincil *s.* анхны, түрүүчийн, эхний, гол, үндсэн, суурь.

birincilik, -ği *is.* 1. тэргүүн, нэгдүгээр байрны шагналтан, тэргүүлэгч, аварга. 2. тэргүүн байрны төлөө уралдаан тэмцээн, аварга шалгаруупах тэмцээн. "*Güreş birincilikleri başladı.*" Бөхийн аварга шалгаруулах тэмцээн эхэллээ.

birisi *zm.* хэн нэгэн, нэгэн хүн.

birkaç *s.* хэдэн, цөөн, цөөн тооны, бага.

bir kere *s.* 1. үнэндээ, үнэн хэрэгтээ. 2. нэг удаа, ганц удаа.

bir kerecik *zf.* нэгхэн удаа, ганцхан удаа.

birleşen *s. mat.* огтлолцсон, хөндлөн огтлолцсон (шулуун).

birleşik, -ği *s.* нэгдсэн, нийлсэн, хамтарсан, нэгдмэл, нийлмэл, хамтын.

birleşik cümle *is. gr.* нийлмэл өгүүлбэр.

birleşik fiil *is. gr.* нийлмэл үйл үг. "*Hissetmek*" Мэдрэх, "*Hasta olmak*" Өвчлөх.

birleşim нийлэх, хамтрах, цуглах, нэгдэх.

birleşim *is.* 1. birleşmek үйлийн нэр. 2. их хурлын тухайн едрийн хуралдаан. 3. *biy.* хээлтүүлэг, нийлүүлэг, ороо.

birleşme *is.* birleşmek үйлийн нэр.

birleşme değeri *is. kim.* валент, валент чанар, атомын бусад атомтай нэгдэх чадвар.

birleşmek *(nsz, -le)* 1. нэгдэх, нийлэх, хамтрах. 2. уулзах, учрах. 3. санал нийлэх, хэлцэн тохирох, тохиролцох. 4. цугларах, нэгдэх. 5. дотносох. 6. хурьцал үйлдэх, хурьцах.

birleştirme *is.* birleştirmek үйлийн нэр.

birleştirmek *(-i, -le)* нэгтгэх, нэгдүүлэх, нийлүүлэх, холбох, хамтатгах.

birlik, -ği *is.* 1. ганц байдал, цорын ганц байх. 2. нэгдэл. "*Türk milletinin birliği.*" Турк үнэдстний нэгдэл. 3. эвсэл, холбоо. "*Öğrenciler birliği.*" Ою утны холбоо. 4. (цэргийн) нэгдсэн анги. 5. *müz.* бүхэл нот, дөревтийн нот. 6. *fel.* нэгдэл, нягтрал, салшгүй хэсэг.

birlikte *zf.* 1. хамтдаа, цугтаа, бүгдээр. 2. хажуудаа, цуг.

birliktelik, -ği *is.* хамт байх, хамтран амьдрах.

bir sürü *s.* нэлээн олон, овоо их.

birtakım *s.* хэдэн, хэд хэдэн, нэлээд хэдэн.

bir tane *s.* гав ганц, цорын ганц, ганцхан.

bir tanem *is.* хорвоод ганц (хайр энхрийллийн үг).

bir temiz *zf.* нэлээд сайн, овоо, бузгай.

bir vakitler *zf.* нэг үе, тэр үед, дээр үед, тэр цагт.

bir yana *zf.* өөр, бусад нь, гадна. "*Bizi, ölüm bir yana, kimse ayıramaz.*" Биднийг үхлээс бусад нь хагацааж чадахгүй.

bir yol *zf.* нэг удаа, ганц удаа.

bir zaman *is.* 1. нэг үе, дээр үед, тэр цагт, тэр үед. 2. нэг үе, нэг хэсэг, жаахан, тодорхой хугацаагаар.

bir zamanlar *zf.* нэгэн үе, тэр нэгэн цагт, тэр үед.

bisiklet *is.* дугуй, унадаг дугуй.

bisikletçi *is.* ve *s.* дугуйчин.

bisikletli *s.* дугуйтай.

bisiklet yolu *is.* дугуйн зам.

bisküvi *is.* бисквит, жигнэмэг.

bismillâh *ünl.* "Бурханы нэрээр" (ямар нэгэн ажил үйлийг хийж эхлэхдээ хэлнэ, мөн гайхсан, айсан үед хэлнэ.)

bit *is. zool.* бөөс.

bîtap *s.* ядарсан, сульдсан, тэнхээгүй. ~ **düşmek** маш их ядрах, сульдах, сөхөрч унатлаа ядрах.

bîtaraf *s.* төвийг сахисан, төвийг сахигч.

bîtaraflık, -ğı *is.* төвийг сахих.

bitek *s.* үржил шимтэй, ургац сайтай.

bitelge *is.* ургац сайтай байх, үржил шим, өн.

bitey *is. bot.* ургамлын аймаг.

bitik *s.* 1. сул, дорой, тэнхэлгүй, тамиргүй. 2. муу, муугаар, аягүй, эвгүй.

bitim *is.* 1. bitmek үйлийн нэр. 2. төгсгөл, эцэс, сүүл.

bitirim *s. argo.* 1. ухаалаг, сүрлэг, жавхаатай. 2. *is. argo.* мөрийтэй тоглоомын газар.

bitirimhane *is.* мөрийтэй тоглоомын газар.

bitirme *is.* bitirmek үйлийн нэр.

bitirmek *(-i)* 1. төгсгөх, дуусгах, тегсгөл болгох, дуусгавар болгох, дүүргэх, шувтлах, шавхах, шавхан дуусгах, барах. 2. ядраах, зүдрээх, сульдаах, доройтуулах, хүч барах. 3. үгүй хийх, гүйцээх, сүйрүүлэх.

bitiş *is.* bitmek үйлийн нэр, тегсгел, дуусгав ар болох.

bitişik, -ği *s.* **1**. зэргэлдээ, залгаа нийлсэн. 2. *is.* херш, айл, саахалт. 3. *s.* хажуу, хажуугийн.

bitişken *s. gr.* залгамал (хэл). ~ **dil** *is. gr.* залгамал хэл.

bitişme *is.* bitişmek үйлийн нэр.

bitişmek *(nsz)* нийлэх, залгах, хүрэх, хавирах.

bitki *is. bot.* ургамал. ~ **örtüsü** ургамлын аймаг.

bitki bilimci *is.* ботаникч, ургамалч, ургамал судлагч.

bitki bilimi *is. bot.* ботаник, ургамал судлал.

bitkin *s.* эцэж ядарсан, сульдсан, тэнхэлгүй, тамир тэнхээгүй, эцэж туйлдсан.

bitkinlik, -ği *is.* эцэж ядрах, сульдах, эцэж туйлдах, хүч тамир барагдах.

bitki patalojisi *is.* ургамлын өвчин судлал.

bitkisel *s.* ургамлын, ургамлын гаралтай, ургамлаас гаргаж авсан. "*Bitkisel yağı.*" Ургамлын гаралтай тос, ургамлын тос.

bitkisel hayat *is. tıp.* ком, оврого.

bitleme *is.* bitlemek үйлийн нэр.

bitlemek *is.* беес түүх, бөөснөөс салгах.

bitlenme *is.* bitlenmek үйлийн нэр.

bitlenmek *(nsz)* бөөстөх.

bitli *s.* 1. беестэй. 2. *mec.* харамч, хорголоо тоолсон, нарийн.

bitme *is.* bitmek үйлийн нэр.

bitmek, -er (l) *(nsz)* **1**. тегсөх, дуусах, төгсгөл болох. 2. дуусах. "*Dün aksam param bitmişti.*" Өчигдөр орой миний менгө дуусчихсан. 3. тэнхэл барагдах, хүч тэнхэлгүй болох, тамирдах, сульдах, эцэж ядрах. 4. *argo.* ухаангүй дурлах, их шохоорхох, шагширах, аманд нь орчих шахах. **bitmez tükenmez** эцэс тегсгөлгүй.

bitmek, -er (ll) *(nsz)* 1. ургах, өсөх, боловсрох, гарах (үс, ургамал). 2. *argo.* гэнэт гарч ирэх.

bitpazarı *is.* хуучин юм борлуулах зах.

bitüm *is. jeol.* 1. цардас, лав, барагшин, газрын давирхай. 2. асфальт, хар давирхай (зам засахад хэрэглэнэ).

bitümleme *is.* bitümlemek үйлийн нэр.

bitümlemek *(-i)* асфальтлах, давирхайдах, асфальт нялах.

biyel *is.* зүтгүүр, хөллүүр, чирүүл, тагуур.

biyoelektrik, -ği *is.* био цахилгаан, амьтны гаралтай цахилгаан.

biyoelektronik, -ği *is.* биоэлектроник.

biyoenerji *is.* биоэнерги, биологийн үйл ажиллагааны эрчим хүч.

biyofizik, -ği *is.* биофизик, биологийн физик.

biyograf *is.* намтарч, намтар зохиогч.

biyografi *is.* намтар, биеийн түүх, цадиг.

biyografik *s.* намтрын, биеийн түүхийн.

biyojeografi *is.* биогеографи.

biyokatalizör *is.* фермент, биокатализатор.

biyokimya *is.* биохими (амьд бодисын бүрэлдэхүүний хувиллын судлал).

biyolog *is.* биологич,амь судлагч.

biyoloji *is.* биологи, амь судлал.

biyolojik *s.* биологийн, амь судлалын.

biyopsi *is. tıp.* биопси. **~ yapmak** биопси авах, биопсийн шинжилгээ хийх.

biyosfer *is.* биосфер.

biz (I) *zm.* 1. бид (нэгдүгээр биеийн төлөөний үгийн олон тоо). 2. зарим тохиолдолд нэгдүгээр биеийн төлөөний үгийн ганц тооны (би) оронд хэрэглэгдэнэ.

biz (II) *is.* 1. шөвөг. 2. зүү, тэвнэ. **~ bize** зөвхөн бид, өөр хоорондоо.

bizce *zf.* бидний үзэл бодлоор.

bizimki *zm.* 1. манай, бидний, манайх, өөрсдийнх. 2. манайхан, өөрийнхөн, өөрсдийнхөн.

bizmut *is. kim.* висмут.

bizon *is. zool.* америкийн сарлаг, бизон.

bizzat *zf.* өөрөө, биеэрээ, нүүрээрээ.

blok *is.* 1. эвсэл, бүлэг, бүлэглэл, нэгдэл. 2. гулдмай, блок. 3. бие биетэйгээ залгаа том байшингууд. блокон байшингууд. 4. *sp.* (воле йбол) хаалт.

blokaj *is.* 1. bloke etmek үйлийн нэр. 2. саад, тотгор, хаалт 3. (барилгын) суурь суулгах, суурь тавих.

bloke *s.* хориг, хориглогдсон, хураагдсан. **~ etmek** 1) хураах, хураан авах, хорио тавих. 2) дайны байдалд байгаа нэг улсын бусад улстай харьцааг нь хориглох, хүрээлэн хяхах, хориг тавих. 3) хаах, саад болох, саатуулах. 4) *sp.* (хөл бөмбөг) бөмбөг хаах.

bloknot *is.* еврийн дэвтэр, тэмдэглэ лийн дэвтэр.

blöf *is.* хоосон гайхуулалт. **~ yapmak** хоосон гайхуулах, үгээр хуурах, мэхлэх.

blûz *is.* гадуур цамц.

boa *is. zool.* 1. аварга могой, хоргүй болов ч өөрийн биеэрээ олзоо ороож алдаг могой. 2. ангийн үсэн зах.

bobin *is.* 1. утасны гол, ээрүүл. 2. бул, гол. 3. *fiz.* ороомог утас.

boca *is. den.* (хөлөг онгоцны) нөмөр тал, салхины доод тал.

bocalama *is.* bocalamak үйлийн нэр.

bocalamak *(nsz)* 1. (хөлөг онгоц) салхи уруудан хөвөх, салхи сөрж чадахгүй байх. 2. тээнэгэлзэх, эргэлзэх, гайхах, яахаа мэдэхгүй байх, юу хийхээ мэдэхгүй байх, учраа олохгүй байх.

boci *is.* гурван дугуйтай цойцон тэрэг.

bocuk, -ğu *is.* 1. христосын мэндэлсэн өдөр. 2. гахай.

bodrum *is.* хонгил.

bodrum katı *is.* доод хонгил, хамгийн доод давхар.

boduç, -cu *is.* жижиг модон домбо, жижиг шавран домбо.

bodur *s.* навтгар, намхан, охор биетэй, тагдгар, тагжгар.

boğa (I) *is.* бух, шар.

Boğa (II) *is.* Үхрийн орд.

boğa güreşi *is.* бухын тулалдаан.

boğak, -ğı *is. hlk.* бах, хоолой хавдах.

boğanak, -ğı *is. hlk.* ширүүн бороо, аадар бороо

boğası *is. hlk.* дотор даавуу, нимгэн даавуу.

boğaz *is.* 1. хоолой. "*Boğazı ağrımak.*" Хоолой өвдөх. 2. хоолой, амсар, хүзүү, цорго. 3. хавцал. "*Dağ boğazı.*" Уулын хавцал. 4. (тэнгисийн) хоолой. 5. *mec.* ам бүл, идэх хүн. "*Bizim evde beş boğaz var.*" Манай гэр бүл таван ам бүлтэй. 6. идэх уух, хоол, хүнс. 7. хооллох ундлах, хоол хүнсээр хангах. **~ açmak** модны үндэс хөвсийлгех, сэвсийлгэх, зөөлрүүлэх. **~ı düğümlenmek** хоолой зангирах. **~ı kurumak** хоолой хатах, цагнах. **boğazına düşkün** ховдог, идэмхий. **~ına indirmek** хамаа намаагүй идэх. **~ına kadar** хүзүүгээр, хоолойгоор (давсан). **~ından geçmemek** хоолойгоор орохгүй байх, хоолойгоор давахгүй байх. **~ını doyurmak** цадах, гэдсээ цатгах. **~ını yırtmak** байдаг чадлаараа хашгирах, хоолойгоо сөөтөл бархирах.

boğaz ağrısı *is.* хоолой өвдөх.

boğazlama *is.* boğazlamak үйлийн нэр.

boğazlamak *(-i)* **1.** (хүн, амьтан) хоолойг нь огтолж алах, хоолойг нь зүсэх. 2. толгойг нь тас чавчих, зэрлэгээр алах, хоолой хэрчих.

boğazlanma *is.* boğazlanmak үйлийн нэр.

boğazlanmak *(nsz)* boğazlamak үйлийн үйлдэгдэх хэв.

boğazlaşma *is.* boğazlaşmak үйлийн нэр.

boğazlaşmak *(nsz, -le)* бие биеэ боох, багалзуурдах, алалцах, үзэлцэх.

boğazlı *s.* 1. хоолойтой, амсартай, цорготой. 2. ховдог, идэмхий.

boğma *is.* 1. boğmak үйлийн нэр. 2. жимсний нэрмэл архи.

boğmaca *is. tıp.* багтраа, амьсгаа давчдах, амьсгаа боох.

boğmaca öksürüğü *is. tıp.* бүгшүүлдэг ханиад, хоолой татдаг ханиад, зуу хоногийн ханиад, хөхүүлэг.

boğmak, -ar *is.* 1. багалзуурдаж алах, боох, боож алах, боомилж алах. 2. боох, чанга боох, уях. 3. *mec.* хүрээлэх, нэлд нь бүрхэх, бүрэх.

4. *mec.* дарах, бүдэгрүүлэх, дууг дарах. 5. хаах, нуух, дарах. 6. хаах, боох, саад болох, саад тотгор учруулах, хяхах, хяхаж хавчих. 7. *mec.* бухимдуулах, залхаах, тэвчээр алдуулах.

boğucu *s.* 1. амьсгал давчдуулсан, амьсгаадуулсан. 2. амьсгал хордуулсан, амьсгаа боосон, бүгчимдүүлсэн. 3. бүгчим, бүгчим халуун.

boğuk *is.* сөөнгө, бөглүү, шахсан, бүдэг, хяхнасан (хоолой, чимээ).

boğulma *is.* boğulmak үйлийн нэр.

boğulmak *(nsz)* 1. boğmak үйлийн үйлдэгдэх хэв. 2. живж үхэх, бүгтэрч үхэх, багтарч үхэх. 3. амьсгал давчдах, бүгтрэх, багтрах. 4. *mec.* бухимдах, давчдах.

boğum *is.* 1. *anat.* зангилаа. "*Sinir boğumları.*" Нервийн зангилаа. 2. (хуруууны, зэгс, дэрсний) үе, ишний үе.

boğumlanma *is.* **1.** boğumlanmak үйлийн нэр. 2. дуудлага, дуудахуй, авиаг өгүүлэх.

boğumlanmak *(nsz)* 1. зангирах, зангилаа үүсэх, овгор товгор болох. 2. өгүүлэх эрхтэн ажиллах.

boğuntu *is.* 1. багтраа, бүгчимдэх амьсгал давчдах, амьсгаа давхарлах. 2. бухимдал, давчдах. 3. *argo.* дамлах, панзлах. **~ya getirmek** *argo.* хуурах, мэхлэх, гол гаргах, голруулах (эд зүйлс, мөнгө).

boğuşma *is.* boğuşmak үйлийн нэр.

boğuşmak *(nsz, -le)* 1. биө биөнээ багалзуурдах, барьцалдах, нэг нэгнийгээ заамдах, барилцан авах. 2. түлхэлцэх, биө бие э түлхэх.

bohça *is.* 1. боох даавуу, баглах даавуу, баадан. 2. (жижигхэн) тамхины уут.

bohçalama *is.* bohçalamak үйлийн нэр.

bohçalamak *(-i)* боох, баадагнах, даавуунд ороох.

bohem *is.* və *s.* амиа аргацаагч, бэртэгчин (сэхээтэн, урлагийн хүн).

bok *is. kaba.* **1.** өтгөн, баас, ялгадас. 2. *s. kaba.* хог, шаар, адгийн амьтан. 3. *kaba.* өөдгүй, ягир, муу байдал. "*İş boka sarmak.*" Ажил олхиогүй байх/ажил муу байх. **~ atmak** гүжирдэх, гүтгэх, нэрийг нь муутгах. **~ etmek** (ажил) нураах, гутаах. **~tan** ямар ч хэрэггүй, хогийн.

boklu *s. kaba.* баастай, баасандаа хутгалдсан, заваан, бохир.

boks *is. sp.* бокс **~eldiveni** боксын бээлий, **~yapmak** боксдох.

boksör *is.* боксчин, нударгалагч.

bol *s.* 1. элбэг, элбэг дэлбэг, арвин, элбэг баян. 2. өргөн, том, чөлөөтэй, элбэг, уудам, уужим, халхгар. **~ bol** *zf.* элбэг, элбэг дэлбэг, арвин.

bolero *is.* 1. (эмэгтэй) хантааз. 2. *müz.* болеро.

boliçe *is. hlk.* өвөй эмэгтэй.

bollanma *is.* bollanmak үйлийн нэр.

bollanmak *(nsz)* өргөн болох, өргөсөх, өргөжих, тэлэх.

bollaşma *is.* bollaşmak үйлийн нэр.

bollaşmak *(-i)* элбэгших, томдох, өргөсөх, өргөн болох, элбэг болох, халхайх.

bolluk, -ğu *is.* 1. өргөн байх, өргөн уудам байх, уудам байх, дэлгэр байх. 2. элбэг байх, элбэг дэлбэг байдал, арвин байдал. 3. *s.* элбэг дэлбэг, элбэг баян (газар). 4. *is.* илүүдэл, ихдэлт, илүү гарах.

bomba *is.* бөмбөг (зэвсэг). "*El bombası.*" Гар бөмбөг. "*Atom bombası.*" Атомын бөмбөг.

bombalama *is.* bombalamak үйлийн нэр.

bombalamak *(-i)* бөмбөгдөх, бөмбөг хаях.

bombalanma *is.* bombalanmak үйлийн нэр.

bombalanmak *(nsz)* бөмбөгдүүлэх.

bombardıman *is.* 1. бөмбөгдөлт. 2. их бууны галаар шүрших. **~ etmek** 1) бөмбөгдөх, бөмбөг хаях, буудах. 2) *mec.* хараах, загнах, зандчих.

bombardıman uçağı *is. ask.* бөмбөгдөгч онгоц.

bombardon *is.* их бүрээ.

bomboş *s.* хов хоосон.

bonbon *is.* чихэртэй жимс.

boncuk, -ğu *is.* шүр.

bonfile *is.* гол мах.

bonkör *s.* 1. сайхан сэтгэлтэй. 2. өглөгч.

bono *is.* өрийн бичиг, зээлийн баримт.

bor (I) *is. hlk.* атар газар.

bor (II) *is. kim.* бор.

bora *is.* (бороо ны өмнөх) хүчтэй салхи. **~ gibi** ширүүн, догшин ууртай.

boraks *is. kim.* тунсаа.

boran *is. coğr.* салхи, шуургатай, дуу цахилгаантай бороо.

borazan *is.* 1. бүрээ. 2. бүрээч, бүрээчин.

borç, -cu (I) *is.* 1. өр, өр шир, өгцөө, зээл. 2. *mec.* өр, үүрэг, алба, ая хариулах. **~ almak** өр хийх, зээл авах. **~ bini aşmak** өрөнд баригдах. **~ vermek** зээл өгөх, зээлүүлэх. **~ bilmek** үүрэг гэж үзэх, үүргээ мэдэх. **~tan kurtulmak** өрнөөс салах, өргүй болох, өр төлөх. **borca batmak** өрөнд баригдах, өрөнд дарагдах. **borca girmek** өрөнд орох, өртэй болох, өр тавих. **borcunu ödemek** өрөө төлөх, өрөө дарах. **~ harç** *zf.* өр шир тавин, өрөнд орж.

borçlanma *is.* borşlanmak үйлийн нэр

borçlanmak *(-e)* **1.** өр тавих, өртэй болох, өрөнд орох, зээл авах. 2. *mec.* үүрэг хүлээх, өртэй болох, ачийг санах.

borçlu *s.* 1. өртөй, өр тавьсан, зээлтэй. 2. *mec.* үүрэгтэй, ёстой, өртэй. 3. ачаар хийсэн, ачаар олсон, ачийг санах ёстой.

borçsuz *s.* өргүй, зээлгүй, өр ширгүй. **~ harçsız** *zf.* өр ширгүй, өр тавилгүй.

borda *is. dən.* (усан онгоц, завины) хажуу, хажуу тал.

bordo *is.* 1. хүрэн улаан өнгө. 2. *s.* хүрэн улаан, хүрэн улаан өнгөтэй.

bordro *is.* төлбөр, тооцооны баримт, тооцооны хүснэгт. "*Maaş bordrosu.*" Цалингийн тооцооны хүснэгт.

bornoz *is.* уснаас гараад өмсдөг хувцас, хэвнэг (нөмрөг, халаад), усны халаад.

borsa *is.* мөнгөн санхүү ба худалдааны хэлэлцээ хийх газар, бирж, хөрөнгийн бирж. "*Kara borsası.*" Гадаадын мөнгөний нууц худалдаа.

borsa cetveli *is.* биржийн мэдээ.

boru *is.* 1. цорго, гоожуур, хоолой, яндан. **~ hattı** (шингэн юм, хий) дамжуулах хоолой. 2. бүрээ. **~ çalmak** бүрээ үлээх.

borumsu *s.* цорго шиг, хоолой хэлбэртэй.

bostan *is.* 1. ногооны талбай, ногооны цэцэрлэг. "*Bostan korkuluğu.*" Ногооны талбайн мануухай. 2. тарвас, амтат гуан тариалан.

bostancı *is.* 1. ногоочин. 2. *tar.* Оттоманы хаант гүрний үед ордны хамгаалагч ба хотын дэг журмыг сахиулагч цэрэг.

bostanlık, -ğı *is.* ногоо, тарвас, амтат гуа тарихад үржил шимтэй газар.

boş *s.* 1. хоосон, ханхай, хөндий. 2. ажилгүй, ажил эрхлээгүй. 3. мэдлэг муутай, хөндий цээж, хоосон толгой. 4. сул, хоосон. "*Boş kadrosu.*" Сул орон тоо. 5. сул, чөлөөтэй, завтай. "*Yarın sabah boşum, gelebilirsin.*" Маргааш өглөө завтай, чи ирж болно оо. 6. дэмий, хоосон, үр дүнгүй, үр ашиггүй, нэмэргүй. 7. утгагүй, учиргүй, шал дэмий, хоосон. "*Boş gözler.*" Гөлийсөн харц. 8. хоосон, дэмий балай, хөнгөн хуумгай. "*Boş laf.*" Хоосон үг, дэмий хоосон яриа. **~ gezmek** дэмий сэлгүүцэх. **~ bırakmak** хоосон орхих, хоосон үлдээх. **~ dönmek** хоосон буцаж ирэх. **~ durmak** ажилгүй байх. **~ durmamak** 1) нэг ч зүгээр суухгүй байх, гар хумхин суухгүй байх. 2) хариу үйлдэл хийх, хийсэн үйлийнх нь төлөө зүгээргүй байх, хариулах. **~ gözlerle bakmak** гөлийсөн харцаар харах, гөлийх. **~ kafalı** усан тархитай, хоосон толгой, мангуу. **~ olmak** гэр бүл салах. **~ vermek** үл ойшоох, тоохгүй байх. **~ yere** дэмий, хоосон, үргүй. **~a çıkmak** талаар болох, талаар өнгөрөх. **~a gitmek** дэмий үрэгдэх (цаг, мөнгө). **~una** дэмий, шал дэмий, хий дэмий, хоосон. **~u boşuna** хий дэмий, хоосон, талаар.

boşalma *is.* **1.** boşalmak үйлийн нэр. 2. *mec.* тайвшрах, уужрах, сэтгэл онгойх.

boşalmak *(nsz)* 1. сулрах, хооcрох, хүнгүй болох, хөндийрөх, ханхайрах. 2. асгарах, гоожих, урсаж гарах, юүлэгдэх. 3. *mec.* тайв шрах, уужрах, сэтгэл онгойх. 4. (амьтан) суллагдах, тавигдах. 5. (уяа) тайлагдах, алдуурах, задрах.

boşaltma *is.* boşaltmak үйлийн нэр.

boşaltmak *(-i)* 1. суллах, хоослох. 2. асгах, ю үлэх. 3. буугаар шүрших. 4. сэтгэлээ онгойлгох, сэтгэлээ уудлах. 5. бөөлжих. 6. суллах, тайлах, задлах.

boşama *is.* boşamak үйлийн нэр.

boşamak *(-i)* гэр бүл салах, гэрлэлт цуцлах.

boşanma *is.* 1. boşanmak үйлийн нэр. 2. гэр бүл салалт, гэр бүл цуцлалт.

boşanmak *(nsz, -den)* 1. гэр бүл салах, гэр бүл цуцлуулах. 2. (амьтан) суллагдах, тавигдах, уяанаас алдуурах. 3. асгарах, цутгах. "*Bardaktan boşanırcasına yağmur yağıyor.*" Хувингаар цутгасан юм шиг бороо орж байна. 4. хүн амьтангүй болох, хооcрох, хөндийрөх, ханхайрах. 5. эгшин уйлах, цурхиран уйлах. 6. мултрах, ангижрах. 7. сэтгэлээ уудлах, сэтгэлээ онгойтол ярих, сэтгэл уужрах.

boşboğaz *s.* 1. чалчаа, бураа, задгай амтай. 2. чалчаа, хагархай хэнгэрэг.

boşboğazlık, -ğı *is.* дэмий яриа, чалчаа үг. **~ etmek** дэмий чалчих, дэмий ярих, бурах.

boşlama *is.* эс тоомсорлол, хайнга хандах, хайхрамжгүй байдал.

boşlamak *(-i)* 1. орхих, үлдээх. 2. тоомсорлохгүй байх, хайнга хандах, эс тоомсорлох, хайхрахгүй байх.

boşluk, -ğu *is.* **1**. нүх, гүн нүх, хоосон нүх, хөндий, хонхорхой. 2. *fiz.* вакуум, сийрэг хийтэй, хөндий, хоосон орон зай. 3. зай, завсар. 4. хооcрол, эзэнгүйдэл, ганцаардал. 5. *mec.* хомсдол, дутагдал.

boşuna *zf.* дэмий, хоосон, үргүй.

boş zaman *is.* чөлөөт цаг.

bot (I) *is.* 1. жижиг усан онгоц, завь. 2. сэлүүрт завь.

bot (II) *is.* урт түрийтэй гутал, оохой.

botanik, -ği *is.* ботаник, ургамлын судлал. "*Botanik bahçesi.*" Ботаникийн цэцэрлэг. "*Botanik parkı.*" Цэцэрлэгт хүрээлэн.

botanikçi *is.* ботаникч, ургамалч, ургамал судлагч.

boy *is.* 1. чац, биө, нуруу. 2. урт. 3. өндөр. 4. (даавуу) хэмжээ, хэмжигдэхүүн. 5. (гол, далайн) эрэг, хажуу, зах. 6. цаг, хугацаа. 7. зай, хоорондын зай. 8. туульс, домог. **~ almak** өндөр болох, өсөх. **~ atmak** өндөр болох, өсөх, хөгжих. **~ göstermek** 1) үзэгдэх, харагдах. 2) бусдад гайхуулах, бусдад харуулах. **~ ölçüşmek** уралдах, өрсөлдөх, эн зэрэгцэх.

boy (II) *is. sos.* ураг, овог, отог.

boya *is.* 1. будаг, будагч бодис. "*Sulu boya.*" Усан будаг. 2. өнгө. 3. *hlk.* бэх. 4. *mec.* нүд хуурах, үзэмж. **~ kullanmak** будах, нүүрээ будах. **~ tutmak** будагдах, будаг орох, өнгө авах. **~ vurmak (**vəya **çekmek, sürmek)** будах.

boyacı *is.* 1. будаг зардаг хүн. 2. будагчин. 3. будгийн дэлгүүр.

boya fırçası *is.* будгийн багс.

boyahane *is.* будах газар.

boya kalemi *is.* өнгийн харандаа, будгийн харандаа.

boyalı *s.* 1. будагтай, будагдсан 2. өнгөтэй.

3. нүүрээ их будсан (эмэгтэй).

boyama *is.* 1. boyamak үйлийн нэр. 2. өнгөтэй алчуур. 3. *s.* будагтай, будагдсан, будаг түрхсэн.

boyamak *(-i, -e)* 1. будах, будаг түрхэх, будаг нялах. 2. *mec.* доромжлох, гутаах, муу муугаар хэлэх.

boyanma *is.* boyanmak үйлийн нэр.

boyanmak *(nsz, -e)* 1. будах, будаг түрхэх. 2. нүүрээ будах. 3. будаг болох, будаг нялах.

boyar (I) *is. Rus. tar.* боярин, их ноён.

boyar (II) *s.* будагч.

boyar madde *is. kim.* 1. будагч бодис. 2. *bot.* пигмент, нөсөө.

boyasız *s.* 1. будаггүй, будагдаагүй. 2. өнгөгүй. 3. нүүрээ будаагүй (эмэгтэй).

boyatma *is.* boyatmak үйлийн нэр.

boyatmak *(-e)* будуулах, будаг түрхүүлэх.

boyayıcı *s.* будагч.

boy aynası *is.* том толь.

boy boy *is.* ve *s.* төрөл төрлөөрөө, янз янзаараа.

boyca *is.* өндрөөрөө, уртаараа.

boydan boya *s. ve zf.* нэг үзүүрээс нөгөө үзүүр хүртэл, нэг захаас нөгөө зах хүртэл, уртаашаа, нэлэнхүйдээ.

boydaş *s.* 1. адил өндөртэй, адил чацтай, чацуу. 2. *is.* үеийн хүн, чацуу хүн, үетэн, чацуутан, үе тэнгийн.

boykot *is.* бойкот, тэвчих эсэргүүцэл. **~ etmek** бойкот зарлах, эсэргүүцэх, үл ойшоох.

boykotçu *is.* бойкот зарлагч, эсэргүүцэгч, үл ойшоогч.

boylam *is. astr.* уртраг.

boylama *is.* boylamak үйлийн нэр.

boylamak *(-i)* 1. (хүсэлгүйгээр) гэтлэх, туулах, гатлах. 2. живэх. 3. унах, ойчих. 4. туульс хайлах.

boylanma *is.* boylanmak үйлийн нэр.

boylanmak *(nsz)* уртсах, урт болох, сунах.

boylu *s.* 1. чацтай, нуруутай. "*Kısa boylu.*" Намхан нуруутай. 2. өндөр. "*Boylu adam.*" Өндөр хүн. **~ boslu** *s.* гуалиг биетэй, бие тэгш, бие бялдар сайтай.

boylu boyunca *zf.* уртаашаа.

boylu poslu *is. bk.* boylu boslu.

boynuz *is.* 1. эвэр. 2. *s.* эвэр, эврээр хийсэн. **~ dikmek** эр нөхрөө хуурах, араа нь тавих. **~ eğmek** хүлээн зөвшөөрөх, толгой гудайлгах. **~ takmak** эр нөхөртөө хууртагдах, араараа тавиулах.

boynuzlama *is.* boynuzlamak үйлийн нэр.

boynuzlamak *(-i)* 1. мөргөх, эврээр олих. 2. *mec.* эр нөхрөө хуурах, араар нь тавих.

boynuzlanma *is.* boynuzlanmak үйлийн нэр.

boynuzlanmak *(nsz)* 1. (эврээр) олих, мөргүүлэх, сүлбүүлэх, эврээр сүлбүүлж шархтах. 2. эвэр нь унах. 3. *mec.* эхнэртээ хууртагдах, араараа тавиулах.

boynuzlu *s.* 1. эвэртэй, эвэрт. 2. *mec.* давхар малгайт, эхнэртээ маллуулдаг эр. 3. *argo.* тролейбус.

boynuzsuz *s.* эвэргүй, мухар, тоймог, моголцог.

boyun, -ynu *is.* 1. хүзүү. 2. хоолой, хүзүү, цорго, нарийн хэсэг, шувтан тал, онги. 3. хариуцлага. 4. *coğr.* даваа. **~ borcu** үүрэг, алба, үүрэг даалгавар. **~ eğmek** дагах, захирагдах, дуулгавартай сонсох, үг дуугүй дагах. **~ kesmek** толгой гудайлгах, толгой бөхийлгөх. **~ olmak** *hlk.* даах, даалт гаргах, баталгаа агах, батлах. **boynuna geçirmek** өөрийнх болгох, өөрчлөх, хувьдаа авах, эзэмших. **boynuna sarılmak** хүзүүгээр тэврэх, хүзүүдэх. **boynunu bükmek** 1) толгойгоо унжуулах, толгойгоо ганзагалах, уруу царайлах. 2) хүлээн зөвшөөрөх, үг дуугүй дагах. 3) (ургамал) гандах, гундах. **boynu bükük** толгойгоо унжуулсан, толгойгоо ганзагалсан, уруу царайлсан, гутарсан, урвайсан. **boynunu vurmak** толгойг нь таслах, толгой цавчих.

boyuna *zf.* 1. дагуу, уртааш нь, уртаашаа, тууш, гулд. 2. зогсолтгүй, үргэлжлүүлэн.

boyun bağı *is.* зангиа.

boyunca *zf.* 1. дагуу, уртаашаа, тууш, гулд. "*Sahil boyunca.*" Эрэг дагуу. 2. турш. "*On yıl boyunca.*" Арван жилийн турш.

boyunduruk, -ğu *is.* 1. буулга. 2. *mec.* талхи, талхидал, дөнгө, дарлал. **~ altına girmek** дарлагдах, талхидуулах, эрхэнд орох. **boyunduruğa almak** дарлах, талхих, эрхэндээ оруулах.

boyunlu *s.* хүзүүтэй, хоолойтой.

boyunluk, -ğu *is.* хүзүүвч.

boyut *is.* 1. хэмжээ, цар хүрээ, багтаамж, онцлог шинж. 2. *mec.* байдал, бодит байдал. 3. *mat.* хэмжигдэхүүн, хэмжээ. **~ katmak** өөр онцлог шинжтэй болгох, шинэчлэх, өргөн цар хүрээтэй болгох, өргөсгөх. **~ kazanmak** өргөн цар хүрээтэй болох, өөрмөц шинэ онцлог шинжтэй болох, байдал шинэчлэгдэх.

boyutlu *s.* хэмжээтэй, цар хүрээтэй, онцлог шинж бүхий, өөрмөц, багтаамжтай, хэмжээтэй.

boz *is.* 1. бор, хөх бор, хөх саарал, ороо. 2. *s.* бор өнгөтэй, хөх бор өнгийн, хөх саарал, ороо. 3. *s.* атар (газар).

boza *is.* арвай буудай, эрдэнэ шиш, шар будаа гэх мэт үр тарианы эсгэсэн гурилаар хийсэн өтгөвтөр, бага зэрэг чихэрлэг ба гашуун амт бүхий зөөлөн архи.

bozarma *is.* bozarmak үйлийн нэр.

çekek, -ği *is. hlk.* завь, жижиг усан онгоцны зогсоол, байр.

çekeleme *is.* çekelemek үйлийн нэр.

çekelemek *(-i)* аяар аяар татах.

çekelez *is. hlk.* хэрэм.

çekememe *is.* çekememek үйлийн нэр.

çekememek *(-i)* 1. татаж чадахгүй байх, чангааж чадахгүй байх, чирж чадахгүй байх. 2. *mec.* хүлцэж чадахгүй байх, үзэж чадахгүй байх, тэвчихгүй байх, тэсэхгүй байх. 3. *mec.* (атаархсанаас болж) дургүй байх, үзэхгүй байх.

çekememezlik, -ği *is.* атаа, атаархал, жөтөө, хүлцэшгүй байдал, тэвчихгүй байх.

çekemez *s.* атаархуу, атаач, жөтөөч.

çeker *is.* 1. жин, жинлүүр, пүү, дэнс. 2. зүтгүүр, хөллүүр, чирүүл, татуур.

çeki *is.* 1. жин. 2. 250 килограммын хэмжээтэй түлээ, мод гэх мэт хүнд зүйлийг жигнэхэд хэрэглэдэг хүндийн хэмжих нэгж. 3. *hlk.* (толгойн) алчуур. 4. эмх, цэгц, эмх цэгц, дэг журам. 5. *mec.* уйтгар, гуниг, зовлон. **~ye gelmek** дэг журамд орох, зохицох, нийцэх, цэгцрэх. **~ye gelmez** 1) хэмжээлшгүй, хэмжээгүй, асар том, асар их, хэмжиж боломгүй. 2) засаршгүй, эмхэлж боломгүй, эмх цэгцээ алдсан.

çekici *is.* 1. зүтгүүр, чирэгч, татуур, татагч. 2. *mec.* дур булаам, сэтгэл татам, сүндлэг, үзэсгэлэнтэй. 3. чирэгч машин, аврах машин тэрэг.

çekicilik, -ği *is.* 1. дур булаам байдал, сэтгэл татам байдал, сүндлэх, гоо үзэсгэлэн. 2. *fiz.* татах хүч.

çekiç, -ci *is.* 1. алх, лантуу, балт. 2. *sp.* бөөрөнцөг.

çekiç atma *is. sp.* бөөрөнцөг шидэлт

çekiç kemiği *is. anat.* (чихний) алх мөгөрс.

çeki düzen *is.* эмх, цэгц, эмх цэгц, дэг журам. **(birine, bir şeye) ~ vermek** эмх журам тогтоох, эмх журамтай болгох, эмхтэй болгох, эмхлэх, цэгцлэх, замбараатай болгох.

çekik *s.* 1. жартгар. **~ göz** жартгар нүд. 2. шовгор, хонхор, хонхойсон. "*Çekik karın.*" Хонхойсон гэдэс.

çekiliş *is.* çekilmek үйлийн нэр.

çekilme *is.* 1. çekilmek үйлийн нэр. 2. (өөрийн хүсэлтээр) огцрох, халагдах, гарах. 3. *jeol.* ус татрах. 4. *ask.* ухрах, ухралт. 5. *sp.* буулт өгөх, тэмцээнээс гарах.

çekilmek *(nsz, -e, -den)* 1. çekmek үйлийн үйлдэгдэх хэв. 2. холдох, зайлах, хөндийрөх, цаашлах. 3. (өөрийн хүсэлтээр) огцрох, халагдах, орхих, гарах. 4. татрах, багасах. "*İneğin sütü çekildi.*" Үнээний сүү татрав. 5. ганцаар суух, олноос хөндийрөх, хүнгүй газар очих, олноос зайлах, сөдгийрөх. 6. холдох, зайлах, орохоо байх. "*Dükkân karmakarışık, mallar bayat ve bozulmuş, müşterileri birer birer çekiliyordu.*" Дэлгүүр ундуй сундуй, бүтээгдэхүүнүүд нь хуучирч муудсан, үйлчлүүлэгчид нь орохоо больсон байлаа. 7. ухрах. 8. оролцохгүй байх, оролцохоос татгалзах, гарах, орхих. "*Yarışmadan çekilmek.*" Тэмцээнийг орхих. 9. тэвчих, хүлцэх, тэсвэрлэх, хүлцэнгүй хандах. "*Çekilmez dert.*" Тэсвэрлэшгүй зовлон.

çekim *is.* 1. çekmek үйлийн нэр. 2. *fiz.* таталцал, таталт. "*Yer çekimi.*" Дэлхийн таталцал. 3. *gr.* ялгаллахуй, хувилахуй. **~ eki** *is. gr.* нөхцөл. 4. *sin.* зураг авалт.

çekimci *is.* 1. продюсер. 2. кино зураглаач.

çekimleme *is.* çekimlemek үйлийн нэр.

çekimlemek *(-i) fiz.* татах.

çekimsenme *is.* çekimsenmek үйлийн нэр.

çekimsenmek *(-den)* цааргалах, цээрлэх, түдгэлзэх, биеэ барих, зайлсхийх, далдирах,

болгоомжлох.

çekimser *is.* түтгэлзсэн, биөэ барьсан,зайлсхийсэн, болгоомжилсон.

çekince *is.* болгоомж, болгоомжлол, хаширлах, биеэ барьсан байдал. **~ koymak** болгоомжлох, хаширлах, болгоомжилж буйгаа илэрхийлэх.

çekingen *s.* ичимтгий, ичимхий, зовомтгой, эрээлхэг, нэрэлхүү, бишүүрхүү, бүрэг. **~ davranmak** ичих, зовох, эрээлхэх, нэрэлхэх, бишүүрхэх, гэрэвших.

çekingenlik, -ği *is.* ичимтгий байдал, ичимхий зан, нэрэлхүү зан, бүрэг зан.

çekinme *is.* çekinmek үйлийн нэр.

çekinmek *(-den)* 1. аягүйрхэх, ичих, зовох, санаа зовох, нэрэлхэх, гэрэвших, бишүүрхэх, болгоомжлох, цааргалах, биеэ барих, зайлсхийх, далдирах. 2. нүүр амаа будах.

çekinti *is.* тээнэгэлзэл, эргэлзээ.

çekirdek, -ği *is.* 1. жимсний яс. 2. самар. 3. *biy.* бөөм. 4. *fiz.* цөм. 5. алт мөнгөн эдлэлийн гар урлалд хэрэглэдэг. 6. гол, гол хүч, гол зүйл, үндэс, суурь, гол төв. "*Çekirdek kadro.*" Гол бүрэлдэхүүн. 7. модны гол.

çekirdekli *s.* ястай, үргүй (жимс).

çekirdeksiz *s.* ясгүй, үргүй. "*Çekirdeksiz üzüm.*" Ясгүй усан үзэм.

çekirge *is. zool.* дэвхрэг,царцаа.

çekirge kuşu *is. zool.* хар тодол (шувуу).

çekiş *is.* 1. çekmek үйлийн нэр. 2. зүтгүүр, зүтгүүр хүч. 3. *hlk.* хэрүүл, маргаан.

çekişken *s. hlk.* хэрүүлч, хэл амтай.

çekişme *is.* çekişmek үйлийн нэр.

çekişmek *(nsz, -le)* 1. татах, таталцах, чангаах. 2. (биө бие рүүгээ) тулгах, гаргах, далайх, өргөх. "*Bıçak çekişmek.*" Хутга тулгах. 3. сугалах. "*Kura çekişmek.*" Шавга орхих, шавга хаях. 4. хэрэлдэх, муудалцах, маргалдах, хэрүүл хийх. 5. өрсөлдөх, уралдах, үзэлцэх, тэмцэлдэх. **çekişe çekişe pazarlık etmek** наймаалцах, үнэ хаялцах.

çekişmeli *s.* 1. хэрүүлтэй, маргаантай,хэл амтай,хэрэлдүүлсэн, хэрүүл хийлгэсэн. 2. өрсөлдөөнтэй.

çekiştirme *is.* çekiştirmek үйлийн нэр.

çekiştirmek *(-i)* 1. татах, чангаах. 2. зулгаах, татах, суга татах. "*Saçlarını çekiştirmek.*" Үсээ зулгаах. 3. *mec.* муулах, муу хэлэх, муучлах.

çekkin *s.* оролцоогүй, хайхрамжгүй, ажиггүй, хэнэггүй.

çekme *is.* 1. çekmek үйлийн нэр. 2. шургуулга, шургуул. 3. өндөр мөчир, гишүүг татаж огтлох зориулалттай, урт иштэй, шүдтэй хутга. 4. комбинзон, бадай (үргэлж оёсон өмд, цамц). 5. утсан хөгжим. 6. чангаах, татаж өөр лүүгээ ойртуулах. 7. агших, авчих. 8. *s.* хэлбэр сайтай, тэгш, гоё, сайхан. "*Çekme burun.*" Шулуун хамар. 9. *s.* татаж өмсдөг, татагддаг.

çekmece *is.* 1. шургуулга, шургуул. 2. авдар. 3. далайн тохой, тэнгисийн булан.

çekmeceli *s.* шургуулгатай, шургуултай.

çekmecesiz *s.* шургуулгагүй, шургуулгүй.

çekmek *(-i, -e)* 1. татах, чирэх, чангаах. 2. даах. "*Bu araba beş yüz kilodan fazla çekmez.*" Энэ машин таван зуун килограммаас илүүг даахгүй. 3. татах, сунгах, тэлэх. "*İp çekmek.*" Утас татах. 4. уусгах, шингээх. "*Su çekmek.*" Ус шингээх. 5. зөөх. 6. өөр тийш нь татах, зайлуулах, хажуу тийш нь болгох. 7. хураах. 8. татах, сорох, гүнзгий амьсгаа авах, дотогш татах. 9. сугалах, далайх, гаргах, тулгах. "*Bıçak çekmek.*" Хутга тулгах. 10. цохих, шаах, балбах, зодох, жанчих, нанчих. "*Dayak çekmek.*" Алгадах. 11. татах. "*Devlet elçisini çekti.*" Улс өөрийн элчин сайдаа татав. 12. жинтэй байх, хүнд байх, татах. "*Yaş odun ağır çeker.*" Нойтон мод хүнд байна. 13. татах, хаах, хаалт хийх, хаалт босгох, барих, өрөх. "*Duvar çekmek.*" Хана өрөх. 14. сугалах, шавга орхих, шавга хаях. 15. гаргаж авах, нэрэх. "*İspirto çekmek.*" Спирт нэрэх. 16. зурах, татах, түрхэх, нүүрээ будах. "*Çizgi çekmek.*" Зураас татах, "*G züne sürme çekmek.*" Нүдээ нүд хүрээлэгчээр будах. 17. хуулах, буулгах, хуулан бичих, дахин хуулах, цайруулах, сийрүүлэх. 18. авах, буулгах. "*Fotoğraf çekmek.*" Зураг авах. 19. тээрэмдэх, талхлах, татах, нүдэх, нунтаглах. 20. (машин, унаа тэрэг) ачих, ачаалах. "*Kamyon üç ton kömür çekti.*" Ачааны машин гурван тонн нүүрс ачив. 21. (вексель, өр төлөх баталгаа, чех гэх мэт) албан ёсны болгон хэрэгжүүлж эхлэх, хэрэглээ эхлэх, хүчинтэй болгох. 22. анхаарал татах, дур татах, сүндлэх. 23. сониурхах, сонирхон орох, сонирхол татах, сонирхол төрүүлэх, татах, дуртай болгох. "*Müşteriler çekmek.*" Үйлчлүүлэгчдийг татах. 24. төлөх, зардлыг нь даах. "*Beni lokantasına götürdü, âlâ bir öğle yemeği çekti.*" Намайг өөрийн хоолны газар аваачаад, амттай сайхан өдрийн хоолонд оруулав. 25. зүрх сэтгэлээрээ мэдрэх, зүрх сэтгэлдээ амьдруулах, үзэх, амсах, туулах, санах, санагалзах, мөрөөдөх. "*Hasretini çekmek.*" Санах, мөрөөдөх, санан уйтгарлах. "*Neler çektik neler!*" Юу эс үзсэнийг тэр гэхэв дээ. 26. *argo.* татах, тогтоох, архи уух, хөнтрөх. "*Hadi bir tane daha çek.*" Алив дахиад нэг татчих/тогтоочих. 27. явах, хөдлөх, хөдөлгөх. "*Hadi çek!*" За хөдөльө! 28. адил байх, адилхан байх, төстэй байх, дуурайх. "*Anasına çekmiş.*" Ээжийгээ дуурайсан байна. 29. байцаах, асуух, шалгаах. *Sorguya çekmek* байцаалт хийх, байцаах. 30. утгыг гуйвуулах, гажуудуулах, мушгих, мушгиж буруутуулах. "*Bak, sözümü nereye çekti!*" Хар даа, миний хэлсэн үгийг гуйв уулж байгааг нь! 31. бүтээх, нөмрөх, өмсөх, углах. "*Yorganınızı başınıza çeker uyursunuz.*" Хөнжлөө толгой дээрээ нөмрөөд унтахгүй юу. 32. үргэлжлэх, хугацаатай, хугацаа авах. "*Şubat ayı yirmi sekiz gün çeker.*" Хоёрдугаар сар хорин найман өдөртэй. 33. агших, авчих. 34. нурших, ярих, унших. "*Nutuk çekmek.*" Нурших. "*Gazel*

çekmek." Шүлэг унших. 35. өлгөх, зүүх. "*Bayrak çekmek.*" Туг өргөх. 36. будах, түрхэх, нялах. "*Boya çekmek.*" Будах, будаг түрхэх. 37. илгээх, явуулах. "*Telgraf çekmek.*" Цахилгаан шуудан явуулах 38. татах, сорох. "*Baca iyi çekiyor.*" Яндан сайн татаж байна. **çek arabanı!** (veya **çek!**) эндээс зайл! **çekip almak** холдуулах, зайлуулах, ажлаас нь гаргах. **çekip çevirmek** эрхлэх, захирах. **çekip gitmek** орхиж явах, орхин одох,салж одох

Çekoslovakyalı *z. is. esk.* чехославак хүн.

çektirme *is.* 1. çektirmek үйлийн нэр. 2. *den.* том далбаат усан завь.

çektirmek *(-i, -e)* 1. çekmek үйлийн үйлдүүлэх хэв. 2. зовоох, зовлон учруулах, зовлон тарих, шаналгах.

çekül *is. fiz.* эгц хажуу.

çelebi *s.* 1. буурь суурьтай, төлөв, түвшин, хүмүүжилтэй. 2. *esk.* эрхэм, нөхөр, ноён. 3. *is.* Бө кташи ба Мевлөви зэрэг шашны бүлгийг үүсгэн байгуулагч тэргүүн нарт өгдөг хэргэм цол.

çelenk, -gi *is.* 1. цэцэг титэм, гөрсөн цэцэг. 2. *esk.* титэм, овоодой. **~ koymak** цэцэг тавих.

çelik, -ği (I) *is.* 1. ган, болд. 2. *s.* ган, болд, ганаар хийсэн. "*Çeliğe su vermek.*" Ган хатаах, хаттай болгох. "*Çelik başlık.*" Ган дуулга. **~ kasa** сейф, мөнгөний авдар, үнэт эд зүйлс хийдэг авдар.

çelik, -ği (II) *is.* 1. богинохон тайрагдсан мөчир. 2. үндэслүүлэгч мөчир.

çelikhane *is.* болд цутгах үйлдвэр, ган цутгах үйлдвэр.

çelikleme *is.* çeliklemek үйлийн нэр.

çeliklemek *(nsz)* үндэслүүлэгч мөчрөөр мод тарих, мод үрслүүлэх.

çelikleşme *is.* çelikleşmek үйлийн нэр.

çelikleşmek *(nsz)* 1. хатах, хатан болох, хаттай болох. 2. *mec.* болд шиг бат бөх болох.

çelikleştirme *is.* çelikleştirmek үйлийн нэр.

çelikleştirmek *(-i)* 1. хатаах, хатан болгох, хаттай болгох. 2. *mec.* хүчжүүлэх, хүч чадалтай болгох.

çelikli *s.* гантай, болдтой, ган, болд.

çelim *is. hlk.* хүч, бяр, чадал.

çelimli *s.* хүчтэй, чадалтай, бяртай.

çelimsiz *s.* хүчгүй, бяр чадалгүй, дороо.

çelişik *s.* зөрчилтэй, зөрөлдөөнтэй, харшлалдсан.

çelişiklik, -ği *is.* зөрүү, зөрчилтэй байдал, зөрөлдөөн, харшлалдах.

çelişken *s.* bk. çelişik.

çelişki *is.* зөрчил, зөрөлдөөн, харшлалдаан.

çelişkili *s.* зөрчилтэй, зөрөлдөөнтэй, харшлалдсан.

çelişkisiz *s.* зөрчилгүй, зөрөлдөөнгүй.

çelişme *is.* зөрчил, зөрөлдөөн, харшлалдаан.

çelişmek *(nsz, -le)* зөрчилдөх, зөрөх, зөрчих, харшлалдах.

çelişmeli *s.* bk. çelişik, çelişkili.

çelişmesiz *s.* bk. çelişkisiz.

çelme *is.* 1. çelmek үйлийн нэр. 2. дэгээдэх, хөлөөр таших. 3. (толгойн) гурвалжин алчуур. **~ takmak** 1) дэгээдэх, хөлөөр таших. 2) *mec.* хүний доогуур хөлөө шургуулж бүдрүүлэх, хүний ажилд саад болох.

çelmece *zf.* толгой эргүүлсэн, учир нь олдохгүй, самууруулсан.

çelmek, -er *(-i)* 1. унагаах, дэгээдэж унагаах. 2. саад болох, саатуулах, зам хөндөлдөх, зам хаах. 3. (алчуур) ороох, боох, уях. 4. хөндлөн тайрах, хөндлөн огтлох. 5. алдагдуулах, алдуулах, таслах. "*Bu gürültü uykumu çeldi.*" Энэ чимээ нойр тасалчихлаа. 6. самууруулах, алмайруулах,саатуулах, алгасуулах. 7. маань мэгзэм унших, тарни унших. 8. *mec.* (үзэл бодол, үйл хөдлөл) зөрчилдөх, зөрөх, харшилдах.

çelmeleme *is.* çelmelemek үйлийн нэр.

çelmelemek *(-i)* дэгээдэх, хөлөөр таших.

çeltik, -ği *is.* цэвэрлээгүй цагаан будаа. "*Çeltik tarlası.*" Цагаан будаан тариалангийн талбай, тутраганы талбай.

çeltikçi *is.* цагаан будаа тариалагч, тутрага тариалагч.

çeltikçilik, -ği *is.* цагаан будаа тариалах, тутрага тариалах.

çeltik kargası *is. zool.* билүүс.

çember *is. mat.* 1. цагираг, хүрээ, тойрог, дугуй. 2. цагираг, бүслүүр, боолт, бөгж. 3. дугуй, цагираг (хүүхдийн тоглоом). 4. бүслүүр, хүрээ. 5. том, шаглаатай толгойн алчуур. 6. *mec.* хүнд байдал, хүнд хэцүү байдал, хүнд бэрх байдал, аргагүйдэл. 7. *sp.* сагсны шийд. **~ çevirmek** (хүүхэд) дугуй өнхрүүлэх, цагираг өнхрүүлж тоглох. **~ geçirmek** хүрээгээр бэхлэх, бөгжөөр бүслэх, цагиргаар ороох, бүслүүр углах. **~ içine almak** (veya **çembere almak**) хүрээлэх, тойрох, бүслэх. **~i yarmak** бүслэлтийг сэтэлж гарах.

çemberleme *is.* çemberlemek үйлийн нэр.

çemberlemek *(-i)* хүрээгээр бэхлэх, бөгжөөр бүслэх, цагиргаар ороох, бүслүүр углах.

çemberlenme *is.* çemberlenmek үйлийн нэр.

çemberlenmek *(nsz)* 1. үйлийн үйлдэгдэх хэв. 2. дүгрэг болох, дугариглах, бөөрөнхий болох, дугуй хэлбэртэй болох, тойрог болох, цагирган болох, цагираг хэлбэртэй болох.

çemen *is. bot.* гоньд, гоньдны үр.

çemrek *s. hlk.* (ханцуйгаа) шамласан, (хормойгоо) шуусан, сөхсөн.

çemreme *is.* çemremek үйлийн нэр.

çemremek *(-i) hlk.* ханцуй шамлах, хормой шуух, дээш сөхөх.

çemrenme *is.* çemrenmek үйлийн нэр.

çemrenmek *(nsz)* 1. (ханцуй, хормой) шамлах, шуух, сөхөх. 2. *mec.* ажилд ханцуй шамлан орох, бэлтгэх, бэлдэх, зэхэх.

çençen *s. hlk.* чалчаа, бураа, хагархай хэнгэрэг, далан долоон үгтэй.

çene *is.* 1. эрүү. 2. хавчуур, хавчаар. 3. шал шал хийх, илүү олон үг дэлгэх, шалиг марзан ярих, чалчих, далан долоон үг дэлгэх. 4. *hlk.* булан. **~ çalmak** чалчих, бурах, донгосох, далан долоон үг дэлгэх, дэмий ярих. **~ yarıştırmak** ам булаалдан ярилцах, хөөрөлдөх, чалчих. **~ yormak** шал хэрэггүй ярих, дэмий ярих, хий дэмий чалчих. **~si açılmak** ярьж гарах, яриандаа халаад бурж гарах. **~si atmak** эрүү нь дагжтал чичрэх. **~si oynamak** зажлах, хивэх, бувар бувар хийх, бувганах. **~sini bıçak açmamak** (уйтгарлан гунигласнаас болж) дуугаа хураах, дуугүй болох. **~sini kapatmak** дуугүй болгох, амыг нь таглах, амыг нь хамхих. **~sini tutmak** дуугүй байх, дуугүй өнгөрүүлэх, дуугүй суух, таг чиг суух. **~sinin bağı çözülmek** амны нь үдээс алдрах, чалчиж гарах. **~si kuvvetli** уран үгтэй, хэлэмгий, яриа, аманцар.

çenek, -ği *is. bot.* 1. үрийн хэлтэр. 2. *zool.* (шув ууны) дээд хонш, ханшуу, доод хонш, эшүү.

çeneleşme *is.* çeneleşmek үйлийн нэр.

çeneleşmek *(-e)* ярилцах, хөөрөлдөх. чалчицгаах.

çeneli *s.* 1. эрүүтэй. 2. *mec.* чалчаа, яриа, бураа, задгай амтай.

çenet, -di *is. bot.* хавтас, далавч, нээлхий.

çengel *is.* гох, дэгээ, чагт. **~ takmak** *mec.* хүний доогуур хөлөө шургуулж бүдрүүлэх, хүний ажилд саад болох, хорлох.

çengelleme *is.* çengellemek үйлийн нэр.

çengelli *s.* гохтой, дэгээтэй, чагттай. "*Çengelli iğnesi.*" Дэгээ зүү, тавтай зүү.

çengi *is.* танцчин эмэгтэй, бүжигчин эмэгтэй.

çenileme *is.* çenilemek үйлийн нэр.

çenilemek *(nsz) hlk.* гаслах (нохой).

çentik, -ği *is.* 1. сэтэрхий, ухмай, эмтэрхий, эмтгий. 2. *s.* сэтэрхий, ухмай, эмтэрхий, эмтгий, эмтэрсэн иртэй, шүд гарсан. "*Çentik bıçak.*" Эмтэрсэн иртэй хутга. 3. говил, догол.

çentikleme *is.* çentiklemek үйлийн нэр.

çentiklemek *(-i)* 1. сэтлэх, эмтлэх, шүд гаргах, ирийг эмтлэх. 2. нарийхан хэрчих.

çentme *is.* çentmek үйлийн нэр.

çentmek, -er *(-i)* 1. сэтлэх, эмтлэх, шүд гаргах, ирийг эмтлэх. 2. нарийхан хэрчих.

çepeçevre *s. ve zf.* эргэн тойрон, тойроод, хүрээлээд.

çepel *is.* 1. бохир, буртаг, хир, шавар, өнгөр. 2. хог, хольц. "*Buğdayın çepelini ayıkladı.*" Буудайн хогыг ялгав. 3. гал түлэхэд амархан ноцдог хуурай мөчир, гишүү. 4. *hlk.* бүүдийсэн, бүрхэг, үүлтэй тэнгэр.

çepelleme *is.* çepellemek үйлийн нэр.

çepellemek *(-i)* (хогтой) холих, хутгах.

çepelli *s.* хогтой, хольцтой. "*Çepelli buğday.*" Хогтой буудай.

çeper *is. hlk.* 1. хана, хашаа, хайс. 2. таарамж муутай хүн, зан муутай хүн, ааш муутай хэн нэгэн. 3. гал түлэхэд амархан ноцдог мөчир, гишүү. 4. жимсний цэцэрлэг. 5. *biy.* хальс, шар хальс, бүрхэвч.

çepiç, -ci *is. hlk.* ишиг.

çerçeve *is.* 1. жааз, гуу. 2. хүрээ. 3. *mec.* хэм, хэмжээ, хүрээ. "*Pencere çerçevesi.*" Цонхны хүрээ.

çerçeveleme *is.* çerçevelemek үйлийн нэр.

çerçevelemek *(-i)* жаазлах, гуулах, хүрээлэх, хүрээ хийх.

çerçeveletme *is.* çerçevelетmek үйлийн нэр.

çerçeveletmek *(-i)* жаазлуулах, гуулуулах, хүрээлүүлэх, хүрээ хийлгэх.

çerçeveli *s.* жаазтай, гуутай, хүрээтэй, жаазлуулсан.

çerçevesiz *s.* жаазгүй, гуугүй, хүрээгүй.

çerçi *is.* үүргийн наймаачин.

çer çöp *is.* 1. модны хог, зомгол. 2. хаягдал, хог, орхидос, хог новш.

çerez *is.* 1. зууш. 2. төрөл бүрийн самар, хатаасан жимсний нийт өрөнхий нэр.

çerezlenme *is.* çerezlenmek үйлийн нэр.

çerezlenmek *(nsz)* 1. зууш идэх, зууш зооглох. 2. самар чөмөх, хатаасан жимс идэх. 3. *mec.* жавших, ашиглах.

çerge *is.* гэр, майхан, цацар.

çeri *is. esk.* цэрэг.

Çerkez *z. is.* 1. чөркөс хүн. 2. *s.* черкөс, черкесийн, черкес үндэстний.

çerviş *is.* 1. өөхөн тос. 2. шөл.

çeşit, -di *is.* 1. төрөл, зүйл, зэрэг. 2. төрөл зүйл, анги. 3. *s.* олон төрлийн, янз бүрийн, олон янзын.

çeşitkenar *s.* олон талт, тэгш бус талт.

çeşitkenar üçgen *is. mat.* тэгш бус талт гурвалжин.

çeşitleme *is.* çeşitlemek үйлийн нэр.

çeşitlemek *(-i)* төрөлжүүлэх.

çeşitlendirme *is.* çeşitlendirmek үйлийн нэр.

çeşitlendirmek *(-i)* төрөлжүүлэх.

çeşitlenme *is.* çeşitlenmek үйлийн нэр.

çeşitlenmek *(nsz)* төрөлжих.

çeşitli *s.* ve *zf.* элдэв, төрөл бүрийн, янз бүрийн, элдэв янзын.

çeşitlilik, -ği *is.* янз бүрийн байдал, өөр өөр байдал, харилцан адилгүй байх.

çesme *is.* усны цорго, ундны усны цорго.

çeşni *is.* 1. амт, амт чанар. 2. *mec.* амтархах, шимтэх. **~sine bakmak** амталж үзэх, амсаж үзэх, амтыг нь үзэх.

çeşnileme *is.* çeşnileme үйлийн нэр.

çeşnilemek *(nsz)* амтлах, амт оруулах.

çeşnilenme *is.* çeşnilenmek үйлийн нэр.

çeşnilenmek *(nsz)* амт орох.

çeşnili *s.* 1. амттай, амтлаг. 2. *mec.* амтархан, шимтэн.

çeşnilik, -ği *is.* хоол амтлагч.

çete *is.* бүлэг дээрэмчин, бүлэг зандалчид, эсэргүүцэгчдын бүлэглэл.

çeteci *is.* дээрэмчин, зандалчин, эсэргүүцэгч.

çetin *s.* хатуу, чанга, хэцүү, бэрхшээлтэй, хүнд, төвөгтэй, ярвигтай.

çetrefil *s.* 1. бэрхшээлтэй, төвөгтэй, ярвигтай. 2. хазгай, алдаатай, буруу. "*Onun çetrefil bir dili var.*" Тэр хазгай хэлтэй юм байна.

çevgen *is.* мод, саваа, бэрээ, шийдэм.

çevik *s.* дүйтэй, онгтой, гавшгай, шаламгай, хүйхэр, түргэн хөдөлгөөнтэй.

çeviklik, -ği *is.* гавшгай, шаламгай, онгтой байдал, хүйхэр байх.

çeviren *is.* орчуулагч.

çevirgeç, -ci *is. fiz.* сэлгүүр (цахилгаан гүйдлийг сэлгүүлэн явуулах багаж).

çeviri *is.* орчуулга.

çevirici *is.* 1. орчуулагч, хэлмэрч. 2. *fiz.* сэлгүүр.

çevirim *is.* 1. эргэлт. 2. *sin.* кино зураг авах.

çevirme *is.* 1. çevirmek үйлийн нэр. 2. шорлог. 3. *ask.* бүслэлт. 4. *s.* орчуулгын, орчуулсан, хөрв үүлсэн.

çevirmek *(-i)* 1. эргүүлэх, эргүүлж явуулах, чиглэлийг нь өөрчлөх. 2. эргүүлэх. "*Kitabın yaprağını çevirmek.*" Номын хуудас эргүүлэх. 3. орчуулах, хөрвүүлэх. 4. эргүүлэх, эргүүлдэх, мушгих. 5. болгох, болгож хувиргах, сүйтгэх, сүйрүүлэх, баллах, эвдэрхий балгас болгож хувиргах. "*Harabeye çevirmek.*" Үнсэн товрог болгох, сүйрүүлэх. 6. удирдах, зохицуулах, авч явах. 7. буцаах, эргүүлэх, буцааж явуулах, замаас буцаах. 8. буцаах, эргүүлэх, буцаан илгээх, эргүүлэн өгөх. 9. өнгийг эргүүлэх (хувцас г.м). 10. (үгийн утгыг) буруу ташаа тайлбарлах, өөрчлөх, хувиргах, гуйвуулах, гажуудуулах, мушгих. 11. далд явуулга явуулах, далдуур хөнөөх, хорлох. 12. бүслэх, хүрээлэх. 13. болгох, хувиргах, болгож хувиргах, өөрчлөх, болгож өөрчлөх. "*Evlerini otele çevirdiler.*" Гэрээ зочид буудал болгон өөрчилчихсөн. 14. өөрчлөгдөх, хувирах. 15. хөзөр тоглох.

çevirmen *is.* орчуулагч, хэлмэрч.

çevirtme *is.* çevirtmek үйлийн нэр.

çevirtmek *(-i, -e)* çevirmek үйлийн үйлдүүлэх хэв.

çevre *is.* 1. орчин, орчин тойрон, ойр хавь. 2. *mec.* орчин тойрон, орчин тойрны хүмүүс, эргэн тойрны хүмүүс. 3. *mec.* хүрээ, бүлэг. 4. байгаль орчин, хүрээлэн байгаа орчин. "*Çevre kirliliği.*" Байгаль орчны бохирдолт. 5. *mec.* орчин, нөхцөл. 6. шаглаатай нусны алчуур. 7. *mat.* хүрээ.

çevre açı *is. mat.* багтсан өнцөг.

çevre bilimi *is.* экологи, экологийн шинжлэх ухаан.

çevreleme *is.* çevrelemek үйлийн нэр.

çevrelemek *(-i)* 1.бүслэх,хүрээлэх,тойрох.2.х язгаарлах, хэмжээлэх, хэмжээг нь тодорхойлох.

çevrelenme *is.* çevrelenmek үйлийн нэр.

çevrelenmek *(nsz)* çevrelenmek үйлийн үйлдэгдэх хэв.

çevren *is.* тэнгэрийн хаяа, тэнгэрийн хормой, хаяалбар.

çevresel *is.* орчин тойрны, хавь ойрын.

çevre yolu *is.* хот хоорондын зам.

çevri *is.* 1. (үгийн утга) буруу ташаа тайлбар, өөрчлөх, хувиргах, гажуудуулах, мушгих, мушгин гуйвуулах. 2. хуй салхи, усны эргүүлэг, усны ойл, эргэц.

çevrik *s.* эргэсэн, эргүүлсэн.

çevrileme *is.* çevrilemek үйлийн нэр.

çevrilemek *(-i)* буруу ташаа тайлбарлах, өөрчлөх, хувиргах, гажуудуулах, мушгих, мушгин гуйвуулах.

çevrili *s.* 1. бүслэгдсэн, хүрээлэгдсэн, тойрсон. 2. эргэсэн, эргүүлсэн.

çevrilme *is.* çevrilmek үйлийн нэр.

çevrilmek *(nsz, -e)* 1. çevirmek үйлийн үйлдэгдэх хэв. 2. эргэх, эргэн харах, хандах.

çevrim *is.* 1. үе, цаг. 2. *fiz.* цахилгаан гүйдэл.

çevrimsel *s.* мөчлөгийн, орчилын, үет, мөчлөгт, орчилт.

çevrinme *is.* эргэх, эргэлдэх.

çevrinmek *(nsz)* эргэх, эргэлдэх, тойрох, эргэж тойрох.

çevrinti *is.* 1. эргэлт, эргэх, эргэлдэх, тойрох. 2. хуй салхи, усны эргүүлэг, усны ойл, эргэц. 3. төрөл бүрийн үр тарианы холимог.

çevriyazı *is.* ve *d.b.* галиг, авианы галиг, галигчлал.

çeyiz *is.* инж. ~ **düzmek** инж бэлдэх.

çeyizleme *is.* çeyizlemek үйлийн нэр.

çeyizlemek *(-i)* инж бэлдэж өгөх.

çeyrek, -ği *s.* 1. дөрөвний нэг, мөч, мөчлөг. "*Çeyrek asır.*" Зууны мөчлөг. 2. *is.* арван таван минут, цагийн дөрөвний нэг хугацаа. "*Bire çeyrek var.*" Нэг цагт арван таван минут дутуу байна. 3. *esk.* мөнгөн зоосны дөрөвний нэгтэй тэнцэх таван мөнгө. 4. *argo.* марк (Германы мөнгөн дэвсгэрт).

çıban *is.* идээлсэн газар, хатиг, буглаа, хувилдас. ~ **açmak** идээ хагалах. ~ **işlemek** идээ гоожих.

çıbanbaşı *is.* амин чухал асуудал/сэдэв, эгзэгтэй асуудал, эмзэг асуудал.

çıdam *is. esk.* тэвчээр, тэсвэр, хатуужил.

çıdama *is.* çıdamak үйлийн нэр.

çıdamak *(-e)* тэвчих, хүлцэх, тэсвэрлэх.

Çıfıt *z. is.* 1. еврей хүн. 2. (çıfıt) хутган үймүүлэгч, далдуур хөнөөгч, далд явуулга хийгч.

çığ *is.* 1. цасан уруй, бөөн цас, цасны нур. 2. *hlk.* ташаалавч, далдавч, гүйлгээ хана, хананцар. ~ **düşmek** цасны нуралт.

çığa *is. zool.* шүхэрлэг загас.

çığıltı *is.* шуугиан, дуу чимээ.

çığır *is.* 1. цасны нурын мөр, цасны нурын цасан дээр гаргасан нарийн судаг. 2. жим, харгуй. 3. мөр. 4. *mec.* арга зам, үүд хаалга, шинэ бололцоо. **~ açmak** зам зааж өгөх, зам тавьж өгөх, бололцоо нээж өгөх, үүд хаалга нээх. **(iş) ~ından çıkmak** (ажил хэрэг) бүтэлгүй болох, сандаах.

çığlık, -ğı *is.* орилоон, чарлаан, бархирах дуу. **~ atmak (koparmak** vэya **basmak)** орилох, чарлах, бархирах.

çığrışma *is.* çığrışmak үйлийн нэр.

çığrışmak *(nsz, -le)* орилолдох, чарлалдах, бархиралдах.

çıkagelme *is.* çıkagelmek үйлийн нэр.

çıkagelmek *(nsz)* гэнэт ирэх, гэнэт гарч ирэх.

çıkak, -ğı *is. hlk.* гарах газар, хаалга.

çıkan *is. mat.* хасагдагч.

çıkar *is.* ашиг, хонжоо, эрх ашиг. **~ına bakmak** ашиг хонжоо хайх, өөрийн эрх ашгаа бодох, амин хувиа бодох, хувийн ашиг хичээх, олзонд шунах.

çıkarcı *is.* ашигч, ашиг хонжоо бодогч, хомхой зант, хувьдаа завшигч, хувийн ашиг хичээгч, олзонд шунагч (хэн нэгэн).

çıkarılma *is.* çıkarılmak үйлийн нэр.

çıkarılmak *(-den, -e)* çıkarmak үйлийн үйлдэгдэх хэв.

çıkarım *is.* 1. çıkarmak үйлийн нэр. 2. *man.* дүгнэлт, гаргалга.

çıkarma *is.* **1.** çıkarmak үйлийн нэр. 2. *mat.* хасах үйлдэл. 3. *ask.* цэрэг буулгах, десант буулгах.

çıkarma birliği *is. ask.* тэнгисийн дөсантын нэгдсэн анги.

çıkarmak *(-i, -den, -e)* 1. гаргах. 2. хүргэх. "*Bu para ile ayı çıkaramayız.*" Энэ мөнгөөр сарын эцсийг хүргэж чадахгүй нь. 3. ойлгох, мэдэх, гаргах. 4. гаргах, илрүүлэх, илчлэх. "*Yalanını çıkarmak.*" Худлыг нь илчлэх. 5. санах. 6. *mec.* хэлэх, ярих, гаргах. "*Bu dedikoduyu kesin o çıkarmıştır.*" Энэ хов живийг тэр л гаргасан. 7. таашаал авах, тааламжтай байх, таалагдах. 8. (уур, уцаар, омог, өшөө, хорсол) гаргах, тайлах, авах. "*Öfkesini benden çıkardı.*" Уураа надад гаргав. 9. (цалин, хөлс, мөнгө) олох, авах, хангах, нөхөж чадах. "*Ekmeğini taştan çıkarmak.*" Зовж байж хоолоо олох. "*Masrafını çıkarmak.*" Зардлаа нөхөх. 10. үзүүлэх, харуулах, харагдуулах, таниулах. "*Suçlu çıkarmak.*" Буруутан болгож харуулах. 11. гаргах, гадагшлуулах. "*Yediğini çıkarmak.*" Идсэн ууснаа гаргах. 12. холдуулах, зайлуулах, гаргах, халах, хөөх, хөөж гаргах. 13. (хувцас, гутал зэргийг) тайлах, гаргах, авах. "*Şapkasını çıkarmak.*" Малгайгаа авах. 14. гаргах, хэвлэх, хэвлэн нийтлэх, нийтлэх. "*Gazete çıkarmak.*" Сонин гаргах. 15. арилгах. "*Lekeyi çıkarmak.*" Толбо арилгах. 16. гаргах, учруулах. "*Bir detektif bürosu açmış, hükümet zorluk çıkardığından kapatmıştı.*" Нэгэн тагнуулын хэлтэс нээсэн боловч засгийн газар асуудал гаргасан учир хаасан юм. 17. үйлдвэрлэх, гаргах. 18. *mat.* хасах, хасах үйлдэл хийх.

çıkarsama *is. fel.* дүгнэлт, гаргалга.

çıkartı *is.* баас, өтгөн, өтгөн мөр.

çıkartılma *is.* çıkartılmak үйлийн нэр.

çıkartılmak *(-den)* çıkartmak үйлийн үйлдэгдэх хэв.

çıkartma *is.* **1.** çıkartmak үйлийн нэр. 2. хуулах цаас, буулгах цаас. 3. хуулбар зураг, буулгав ар зураг.

çıkartmak *(-e, -den)* çıkarmak үйлийн үйлдүүлэх хэв.

çıkar yol *is. mec.* гарах арга, арга зам.

çıkı *is.* ваадан, боодол.

çıkık, -ğı *s.* 1. булгарсан, мултарсан. 2. урагшаа илүү гарсан, төвийсөн, хэрдэг. 3. *is.* үе мултрах, булгарах, булгалах.

çıkıkçı *is.* бариач.

çıkılama *is.* çıkılamak үйлийн нэр.

çıkılamak *(-i)* боох, ваадагнах.

çıkılma *is.* çıkılmak үйлийн нэр.

çıkılmak *(-e)* гадаа гарах, дээр гарах. "*Dağa çıkıldı.*" Уулан дээр гарав. "*Bu havada dışarıya çıkılmaz.*" Ийм өдөр гадагшаа гаралтгүй.

çıkın *is.* ваадан, боодол. **~a koymak** ваадагнах.

çıkınlama *is.* çıkınlamak үйлийн нэр.

çıkınlamak *(-i)* ваадагнах, вааданд боох.

çıkıntı *is.* 1. нэгэн зүйлийн урагшаа илүү гарсан хэсэг, төвийсөн хэсэг, товгор газар. 2. номын зах дээрх тэмдэглэл.

çıkıntılı *s.* товгор, төвгөр, овгор, гүвгэр, төвийсөн, товойсон.

çıkıntısız *s.* овгоргүй, товгоргүй, төвгөргүй, товойгоогүй.

çıkış *is.* 1. çıkmak үйлийн нэр. 2. гарах газар, гарц, гарах хаалга. "*Çıkış kapısı.*" Гарах газар, хаалга. "*Çıkış yolu.*" Гарах арга, арга зам, гарах зам. 3. аашлах, загнах, зандрах. 4. өөд газар, өгсүүр газар. 5. *ask.* дайралт, довлолт. 6. *(бөх)* дэвэх. 7. *sp.* гараа, гараанаас гарах. 8. (сургууль) төгсөх, төгсөлт. "*Çıkış belgesi.*" Төгсөлтийн баримт. **~ almak** ажлаас гарах, халагдах. **~ vermek** ажлаас гаргах, халах.

çıkışlı *is.* төгсөгч. "*Okulun 1930 yılı çıkışlıları toplandı.*" Сургуулийн 1930 оны төгсөгчид цугларав.

çıkışma *is.* çıkışmak үйлийн нэр.

çıkışmak *(-e)* 1. аашлах, загнах, зандрах. 2. хүрэх. "*Param çıkışmadığı için arkadaşımdan borç aldım.*" Миний мөнгө хүрэхгүй учраас найзаасаа мөнгө зээллээ.

çıkıştırma *is.* çıkıştırmak үйлийн нэр.

çıkıştırmak *(-i)* хүргэх.

çıkıt, -ğı *is.* bk. çıkak.

çıkma *is.* 1. çıkmak үйлийн нэр. 2. тагт,

балкон. 3. номын зах дээрх тэмдэглэл. 4. гарсан, гаралтай, гарал үүсэлтэй. 5. хуучин, хэрэглэсэн.

çıkmak, -ar *(-den)* 1. гарах. *"Evden çıkmak."* Гэрээс гарах. 2. гарах, авах, гаргаж авах. *"Sütten yağ çıkar."* Сүүнээс тос гардаг. 3. гарах, төгсөх. *"Enstitüden bu sene mi çıktınız?"* Та институтыг энэ жил төгссөн үү? 4. салах, хагацах, салж явах, явах. 5. хугацаа дуусаж гарах. *"Hastaneden çıkmak."* Эмнэлэгээс гарах. *"Ceza evinden çıkmak."* Шоронгоос гарах. 6. хийгдэх, явагдах, бүтэх, биөлэх, гүйцэлдэх. *"İşler çabuk çıkmıyor."* Ажил урагшлахгүй байна. 7. хасагдах, хороогдох. 8. сугарах, гарах, салах, мултрах. *"Bəbəğin patiği çıktı."* Нялх хүүхдийн бойтог нь сугарчихлаа. 9. *mec.* зарах, зарчих, зарцуулах, хэрэглэх. *"Para çıkmak."* Мөнгө зарах. 10. ямар нэгэн байдалд байгааг илэрхийлнэ, байх, болох. *"Borçlu çıkmak."* Өртэй болох. *"Kârlı çıkmak."* Ашиг олох. *"Alacaklı çıkmak."* Авлагатай болох. 11. гарах, дээр гарах, өгсөх, авирах. *"Dağa çıkmak."* Уулан дээр гарах. *"Merdiven çıkmak."* Шатаар өгсөх. 12. гарах, илрэх, тодорхой болох, олдох. *"Sularda bakteri çıktı."* Усанд бактери олдов. 13. уулзах, уулзалт хийх, бараалхах. *"Bakana çıkmak."* Сайдад бараалхах. 14. аз таарах, хожих. *"Piyonga çıkmak."* Хонжворт сугалаа хожих. 15. явах, одох, мордох. *"Yola çıkmak."* Замд гарах. 16. (шийдвэр, тогтоол) гарах. 17. гэнэт гарч ирэх, тааралдах, таарах, тулгарах. 18. үнэтэй байх. 19. (жүжгийн) дүрд тоглох. 20. хүрэх, очих, хүрч очих. 21. газар хөл тавих. 22. тарах, түгэх, дэлгэрэх, дуулдах, сонсогдох. 23. ...тай болох, гарах. *"Bayramın son günü her iki kadının da işleri çıkmıştı."* Баярын сүүлчийн өдөр хоёр эмэгтэйд хоёуланд нь ажил гарав. 24. гарах, анхилах, ханхлах, үнэртэх. *"Buradan pis kokular çıkıyor."* Эндээс өмхий үнэр ханхалж байна. 25. өрсөлдөх, уралдах, эн зэрэгцэх. 26. (байшин барилга) барих. 27. арилах, гарах. *"Lekə çıkmak."* Толбо арилах. *"Kumaşın boyası çıktı."* Даавууны будаг нь гарчихаж. 28. зан чанар, шинж чанар, онцлог нь сүүлд ойлгогдох, сүүлд гарч ирэх, илрэх, тодрох. *"O da ötekiler gibi soysuz çıktı."* Тэр ч бас нөгөөдүүл шигээ өөдгүй амьтан байна шүү дээ. 29. мултрах, сугарах, салах, хөндийрөх, ховхрох. 30. болох, гарах. *"Fırtına çıkmak"* шуурга дэгдэх. *"Soğuk çıkmak."* Хүйтэн болох, хүйтрэх. 31. худалдаанд гарах. 32. ургах, гарч эхлэх, соёолох, цухуйх, гарах. 33. гарах, өгөх, олгох. *"Maaş çıkmak."* Цалин олгох. *"Emir çıkmak."* Тушаал гарах. 34. (сар, улирал) өнгөрөх, дуусах. *"Mart çıkmak."* Гуравдугаар сар дуусах. *"Kış çıkmak."* Өвөл дуусах. 35. (үнэ) өсөх, нэмэгдэх. 36. өсгөх, үнийг нь нэмэгдүүлэх. 37. дуугаа өндөрсгөх. 38. мартах. 39. (сар, нар) мандах, гарах. 40. хэвлэгдэх, хэвлэгдэн гарах. 41. биөлэгдэх, биөлэх. *"İnsanın her gördüğü rüya çıkmaz ya!"* Хүний зүүд болгон биөлэгддэггүй шүү дээ! 42. сэртэндэх. 43. гарах, үүсэх. *"Anlaşmazlık çıkmak."* Зөрчилдөөн гарах.

çıkmaz *s.* və *is.* 1. мухар, мухар гудамж, мухар зам. *"Çıkmaz sokağı."* Мухар гудамж. 2. *s. mec.* мухардмал, тулгамдсан, аргагүйдсэн. **~a girmek** мухардах, мухардалд орох. **~a sokmak** мухардалд оруулах.

çıkrık, -ğı *is.* 1. худгийн цах. 2. ээрүүл, иг. 3. дамар хүрд блок.

çıktı *is. tic.* 1. бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний гарц, гарц. 2. хаягдал. *"Sanayi çıktısı."* Үйлдвэрийн хаягдал. 3. комьютерээс хэвлэж гаргах. 4. төгсөлтийн баримт.

çıldırasıya *zf.* галзуурмаар, галзуурах шахан, ухаангүй.

çıldırma *is.* çıldırmak үйлийн нэр.

çıldırmak *(nsz)* 1. галзуурах, солиорох. 2. ухаангүй хүсэх, ухаангүй дурлах, өдрийн бодол шөнийн зүүд болох, нойр хоолоо мартах, ихэд хүсэх.

çıldırtma *is.* çıldırtmak үйлийн нэр.

çıldırtmak *(-i)* çıldırmak үйлийн үйлдүүлэх хэв.

çılgın *s.* 1. галзуу, солиотой. 2. гайхалтай, гайхамшигтай, аугаа их. *"Çılgın bir âşk."* Аугаа их хайр дурлал. **~a dönmek** галзууртлаа уурлах, ухаангүй баярлах, хагартлаа баярлах.

çılgınca *s.* və *zf.* 1. галзуу юм шиг, солиотой юм шиг, ухаанаа алдталаа, ухаангүй. *"Ona çılgınca âşık oldum."* Би түүнд ухаангүй дурлачихжээ. 2. маш, дэндүү, учиргүй, тоймгүй.

çılgıncasına *zf.* галзуу, солиотой, галзуурсан юм шиг.

çılgınlaşma *is.* çılgınlaşmak үйлийн нэр.

çılgınlaşmak *(nsz)* галзуурах, галзуурсан мэт болох, солиорох.

çılgınlık, -ğı *is.* галзуурал, солио, ухаангүй байдал.

çın *s.* үнэн, зөв, лав, магад, гарцаагүй. **~ tutmak** батлах, нотлох, үнэн гэх.

çın çın *zf.* жин жин, дин дон.

cıngar *is. argo.* хэрүүл, хэрүүл шуугиан, хэрүүл дуруул. **~ çıkarmak** хэрэлдүүлэх, хэрүүл хийлгэх, хэрүүл шуугиан дэгдээх. **~ kopmak** хэрүүл болох, хэрүүл шуугиан дэгдэх.

çıngırak, -ğı *is.* бяцхан хонх, жижиг хонх. **çıngırağı çekmek** *argo.* мажийх, үхэх.

çıngıraklı *s.* 1. хонхтой. 2. *mec.* хангинам, дунгинасан, жингэнэсэн, цангинасан, чанга, дуутай.

çıngır çıngır *zf.* жин жин, дин дон.

çıngırdak, -ğı *is.* 1. бяцхан хонх. 2. шаржигнадаг тоглоом.

çıngırdama *is.* çıngırdamak үйлийн нэр.

çıngırdamak *(nsz)* дуугарах, хангинах, жингэнэх, цангинах.

çıngırdatma *is.* çıngırdatmak үйлийн нэр.

çıngırdatmak *(-i)* дуугаргах, цохих, хангинуулах, жингэнүүлэх, цангинуулах.

çıngırtı *is.* хангинах чимээ, жингэнэх авиа, цангинах дуу.

çınlama *is.* çınlamak үйлийн нэр.

çınlamak *(nsz)* 1. дуугарах, хангинах, жингэнэх, цангинах. "*Kulak çınlamak.*" Чих хангинах. 2. цуурайтах.

çınlatma *is.* çınlatmak үйлийн нэр.

çınlatmak *(-i)* çınlamak үйлийн үйлдүүлэх хэв.

çınsabah *zf.* өглөөгүүр, өглөө эртхэн.

çıpı çıpı *is.* (хүүхдийн хэлээр) усанд орох.

çıpıldak *s.* (хүүхдийн хэлэнд) нүцгэн, шалдан.

çıpır *is.* зомгол, цавчдас.

çıpır makinesi *is.* цавчигч машин.

çıplak *s.* 1. нүцгэн, шалдан. 2. үсгүй, халзан. 3. нүцгэн, өвс ургамалгүй. 4. хоосон, хөндий, ханхай. 5. *mec.* энгийн. "*Çıplak bir anlatım.*" Энгийн тайлбар. 6. *mec.* байгаа байдлаар нь, байгаагаар нь, ил, тод. 7. *is.* нүцгэн биеийн зураг. 8. *is.* ядуу хүн, үгийгүү хоосон хүн. **~ gözle görmek** энгийн нүдээр харах.

çıplak at *is.* зайдан морь.

çıplaklık, -ğı *is.* нүцгэн бие, шалдан бие, нүцгэн шалдан. **(bütün) çıplaklığıyla** байгаагаар нь, байгаа байдлаар нь, нууж хаах зүйлгүй, ил тод.

çıplanma *is.* çıplanmak үйлийн нэр.

çıplanmak *(nsz)* нүцгэрэх, нүцгэн болох, шалдлах.

çıra *is.* 1. хусны үйс. 2. *hlk.* тосон дэн, гийгүүлэгч.

çırak, -ğı *is.* 1. дагалдан, шавь. 2. туслах, туслагч.

çıraklık, -ğı *is.* 1. дагалдах, дагалдан сурах. 2. дагалдан болох, шавь болох. 3. дагалдангийн цалин, хөлс. 4. дагалдангуудын ажлын байр. **~ etmek** дагалдангаар ажиллах, дагалдах.

çırakman *is.* 1. бамбарын суурь, лааны суурь. 2. сүрэг загасыг эрэг, хөвөө рүү ойртуулан барихын тулд шөнө дөлөөр ноцоох гал. 3. лааны суурь, чийдэнгийн суурь.

çırçıplak, -ğı *s.* нүв нүцгэн, шав шалдан.

çırçır (I) *is.* хөвөн цэвэрлэх машин.

çırçır (II) *is.* 1. бяцхан булаг, шанд 2. *zool.* хээр талын хүрэлзгэнэ.

çırçırlama *is.* çırçırlamak үйлийн нэр.

çırçırlamak *(-i)* хөвөн цэвэрлэх.

çırılçıplak, -ğı *s.* 1. нүв нүцгэн, шав шалдан. 2. *mec.* маш энгийн, тов тод, ив илт.

çırnık, -ğı *is. den.* 1. жижиг завь. 2. нэгэн төрлийн том далбаат онгоц.

çırpı *is.* зомгол, зоргодос.

çırpılmak *(nsz)* çırpmak үйлийн үйлдэгдэх хэв.

çırpınma *is.* çırpınmak үйлийн нэр.

çırpınmak *(nsz)* 1. тэлчлэх, тэлчигнэх, тарчлахс. 2. (булчин шөрмөс) татах, татваганах, таталдах, татвалзах. 3. *mec.* сандрах, мэгдэх, самгардах. 4. дэрвэлзэх, далбаганах, сэрвэлзэх, сэрчигнэх, намилзах. "*Bayrak çırpınmak.*" Далбаа дэрвэлзэх. 5. *mec.* их зүтгэл гаргах, байдаг хүчээрээ чармайх, мэрийх, их хөлс хөдөлмөр гаргах.

çırpıntı *is.* 1. bk. çırpınma. 2. усны долгио, долгилоо, давалгаа.

çırpıntılı *s.* долгиотой, долгилоотой, давалгаатай.

çırpışma *is.* çırpışmak үйлийн нэр.

çırpışmak *(nsz)* (шувуу) далавчаа дэвэх, эрвэлзүүлэх, эрвэн дэрвэн хөдөлгөх.

çırpıştırma *is.* çırpıştırmak үйлийн нэр.

çırpıştırmak *(-i)* ингэс тэнгэс хийх, хайнга хийх, хааш яаш хийх.

çırpma *is.* **1.** çırpmak үйлийн нэр. 2. далд оёос.

çırpmak, -ar *(-i)* 1. сэгсрэх. 2. дэвэх. "*Kanatlarını çırpmak.*" Далавчаа дэвэх. 3. таших. "*El çırpmak.*" Алга таших. 4. нэг юмны үзүүрээс нь бага зэрэг тайрах, огтлох, танах, хяргах, хайчлах, өөлөх. 5. (хурдан, байнга) хутгах. 6. *mec.* хулгайлах.

çıt *is.* чад, тас. (юм хугарахад гарах дуу). **~ çıkarmamak** ямар ч чимээ гаргахгүй байх. **~ çıkmamak** ямар ч чимээ гарахгүй байх, чив чимээгүй байх, нам гүм байх. **~ yok** чив чимээгүй, нам гүм.

çıtak, -ğı *is. hlk.* 1. түлээчин. 2. *s.* танхай, балмад, зодоонч.

çıtçıt *is.* (хувцасны) дардаг товч.

çıtı pıtı *s.* бяцхан, эгдүүтэй.

çıtır çıtır *zf.* тас няс, тас тас, тас, чад, чад чад. **~ etmek** тас няс хийх, тас хийх, чад хийх, чад чад хийх, тачигнах. **~ konuşmak** дуржиганатал ярих.

çıtırdama *is.* çıtırdamak үйлийн нэр.

çıtırdamak *(nsz)* тас няс хийх, тас хийх, тас тас хийх, чад хийх, чад чад хийх, тачигнах.

çıtırdatma *is.* çıtırdatmak үйлийн нэр.

çıtırdatmak *(nsz)* çıtırdamak үйлийн үйлдүүлэх хэв.

çıtır pıtır *zf.* 1. (хүүхэд) шулганан (ярих). 2. *s.* бяцхан, эгдүүтэй.

çıtırdı *is.* тачигнах дуу, чад хийх чимээ, тас няс хийх дуу, тас хийх чимээ.

çıtkırıldım *is. ve s.* танхил, танхилхан, булбарай.

çıtlama *is.* çıtlamak үйлийн нэр.

çıtlamak *(nsz)* тас хийх, чад хийх.

çıtlatma *is.* çıtlatmak үйлийн нэр.

çıtlatmak *(-i)* 1. тас хийлгэх, чад хийлгэх, чад гэж дуугаргах. 2. *mec.* бүтүү хэлэх, ёгт сануулах, бүтүү дохио өгөх, бүтүү заах.

çıvdırma *is.* çıvdırmak үйлийн нэр.

çıvdırmak *(-i)* çıvmak үйлийн үйлдүүлэх хэв.

çıvgar *is. hlk.* зүтгэлцэх, хажууд нь хөллөсөн, зэрэгцээ. "*Çıvgar at.*" Хажууд нь хөллөсөн морь.

çıvlama *is.* çıvlamak үйлийн нэр.

çıvlamak *(nsz) hlk.* оргилон урсах, цутган урсах, олгойдон гоожих.

çıvmak, -ar *(nsz)* 1. үсрэх, харайх, дэгдэх, дэвхрэх, цовхрох. 2. ойх.

çıyan *is. zool.* зуун хөлт, жаран хөлт.

çıyanlık, -ğı *is.* урвах, тэрслэх. **~ etmek** урвах, тэрслэх.

çiçek, -ği *is. bot.* 1. цэцэг. 2. хээрийн цэцэг, талын цэцэг, цэцэрлэгт хүрээлэнгийн цэцэг. 3. *mec.* муухай хүн, өөдгүй амьтан, олиггүй хүн. 4. *tıp.* цэцэг өвчин, бодоо, цагаан бурхан. **~ açmak** 1) цэцэг цэцэглэх, дэлгэрэх. 2) урган гарч ирэх, цэцэглэн дэлгэрэх. **~ çıkarmak** цэцэг өвчнөөр өвчлөх, цагаан бурхан тусах. **~ gibi** цэцэг шиг, цэвэр цэмцгэр, гоё, сайхан, үзэсгэлэнтэй. **~ yağı** наран цэцгийн тос. **çiçeği burnunda** *tkz.* шив шинэхэн, шинэ, шинэхэн.

çiçek aşısı *is.* цэцэг өвчний вакцин.

çiçek bahçesi *is.* цэцэгт хүрээлэн.

çiçekçi *is.* **1**. цэцэгч, цэцэг худалдагч. 2. цэцгийн дэлгүүр.

çiçekçilik, -ği *is.* цэцэг тарих, цэцэг тарилга.

çiçek dürbünü *is.* калейдоскоп.

çiçekleme *is.* çiçeklemek үйлийн нэр.

çiçeklemek *(-i)* 1. цэцэг тарих. 2. цэцгээр чимэглэх, цэцгээр хүрээлэх.

çiçeklendirme *is.* çiçeklendirmek үйлийн нэр.

çiçeklendirmek *(-i)* 1. цэцэглүүлэх, цэцгээр чимэх. 2. цэцэглүүлэн харагдуулах, цэцэг мэт харагдуулах.

çiçeklenme *is.* 1. цэцэглэх, цэцэглэлт, цэцэг дэлбээлэх. 2. цэцэг дэлбээлэх цаг.

çiçeklenmek *(nsz)* цэцэглэх, цэцэг ургах, цэцгээр дүүрэх.

çiçekleşme *is.* çiçekleşmek үйлийн нэр.

çiçekleşmek *is.* цэцэг шиг болох, цэцгэн хэлбэртэй болох.

çiçekli *s.* цэцэгтэй, цэцгэн, цэцгийн зурагтай.

çiçeklik, -ği *is.* 1. цэцгийн ваар. 2. цэцгийн овоо, цэцгийн мандал, цэцгийн хэвтэш. 3. *bot.* цэцгийн суудал.

çiçek sapı *is.* цэцгийн иш, шилбэ.

çiçeksiz *s.* цэцэггүй.

çift *s.* 1. хос, хосмолжин, хоёр. "*Bir çift ayakkabı.*" Нэг хос гутал. "*Çift camlı.*" Давхар цонхтой. 2. эр эм хоёр, хос, хоёр, ижил. "*Bir güvercin çifti.*" Хос тагтаа. 3. хослох, хосолсон, хосолж хөллөсөн (морь). 4. хавчуур, хавчуурга, чимхүүр, хямсаа. **~ dikiş** 1) давхар оёос. 2) *argo.* ангидаа улирах. **~ görmek** хоёрлож харагдах, хоёр болж харагдах, нүд эрээлжлэх, согтох. **~ koşmak** хосолж хөллөх. **~ sürmek** газар хагалах. **~ kanatlılar** *is. zool.* хоёр жигүүртэн амьтад, хоёр дальтай амьтдын аймаг (ганцхан хос далавчтай ялаа батгана зэрэг жижиг амьтад).

çiftçi *is.* тариачин.

çiftçilik, -ği *is.* тариалан, газар тариалан, тариалангийн ажил. **~ etmek** газар тариалангийн ажил эрхлэх.

çift çubuk, -ğu *is.* 1. тариалангийн ажилд хэрэглэгдэх бүхий л машин техник, тоног төхөөрөмж. 2. эд хөрөнгө. **çift çubuğa gitmək** тариалангийн ажил эрхлэх.

çifte *s.* 1. давхар, хос, хоёр. 2. хоёр сэлүүртэй (завь). 3. *is.* хоёр амтай буу. 4. *is.* (адуу мал) өшиглөх, тийрэх, хайрах. **~ atmak** 1) (адуу мал) хойд хоёр хөлөөрөө тийрэх, хайрах, өшиглөх. 2) хоёр амтай буугаар буудах. **~ yemek** өшиглүүлэх, тийрүүлэх, хайруулах.

çiftehane *is.* шувууны байр, шувууны хашаа.

çifteleme *is.* çiftelemek үйлийн нэр.

çiftelemek *(-i)* 1. (адуу мал) хойд хоёр хөлөөрөө тангарах, хайрах, өшиглөх. 2. *(nsz) den.* (усан онгоц) хоёр дахь зангуугаа хаях.

çiftelenme *is.* çiftelenmek үйлийн нэр.

çiftelenmek *(nsz)* өшиглүүлэх, тийрүүлэх, хайруулах.

çifte nağra *is. müz.* яруу хэнгэрэг.

çifter çifter *zf.* хос хосоор, хоёр хоёроор.

çiftleşme *is.* үйлийн нэр.

çiftleşmek *(nsz, -le)* 1. хослох, ижилсэх, нийлэх. 2. (эр эм амьтад) нийлэх, гишгих.

çiftleştirme *is.* çiftleştirmek үйлийн нэр.

çiftleştirmek *(nsz, -le)* 1. хослуулах, ижилсүүлэх, нийлүүлэх. 2. нийлүүлэх, хээлтүүлэх, гишгүүлэх.

çiftlik, -ği *is.* эзэмшил газар, эдлэн газар.

çiftsayı *is. mat.* тэгш тоо.

çiftteker *is.* дугуй.

çifttekerci *is. ve s.* дугуйчин.

çift zamanı *is.* газар хагалах цаг.

çiğ *s.* 1. түүхий, дутуу болсон, дутуу чанасан. "*Çiğ et.*" Түүхий мах. 2. бодлогогүй, болчимгүй, зохисгүй, зүй бус. "*Çiğ söz.*" Болчимгүй үг. 3. (гэрэл, өнгө) нүд гялайм, цалайм, содон, хурц. **(birini) ~ ~ yemek** *mec.* барьж идэх. **~ düşmek** тааламжгүй сэтгэгдэл төрүүлэх, онцгүй санагдах, бүдүүлэг, зохимжгүй санагдах. **~ kaçmak (veya düşmək)** зохисгүй байх, зүй бус байх, таарамжгүй байх, болчимгүй байх. **çiğ yemedim ki karnım ağrısın** хэрэг хийсэн биш дээ ямар, ю унаас айхав.

çiğleşme *is.* çiğleşmək үйлийн нэр.

çiğleşmək *(nsz)* 1. болчимгүй загнах, бодлогогүй хандах, зүй бус харьцах, зохисгүй хандах. 2. бүдүүлэг зан гаргах, эрээ цээргүй загнах.

çiğneme *is.* çiğnemək үйлийн нэр.

çiğnemek *(-i)* 1. зажлах, хивэх. 2. гишгэх, гишгэлэх, дайрах. 3. *mec.* (хууль дүрэм) зөрчих, улан доороо гишгэх, үл тоомсорлох, захирагдахгүй байх. 4. *mec.* ноёрхох, захирах.

çiğnenme *is.* çiğnenmek үйлийн нэр.

çiğnenmək *(nsz)* 1. çiğnemek үйлийн үйлдэгдэх хэв. 2. *mec.* эзлэгдэх.

çiklet *is.* бохь.

çikolata *is.* шоколад.

çikolatalı *s.* шоколадтай.

çil (I) *is. zool.* цорхируу, хөх ногтруу, хөтүү.

çil (II) *is.* 1. сэвх, бөрт, бүдэн. 2. *s.* толботой, цоохор. 3. шинэ, гялалзсан, өнгөлөг.

çile (I) *is.* 1. мусульман шашинтай лам нарын дөчин өдөр. 2. зовлон, зовлон зүдүүр. **~ çekmek** зовох, зүдрэх, зовлон эдлэх, тарчлах. **~den çıkarmak** уурлуулах, уурыг нь хүргэх, галзууртал уурлуулах, хилэгнүүлэх. **~den çıkmak** 1) тэсэхээ байх, тэвчээрээ барах, тэвчээрээ алдах, галзууртлаа уурлах. 2) зовлон дуусах, зовлонгоос ангижрах, зовлон зүдүүрээс салах ороолт, утас, нарийн утас.

çile (II) *is.* 1. (утасны) ороомог, ороолт. 2. (нумны) хөвч.

çilek, -ği *is. bot.* гүзээлзгэнэ.

çilekeş *is.* ve *s.* зовж зүдэрсэн, зовлон эдэлсэн, зовсон, зовлон их үзсэн, зовж шаналсан (хүн).

çileli *s.* 1. зовсон, зовлонтой, зовлонт, зовж зүдэрсэн, зовлон их үзсэн. 2. зовлонд унагасан, зовлон учруулсан.

çilingir *is.* цоож урлагч дархан, төмөрч дархан, төмрийн дархан.

çilingirlik, -ği *is.* цоож хийх.

çilinger sofrası *is.* идээ зоогны ширээ.

çillenme *is.* çillenmek үйлийн нэр.

çillenmek *(nsz)* сэвхтэх.

çilli *s.* сэвхтэй, бөрт.

çim *is. bot.* таримал зүлэг, таримал өвс, ногоо.

çim çim *zf.* дуртай дургүй, дургүй, хүсэлгүй.

çimdik, -ği *is.* 1. çimdiklemek үйлийн нэр. 2. *s.* чимх. "*Bir çimdik tuz*" Нэг чимх давс. 3. *mec.* ёжтой үг, ёжилсон үг, чимхсэн үг. **~ atmak** (veya **basmak**) чимхэх.

çimdikleme *is.* çimdiklemek үйлийн нэр.

çimdiklemek *(-i)* 1. чимхэх. 2. чимхлэх, чимхлэн авах. "*Bu ekmeği kim çimdiklemiş.*" Энэ талхнаас хэн чимхэлж авав.

çimen *is.* 1. өвс, ногоо, ургамал ногоо. 2. гоньд.

çimenli *s.* өвстэй, ногоотой, өвс ногоотой.

çimenlik, -ği *is. ve s.* өвс ногоотой, өвстэй, ургамал ногоотой (газар).

çimento *is.* цемент, гахиур. "*Çimento fabrikası.*" Цементийн үйлдвэр.

çimentolama *is.* çimentalamak үйлийн нэр.

çimentolamak *(-i)* цементлэх.

çimentli *s.* цементтэй, гахиуртай.

çimentosuz *s.* цементгүй, гахиургүй.

çimleme *is.* çimlemek үйлийн нэр.

çimlemek *(-i)* ногоожуулах, зүлэгжүүлэх, ногоо тарих.

çimlenme *is.* çimlenmek үйлийн нэр.

çimlenmek *(nsz)* 1. ногоорох, хөхрөх. 2. ногоо ургах, сүеэлэх. 3. *(mec)* хумслах, жавших. 4. бага багаар авч идэх, тамшаалж идэх.

çimmek *(nsz) hlk.* шумбах, шунгах.

Çinçe *z. is.* Хятад хэл.

çinçilya *is.* шиншилла, үнэт үслэг арьстай, зөөлөн, мөнгөлөг үстэй нэгэн мэрэгч амьтан.

Çingene *z. is.* 1. цыган үндэстэн, цыган хүн. 2. *s. mec. (çingene)* харамч. **~ pembesi** 1) тод ягаан өнгө, хурц ягаан өнгө. 2) *s.* тод ягаан, тод ягаан өнгөтэй, хурц ягаан.

Çingenece *z. is.* 1. цыган хэл. 2. *s.* ve *zf.* цыган шиг, цыган маягаар.

çingeneleşme *is.* çingeneleşmek үйлийн нэр.

çingeneleşmek *(nsz)* харамлах, харамч зан гаргах.

Çin gülü *is. bot.* камелли.

çini *is.* 1. шаазан, шаазан эдлэл. 2. *s.* шаазан, шаазангаар хийсэн.

çinici *is.* шаазан хийгч, шаазан эдлэлийн худалдагч.

çinicilik, -ği *is.* шаазан эдлэлийн урлаг.

çinili *s.* шаазан, шаазантай, шаазангаар бүрэгдсэн.

çinko *is. kim.* 1. цайр. 2. *s.* цайран, цайраар хийсэн, цайрт.

çinkograf *is.* цайр барч.

çinkografi *is.* цайраар бар хийх.

Çinli *öz. is. ve s.* 1. хятад хүн, нангиад хүн. 2. хятад, нангиад, хятадын, хятад үндэстний.

çintiyan *is. hlk.* эмэгтэй хүний шалбуур өмд, шарваар өмд.

çiriş *is.* цавуу.

çirişleme *is.* çirişlemek үйлийн нэр.

çirişlemek *(-i)* цавуу түрхэх.

çirişlenme *is.* çirişlenmek үйлийн нэр.

çirişlenmek *(nsz)* цавуу түрхэх.

çirişli *s.* цавуутай, цавуу түрхсэн.

çirkef *is.* 1. угаадас. 2. *s.* булай, ой гутмаар, зэвүүрхэм, дур гутам, жигшүүртэй, олиггүй.

çirkin *s.* 1. муухай, царай муутай. 2. муухай, зохисгүй, эвгүй, шударга бус, жигшим, булай. 3. бохир (ажил).

çirkinleşme *is.* çirkinleşmek үйлийн нэр.

çirkinleşmek *(nsz)* 1. муухай болох, царай алдах. 2. булай авирлах, жигшмээр аашлах, зохисгүй загнах.

çirkinlik, -ği *is.* 1. муухай үзэмж, муухай байдал. 2. бузар явдал, муухай хэрэг, жигшмээр явдал.

çiroz *is.* 1. балмад загас, хар амар загас, хатаасан балмад загас. 2. *mec.* их туранхай, яс арьс болсон (хүн).

çiselemek *(nsz)* шивэрэх, шивэр шивэр орох. "*Yağmur çiseliyor.*" Бороо шивэрч байна.

çis *is.* ургамлын шүүс, шим.

çise *is. hlk.* шивэрээ бороо.

çiseleme *is.* çiselemek үйлийн нэр.

çiselemek *(nsz)* бороо шиврэх, бороо шивэрч орох, бороо шивэр шивэр орох.

çiseme *is.* çisemək үйлийн нэр.

çisemek *is.* bk. çiselemək.

çisenti *is.* шиврээ бороо.

çiş *is.* (хүүхдийн хэлэнд) шээс. **~ etmek** шээх. **~i gelmek** шээс нь хүрэх.

çişik, -ği *is. hlk.* бүжин, бүжинхэй.

çit (I) *is.* хашаа, хороо, хайс.

çit (II) *is. hlk.* 1. даавуу. 2. толгойн алчуур.

çitileme *is.* çitilemek үйлийн нэр.

çitilemek *(-i)* үрэх, нухах, үрж угаах.

çitleme *is.* çitlemək үйлийн нэр.

çitlemek *(-i)* 1. самар цөмөх. 2. хашаа барих, шивээлэх, хороолох.

çitme *is.* çitmək үйлийн нэр.

çitmek *(-i)* 1. холбох, залгах, нийлүүлэх. 2. сүлжин нөхөх, цойлдох, нөхөөс тавих, нөхөх. 3. үрэх, нухах, үрж угаах.

çivi *is.* хадаас. **~ gibi** 1) тэсвэртэй, хатуужилтай, өлчир. 2) хүйтэн. **(el, ayak** və **parmak) ~ gibi olmak** хөлдөх, хөлдөх шахах, бээрэх, даарах. **~ kesmek** бээрэх, даарах, осгох, жихүүцэх. **~ kestirmek** даруулах, бээрүүлэх, осгоох, жихүүцүүлэх. **~ sokmak** саад учруулах, саад болох, төвөг учруулах.

çivileme *is.* çivilemək үйлийн нэр.

çivilemek *(-i, -e)* 1. хадаасаар хадах. 2. *mec.* бүлэх, шаах, алах, хороох. 3. хөдөлгөөнгүй зогсоох, хөдөлгөөнгүй суулгах, хадаастай юм шиг орхих 4. гөлрөх, ширтэх 5. *mec.* тогтоох, байрлуулах, хадах, бэхлэх.

çivilenme *is.* çivilənmək үйлийн нэр.

çivilenmek *(nsz)* 1. хадаасаар хадагдах. 2. *mec.* хөдөлгөөнгүй зогсох, хөдөлгөөнгүй суух, хадаастай юм шиг байх, хадагдах.

çiviletme *is.* çiviletmek үйлийн нэр.

çiviletmek *(-i)* хадаас хадуулах.

çivili *s.* 1. хадаастай. 2. хадагдсан. 3. *is.* нэгэн төрлийн спортын зориулалттай гутал, хадаастай гутал.

çivisiz *s.* хадаасгүй, хадаагүй.

çivit, -di *is.* хөх зос, хөхөц.

çivitleme *is.* çivitlemək үйлийн нэр.

çivitlemek *(-i)* цагаан хэрэглэлийг хөхөцтэй усанд зайлах.

çivitli *s.* 1. хөх зостой, хөхөцтэй. 2. хөхөцтэй усанд зайлагдсан.

çivit mavi *is.* хөх өнгөс.

çivitsiz *s.* хөхөцгүй, хөхөцтэй усанд зайлагдаагүй.

çiy *is.* шүүдэр.

çiyleme *is. hlk.* шиврээ бороо.

çiylemek *(nsz)* бороо шиврэх, бороо шивэр шивэр орох.

çizdirme *is.* çizdirmək үйлийн нэр.

çizdirmek *(-i, -e)* çizmək үйлийн үйлдүүлэх хэв.

çizelge *is.* хүснэгт.

çizgə *is.* диаграмм, график, жишиг зураг.

çizgi *is.* **1.** шугам, зураас. 2. байдал, төрх, хэлбэр. *"Yüz çizgisi."* Нүүрний төрх. 3. *mat.* үүсгэгч шугам. 4. *mec.* үндэс, суурь. 5. *mec.* хил, хязгаар, зааг. **~ çekmek** 1) шугамдах, шугам татах, зураас зурах. 2) *mec.* дуусгавар болгох, төгсгөл болгох, дуусгах.

çizgi film *is. sin.* хүүхэлдэйн кино

çizgileme *is.* çizgilemək үйлийн нэр.

çizgilemek *(-i)* шугамдах, шугам татах, зураас зурах.

çizgili *s.* шугамтай, шугамдсан, зураастай, зурагдсан.

çizgilik, -ği *is.* шугам зургийн самбар.

çizgi ölçek, -ği *is.* хураангуй хэмжээ, хураангуйлсан хэмжээ, масштаб.

çizgi resim, -smi *is.* зураасан зураг.

çizgisel *s.* шугамын, зураасан.

çizgisiz *s.* шугамгүй, зураасгүй.

çizi *is.* 1. bk. çizgi. 2. шан, ховил, гурви, анжисны мөр, хагалмай. 3. *mec.* зан, харьцаа.

çizik, -ği *s.* 1. зурагдсан, зүсэгдсэн. 2. *is.* bk. çizgi.

çizim *is. mat.* шугам зураглал.

çizinti *is.* шалбархай.

çizme (I) *is.* түрийтэй гутал.

çizme (II) *is.* çizmək үйлийн нэр.

çizmeci *is.* гуталчин.

çizmek *(-i)* 1. шугамдах, шугам татах, зураас зурах. 2. зурах, зураг зурах. 3. дүрслэн өгүүлэх, дүрслэн бичих. 4. зурах, зүсэх, урах. 5. дээгүүр нь зурах, баллах, хасах, дарах. *"Bu iki kelime gereksizdir, çiziniz."* Энэ хоёр үг хэрэггүй, дарчих.

çizmeli *s.* түрийтэй гуталтай.

çoban *is.* 1. малчин. 2. Сугар гариг. **~ köpeği** хоточ нохой.

çobanaldatan *is. zool.* тэмээн хараацай, шөнийн хараацай.

çobanlık, -ğı *is.* 1. мал хариулах. 2. малчны хөдөлмөрийн хөлс, цалин. **~ etmek** мал хариулах.

Çoban Yıldızı *z. is. astr.* Сугар гариг.

çocuk, -ğu *is.* 1. хүүхэд. *"Çocuk bahçesi."* Хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн. *"Çocuk bakıcısı."* Хүүхэд асрагч, асрагч эх. *"Çocuk bezi."* Манцуй, өлгий, ороолт, хүүхдийн даавуу. *"Çocuk yuvası."* Цэцэрлэг, ясли. 2. үр хүүхэд, үр. 3. бага насны хүүхэд, балчир хүүхэд. 4. залуу эр, хүү. 5. хүүхдээрээ, томоогүй, томоо суугаагүй, хүүхэд шиг (хүн). 6. (ахимаг хүмүүсийн хооронд) насаар дүү хүн. 7. хал үзэж хашир суугаагүй, залуу, дадлага туршлагагүй (хүн). **~ aldırmak** үр хөндүүлэх, зулбуулах. **~ düşürmek** зулбах. **~ dünyaya getirmek** хүүхэд төрүүлэх. **~ gibi** 1) хүүхэд шиг, гэнэн, цайлган. 2) хүүхдээрээ, хүүхэд шиг, хүүхэд зантай, хүүхдэрхүү (нас бие гүйцсэн хүн). **~ gibi sevinmek** хүүхэд шиг баярлах, хүүхэд шиг хөөрөх. **~ işi** амархан ажил, хялбар

ажил. ~ **oyuncağı** 1) ялигүй, үл ялих, шалихгүй, өчүүхэн зүйл. 2) амархан ажил, хялбархан ажил. ~ **yapmak** хүүхэдтэй болох. ~ **yetiştirmek** хүүхэд хүмүүжүүлэх, хүүхэд өсгөх. **çocuğu olmak** хүүхэдтэй болох, хүүхэд төрөх.

çocuk bilimci *is.* хүүхдийн эмнэл зүйч.

gonca *is.* цоморлиг, гөлөг, нахиа.

gondol *is.* гондол, нэгэн төрлийн завь.

goril *is. zool.* мич, горилл бич.

göbek, -ği *is. anat.* 1. хүйс, хүй. 2. тарган гүзээ. 3. (улс, хотын) төв, дунд хэсэг. 4. (зарим ногооны) гол. "*Lahana göbeği.*" Байцааны гол. 5. үе, үр удам, хойч үе. 6. дунд хэсэг, дунд тал, гол. 7. (замын) тойрог. **~ adı** шинэ төрсөн хүүхдийн хүйг нь таслах үед өгсөн нэр. **~ atmak** 1) бүсэлхийгээрээ хөдлөн бүжиглэх. 2) их баярлах, ихэд хөөрөх. **~ bağlamak** таргалах, гүзээ суух.

göbeklenmek *(nsz)* таргалах, гүзээ суух.

göbekli *s.* гүзээтэй, тарган гүзээтэй.

göç *is.* нүүдэл, шилжин суулт, нүүдэл суудал, цагаачлал. **~ etmek** нүүх, шилжин суух, нүүдэл суудал хийх, цагаачлах.

göçebe *is.* 1. нүүдэлчин, хэсүүлчин, тэнүүлч. 2. *s.* нүүдлийн, хэрмэл, тэнэмэл. "*Göçebe kuşlar.*" Нүүдлийн шувууд. "*Göçebe hayatı.*" Нүүдлийн амьдрал.

göçebelik, ği *is.* нүүдэл, нүүдлийн амьдрал.

göçmek, -er *(-den, -e)* 1. нүүх, нүүдэл суудал хийх. 2. (шувууд) нүүх, нүүдэл хийх. 3. *(nsz)* нурах, унах, нурж унах. 4. *(nsz)* үхэх, үгүй болох 5. суурьших, байрлах, суух.

göçmen *s.* 1. цагаачин, цагаачлагч. 2. нүүдлийн (амьтад).

göçük, -ğü *s.* 1. нурсан, унасан, нурж унасан (газар). 2. хөрсний суулт.

göğüs, -ğsü *is.* 1. цээж, хэнхдэг, (цээжний) хэнхэрцэг. 2. *mec.* хөх. **~ germek** улаан нүүрээр тулах, тэмцэх, тулах. **göğsü kabarmak** бахдах, бахархах, бардамнах, сэтгэл хангалуун байх.

gök, -ğü *is.* 1. огторгуй. 2. тэнгэр. 3. *s.* хөх цэнхэр. **~lere çıkarmak** магтах, тэнгэрт тултал нь магтах, амаа олохгүй магтах. **~ gürültüsü** тэнгэрийн дугарах дуун.

gökbilimci *is. astr.* одон орон судлаач.

gökbilim *is. astr.* одон орон судлал.

gökcismi *is. astr.* огторгуйн биетүүд.

gökçe *s.* 1. тэнгэрийн, огторгуйн. 2. хөх цэнхэр 3. сайхан, хөөрхөн.

gökdelen *is.* тэнгэр баганадсан барилга.

gökkuşağı *is.* солонго.

göktaşı *is. astr.* солир, солирын чулуулаг.

Göktürk *z. is. tar.* 6–гаас 8–р зууны үед Монгол болон Төв Азид амьдарч байсан хуучин Түрк улс, түрк үндэстэн.

gökyüzü *is.* тэнгэр, тэнгэр огторгуй.

göl *is. coğr.* нуур.

gölcük, -ğü *is.* жижиг нуур, цөөрөм.

gölek, -ği *is. hlk.* ус тогтсон газар, цөөрөм.

gölet *is. hlk.* жижиг нуур, усан сан, цөөрөм.

gölge *is.* 1. сүүдэр. 2. сүүдрэвч, халхавч, нөмөр. 3. сүүдэрлэлт, харлуулалт. 4. *mec.* дагуул, сүүдэр мэт дагадаг хүн. 5. *mec.* хамгаалал, өмгөөлөл, нөмөр, өмөг. "*Kendi gölgesi altına almak.*" Хамгаалалдаа авах, өмгөөлөлдөө авах, өмөг болох. **~ etmek** бараалах, халхлах, сүүдэрлэх, харанхуйлах, харанхуй болгох, бүрхэх, хаах. **~de bırakmak** (хэн нэгний) дээр гарах, давах, дарах, (хэн нэгнээс)давуу байх. **~de kalmak** нэр алдар нь алдаршаагүй байх, олны танил болоогүй байх, танил болоогүй байх.

gölgelemek *(-i)* 1. халхлах, бүрхэх, сүүдэрлэх, харанхуйлах, харанхуй болгох. 2. *mec.* сүүдэр гарган зурах, сүүдэрлүүлэх, харлуулах. 3. *mec.* (нэр төр, үнэ цэнийг нь) унагах, унтраах, муутгах.

gölgeli *s.* 1. сүүдэртэй. 2. *mec.* тод бус, ил бус.

gölgelik, -ği *is.* 1. сүүдэр газар. 2. сүүдрэвч, халхавч.

gömlek, -ği *is.* 1. цамц. 2. (номны) хавтас. 3. үе, үе удам. 4. дотуур цамц, дотуур хувцас. 6. (гэрлийн) бүрхүүл, бүрээс.

gömmek, -er *(-i, -e)* 1. оршуулах, булшлах, нутаглуулах, хөдөөлүүлэх. 2. булах, нуух. 3. *mec.* ...ээс урт наслах.

gömü *is.* булж нуусан эрдэнэс.

gömülmek *(nsz)* 1. булшлагдах, оршуулагдах. 2. шигдэх, шигдэж суух. 3. *(-e) mec.* үгүй болох, алга болох, үзэгдэхгүй болох, харагдахгүй болох. 4. булагдах, дарагдах.

gömülü *s.* 1. булаатай, булаатай байгаа, булагдсан байгаа, дарагдсан, газар доор булагдсан байгаа. 2. алга болсон, үгүй болсон, булагдсан. "*Denizin derinliklerine gömülü gemi.*" Далайн ёроолд живсэн усан онгоц.

gömüt *is.* оршуулга, шарил, булш.

gönderen *is.* илгээгч, явуулагч.

gönderici *is.* илгээгч, илгээж байгаа хүн, явуулж байгаа хүн.

gönderme *is.* илгээлт, илгээх, явуулах.

göndermek *(-i, -e)* 1. явуулах, илгээх. 2. гаргаж өгөх, үдэж явуулах, аян замд үдэх, үдэн гаргах.

gönenç, -ci *is.* элбэг дэлбэг байдал, хангалуун байдал, чинээлэг амьдрал, хангалуун амьдрал.

gönlünce *zf.* хүсэлтээр, хүссэнээр, хүссэн шиг.

gönül, -nlü *is.* 1. сэтгэл, зүрх сэтгэл, сэтгэл зүрх. 2. *mec.* хүсэл, эрмэлзэл, хүсэл эрмэлзэл. "*Okumaya gönlün var mı?*" Чамд сурах хүсэл байна уу? **~ almak (veya gönlünü almak)** 1) баярлуулах, баясгах. 2) аргадах, сэтгэлий нь засах, тайтгаруулах, тайвшруулах. **~ vermek (veya bağlamak)** чин сэтгэлээсээ хайрлах, сэтгэл зүрхээрээ холбогдох, хайртай болох. **~ü olmak** хүлээн зөвшөөрөх, таарамжтайд тооцох, сэтгэлд нийцэх, сэтгэл хангалуун болох, зевшөөрөл өгөх, дэмжих, сайшаах, дуртай байх.

gönüllü *s.* 1. сайн дурааараа, хүслээрээ, өөрийн хүсэлтээрээ, саналаараа. 2. их сонирхолтой. 3. *is.* хайртай хүн.

gönülsüz *s.* ve *zf.* хүсэлгүй, дургүй, сэтгэлгүй, хүчээр, дуртай дургүй.

göre *e.* 1. дагуу, тааруулан, тохируулан. "*Modaya göre giyinmiş.*" Моодонд тохируулж хувцасласан байлаа. 2. харвал, харахнээ, тооцв ол, –ээр бол. "*Onların dediğine göre bunların hepsi hikayeymiş.*" Тэдний хэлсэнээр бол энэ бүхэн үлгэр л юм байна лээ дээ./Тэдний хэлснийг сонсохнээ энэ бүхэн үлгэр л юм билээ. 3. асуув ал, хувьд. "*Bana göre ikisi de bir.*" Миний хувьд хоюулаа л адилхан./Надаас асуух юм бол хою улаа л адилхан.

görece *s.* харьцангуй.

görecelik, -ği *is.* харьцангуй (чанар). "*Görecelik kanun.*" Харьцангуйн онол.

görecilik, -ği *is. fel.* харьцангуйсгах үзэл (сургаал).

göreli *s.* холбоотой, харилцан уялдаатай.

görelik, -ği *is.* холбоо, харилцан уялдаа.

görenek, -ği *is.* ёс заншил, заншил, хэвшил, хэв заншил.

görev *is.* 1. үүрэг, үүрэг даалгавар. 2. албан үүрэг, албан тушаал. 3. *fizy.* (эрхтэн, эд эсийн) үүрэг. **~ almak** халах, огцруулах. **~in suistimali** албан тушаалаа буруугаар ашиглах.

görevlendirmek *(-i, -le)* үүрэг өгөх, үүрэг хүлээлгэх, үүрэг ноогдуулах.

görevli *s.* 1. үүрэг гүйцэтгэгч, үүрэгтэй. 2. *is.* албан хаагч, ажилтан.

görgü *is.* 1. ёс, ёс зүй, зүй ёс, ёс журам, ёс дүрэм. 2. дадлага, туршлага, хэрсүүжил. 3. харсан байх. "*Görgü tanığı.*" Гэрч, нүдээрээ харсан хүн, нүдээрээ үзсэн хүн.

görgülü *s.* 1. туршлагатай, дадлагатай, хашир, догь. 2. хүмүүжил боловсролтой, сургамжтай, ая дантай боловсорсон, хүмүүжсэн.

görgüsüz *s.* 1. туршлагагүй, дадлагагүй, юм үзээгүй, юм мэдэхгүй, мэдлэг багатай. 2. хүмүүжилгүй, сургаал муутай, бүдүүлэг, ая дангүй, дангүй.

görgüsüzlük, -ğü *is.* 1. туршлагагүй (байх), юм үзээгүй(байх), юм мэдэхгүй(байх). 2. ая дангүй явдал, дан мэдэхгүй байх, хүмүүжил боловсролгүй байх.

görkem *is.* сүрлэг байдал, сүр жавхлан, эрхэмсэг байдал.

görkemli *s.* сүрлэг, сүр жавхлантай.

görmek, -ür *(-i)* 1. харах, үзэх. 2. ойлгох, ухаарах. 3. уулзах, очиж уулзах. "*Bugün müdürü göreceğim.*" Өнөөдөр даргатай уулзана. 4. үнэлэх, дүгнэх. "*Durumu k tü g rdüm.*" Байдал муу гэж харлаа. 5. нүдээрээ харах, нүдээрээ үзэх, үзэж харах. 6. хийх, гүйцэтгэх. "*İş görmek.*" Ажил хийх. 7. *(-den)* авах, заалгах. "*Birinden ders*

g rmek." Нэг хүнээр хичээл заалгах. 8. тулгарах, амсах, үзэх.

görmez *s.* үе *is.* хараагүй, харах чадваргүй, сохор. **~den gelmek** хараагүй юм шиг өнгөрөөх.

görsel *s.* харааны.

görücü *is.* гэрлэх насны эрд бэр харахаар яваа хүн, зууч эхнэр, зууч эр.

görücülük, -ğü *is.* зуучлах, бэр харах.

görüm *is.* харах чадвар.

görümce *is.* хадам эгч, нөхрийн эгч, нөхрийн эмэгтэй дүү.

görünmek *(nsz, -e)* 1. үзэгдэх, харагдах. 2. санагдах, сэтгэгдэл төрүүлэх. "*Üzgün ve yorgun görünüyordu.*" Шаналсан, ядрангуй харагдаж байлаа. 3. шиг харагдах, адилхан байх.

görüntü *is.* 1. хий үзэгдэл, сүүдэгнэх. 2. *fiz.* дүр дүрслэл, тусгал, дүрс. 3. зураг, кино зураг. 4. үзэмж, газар нутгийн байдал, уул усны байдал, байгаль.

görünüm *is.* дүр төрх, дүрс байдал, харагдах байдал.

görünürde *zf.* гаднаас харахад, харагдаж байгаа нь, байгаа байдал нь.

görünüş *is.* 1. гаднах байдал, гадаад байдал, бараа, үзэмж. 2. үзэмж, газар нутгийн байдал, уул усны байдал, байгаль. "*Pencereden güzel görünüş görünüyordu.*" Цонхоор сайхан үзэмж харагдаж байв.

görünüşte *zf.* гаднах байдлаас нь харахад, дүр төрхөөс нь харахад.

görüş *is.* 1. үзэгдэл, харагдах, хараа. 2. *mec.* үзэл, бодол, үзэл бодол, санаа бодол. **~ açısı** 1) санал, үзэл. 2) харах чадвар, харж чадах хэмжээ хязгаар. **~ ayrılığı** зөрөлдөөн, зөрөө, санал зөрөх, өөр өөр үзэлтэй байх.

görüşme *is.* уулзалт, ярилцлага.

görüşmek *(-le)* 1. уулзах, ярьж хөөрөх, хөөрөлдөх. 2. *(-i)* хэлэлцэх, зөвшилцөх, хэлэлцэж ярилцах, шүүмжлэн хэлэлцэх. "*Bu sorunu daha geniş zamanda görüşmeli.*" Энэ асуудлыг арай тухтай үед хэлэлцэж ярилцах хэрэгтэй.

görüştürmek *(-i, -le)* уулзуулах.

gösterge *is.* 1. шинж, шинж тэмдэг. 2. заах тамдэг, заалт, тэмдэг, дүн, жагсаалт. 3. *fiz.* илрүүлэгч, индикатор.

gösteri *is.* 1. үзвэр, тоглолт. 2. жагсаал, цуглаан. 3. (санаа бодол) илэрхийлэл.

gösteriş *is.* 1. үзүүлэх, харуулах. 2. маяг, маяг гаргах, хуурмаг зан байдал, нүд хуурах явдал. 3. үзэмж, гаднах байдал, гадаад байдал. **~ yapmak** маяг гаргах, маяглах, хуурмаг загнах, (айлгаж, гайхуулж, сайрхахын тулд) нүд хуурах.

gösterişli *s.* сүртэй, сүр бараатай, үзэмжтэй, үзэсгэлэнтэй.

gösterişsiz *s.* 1. даруухан, жирийн, энгийн, сүргүй. 2. маяггүй, илүү дутуу аашгүй, янз бүйн маяггүй.

göstermek *(-i, -e)* 1. үзүүлэх, харуулах. 2. заах, үзүүлэх, зааж харуулах. "*Uzaktaki ağacı parmağıyla gösterdi.*" Тэртээ байгаа модыг хуруугаараа зааж харуулав. 3. тодорхойлох, харуулах, үзүүлэх. "*Bu söz onun iyi niyetini gösteriyor.*" Энэ үг нь түүний сайн санааг харуулж байна. 4. батлах, нотлох, батлан үзүүлэх, нотолж үзүүлэх. "*Bunu size göstereceğim.*" Би үүнийг та нарт нотлох болно. 5. сургах, заах, зааж өгөх, үзүүлэх, тайлбарлах. "*Yol göstermek.*" Зам заах. 6. хий гэж хэлэх, хий гэх, үүрэг даалгах. 7. *(-i)* сайхан харагдуулах, харагдуулах. "*Bu elbise seni güzel gösteriyor.*" Энэ даашинз чамайг сайхан харагдуулж байна. 8. *(-e) mec.* ширүүн байдлаар хариу өгөх.

göt *is. kaba.* 1. доод тал, ёроол. 2. бөгс. 3. *mec.* зориг зүрх, хүч чадал. **~ten bacaklı** намхан, намхан нуруутай.

götürmek *(-i, -den, -e)* 1. зөөх, зөөж аваачих, хүргэж өгөх, аваачиж өгөх, хүргэх. 2. *(-i, -e)* хамт явах, хажуудаа хэн нэгнийг авч явах. 3. үгүй болгох. 4. *(-i)* үхүүлэх, үхэлд хүргэх. "*Hastalık çok insanı götürdü.*" Өвчин олон хүнийг үхэлд хүргэсэн. 5. *(-i)* тэвчих, тэсвэрлэх, тэвчээд өнгөрүүлэх. 6. *(-i, -e)* хүргэж өгөх, дөхүүлж өгөх. "*Beni evime kadar götürdü.*" Намайг гэр хүртэл хүргэж өгсөн. 7. хүргэх, болгох, үр дагаварт хүргэх. 8. баригдах, баривчлагдах.

götürüm *is. hlk.* тэвчээр, тэсвэр.

götürümlü *s.* тэвчээртэй, тэсвэртэй, тэсвэр тэвчээртэй.

gövde *is.* 1. их бие, мухар бие, цээжин биө. 2. хүний бие. 3. гулууз. **~ye indirmek** *tkz.* ховдоглон идэх, их идэх.

gövdeli *s.* том биетэй, лаглагар хүн.

gövermek *(nsz)* ногоорох.

göz *is.* 1. нүд, харах эрхтэн. 2. харц 3. хэсэг, тасалгаа. "*Çantanın gözleri.*" Цүнхний тасалгаанууд. 4. нүх, цоорхой. "*İğnenin gözü.*" Зүүний нүх. 5. шургуулга, нүд. "*Masanın gözleri.*" Ширээний нүднүүд. 6. булаг, эх булаг. 7. цагаан хэл ам. "*Allah nazardan saklasın.*" Бурхан цагаан хэл амнаас хамгаалах болтугай. 8. нахиа. **~ açtırmamak** амсхийлгэхгүй байх, сэхээ авхуулахгүй байх, амраахгүй байх, амьсгаа авах завгүй байлгах, боломж олгохгүй байх. **~ alıcı** харц булаам, сэтгэл татсан, дур булаам, сэтгэл татам, гайхам сайхан, гуа үзэсгэлэн бүрдсэн, дур сэтгэл татах, сүндлэг, үзэсгэлэнтэй, харж ханашгүй. **~ almak** харц булаах, нүд булаах, сэтгэл татах, дур булаах, дур татах, анхаарал татах, сүндлэх. **~ ardı etmek** үл тоомсорлох, үл хайхрах, хэрэгсэхгүй байх, хайхрахгүй байх. **~ atmak** харах, үзэх, хальт харах, хальт үзэх, өнгөцхөн харах, гүйлгэн харах, гүйлгэн үзэх, гүйлгэн унших. **~ boyamak** нүд хуурах, мэхлэх, нүд алдуулах, залилах, эндүүрүүлэх. **~ damlası** нүдний дусаагуур. **~ değmek** цагаан хэл ам тусах. **~ dikmek** шунах, хорхойтох, өнгөлзөх, шунахайрах, атаархаж харах, өөрийн

болгох санаатай байх. "*Başkasının malına göz dikmek.*" Хүний юманд шунахайрах./Хүний юм руу өнгөлзөх. ~ **gezdirmek** 1) гүйлгэн үзүүлэх, гүйлгэж харах. 2) хальт харах, хальт үзэх, өнгөцхөн харах. ~ **hapsine almak** нүд салгахгүй байх, харц салгахгүй байх. ~ **kamaştırıcı** харж ханашгүй, гайхамшигтай, гялбаж унамаар, гоё сайхан, хурц, содон, нүд гялбуулам. "*G z kamaştırıcı bir güzellik.*" Харж ханашгүй сайхан. ~ **kamaştırmak** 1) нүд гялбуулах. 2) *mec.* гайхуулах, хачирхуулах, сэтгэл татах, дур булаах. "*Güzelliği ile göz kamaştırmak.*" Гуа үзэсгэлэнгээрээ гайхуулах. ~ **kararı** нүдэн баримжаа, багцаа, баримжаа. ~ **kırpmak** 1) нүд анивчих, анив хийх, ирмэх, цавчих. 2) нүд ирмэх, нүд имнэх. ~ **kulak olmak** 1) харах, сахих, харгалзах, халамжлах, санаа тавих, элбэрэх, арчлах, харж хандах. 2) мэдэхийг хичээх, чих тавин сонсох. ~ **önünde bulundurmak (veya tutmak)** анхааралдаа авч байх, анхааралдаа авах, анхаарах, санах, санаж явах, мартахгүй байх, харгалзах, бодолцох, тооцоолох. ~ **önüne getirmek** төсөөлөх, багцаалах, тухайлах. ~ **süzmek** талмайрах, талмиаран харах. ~ **ucuyla bakmak** нүднийхээ булангаар сэмхэн харах, хулгайгаар харах. **~den düşmek** хайр хишгийг алдах, нэрээ хугалах, хүндээ барах, хайр алдах, хайр даахгүй байх, итгэл алдах, итгэх аргагүй болох. **~den geçirmek** 1) унших, гүйлгэн унших. 2) тал бүрээс нь анхааралтай судлах, ширтэн харах, тал бүрээс нь харах, судлах, шинжлэх, хянан үзэх. **~den kaçırmak** анзааралгүй өнгөрөөчих, харалгүй өнгөрөөчих, үзэлгүй өнгөрөөчих, таг мартчихах. **~(ün)den kaçmak** үзэлгүй өнгөрөх, алдах, өнгөрүүлэх, харалгүй өнгөрүүлэх, ажихгүй өнгөрүүлэх, хараанд өртелгүй үлдэчих. **~den kaybolmak** нүднээс далдрах, далдрах, далд орох, алга болох, харагдахгүй болох. **~e almak** 1) зориглох, зүрхлэх, зориг гаргах, зүрх гаргах, аз үзэх, аз турших, шийдэх. 2) бодолцох, харгалзах, анхааралдаа авах. **~e batmak** 1) илт үзэгдэх, анхаарал татах, нүдэнд тусах, нүдэнд өртөх, ад болох, ад үзэгдэх. 2) нүдэнд аягүй үзэгдэх, зохимжгүй харагдах, нүдэнд хүйтэн харагдах. **~e çarpmak** анхаарал татах, содон харагдах, нүдэнд тусах, нүдэнд өртөх. **~e gelmek** цагаан хэл ам хүрэх, нүдний хор орох. **~e girmek** (ааш зан, авьяас чадвараараа) нүдэнд өртөх, итгэл олох, тоогдох, хайр хишиг хүртэх, таашаагдах, таалагдах, аятайхан санагдах, санаанд нийцэх, хайр хүлээх. **~leri kapanmak** 1) нүд аних, таалал төгсөх, нас барах, өөд болох, үхэх. 2) нүд нь анилдах, нойр нь их хүрэх. **~leri yaşarmak** 1) нүд нь цийлэгнэх, нулимс унагах, нулимс гүйлгэнүүлэх. 2) уярах, нүд нь дүүрэх. **~lerinden okumak** бодлыг нь тааварлаж мэдэх, санааг нь таах, харцнаас нь ойлгох. **~lerine inanamamak** нүдэндээ итгэж чадахгүй байх, итгэж ядах. **~lerini açmak** 1) сэрэх, нүдээ нээх. 2) ухаан орох, сэргэх. **~lerini alamamak** харц салгаж чадахгүй байх. **~lerini dikmek** анхааралтай харах, харц салгахгүй байх, хараа салгалгүй харах, ширтэх. **~ü açık gitmek** хүсэл нь бие лэлгүй нас нөгчих. **~ü açılmak** нүд тайлагдах, сайн мууг ялгаж эхлэх, ухаантай болох, ухаан орох, хашир суух. **~ü arkada kalmak** (орхисон эд зүйлдээ юм уу орхиод явж байгаа хүнд) санаа зовох, сэтгэл зовних, сэтгэл хямрах, тайван байж чадахгүй байх. **~ü arkada olmak** санаа зовох, сэтгэл зовох, сэтгэл түгших, тэвдэх, цаг үргэлж бодох. **~ü dalmak** гөлрөх, ширтэх. **~ü doymak** цадах, ханах, идэж ханах, хангалттай болох. **~ü doymamak** хомхойрох, ховдоглох, шунахайрах, ханахгүй байх, цадахгүй байх. **~ü kalmak** 1) сэтгэл хоргодох. 2) атаархах, шунах, хорхойтох. **~ü korkmak** айх, эмээх, хулчийх, зүрх алдах, зүрх хүрэхгүй байх, шантрах. **~ü olmak** шунах, хорхойтох, шунахайрах, санаархах, эрмэлзэх, сонирхох, их хүсэх. **~ü takılmak** ширтэх, ширтэж харах, гөлөрч харах. **~ü tutmak** итгэх, найдах, сэтгэлд нийцэх, сэтгэлд таарах, сэтгэлд таатай байх, аятайхан санагдах, сайхан сэтгэгдэл төрүүлэх. **~ü yememek** хийж зүрхлэхгүй байх, зүрх хүрэхгүй байх, өөртөө итгэлгүй байх, чадна гэдэгтээ итгэхгүй байх. **~ü yılmak** хулчийх, шантрах, сүрдэх, сэрвээдэх. **~ü(leri) yolda kalmak** нүдээ хөхөртөл харах. **~ün aydın** баяр хүргэе. **~ünde tütmek** их санах, санан уйтгарлах, санан гуниглах. "*İstanbul gözünde tüter.*" Станбулыг ихэд санан уйтгарлана. **~üne girmek** итгэл олох, тоогдох, хайр хишгийг нь хүртэх, таашаагдах, таалагдах, санаанд нийцэх, хайр хүлээх. **~üne kestirmek** 1) таалагдах, аятайхан санагдах, сэтгэлд нь нийцэх, сэтгэлд зохих, сэтгэлд таалагдах. 2) чадна гэж найдах, амжилтад хүрнэ гэж бодох, авьяас чадвартай гэж үнэлэх, амжилтад хүрэх хүн гэж бодох. **(birinin) ~ünü açmak** (хэн нэгний) үзлийг нь өөрчлөх, (хэн нэгэнд) зөвлөх, сануулах. **~ünü boyamak** нүдийг нь хуурах, залилах, хуурах, мэхлэх. **~ünü dört açmak** (хуурташгүйн тулд) сонор сэрэмжтэй байх, анхааралтай байх, сэргэлэн байх. **~ünü kırpmadan ичиж** зоволгүй, айж эмээлгүй. **~ünü korkutmak** айлгах, сүрдүүлэх, шантраах, зүрхийг нь үхүүлэх. **~ünü seveyim** (гуйлт, хайр энхрийлэлийг илэрхийлнэ) хайрт минь, хонгор минь, чамаас гуйя, хичээгээрэй, гуйя, гуйж байна, бурхныг бодож. **~ünün bebeği gibi sevmek** нүднийхээ цөцгий мэт хайрлах. **~ünün önünden gitmemek** мартаж чадахгүй байх, нүдэнд нь харагдаад салахгүй байх. **~ünün önüne gelmek** нүднийх нь өмнүүр өнгөрөх, нүдэнд нь харагдах, санагдах, дурсагдах, бодогдох. **~ünün yaşına bakmamak** огт өрөвдөхгүй, өрөвдөж хайрлахгүй, асгарах нулимсыг нь харалгүй.

gözakı *is. anat.* нүдний цагаан.

gözaltı *is.* баривчлага, хараа хяналт. **~na almak** баривчлах, хараа хяналтан дор байлгах.

gözbebeği *is. anat.* 1. нүдний цэцгий, хүүхэн хараа, хүүхэн нүд. 2. *s. mec.* эрхэм чухал, эрхэм нандин (хүн, эд зүйлс г.м).

gözcü *is.* 1. харуул, ажиглагч. 2. *hlk.* нүдний эмч.

gözdağı *is.* айлгах, сүрдүүлэх, мохоох, сүрдүүлэлт, айн сүргүүлэлт. **~ vermek** сүрдүүлэх, айлгах, айлган сүрдүүлэх.

gözde *s.* 1. шадар, дотно, дотнын, ивээгдсэн, хайртай, дуртай (хүн, зүйл). 2. *is.* хайр хүртсэн эмэгтэй, хайртай эмэгтэй, ивээгдсэн эмэгтэй.

göze *is. biy.* 1. эс. 2. *hlk.* булаг, усны эх булаг.

gözenek, -ği *is. biy.* 1. амьсгалын жижиг сүв, амьсгуур(ургамлын). 2. *anat.* сүв, сиймхий. "*Deri gözenekleri.*" Арьсны сүв. 3. нүх, сүв.

gözerimi *is. astr.* тэнгэрийн хаяа.

gözetici *s.* хянагч, харгалзагч, хамгаалагч, өмгөөлөгч.

gözetim *is.* 1. шалгалт, хяналт, үзлэг. 2. хамгаалт, өмгөөлөл, нөмөр, өмөг. 3. хараа хяналт.

gözetleme *is.* хянах, ажиглах.

gözetlemek *(-i)* 1. нууцаар харах, нууцаар ажиглах. 2. харж хянах, хянах, ажиглах.

gözetleyici is. хянагч, шалгагч, ажиглагч.

gözetmek *(-i)* 1. харах, хамгаалах, өмгөөлөх, халамжлах, асрах. 2. чухалчлан үзэх, анхааран үзэх, анхааралдаа авах, анхааралдаа авах. 3. хүлээх, сахих, анах. "*Uygun zamanı gözetmek.*" Тохиромжтой цаг хүлээх.

gözkapağı *is. anat.* зовхи, аньсага.

gözlem *is.* 1. ажиглал, ажиглалт, ажиглан шинжих, ажиглан шинжлэх, шинжлэл. 2. ажиглалт. 3. *astr.* ажиглалт.

gözlemci *is.* 1. ажиглагч, шинжээч. 2. ажиглагч.

gözleme (I) *is.* ажиглалт, ажиглал, ажиглах.

gözleme (II) *is.* бин, шарвин.

gözlemek *(-i)* 1. харах, харуулдах, хүлээх. 2. анхааралтай харах, ажиглах, ажих. 3. судлах, шинжлэх. 4. нууцаар харах, нууцаар ажиглах, сэмхэн харах.

gözlemevi *is. astr.* одон орныг судлах төв, одон орны оргил (одон орон, цаг уур зэргийг ажиглах тусгай төхөөрөмжтэй байшин).

gözleyici *is.* ажиглагч.

gözlü *s.* 1. нүдтэй. "*Yeşil gözlü.*" Ногоон нүдтэй. 2. тасалгаатай, нүдтэй, шургуулгатай. "*Bu masa üç gözlüdür.*" Энэ ширээ гурван нүдтэй. 3. нүхтэй.

gözlük, -ğü *is.* 1. нүдний шил. 2. (морины) нүдний саравч, нүдний хамгаалагч. **~ takmak** *tkz.* 1) нүдний шил зүүх. 2) сайн харах, анхаарах.

gözlükçü *is.* 1. нүдний шилний газар. 2. нүдний шил зардаг хүн, нүдний шилч.

gözlüklü *s.* нүдний шилтэй, нүдний шил зүүсэн, нүдний шил зүүдэг.

gözlüksüz *s.* нүдний шилгүй, нүдний шил зүүгээгүй, нүдний шил зүүдэггүй.

gözükmek *(nsz)* харагдах, үзэгдэх.

gözyaşı *is.* нулимс.

grafik *is.* зурмаг, хүснэгт, жишиг зураг, график.

grafit *is. jeol.* бал чулуу.

gram *is.* грамм.

gramer *is.* хэл зүй, хэлний зүй, дүрэм.

gramofon *is.* авиа тэмдэглүүр.

granit *is. jeol.* боржин чулуу.

gravür *is.* сийлбэр.

gravürcü *is.* сийлбэрчин.

gravyer *is.* Швейцарт хийдэг нэгэн төрлийн шаргал өнгөтэй, тослог бяслаг

grev *is.* ажил хаялт. **~ yapmak** ажил хаях.

grevci *is.* ажил хаягч.

greyfurt *is.* гашуун жүрж.

gri *is. ve s.* саарал, хөх саарал, хөх бор, бор, орог.

grip, -bi *is.* томуу, ханиад. **~ olmak** ханиад хүрэх.

grup, -bu *is.* бүлэг, хэсэг, групп.

gruplaşmak *(nsz)* хэсэг болох, бүлэг болох, групп болох.

guatr *is. tıp.* бамбай.

gudde *is. anat.* булчирхай.

guguk, -ğu *is.* хөхөө. **~lu saat** хөхөөтэй цаг.

gurbet *is.* харь газар, хүний нутаг, харь нутаг. **~e gitmek** харь одох, харь нутагруу явах, хүний нутаг руу явах. **~te olmak** харь газар байх, хүний нутагт байх, эх нутгаасаа хол амьдрах.

gurbetçi *is.* харь газар амьдардаг хүн, хүний нутагт амьдардаг хүн, эх нутгаасаа хол амьдардаг хүн.

gurbetçilik, -ği *is.* харь газар амьдрах, хүний нутагт амьдрах.

gurlamak *(nsz)* ходоод хоржигнон дуугарах.

guruldamak *(nsz)* ходоод хоржигнон дуугарах.

gurultu *is.* хоржигнох дуу, хүржигнэлт.

gurup, -bu *is.* жаргах, нар жаргах.

gurur *is.* 1. бахархал, бахдал, урдаа барих юм. 2. их зан, ихэрхэг зан, омог, бардам зан, сайрхал. **~ duymak** бахархах.

gururlanmak *(nsz)* бахархах, бардах.

gururlu *s.* 1. нэр төртэй. 2. их зантай, ихэрхэг зантай, биөэ тоосон, бардам.

gut *is. tıp.* тулай өвчин.

gübre *is.* бордоо.

gübrelemek *(-i)* бордох.

gücendirmek *(-i)* гомдоох, гутраах.

gücenmek *(nsz, -e)* гомдох, юм санах, гутрах.

güç (I) *s.* 1. хүнд, хүчир, хэцүү, бэрх, бэрхтэй. "*Eski yazıyı öğrenmek güç bir işti.*" Хуучин бичиг сурах бэрхтэй ажил байсан. 2. *zf.* арай хийж,

арай чамай, дөнгөн данган, үлгэн салган. **~üne gitmek** гомдох, урам алдрах, гутрах. **~ gelmek** хүнд байх, хэцүү байх, бэрх байх.

güç, -cü (lI) *is.* 1. хүч, чадал, хүч чадал. 2. хүчин чадал, чадвар.

güçbelâ *zf.* арай хийж, чуу чамай, арай муруй, арай чамай, дөнгөн данган, арай ядан, арай чуу, үлгэн салган.

güçleşmek *(nsz)* хэцүү болох, бэрх болох, бэрхтэй болох, хүндрэх.

güçlü *s.* 1. хүчтэй, чадалтай, хүч чадалтай. 2. *mec.* нөлөөтэй, хүч нөлөө ихтэй. 3. хүчтэй, ширүүн.

güçlük, -ğü *is.* 1. бэрхшээл, хүндрэл. 2. хүнд бэрх байдал, хүнд байдал, төвөг, бэрхшээл. 3. саад, төвөг.

güçsüz *s.* хүчгүй, чадалгүй, хүч чадалгүй, ядарсан.

güdü *is.* 1. түлхэц, хөдөлгөх хүч, өдөөгч шалтгаан, дотоодын түлхэх хүч. 2. шалтгаан, шалтаг.

güdüm *is.* удирдах ажил, удирдлага.

güfte *is.* дууны шүлэг, уянгын шүлэг.

güğüm *is.* зэсээр хийсэн усны сав.

gül *is. bot.* сарнай. **~ gibi geçinmek** 1) маш сайн ойлголцох. 2) сайхан амьдрах, боломжийн амьдрах.

güldeste *is.* цоморлиг, зохиолын цоморлиг.

güldürmek *(-i)* инээлгэх.

güldürücü *s.* инээдтэй, инээдмийн.

güle güle *zf.* 1. инээж. 2. (аз жаргалтай, баяр баясгалантай амьдраарай, эдлээрэй, хэрэглээрэй г.м) өрөөлийн үг. "*Güle güle kullanın.*" Эд нь хэврэг эзэн нь мөнх байг. "*Güle güle oturun.*" Байрандаа аз жаргалтай суугаарай.

güler yüz *is.* сайхан харьцаа, дотно эелдэг харьцаа. **~ göstermek** сайхан харьцах, эелдэг дотно харьцах.

gülistan *is. esk.* сарнайн цэцэрлэг.

gülkurusu *is.* хатсан ягаан сарнайн өнгө.

gülmek, -er 1. инээх, инээмсэглэх. 2. *(-e)* даажигнах, шоолох, дооглох, тохуу хийх.

gülücük, -ğü *is.* инээмсэглэл.

gülümseme *is.* инээмсэглэл.

gülümsemek *(nsz, -e)* инээмсэглэх.

gülünç, -cü *is.* инээдтэй, хөгтэй, хошин, хөгжилтэй.

gülüş *is.* инээмсэглэл, инээмсэглэх.

gülüşmek *(nsz)* инээлдэцгээх, инээлдэх, хөгжилдөх.

gümrük, -ğü *is.* 1. гаалийн татвар. 2. гаалийн газар. 3. гааль. **~ almak** гаалийн татвар хураах.

gümrükçü *is.* 1. гаальч, гаалийн ажилтан. 2. гаалийн зуучлагч.

gümrüksüz *s.* 1. гаалийн татваргүй. 2. гаалийн татвар төлөөгүй, хулгайн.

gümüş *is.* мөнгө, мөнгөн эдлэл. "*Gümüş ayarı.*" Мөнгөний сорьц.

gümüşlemek *(-i)* мөнгөлөх, мөнгөөр бүрэх, мөнгөөр чимэх.

gün *is.* 1. (нэг) өдөр. 2. нар. 3. нарны гэрэл, нарны туяа. 4. өдөр, өдрийн цаг. 5. цаг хугацаа. 6. сайхан өнгөрөөсөн цаг, аз жаргалтай өнгөрөөсөн цаг мөч. 7. он сар өдөр. **~ batması** нар жаргах. **~ doğmak** 1) өглөө болох, нар мандах, нар ургах. 2) аз завшаантай өдөр болох. **~ görmek** эрүүл саруул элбэг дэлбэг амьдрах, аз жаргалаар дүүрэн амьдрах. **~ü birliğine gitmek** нэг өдрөөр явах, өдөртөө яваад ирэх, өдөртөө очоод эргэж ирэхээр явах. **~ü birlik** өдрөөр, нэг өдрийн. **~ünde** өдөртөө, товлосон өдөртөө, яг товлосон өдөртөө.

günah *is.* 1. нүгэл. 2. (зарим өвөрмөц хэллэгт) хариуцлага. "*Günah benden gitti.*" Ямар ч байсан би хийх юмаа хийсэн үүнээс цааш би хариуцлага хүлээхгүй. 2. гэм, гэм буруу, гэм зэм. **~ çıkarmak** 1) (христиан шашинд) гэмээ хүлээх, гэмээ наминчлах, нүгэлээ наминчлах. 2) *mec.* гэмших, гэмээ хүлээх. **~ işlemek** нүгэл үйлдэх, нүгэл хийх. **~a girmek** нүгэл хийх, нүгэл үйлдэх. **~ını almak** буруугаар бодох, гэмгүй байхад нь буруушаах, сэжиглэх.

günahkar *s.* нүгэлтэй хүн, нүгэлтэн, нүгэлт, нүгэлтэй, хилэнцтэй, нүгэл хилэнцэт.

günahlı *s.* нүгэлтэй, хилэнцтэй, гэм буруутай.

günahsız *s.* нүгэлгүй, хилэнцгүй, гэмгүй, гэм буруугүй.

günaşırı *zf.* өнжөөд нэг, хоёр өдөрт нэг.

günaydın *ünl.* өглөөний мэнд!**günbatısı** *is.* баруун зүг, баруун.

güncel *s.* цаг тухайн, чухал, тулгарсан чухал, өнөөдөр чухал болсон.

güncelik, -ği *is.* өдрийн тэмдэглэл.

güncellik, -ği *is.* өнөөдөр чухал болсон зүйл, цаг тухайн, тулгарсан чухал, чухал.

gündelik, -ği *s.* 1. өдрийн, өдөр тутмын, өдөр бүрийн. 2. өдөр тутмын, өдөр бүр гардаг. "*Birkaç ay sonra Türkiyede ilk gündelik spor gazetesini çıkarıyor.*" Хэдэн сарын дараа Түркт анхны өдөр тутмын спортын сонинг гарав. 3. *is.* өдрийн цалин, өдрийн хөлс.

gündelikçi *is.* ve *s.* өдрөөр цалинждаг (хүн), өдөртөө хөлсөө авч ажилладаг (хүн).

gündem *is.* хуралд хэлэлцэх асуудал. **~e almak** хэлэлцэх хэргийг жагсаан тодорхойлох.

gündoğusu *is.* 1. зүүн, зүүн зүг. 2. зүүн зүгийн салхи.

gündüz *is.* 1. өдөр. 2. *zf.* өдөр, өдрийн цагаар.

güneş *is.* 1. *astr.* нар. "*Güneş gözlüğü.*" Нарны шил, хар шил. "*Güneş tutulması.*" Нар хиртэлт. 2. нарны гэрэл, нарны туяа. **~ batmak** нар жаргах. **~ doğmak** нар мандах, нар ургах. **~ sistemi** нарны систем.

güneşlenmek *(nsz)* нарлах, наранд шарах.

güneşlik, -ği *is.* 1. нарны халхавч, нарны шүхэр. 2. *s.* нартай, нар туссан (газар).

güney *is.* өмнө зүг, өмнө зүгийн.

güngörmüş *s.* 1. сайхан амьдарсан. 2. юм үзсэн, туршлагатай (хүн). 3. их хөгшин, өтөлсөн.

günlük, -ğü *s.* 1. өдрийн, хоногийн, нэг хоногийн. 2. хоногтой, ... өдөр өнгөрсөн, хоногийн, өдрийн. "*On günlük bebek.*" Төрөөд арав хонож байгаа хүүхэд./Арван хоногтой хүүхэд. "*Sekiz günlük gezi.*" Найман хоногийн зугаалга. 3. өдөр тутмын, өдрийн, өдөр тутам гардаг. "*Günlük gazete.*" Өдөр тутмын сонин. 4. *is.* өдрийн тэмдэглэл.

güpegündüz *zf.* гэгээн цагаан өдөр, гэгээн цагаан өдрөөр.

gür *s.* 1. өтгөн, шигүү, их. "*Gür saçlı.*" Өтгөн үстэй. 2. чанга, нижигнэсэн, хангинам, дунгинасан, жингэнэсэн, цангинасан. "*Gür ses.*" Хангинасан дуу, чанга дуу.

Gürcü *z. is.* Гүрж хүн, гүрж үндэстэн.

güreş *is. sp.* бөхийн барилдаан. **~ etmek** барилдах, бөх барилдах.

güreşçi *is. sp.* бөх.

güreşmek *(nsz, -le)* барилдах, бөх барилдах.

gürleme *is.* нүргээн, нижигнээн.

gürlemek *(nsz)* 1. нүргэх, хүнгэнэх. 2. гэнэт өнгөрөх, зуурдаар нас барах.

gürüldemek *(nsz)* нүргэлэх, их дуу чимээ гаргах.

gürültü *is.* 1. шуугиан, чимээ шуугиан. 2. *mec.* хөл үймээн, үймээн самуун. **~ çıkarmak** 1) чимээ шуугиан гаргах. 2) үймээн тарих, үймээн самуун дэгдээх.

gütmek, -der *(-i)* 1. мал хариулах, бэлчээрлүүлэх. 2. *mec.* удирдах, жолоодох. 3. *mec.* биелүүлэх гэж мэрийх, гүйцэлдүүлэх гэж оролдох. "*Amaç (hedef) gütmek.*" Зорилготой байх, санаатай байх. "*Kin gütmek.*" Өш санах, өшөрхөх.

güve *is.* цагаан эрвээхий.

güveç, -ci *is.* 1. хоолны шавар сав. 2. энэхүү саванд хийсэн хоол.

güven *is.* 1. итгэх, итгэл, итгэмж. 2. лав итгэх, бат итгэх. **~ beslemek (veya duymak)** итгэх, найдах, итгэж найдах. **~ kazanmak** итгэл олох. **~ vermek** итгэл төрүүлэх.

güvence *is.* 1. даалт, баталгаа. 2. барьцаа, дэнчин.

güvenceli *s.* баталгаатай.

güvencesiz *s.* баталгаагүй.

güvenç *is.* итгэл, итгэмж.

güvenilir *s.* найдвартай, найдлагатай, итгэлтэй, бат, лавтай, магадтай. "*Güvenilir bir kaynaktan.*" Лавтай эх сурвалжаас, магадтай мэдэх газраас.

güvenlik, -ği *is.* аюулгүй байдал.

güvenme *is.* итгэл, найдвар.

güvenmek (-e) 1. итгэх, найдах. 2. бардах, сайрхах, бардамнах, биеэ магтах, гайхуулах.

güvensiz *s.* итгэхгүй, итгэмжгүй, итгэлгүй, итгэдэггүй.

güvensizlik, -ği *is.* итгэхгүй байх, итгэлгүй явдал, найдлагагүй байх.

güvercin *is. zool.* тагтаа.

güverte *is.* усан онгоцны тавцан.

güvey, -i,-si *is.* шинэ хүргэн, хүргэн.

güya *zf.* шиг, мэт, юм шиг, гэж үү?, гэнэ, бололтой, бодвол, бодоход, байх.

güz *is.* 1. намар. 2. *astr.* өсөн сарын 22 ноос арван хоёр сарын 21 хүртэлх хугацаа.

güzel *s.* сайхан, гоё сайхан, гоё, хөөрхөн, царайлаг, сайн, зөв зохистой. **~ sanat** дүрслэх урлаг.

güzelleşmek *(nsz)* сайхан болох, хөөрхөн болох, гоё болох.

güzellik, -ği *is.* 1. гуа үзэсгэлэн, гоо сайхан. 2. сайн зан, сайн сэтгэл, буянт сэтгэл, зөөлөн сэтгэл, нялуун үг, наалинхай зан.

güzellikle *zf.* аятайхан, эвтэйхэн, сайн дураар, хүслээрээ, саналаараа, зөөлөн, зөөлхөн, эелдэг байдлаар.

güzergâh *is.* 1. аялах зам, дайран өнгөрөх газар, явах чиглэл. 2. зам дагуу. 3. буурчийн газар.

güzide *s.* 1. шилмэл, сонгомол, шилсэн. 2. *is.* боловсорч гэгээрсэн хүн, шилдэг хүн.

güzün *zf.* намар, намар цагт, намрын улиралд.

Ğ

ğ, Ğ Түрк цагаан толгойн ес дэх үсэг. Зөөлөн **g** үсэг гэж нэрлэдэг. Үгийн эхэнд болон үгийн эцэст орохгүй.

H

haber *is.* 1. мэдээлэл, мэдээ. 2. мэдээ (төлев из, радиогийн). 3. мэдлэг. **~ almak** мэдээ авах, мэдэх, мэдээлэл авах. **~ vermek** мэдэгдэх, дуулгах, мэдээ өгөх, мэдээлэх, сонордуулах, хэлэх, мэдээ хүргэх. **~i olmak** мэдэх, мэдэж байх.

haberci *is.* 1. мэдээ хүргэгч, улаач. 2. *mec.* цондон, шинж. 3. мэдээлэгч, мэдэгдэгч.

haberdar *s.* ve *is.* мэдээлэлтэй, мэдээлэл авсан, мэдлэгтэй.

haberleşmek *(nsz, -le)* бие биедээ мэдэгдэх,

харьцаатай байх, харилцан холбоотой байх, бичилцэх, харилцах.

hac, -cı *is.* 1. зарим шашинтнууд ариун гэгээн газруудаар жилийн тодорхой саруудад зочилж очих. 2. хаж мөргөл (мусульман шашинд хийх ёстой таван үргийн нэг, арабаар зилхижжэ сард Араб улсын Мөкка хотод байрлах Кабэд мөргөл хийхээр явах). **~a gitmek** мөргөл хийхээр явах.

hacı *is.* 1. хаж (Мөкка хот орж мөргөл хийгээд ирсэн лал хүн). 2. ариун газруудаар явсан христиан хүн.

hacıyatmaz *is.* дондогмаа (тоглоом).

hacim, -cmi *is.* эзэлхүүн, багтаамж.

haciz, -czi *is. huk.* хөрөнгө битүүмжлэх, хөрөнгө ашиглахыг хорих. **~ emri** хөрөнгө битүүмжлэх тушаал, хөрөнгө ашиглахыг хорисон тушаал. **~ kararı** хөрөнгө битүүмжлэх шийдвэр, хөрөнгө ашиглахыг хорисон шийдвэр. **~ koymak** битүүмжлэх, хөрөнгө ашиглахыг хорих, хөрөнгө хураах.

haç *is.* загалмай, хэрээс.

Haçlılar *z. is. tar.* Загалмайтнууд.

had, -ddi *is. esk.* 1. хязгаар, зах хязгаар, хил. 2. зэрэг, хэм хэмжээ, цадиг, хир хэмжээ, хир чинээ. **haddini bilmek** өөрийнхөө чадлыг мэдэх, цадигаа мэдэх, хир хэмжээгээ мэдэх. **~ini bilmez** цадиггүй, хэр хэмжээгээ мэдэхгүй, хирээ мэдэхгүй, хирээ мэдэхгүй хэтрүү зан ааштай.

hadde *is.* цулих суурь машин.

hademe *is.* үйлчлэгч.

hadım *is.* тайган, засмал эр. **~ etmek** агтлах, засах.

hadise *is.* үйл явдал, хэрэг. **~ çıkarmak** хэрэг тарих.

haf *is. sp.* хагас хамгаалагч.

hafız *s.* 1. хамгаалагч. 2. Коран судрыг бүхэлд нь цээжээр мэддэг, уншдаг хүн.

hafıza *is.* ой, ой ухаан.

hafif *s.* 1. хөнгөн, хөнгөхөн. 2. амар, хялбар. "*Hafif bir iş.*" Хялбар ажил. 3. хөнгөмсөг. "*Hafif bir kadın.*" Хөнгөмсөг эмэгтэй. 4. (хоол, хүнс) хөнгөн, амархан шингэдэг. 5. бага нөлөөтэй, зөөлөн. "*Hafif içki.*" Зөөлөн архи 6. хүнд биш. "*Hafif bir baş ağrısı.*" Толгой бага өвдөх. 7. чухал биш, онц биш, хөнгөн. 8. сул, дорой, тааруухан. "*Hafif bir ses.*" Сул дорой дуу хоолой. 9. хөнгөн, хөнгөрсөн. 10. амархан сэрдэг, сэргэг. "*Uykusu çok hafif.*" Нойр нь сэргэг.

hafiflemek *(nsz)* 1. хөнгөрөх. 2. (нөлөө, хүч) багасах. 3. тайвшрах, уужрах, зовлонгоос ангижрах.

hafiflik, -ği *is.* 1. хөнгөн байдал. 2. тайвшрах, хөнгөрөх. 3. хөнгөмсөг байдал.

hafifmeşrep, -bi *is.* хөнгөмсөг, хөнгөн хийсвэр (эмэгтэй).

hafifsemek *(-i)* үл ойшоох, үл тоох, үл тоомсорлох.

hafta *is.* долоо хоног. **~ içi** ажлын өдрүүд (даваа, мягмар, лхагва, пүрэв, баасан). **~ sonu** амралтын өдрүүд (бямба, ням).

haftalık, -ği *is.* ve *s.* 1. долоо хоног тутмын, долоо хоногт нэг удаа гардаг, долоо хоногийн. 2. *is.* долоо хоногийн хөлс.

haftalıkçı *is.* ve *s.* ажлын хөлсөө долоо хоногоор авч ажилладаг (хүн).

haham *is.* Еврэй шашны лам.

hain *s.* ve *is.* 1. урвагч, урван тэрслэгч. 2. хүн хорлох дуртай, хорлонтой, хорлон санаатай. 3. муу санаатай.

hainlik, -ği *is.* урвалт, урвах, итгэлийг эвдэх.

haiz *s.* ... тай, эзэмшсэн.

hak, -kkı (I) *is.* 1. эрх, хууль ёс, шүүх цааз. 2. шударга явдал, ёс зүй, зүй ёс. 3. эрх тэгш. 4. зарцуулсан хөдөлмөр, зориулсан хөдөлмөр. "*Ana hakkı ödenmez.*" Эхийн ачийг хариулж барашгүй. 5. хувь. 6. хөдөлмөрийн хөлс. 7. *s.* үнэн зөв, зөв зүйтэй, зүйтэй, үнэн. **~ etmek** 1) олох, хүртэх. 2) хийсэн муу зүйлийнхээ хариуг авах. 3) шагнуулах, шагнагдах. **~ kazanmak** эрх олж авах, эрхтэй болох. **~ vermek** зөвтгөх, –ний зөв гэх, зөв гэж үзэх, хүлээн зөвшөөрөх. **~kından gelmek** 1) (хүнд хэцүү ажлыг) амжилттай гүйцэтгэх, амжилттай дуусгах. 2) ялах, дийлэх, хариугаа авах, ешөөгөө авах, шийтгэх. **~ını aramak** шударга байхыг хүсэх, үнэн зөвийг эрэх, шударга үнэнийг шаардах. **~ını helâl etmek** өршөөх. **~ını ödemek** ачийг нь хариулах, тусыг нь хариулах. **~ını vermek** 1) хөдөлмөрийг нь зөв үнэлэх. 2) ёсоор нь хийх, бүрэн гүйцэд хийх, зүй ёсоор нь гүйцэтгэх. **~ını yemek** шударга бус хандах, хөдөлмөрийг нь үнэлэхгүй байх, хөлсийг нь өгөхгүй байх, эрхийг нь эзэрхэх. **~ıyla** ёсоор нь, зүй ёсоор нь, зөв.

hak, -kki (II) *is.* сийлбэр.

Hak, -kkı (III) *z. is.* Бурхан.

hakan *is.* 1. хаан, эзэн хаан. 2. цол хэргэм.

hakaret *is.* доромжлол, хараал, зүхэл, гутаасан үг, дайрсан үг. **~ etmek** доромжлох, гутаах, хараах, дайрах. **~e uğramak** доромжлуулах, хараалгах.

hakem *is.* 1. шүүгч, зарга таслагч, хөндлөнгийн шүүгч, хөндлөнгөөс таслагч. 2. *sp.* шүүгч. "*Hakem kararı.*" Шүүгчийн шийдвэр.

hakemlik, -ği *is.* 1. арбитраж, зарга таслах, шүүх, хөндлөнгөөс таслах, хөндлөнгөөс таслах явдал. 2. шүүгч (байх), шүүгчийн ажил үүрэг.

hakikat, -ti *is.* 1. үнэн, зөв. 2. үнэн магад нь, лав нь, чухам үнэн нь, үнэн зөв, гарцаагүй баримт, үнэн байдал, бодит байдал. 3. *zf.* үнэхээр, үнээр, нээрээ.

hakikaten *zf.* үнэхээр, жинхэнээсээ, чухамдаа, үнэндээ.

hakiki *s.* жинхэнэ, үнэн, бодит.

hâkim *is. esk.* 1. эзэн, эрх баригч. 2. шүүгч. 3. эрх мэдэлтэй, нөлөө бүхий. 4. давуутай байдаг, илүүтэй байдаг, давамгайлсан (байх), давуу

(байх), ноёрхох, ноёлох, зонхилох. 5. (сэтгэлээ, өөрийгөө) захирч чаддаг, барьж чаддаг (хүн). 6. дээрээс бүхэлд нь хардаг, бүхэлд нь харж болох. "*Denize hâkim bir köşk.*" Далайг, бүхэлд нь харж болдог харш. ~ **olmak** 1) давуу байх, давамгай байх, ноёрхох, ноёлох, зонхилох, голлох. 2) ноёрхох, эзэрхэх, нөлөөлөх. 3) мэдэх, сайн мэдэх.

hâkimiyet, -ti *is.* эрх мэдэл, ноёрхол.

hâkimlik, -ği *is.* 1. захирах, ноёрхох байдал, эрх мэдэл. 2. шүүлт, яллалт.

hakkında *e.* ve *zf.* тухай.

haklı *s.* 1. зөв, зүйтэй, зөв зүйтэй, үнэн зөв, шударга. 2. эрхтэй, зүй ёстой, зүйтэй. "*Eşit haklı.*" Тэгш эрхтэй, адил эрхтэй.

haksız *s.* ve *is.* 1. зөв биш, буруу, ташаа, алдаатай, шударга бус. 2. эрхгүй, хууль гүй, зүй бус. "*Haksız kazanç.*" Хууль бус орлого.

haksızlık, -ğı *is.* 1. үнэн шударга бус байдал, үнэн зөв биш байх. 2. шударга бус явдал, ёс бус байдал, зүй бус байдал. ~ **etmek** шударга бус загнах, зүй бус хандах.

hal (I) *is.* 1. байдал, төлөв. 2. байдал, зан байдал, зан ааш, зан авир, ааш байдал. 3. одоо цаг, одоо үе. 4. хүч, хүч чадал, тамир, тэнхээ, тэнхэл. "*Şimdi gezmeye çıkacak halim yok.*" Одоо надад зугаалахаар гарах тэнхэл алга. 5. *mec.* бэрх явдал, зовлон, зовлон бэрхшээл. "*Zavallının başına ne haller geldi.*" Хөөрхийд ямар ямар зовлон тохиолдсон гээч. ~ **hatır sormak** амар мэндий нь асуух, мэнд усы нь мэдэх, сайн муу нь асуух. ~ **olmak** хэцүү байдалд орох, хүнд байдалд орох, үхэх. ~**den anlamak** байдлыг ойлгох. ~**ine gelmek** шиг болох, ... байдалд хүрэх.

hal (II) *esk.* 1. хайлах, хайлуулах. 2. хүнд бэрх байдлаас гарах, үр дүнд хүрэх.

hala *is.* авга эгч.

hâlâ *zf.* эдүгээ болтол, өдгөө болтол, өдгөө хүртэл, өдүй болтол, одоо болтол, өнөө хир нь, одоо хир нь, (тэр цагаас аваад) энэ цагийг хүртэл.

halat *is.* олс, татлага.

halayık, -ğı *is.* шивэгчин.

halbuki *bağ.* үнэндээ, ...боловч, ...хэдийв эр, тэгэвч, ...ч гэсэн, ...ч боловч, харин, гэтэл. "*Bana hiç birşey yapmıyorsun diyor, halbuki bu evi geçindiren kişi benim.*" Намайг юу ч хийхгүй байна л гэх юм үнэндээ энэ гэрийг авч яваа хүн чинь би шүү дээ.

halef *is.* залгамжлагч, өвлөгч.

hâlen *zf.* одоо хүртэл, одоо болтол, одоо ч гэсэн, одоо.

halı *is.* хивс.

haliç, -ci *is.* булан, тохой.

halik, -kı *z. s. esk.* 1. бүтээгч, үүсгэгч, бий болгогч. 2. *is.* z. Бурхан. "*İyilik et denize at, balık bilmezse Hâlik bilir.*" Буян хийгээд далайд хая, загас мэдэхгүй ч Бурхан мэднэ.

halihazır *is.* өнөөгийн байдал, одоогийн байдал, өнөөдрийн байдал.

halis *s.* цэвэр, хольцгүй.

halk *is.* 1. ард, ард түмэн, хүн ам. "*Halk arasında ...*" Ард түмний дунд ... 2. үндэстэн, ард түмэн. "*Yahudi halkı.*" Еврэй үндэстэн. 3. оршин суугчид, хүн, хүмүүс, улс. 4. жирийн ард, эгэл ард.

halka *is.* цагираг, хүрээ, тойрог, дугуй.

halkçı *s.* ард түмний төлөө зүтгэгч.

hallaç, -cı *is.* ноос савагч.

halletmek *(-i)* 1. шийдэх, шийд гаргах, шийдв эрлэх. 2. нэг тийш болгох, зохицуулах, учрыг олох, шийдэх. 3. *mec.* бодох. 4. хайлуулах.

halsiz *s.* тэнхэлгүй, тамиргүй, тамир тэнхээгүй, сул, хүч чадалгүй.

halsizlik, -ği *is.* сул дорой байдал, хүч тэнхээгүй байдал, тэнхэлгүй байдал.

halt *is.* 1. холих, хутгах, хольж хутгах. 2. *tkz.* тэнэг юм хэлэх, тэнэг юм хийх. ~ **etmek** тэнэг юм хэлэх, тэнэг юм хийх.

halter *is. sp.* хүндийн өргөлт.

ham *s.* 1. болоогүй, боловсроогүй, түүхий. "*Ham elma.*" Түүхий алим. 2. боловсруулаагүй, түүхий (эд). "*Ham madde.*" Түүхий эд. 3. *mec.* дэмий, хий хоосон. 4. *mec.* ёс дүрэм мэддэггүй, бүдүүлэг (хүн). 5. сул, дорой.

hamak, -ğı *is.* дүүжин ор.

hamal *is.* ачаа зөөгч.

hamam *is.* саун, ууранд орох газар. ~ **gibi** их халуун, шатаамаар халуун.

hamamböceği *is. zool.* хар жоом.

hamarat *s.* аж ахуйч эмэгтэй, ажилсаг эхнэр, ажилд сайн эмэгтэй.

hamdetmek *(-e)* Бурханд талархах.

hamile *is.* ve *s.* жирэмсэн, биө давхар, хөл хүндтэй. ~ **kalmak** жирэмсэн болох, хөл хүндтэй болох.

hamilelik, -ği *is.* 1. жирэмслэлт, жирэмсэн байх. 2. жирэмсний хувцас.

hamlaç, -cı *is.* гагнуур.

hamlaşmak *(nsz)* сул дорой болох, үлбийх.

hamle *is.* 1. дайралт, дайрах, цохилт, цохих. 2. (шатарт) нүүдэл, нүүдэл хийх.

hammadde *is.* түүхий эд.

hamsi *is. zool.* далайн жараахай, жараахай.

hamur *is.* 1. зуурсан гурил. 2. (цаасны) чанар, төрөл. 3. түүхий, сайн болоогүй (талх, гурилан хүнс). ~ **açmak** гурил хавтгайлах, гурил элдэх.

hamurişi *is.* гурилан хүнс, нарийн боов.

hamursuz *is.* Еврэйчүүд, баярааран хийдэг нэгэн төрлийн нарийн боов.

han (I) *is. tar.* хан, хаан.

han (II) *is.* 1. буурчийн газар, дэн буудал. 2. ажлын байр, плаза.

hancı *is.* ажлын байр түрээслүүлэгч, ажлын байрны эзэн.

hançer *is.* чинжаал хутга.

hane *is.* 1. гэр, байр, сууц. 2. гэр бүл, гэрийнхэн. 3. нүд, бяцхан шүүгээ. 4. *mat.* тооны орон.

hanedan *is.* 1. сурвалжит гэр, язгуурт гэр бүл. 2. *s. esk.* сурвалжит, сурвалжтай, язгуур угсаатай, язгуур гаралтай, язгуурт. 3. *s. mec.* еглегч, харамгүй сэтгэлтэй.

hangar *is.* нисэх онгоцны байр.

hangi *s.* 1. аль, ямар. "*Hangi adam?*" Аль хүн? "*Hangi yıl?*" Хэдэн он?, Аль жил?. 2. аль ч, ямар ч. "*Hangi kitabı açarsan bulursun.*" Аль ч номыг нээсэн олж харна.

hanım *is.* 1. хатагтай, эмэгтэй, бүсгүй, эхнэр, эм хүн. 2. авааль эхнэр, эхнэр, хань. 3. *s.* эелэг зөөлөн. 4. язгууртан эмэгтэй, ахай, авхай.

hanımefendi *is.* хатагтай, авхай, ахайтан.

hanımeli *is. bot.* далан хальс.

hani *zf.* алив нөгөө? хаана байна, хаана, юу болов, яасан, яав, яагаав, санаж байна уу, тэгээгүй юу

hantal *s.* 1. нүсэр том, бүдүүн бааран, болхи том. 2. болхи, бүдүүлэг, эв хавгүй.

hap *is.* 1. үрлэн эм, шахмал эм. 2. *argo.* нэг удаа татах хар тамхи. **~ı yutmak** *tkz.* хүнд байдалд орох, хэцүүдэх.

hapis, -psi *is.* 1. хорио, хорих. 2. хорих ял. 3. шорон, гяндан, хар гэр. 4. шоронгийн хоригдол. **~ yatmak** шоронд орох, хоригдох.

hapishane *is.* шорон, гяндан, хар гэр.

hapsetmek *(-i, -e)* 1. шоронд хорих, гянданд хорих. 2. *mec.* хязгаарлах, хорих. 3. бүтүү газар түгжих, хорих, гаргахгүй байх.

hapşırmak *(nsz)* найтаах.

harabe *is.* 1. балгас, эвдэрхий хот, хотын суурь үлдэгдэл. 2. үлдэгдэл, балгас, нурсан зүйл, нурж унаж байгаа юм, нурах шахсан зүйл.

haraç, -cı *is.* 1. алба, гувчуур, татвар, алба гувчуур. 2. шалж авах менгө, албадан авах мөнгө. **haraca kesmek** хүчээр менге авах, менге татах.

haram *s.* 1. (шашны) хориглосон, хорисон, хориотой, нүгэлт. 2. *is. mec.* хорио, цааз, хорио цааз. "*Haram para.*" Буруу замаар олсон менгө.

harap, -bı *s.* 1. нурсан, сүйрсэн, нурж унаж байгаа, эвдэрхий. 2. ядарсан, сульдсан, эцэж ядарсан 3. *esk.* согтуу, их согтсон, ухаан балартлаа согтсон **~ etmek** нураах, эвдэх, сүйтгэх.

hararet is. 1. халуун, дулаан. 2. цангаа, ангаа, цангах, ангах, ундаасах. 3. тэчьяадал. **~ basmak** 1) цангах, ангах, ундаасах. 2) халууцах.

hararetlenmek *(nsz)* 1. халуун нь нэмэгдэх. 2. ширүүсэх. "*Tartışma hararetlendi.*" Маргаан ширүүслээ.

hararetli *s.* 1. халуунтай. 2. хөөрсөн, хөхүүн, дүрэлзсэн, ширүүн, цогтой.

haraşo *is.* нэг төрлийн ноосны нэхээс.

harbi *s.* 1. сүмбэ (бууны дотрыг цэвэрлэх хэрэгсэл). 2. *s. mec.* шударга, голч, үнэнч, цэх шулуун, шулуун шударга, үнэн зөв. **~ konuşmak** үнэн зөв ярих, шулуун шударга ярих.

Harbiye *is.* Цэргийн сургууль, цэргийн акаде ми, офицерийн сургууль.

harcama *is.* 1. менге зарах, мөнге зарцуулах, менгө үрэх, зарлага. 2. үрлэг, зарлага, зардал.

harcamak *(-i)* 1. үрэх, менгө зарах. 2. зарцуулах, хэрэглэх. 3. *mec.* (хэн нэгнийг) үрэх, үрэн таран хийх, дуусгах.

harcanmak *(nsz)* (хөделмөр, менгө) зарагдах, зарцуулагдах.

harç, -cı *is.* 1. зардал, үрэгдэл. 2. телбөр, телеес, татвар, хураамж. 3. барилгын зуурмаг. 4. хоол амтлагч. 5. (хувцасны) гоёл, чимэглэл, гоёл чимэглэл. 6. бордоо, холимог бордоо.

harçlı *s.* 1. телбөртэй, хураамжтай. 2. чимэглэсэн, гоёл чимэглэлтэй (хувцас).

harçlık, -ğı *is.* халаасны мөнгө.

harçsız *s.* төлбергүй, хураамжгүй.

hardal *is. bot.* гич ургамал.

harekat *is.* цэргийн довтолгоон, дайралт, манёвр.

hareket *is.* 1. хөдлех, хөделгөөн, хөдлел. 2. биеийн хөдөлгөөн. 3. ааш зан, зан ааш, зан байдал. 4. замд гарах, аян замд гарах. 5. хөделгеен. 6. газар хөдлөлт. 6. (галт тэрэг) хөдлех цаг. "*Hareket cetveli.*" Хөдлөх цагийн хуваарь. 7. хурд, аяс. **~ etmek** 1) аян замд гарах, хөдлех, замд гарах, мордох. 2) хөделгөх, биеэ хөдөлгөх. 3) аашлах, авир гаргах, авирлах, зан гаргах. "*Böyle hareket etme, sonra iyi olmaz.*" Битгий ийм авир гарга, дараа нь онцгүй болно. **~e geçmek** хийж эхлэх, хөдөлж эхлэх, ажилдаа орох.

hareketlenmek *(nsz)* хөдлех, хийж эхлэх, хөдөлж эхлэх, ажилдаа орох.

hareketli *s.* 1. хөдлех, хөдөлгеентэй, хөделгеент, эрчимтэй, идэвхтэй. 2. цовоо, сэргэлэн, хөнгөн, гавшгай, хөгжөөнтэй, хөгжилтэй.

harem *is. tar.* гарэм (Оттоман гүрний үед орд харшид байдаг байсан эхнэрүүдийн байр, лалын шашинтны эхнэрүүдийн байр).

harf *is.* үсэг. "*Moğol alfabesinde otuz beş harf vardır.*" Монгол цагаан толгойнд гучин таван үсэг байдаг.

harıl harıl *zf.* зогсолтгүй, тасралтгүй, бүх чадлаараа, бүх хүчээрээ, байдаг чадлаараа.

hariç, -ci *is.* 1. гадна, гадна тал. 2. гадаад орон, гадаад улс, харь газар, хилийн чанад. 3. *zf.* –аас(–ээс, –оос, –еес)гадна, бусад нь, бус нь. "*Turgut hariç, hepimiz kalacağız.*" Тургутаас бусад нь үлдэнэ.

harika *s.* ve *is.* 1. гайхамшигтай, гайхалтай (зүйл), ер бусын (зүйл), гайхамшиг. 2. *mec.* еегүй сайхан, өө сэвгүй, гайхамшигтай, гайхалтай.

harikulade *s.* 1. ер бусын, хосгүй, гайхалтай, гайхмаар, гайхамшигтай. 2. *ünl.* маш сайхан, гайхалтай сайхан.

haris *s.* шунахай, сувдаг, ховдог, хор шартай.

harita *is.* газрын зураг.

haritacı *is.* газрын зургийн мэргэжилтэн.

haritacılık, -ğı *is.* газрын зураг хийх, газрын зургийн зүй.

harlamak *(nsz)* 1. дүрсхийн асах, дүрэлзэх. 2. *mec.* дүрсхийх, дүрсхийн уурлах.

harman *is.* 1. тариа цохих, түгших, тариа хураах. 2. тариа цохих цаг, тариа түгших цаг, тариан талбай. 3. холимог. "*Çay harmanı.*" Цайны холимог. **~ etmek** холих, холимог хийх.

harmancı *is.* тариа цохигч, түгшүүрч.

harmanlamak *(-i)* 1. холих, холимог хийх. 2. эргэх, тойрох. 3. *den.* (усан онгоц) хэлтийн хевж явах.

harp, -bi (I) *is.* дайн.

harp (II) *is.* ятга, босоо ятга.

has *s.* 1. чанар болох, шинж болох, чанартай, угийн байдаг, өнеөх, өвермөц, онцгой. 2. цэвэр, хольцгүй, цул, хамгийн сайн чанарын. 3. *mec.* сайн чанарыг еертее агуулсан (хүн). 4. хааны, эзэн хааны. "*Has bahçesi.*" Эзэн хааны цэцэрлэг.

hasar *is.* гэмтэл, эвдрэл, хохирол. **~a uğramak** гэмтэх, эвдрэх.

hasarlı *s.* гэмтсэн, гэмтэлтэй, эвдэрсэн.

hasat, -dı *is.* 1. тариа хадах, тариа хадалт. 2. тариа.

haset, -di *is.* атаа, жөтее, атаа жетее, жетеерхөл, атаархал. **~ etmek** атаархах, жетеерхех.

hâsıl *s.* болсон, гарсан, гарч ирсэн, үзэгдсэн, үүссэн. **~ olmak** төрех, үүсэх, бий болох, гарах, гарч ирэх, болох.

hasılat *is.* 1. бүтээгдэхүүн. 2. орлого.

hâsılı *zf.* товч хэлэхэд, товчхон хэлэхэд, товчхондоо.

hasım, -smı *is.* 1. дайсан, естен. 2. ерселдөгч, негөө тал, ерселдөгч тал.

hasır *is.* 1. чийрс, сүлжмэл. 2. зэгсэн, зэгсээр хийсэн. "*Hasır sandalye.*" Зэгсэн сандал.

hasırotu *is. bot.* хулс, зэгс, нишингэ.

hasis *s.* 1. харамч, нарийн. 2. еедгүй муу, олиггүй.

hasislik, -ği *is.* 1. өедгүй байдал, олиггүй байдал. 2. харамлах, нарийлах.

hasret *is.* сангалзал, тэмүүлэл, тэсгэлгүй хүсэл, санасан гуниг, санасан уйтгарлал, санан гуних, санан уйтгарлах, уйтгарлан хүсэх. **~ çekmek** санах, мерөөдех, хүсэх, тэмүүлэх, санан гуних, санан уйтгарлах, уйтгарлан хүсэх. **~ kalmak** санах, санагалзах.

hassas *s.* 1. мэдрэмтгий, мэдрэц ихтэй. 2. эмзэг, уян сэтгэлтэй, эмзэг дотортой, соргог мэдрэлтэй, еентөгч, гомдомтгой. 3. нарийн, нарийн нягт, яг зөв, нарийн хэмжүүртэй (багаж). "*Hassas terazi.*" Нарийн жинлүүр.

hassasiyet *is.* мэдрэц, эмзэг дотор, уян сэтгэл, мэдрэмтгий байх, эмзэг байх.

hasta *s. ve is.* 1. евчтэй, өвчинтэй. 2. өвчтөн. 3. *tkz.* сэтгэл мэдрэлийн евчтэй, сэтгэцийн өвчтэй. **~ düşmek (veya olmak)** евчлөх, өвчин тусах.

hastabakıcı *is.* өвчтөн асрагч.

hastalanmak *(nsz)* евчлех, евчин тусах.

hastalık, -ğı *is.* өвчин.

hastane *is.* эмнэлэг.

haşarat *is.* шавж, хорхой шавж

haşhaş *is. bot.* намуу цэцэг (ихэнхдээ том улаан цэцэгтэй байдаг нэг зүйл евсерхег ургамал).

haşin *s.* танхай, балмад, дээрэлхүү.

haşir, -şri *is. esk.* 1. цуглах, беегнөх, беегнерех. 2. дэлхий сөнөх үед үхсэн хүмүүс дахин амилах газар.

haşlama *is.* 1. буцалгах, чанах. 2. *s. ve is.* чанасан, буцалсан, буцалгасан. "*Haşlama et.*" Чанасан мах.

haşlamak *(-i)* 1. чанах, буцалгах, чанаж болгох. 2. халуун усанд дүрэх. 3. (халуун ус) түлэх, ялзлах, ялз түлэх.

haşmet *is.* сүр, сүр жавхлан, сүрлэг байдал, эрхэмсэг байдал.

haşmetli *s.* 1. сүрлэг, сүртэй, сүр жавхлантай. 2. эрхэм дээдэс.

hat, -tta *is. esk.* 1. шугам, зураас. 2. *esk.* бичиг, гар бичиг. 3. зам, шугам. 4. цахилгаан шугам. 5. холбооны шугам. 6. хил, зааг, хязгаар. 7. нүүрний хэлбэр терх. 8. биеийн хэлбэр, галбир.

hata *is.* 1. алдаа, буруу. 2. андуурал, эндүүрэл. 3. нүгэл, хилэнц, гэм, буруу, алдаа. **~ etmek (işlemek** veya **yapmak)** алдаа хийх, алдах, алдаа гаргах. **~ya düşmek** андуурах, эндүүрэх.

hatalı *s.* алдаатай, буруу.

hatasız *s.* алдаагүй, зөв.

hatır *is.* 1. тогтоох, цээжинд хадгалах, ой, ой тогтоолт. "*Söylediğin şey hatırımda.*" Хэлсэн зүйлийг чинь би санаж байгаа. 2. сэтгэл, зүрх. 3. хайр, хайр хүндэтгэл. 4. байдал, мэнд, амар мэнд. **~ sormak** амар мэнд мэдэх, мэнд ус асуух, мэнд асуух. **~ı sayılır** 1) нилээд, нилээн, их. 2) нэр хүндтэй, чухал, хүндэтгэл хүлээсэн. **~ında tutumak** мартахгүй байх, санаж байх. **~ını kırmak** гомдоох, гутраах. **~ını sormak** амар мэнд мэдэх, мэнд ус асуух, мэнд асуух.

hatıra *is.* дурсамж.

hatırlamak *(-i)* санах, дурсах.

hatırlatmak *(-i, -e)* 1. санагдуулах, бодогдуулах. 2. сануулах.

hatırlı *s.* хүндтэй, нэр хүндтэй.

hatim, -mi *is. esk.* 1. дуусгах, эцэслэх, төгсгөх, дүүргэх. 2. Коран судрыг уншиж дуусгах.

hatip, -bi *is.* 1. илтгэгч, үг хэлэгч. 2. номлогч.

hatmetmek *(-i) esk.* 1. дуусгах, эцэслэх, төгсгөх, дүүргэх. 2. Коран судрыг уншиж дуусгах.

hatta *bağ.* харин ч бүр, дээрээс нь, үл барам, тэр ч байтугай, түүний дээр, нэмэрлэж, нэмэрт

нь, түүнээс гадна, түүнчлэн, тэрчлэн, түүгээр ч үл барам.

hatun *is.* 1. эмэгтэй, эмэгтэй хүн, бүсгүй, эхнэр. 2. *tar.* хатан.

hava *is.* 1. агаар, агаарын мандал, хийн бүрхэвч, атмосфер. "*Hava boşluğu.*" Агаарын хоосон орон зай. 2. цаг агаар, цаг уур, тэнгэр. "*Hava raporu.*" Цаг уурын мэдээлэл. "*Havada bir tek bulut yok.*" Тэнгэрт ямарч үүл алга. 3. уур амьсгал, улирлын байдал. 4. салхи. "*Bugün hava güzel olursa, yelkenli kalkacak.*" Өнөөдөр салхи гарвал дарвуулт онгоц хөдлөх болно. 5. хөгжмийн төрөл. 6. сэтгэл, сэтгэл санааны байдал. 7. төрөл, маяг, янз. 8. орчин, байдал, нөхцөл, уур амьгал. "*Dostluk havası.*" Нехерсег байдал, нехерсег уур амьсгал, нехерсег орчин. 9. дур булаам байдал, сэтгэл татах, дур булаам байх. "*Kız güzel değil ama havası var.*" Охин хеерхен биш боловч сэтгэл татна. **~ almak** 1) салхилах, цэвэр агаарт алхах. 2) уужрах, сэтгэл уужрах, сайхан цаг енгереех. **~dan sudan konuşmak** хэрэгтэй хэрэггүй юм ярих, хавийн юм хамж ярих. **~ya uçurmak** дэлбэлэх, тэслэх.

havaalanı *is.* онгоцны буудал.

havacı *is. ask.* 1. нисэх хүчны цэрэг. 2. агаарын тээврийн ажилтан.

havadar *s.* цэвэр агаартай.

havadis *is.* сонирхолтой мэдээ, анхаарал татсан мэдээ.

havai *s.* 1. агаарын. "*Havai fişek.*" Солют. 2. цайвар цэнхэр енгетэй.

maliyet *is. ekon.* еөрийн өртег (бараа үйлдв эрлэх ба худалдан авахад зарсан мөнгө). **~ fiyatı** өртөгийн үнэ.

mallanmak *(nsz)* хөрөнгежих, баяжих.

malt *is.* амуу соёолж.

malul *is.* эрэмдэг зэрэмдэг, тахир дутуу(хүн).

malum *s.* 1. мэдээжийн, мэдээжээр, мэдээж. 2. *is.* мэдээжийн зүйл. 3. *zf.* тийм, мэдээжийн, мэдээжээр, мэдээж, тодорхой, ойлгомжтой, эргэлзээгүй. 4. *gr.* үйлдэгч (үйл үг). **~ olmak** мэдрэгдэх, санагдах.

malumat *ç. is.* 1. мэдлэг, эрдэм мэдлэг, мэдэц, мэдээ, мэдээлэл. 2. *fel.* мэдлэг, мэдээлэл.

malzeme *is.* 1. хэрэглэгдэхүүн, (түүхий)эд, хэрэглэл, хэрэгсэл, материал. 2. мэдээ, мате риал.

mama *is.* хүүхдийн хоол.

mamafih *bağ.* түүний зэрэгцээгээр, үүний зэрэгцээ, ийм боловч, чингэвч, тэгэвч, яавч, тэгсэн ч, яасан ч, ийгээс, гэлээ ч гэсэн.

mamul, -lü *s.* ve *is.* хийсэн, бүтээсэн, үйлдв эрлэсэн (бараа, бүтээгдэхүүн).

mamur *s.* хөгжсөн, цэцэглэсэн, мандан цэцэглэсэн, элбэг дэлбэг, дэвжсэн, тохилог, тохинуун.

mana *is.* утга, утга санаа, утга учир. **~ çıkarmak** 1) урвуулж тайлбарлах, ташаа дүгнэлт хийх, хүний санаанд ороогүйг санах. 2) дүгнэлт хийх, утга гаргах. **~ ya gelmek** 1) утга илэрхийлэх. 2) утга гарах, утгатай байх.

manalı *s.* 1. утгатай, учиртай, утга төгөлдөр, ач холбогдол ихтэй. 2. *mec.* учиртай, учир утгатай. "*Manalı bakış.*" Учиртай харц.

manasız *s.* 1. утгагүй, учиргүй, учир холбогдолгүй. 2. *zf. mec.* утгагүй, учиргүй, шал дэмий, дэмий, үр дүнгүй, зохисгүй.

manastır *is.* хийд, хүрээ.

manav *is.* 1. жимс ногооны мухлаг, жимс ногоо худалддаг газар. 2. жимс ногооны худалдаачин, ногоочин.

manda (I) *is. zool.* одос, усны үхэр, буйвол.

manda (II) *is. huk.* мандат, захирах эрх.

mandal *is.* 1. түгжээ, оньс, цоожны оньс, дэгээ. 2. хувцасны хавчаар, хавчаар. 3. чавхтаст хөгжмийн чих, чих.

mandalina *is. bot.* 1. бэрсүүт жүржний мод. 2. бэрсүүт жүрж.

mandallamak *(-i)* 1. оньсоор түгжих, оньслох. 2. хавчаараар хавчих.

mandarin *is.* хятадын түшмэл, сайд.

mandater *s.* мандаттай, захирах эрхтэй.

mandolin *is.* мандолин.

manej *is.* 1. морин сургуульлт. 2. морин сургуулийн газар, сургуулийн талбай.

manevî *s.* оюуны, оюун ухааны, санаа сэтгэлийн, сэтгэл санааны, хийсвэр. **~ tazminat** *is. huk.* сэтгэл санааны нөхөн телберийн гомдол. **~ evlât** өргемөл хүүхэд, үрчилсэн хүүхэд.

maneviyat *is.* 1. хийсвэр зүйлс. 2. *mec.* сэтгэлийн хүч, сэтгэлийн дэм, дотоод эрч хүч.

manevra *is. ask.* 1. байлдааны сургууль, манёвр. 2. *mec.* манёвр, арга, арга мэх, арга зам.

manga *is. ask.* 1. анги, бүлэг, салаа. 2. дайны онгоцны командын байр.

mangal *is.* хоовон (нүүрс ноцоож хөлчөөх сав). **~ gibi yüreği olmak** эрэлхэг зоригтой байх, эр зоригтой байх, аймшиггүй байх. **~ kömürü** модны нүүрс.

mangan *is. kim.* манган, маргөнц, хүрэнз (хар хүрэн өнгийн төмерлег).

mani (I) *is. psikol.* ин. **büyüklük ~** ихсийн ин. (хөөрөх хий евчин, хөөрех ин).

mâni (II) *is. ed.* шүлэг. **~ söylemek** шүлэглэж хэлэх.

mâni,-i, -yi *is.* саад, тотгор, барцад. **~olmak** саад хийх, саад болох, тотгор болох, саатуулах.

manidar *s.* утгатай, учиртай, утга төгөлдөр.

manifatura *is.* бөс даавуу.

manifaturacı *is.* бөс даавууны худалдаачин.

manifesto *is.* 1. (усан онгоцон дахь ачаа тээшний) падаан, дагавар хуудас. 2. тунхаг, тунхаглал.

manikür *is.* гарын хумс засал. **~ yapmak** гарын хумс засах, хумс засал хийх.

mankafa *s.* тэнэг, моҳдог, ухаан муутай. 2. *hlk.* сахуутай, ямтай (морь).

manken *is.* 1. загвар өмсөгч, манекен. 2. хиймэл хүн, модон хүн (хувцас таруулан оёхын тулд хүний биеийн хэмжээгээр хийсэн модон загвар).

manolya *is. bot.* 1. замбага, мовь. 2. замбага цэцэг.

manometre *is. fiz.* маномөтр, даралт хэмжүүр (битүү саван дахь агаар, уур, хийн даралтыг хэмжих багаж).

mansiyon *is.* сайшаалын бичиг, магтсан үнэлэлт, сайшаасан үнэлэлт, сайшаал.

manşet *is.* 1. (цамцны) ханцуй, нударга. 2. сонингийн гарчиг.

manşon *is.* гарын дүгтуй, углуурга.

mantar *is. bot.* 1. мөөг. 2. илчүү мод, ховил мод, ховолт мод. 3. *tıp.* мөөгөнцөр. 4. хөвүүр, холбого. 5. *argo.* худал, санаанаасаа зохиосон зүйл, дэмий донгосолт. **~ atmak** *argo.* худал ярих, дэмий донгосох, санаанаасаа зохиох.

mantı *is.* манты (элдсэн гурилыг жижигхэн тасалж татсан махтай чимхэн хийсэн нэгэн төрлийн хоол).

mantık, -ğı *is.* 1. учир зүй, учир шалтгааны ухаан, логик. 2. дотоод зүй тогтоол, учир утга, учир, ухаан, бодол.

mantıkdışı *s.* утгагүй, утга учиргүй, учиргүй, логик бус.

mantıklı *s.* 1. ухаантай, ухаалаг, бодлоготой. 2. зүй тогтоолтой, зүйд нийцсэн.

mantıksal *s.* учир зүйн, логикийн.

mantıksız *s.* 1. ухаангүй, бодлогогүй. 2. утгагүй, утга учиргүй, авцалдаагүй, зөрелдөөнтэй.

manto *is.* манто (эмэгтэй хүний халхагар пальто).

manyak, -ğı *is.* 1. хийтэй, хөөрүү, инт, интэй хүн, донтой. 2. *mec.* солиотой, балай.

manyetik *s. fiz.* соронзон, соронзны, соронзот, соронзтой.

manyetizma *is.* 1. соронзон, соронзон чанар. 2. соронзон зүй. 3. ятгах, итгүүлэх, гипноз, ховс.

manzara *is.* 1. хараанд өртех зүйлс. 2. үзэмж, газар нутгийн байдал, уул усны байдал, байгаль. 3. *mec.* дүр, байдал, дүр байдал, дүр төрх, зураг, хөрөг. 4. газар нутгийн зураг, уул усны зураг.

manzaralı *s.* 1. үзэмжтэй. 2. сайхан үзэмжтэй.

maral *is. zool.* марал, эм буга.

marangoz *is.* мужаан, модоч, модны дархан.

maraton *is. sp.* марафон, холын явган уралдаан (42км 96м).

maraz *is.* 1. өвчин, эмгэг. 2. гай, гамшиг, гаслан, зовлон. 3. *mec.* олон ааштай, цамаан, голомтгой.

mareşal *is.* маршал, ерлөг.

margarin *is.* хиймэл тос, маргарин.

marifet *is.* 1. ур чадвар, чадвар, ур эрдэм, ур дүй, дүй. 2. зохисгүй авир, тааламжгүй хэрэг, зохисгүй ааш авир. *"Yaptığın marifeti, beğendin mi?"* Чи хийсэн юм аа хар! 3. *esk.* мэдлэг, мэдэц, эрдэм ухаан, шинжлэх ухаан.

marifetli *s.* ур дүйтэй, ур чадвартай, чадв арлаг.

marina *is.* жижиг моторт онгоцны зогсоол, дарвуулт онгоцны зогсоол.

mark *is.* марк (Гөрман, Финляндийн мөнгөний нэгж).

marka *is.* 1. тэмдэг, тэмдэглээ, худалдааны тэмдэг, брэнд. 2. толоон, тасалбар, металь тасалбар.

markalamak *(-i)* тэмдэглэгээ тавих, худалдааны тэмдэг тавих.

market *is.* дэлгүүр, өөртөө үйлчлэх дэлгүүр.

marki *is.* маркиз (зарим барууны орнуудын дээд зэрэг тайж).

Marksist *is.* və *s.* 1. марксист, Марксын сургалтан. 2. марксист.

Marksizm *z. is.*Марксизм,Марксын суртал.

marmelat *is.* бүржмэл чихэр.

maroken *is.* 1. торгон илэг, торгон арьс. 2. торгон арьсан, торгон илгэн.

Mars *is.* Марс гариг.

marş *ünl.* 1. марш команд. 2. *is.* шагсаалын хегжим. 3. *is.* төрийн дуулал.

mart *is.* гуравдугаар сар.

martaval *is. argo.* худал, хоосон үг.

martı *is. zool.* цахлай, хайлгана.

maruf *s.* нэртэй, алдартай, цуут.

marul *is. bot.* байцааны төрлийн ногоо.

maruz *s.* нэрвэгдсэн, өртсөн. **~ bırakmak** өртөх, нэрвэгдэх, амсах. **~ kalmak** өртөх, нэрв эгдэх, хохирох. "*Değişikliklere maruz kalmak.*" Өөрчлөлтенд өртөх.

marya *is.* 1. эм хонь. 2. эмэгчин амьтан. 3. нэгэн төрлийн жижиг загас.

masa *is.* 1. ширээ. "*Masa örtüsünün renği güzeldi.*" Ширээний бүтээлэгнийх нь өнгө гоё байсан. **~ tenisi** ширээний теннис. 2. ширээ, ширээнийхэн, нэг ширээнд сууж байгаа хүмүүс. "*Beşinci masa yarışmaya katılmayacak.*" Тав дугаар ширээнийхэн тэмцээнд оролцохгүй. 3. хэлтэс.

masaj *is.* барихуй, илбэхүй, массаж.

masal *is.* 1. үлгэр, домог. 2. сургамжит зохиол. 3. *mec.* дэмий хоосон үг, худал яриа.

masat, -dı *is.* ган билүүр.

maskara *is.* ve *s.* 1. инээдтэй, доогтой, алиа. **~ olmak** элэг доог болох, доог болох. 2. шившигтэй, нэр нүүргүй, өөдгүй, олиггүй, шившигт. 3. *is.* карнавалын баг. 4. *is.* сормуусны будаг.

maske *is.* 1. баг, маск. 2. хамгаалах маск, баг. 3. гоо сайхны маск, нүүрний маск 4. *mec.* хуурамч дүр, хуурамч зан ааш. **~si düşmek** үнэн санаа нь илрэх, жинхэнэ нүүр нь гарах. **~sini düşürmek** багий нь хуу татах, хуурамч нүүрий нь илчлэх. **~sini kaldırmak** багаа авч хаях, үнэн царайгаа үзүүлэх.

maskelemek *(-i)* 1. баг зүүх. 2. *mec.* үнэн царайгаа нуух, баг зүүх.

maskeli *s.* 1. багтай, масктай. 2. *mec.* хуурамч багтай. **~li balo** баг наадам.

maslahat *is. esk.* 1. ажил төрөл, ажил хэрэг, чухал ажил, асуудал. 2. *kaba.* эр бэлгийн эрхтэн.

maslak *is. esk.* 1. усны хоолой. 2. цөөрөм, усан сав, резервуар, нөөцлүүр. 3. том ган.

mason *is.* масон (масонлигийг баримтлагч, масоны байгууллагын гишүүн).

masonluk, -ğu *is.* масонлиг (18р зууны үед бий болсон бегеед тусгай мергөл ёслолтой "ёс суртахуунаа ариутган боловсруулах" зорилготой байсан, шашин гүн ухааны нэг урсгал).

masraf *is.* 1. зарлага, зардал. 2. зарлага. гарз, гарлага, үрлэг. **~ etmek** зарлага хийх, зардал гаргах.

masraflı *s.* их зарлага шаардсан, их зардал шаардсан, их зарлагатай, үнэтэй, их үнэтэй, их үнэ зарцуулсан, зарлагатай, зардалтай.

masrafsız *s.* 1. зарлага шаардахгүй, их зардалгүй, зарлагагүй, зардалгүй, гарлагагүй, хямдхан. 2. *mec.* зардал чирэгдэлгүй, хүндрэлгүй.

massetmek *(-i)* хехех, сорох, шимэх, татах.

mastar *is. gr.* үйл үгийн тодорхой бус төлөв.

mastı *is.* дорго нохой.

masum *s.* 1. гэмгүй, нүгэлгүй, хоргүй, буруугүй, хөнөөлгүй, ялт хэрэг хийгээгүй. 2. цайлган цагаан, гэнэн цайлган, гэнэн, гэнэн хонгор. 3. *is. hlk.* хүүхэд.

masun *s. esk.* 1. хамгаалагдсан, сахигдсан, хайрлан хадгалагдсан. 2. нуугдсан.

maşa *is.* 1. хавчуур, хавчуурга, чимхүүр, хямсаа. 2. хямсаа. 3. *mec.* бусдад ашиглуулагч.

maşallah *ünl.* магтаж сайшаахдаа, мөн цагаан хэл амнаас хамгаалахын үүднээс хэлнэ.

maşatlık, -ğı *is.* мусульман биш хүмүүсийн ялангуяа еврей хүмүүсийг оршуулдаг оршуулгын газрын нэр.

maşrapa *is.* (төмөрлөг, шавар) сэнжтэй аяга.

mat (I) *is.* мад. **~ etmek** 1) мад тавих, мадлах, хожих (шатарт). 2) мадлах, үг хэлж чадахгүй болгох, хариулж чадахгүй болгох.

mat (II) *s.* бүдэг, бүүдгэр, хурц биш, тод биш, сүүмгэр.

matara *is.* дашмаг, дорвого.

matbaa *is.* хэвлэх үйлдвэр.

matbaacı *is.* хэвлэгч, хэвлэх үйлдвэрийн эзэн.

matbaacılık, -ğı хэвлэх ажил, ном хэвлэх.

matbuat *is.* хэвлэл, хэвлэх, нийтлэх.

matem *is.* гашуудал, харуусал. **~ tutmak** гашуудал зарлах, гашуудах.

matematik *is.* тооны ухаан, математик.

matematikçi *is.* 1. тооны ухааны мэргэжилтэн, математикч. 2. тооны ухааны багш, тооны багш.

materyal *is.* материал, хэрэглэл, хэрэгсэл.

materyalist *s. fel.* материалист.

materyalizm *is. fel.* материализм.

matine *is.* өглөөний жүжиг, өдрийн жүжиг.

matkap, -bı *is.* өрем(барилгын).

matrah *is.* татвар тодорхойлох суурь үнэлгээ.

matrak, -ğı *is. esk.* 1. шийдэм, бороохой. 2. *s. argo.* инээдтэй, хөгтэй, алиа, хошин.

matris *is.* үсгийн хэв, матриц.

maval *is.* худал, итгэхэд бэрх яриа. **~ okumak** худал хуурмаг ярих.

mavi *is.* ve *s.* 1. цэнхэр өнгө. 2. s. цэнхэр енгийн, цэнхэр, цэнхэр өнгетэй.

mavna *is.* чирүүл онгоц, ачааны усан онгоц.

maya (I) *is.* 1. исгэх хөренге, хөренге, эсгүүр, исгэгч, эсгэл. 2. *mec.* үүсэл, эх булаг, уг сурвалж, үндэс, хүмүүжил, зан чанар, удамшил.

maya (II) *is. hlk.* 1. эмэгчин амьтан. 2. ингэ.

mayalamak *(nsz)* эсгэх.

mayalanmak *(nsz)* эсэх, бүрэлдэх, сагах, хөөх, гашлах, ээдэх.

mayasıl *is. tıp.* 1. толбон үлд, намарс, экзема. 2. шамбарам, гортиг гөвдрүү.

maydanoz *is. bot.* яншуй(ургамал).

mayhoş *s.* 1. эсгэлэн чихэрлэг амт. 2. *mec.* хөндий, хөндийрсөн, дотно биш, хүйтэн, хүйтэрсэн (нөхөрлөл).

mayın *is.* мина, тэсрэх бодис.

mayınlamak *(-i)* мина тавих.

mayıs *is.* тавдугаар сар.

mayışmak *(nzs) hlk.* нозоорох.

maymun *is. zool.* 1. сармагчин, бич. 2. *s. mec.* царай муутай, хөгийн, инээдтэй. 3. *s.* бусдыг элэглэн дууриагч, даган дууриагч.

mayo *is.* усны хувцас, усанд ордог хувцас.

mayonez *is.* сүмс, майонэз.

maytap, -bı *is.* бенгалийн гал.

mazeret *is.* 1. уучлах шалтаг, хүлцэх шалтаг, зөвтгөх шалтаг, цагаатгах шалтгаан, хүндтэй шалтгаан, зөвтгөх шалтгаан, өмөөрөх шалтгаан, өмгөөлөх шалтгаан. "*Ben kabahatime mazeret, haklı sebep aramıyorum.*" Би өөрийнхөө бүдүүлэг байдлыг өмгөөлөх шалтгаан, зөвтгөх шалтаг олохыг оролдохгүй байна. 2. шалтаан, шалтаг. **~ bulmak** шалтаг олох, шалтаг зохиох, зөвтгөх шалтгаан олох, зөвтгөх зүйл олох. "*Kendini haklı gösterecek mazeret bulmak için çok uğraştı ama aklına hiçbir şey gelmedi.*" Өөрийгөө зөвтгөх шалтгаан олох гэж их оролдсон боловч толгойд нь юу ч орж ирсэнгүй.

mazi *s.* 1. өнгөрсөн, урьдын. 2. *gr.* өнгөрсөн цаг.

mazlum *s.* 1. дарлагдсан, дарлуулсан. 2. *mec.* номхон, ноомой, дөлгөөн, даруу, чимээгүй.

mazot *is.* мазут тос.

mazur *is.* ve *s.* уулчлах шалтагтай, хүндэтгэх шалтгаантай. **~ görmek** уучлах, өршөөх, хэлтрүүлэх, хүндэтгэн үзэх.

mebiağ *is.* бүх дүн, бүгд, нийт.

mebus *is.* их хурлын гишүүн, депутат.

mecal, -li *is.* хүч, чадал, хүч чадал, тамир, тэнхээ. **~ kalmamak** хүчгүйдэх, тамиргүйдэх, тамир тэнхээгүй болох, тэнхээгүй болох.

mecalsiz *s.* хүчгүй, чадалгүй, хүч чадалгүй, тамир тэнхээгүй.

mecaz *is.* шилжүүлсэн утгатай үг, үлгэрлэж хэлсэн хэллэг, зүйрлэл.

mecazî *s.* дүрслэлтэй, уран, үлгэрлэж хэлсэн, жишээлж хэлсэн, тойруулж хэлсэн, ёгтолж хэлсэн, зүйрлэсэн, зүйрлэн хэлсэн, зүйрлэлийн.

mecbur *s.* хүчилж, биеэ баалж, бишүүрхүү, албадаж, тулгагдах, аргагүйдсэн, аргагүй болох, шаагдах, үүрэгтэй, ёстой, албатай. "*Biz toprağımızdan düşmanı atmaya mecburuz.*" Бид газар нутгаасаа дайсныг хөөн гаргах ёстой. **~ olmak** тулгагдах, аргагүйдэх, аргагүй болох, шаагдах, хэрэгтэй болох, ёстой болох. **~ etmek** албадах, албадан –уулгах, албадан хийлгэх, –уулах, –үүлэх, тулгах, аргагүй болгох, өөр аргагүй болгох, үүрэг болгох.

mecburen *zf.* албан хүчээр, албаар, өөр аргагүй болоод, аргагүй эрхэнд, аргагүйдээд, тулгагдаад.

mecburi *s.* албадлагын, албадан хийлгэх, албаар хийлгэх, баллагын, тулгагдах, аргагүй болсон, албан журмын.

mecburiyet *is.* зайлшгүй байдал, аргагүй байдал, аргагүй байх, ёстой байх, үүрэгтэй байх, албадагдах. "*Ayağımızı yorganımıza göre uzatmak mecburiyetindeyiz.*" Бид хөнжлийнхөө хэрээр хөлөө жийхээс аргагүй.

meclis *is.* 1. хурал, чуулган, хурлын танхим. 2. зөвлөл. 3. межлис (Түрк улсын их хурал). 4. анд нөхөдийн цуглаан. **~ kurmak** хууч хөөрөхөөр цуглах, хөгжилдөн уулзах.

mecmua *is. esk.* сэтгүүл.

mecnun *s. esk.* 1. шататлаа дурласан, ухаангүй дурласан. 2. галзуу, солиотой. **~ olmak** 1) шататлаа дурлах, ухаангүй дурлах, галзууртлаа дурлах. 2) *mec.* галзуурах, солиорох.

mecra *is.* гулдрил, сав, татуурга, голын салаа.

meçhul, -lü *s.* 1. мэдэгдэхгүй, мэдэхгүй, үл мэдэх, үл таних, танихгүй. 2. *gr.* үйлдэгдэх (хэв).

meddah *is. esk.* 1. меддах (үндэсний өгүүлэгч/яриач). 2. *mec.* биеэ магтагч, хэтэрхий магтагч, сайрхагч, бардамнагч, гайхуулагч.

medenî *s.* 1. иргэншсэн, соёлжсон, болов сон, соёл боловсролын, боловсронгуй соёлын. 2. иргэний, ард иргэний. **~ Kanunu** Иргэний хууль.

medenîleşmek *(nsz)* иргэнших, соёлжих, боловсон болох.

medenîleştirmek *(-i)* соёлжуулах, иргэншүүлэх, иргэншилд хамааруулах, соёлжилд хамааруулах.

medeniyet *is.* иргэншил, соёлжил, соёл иргэншил.

medet, -di *is.* тусламж. **~ ummak** (veya **beklemek**) тусламж хүлээх, тусламж харах.

medrese *is.* 1. (мусульман) шашны сургууль. 2. *esk.* факультет.

medya *is.* хэвлэл мэдээлэл.

medyacı *is.* хэвлэл мэдээлэлийн ажилтан.

mefhum *is. esk.* ухагдахуун, ойлголт.

mefruşat *is.* тавил, тавилга, эд хогшил, засал хогшил, гэрийн хэрэгсэл.

megafon *is.* цагаан хоолой, чанга яригч.

megaloman *is.* ve *s.* ихсийн интэй, ихсийн ин туссан хүн.

megalomani *is. tıp.* ихсийн ин.

meğer *bağ.* гэтэл, харин, тэгтэл, тэгэхэд, тэх хооронд.

meğerse *bağ.* тэгсэн харин, тэгтэл.

mehtap, -bı *is.* сарны гэрэл.

mehter *is. tar.* (янычарын, турк явган цэргийн)хөгжимчин.

mekan *is.* 1. газар, орших газар, суудаг газар, байран нутаг. 2. орон, сууц, орон байр, орон сууц. 3. *fiz. esk.* огторгуй, орон зай.

mekanik, -ği *is.* 1. механизм, оньс, механик. 2. *s.* механизмын, оньсны, мөханизмтай, оньстой. 3. мөханик ажилгаатай. 4. *zf.* **ve** *s. mec.* аяндаа (хийсэн), бодох юумгүй шууд (хийсэн), санаандгүй (хийсэн), өөрөө мэдэлгүй (хийсэн).

mekanizma *is.* 1. мөханизм, оньс. 2. тогтолцоо, байгууламж.

mekik, -ği *is.* (эвхээс утасны) онгоц, шорноок.

mektep, -bi *is.* сургууль.

mektup, -bu *is.* захидал, захиа. **~ almak** захидал авах, захиа авах.

mektuplaşmak *(nsz, -le)* харилцан захидал бичилцэх, захидалаар харилцах, захиагаар харилцах.

melankoli *is.* 1. ухаангүй дурлал, хүчтэй дурлал. 2. үргэлжийн уйтгар гуниг, үргэлжийн дүнсгэр байдал, мелэнхойлог.

melankolik *s.* 1. ухаангүй дурласан. 2. *mec.* уйтгарт, уйтгартай, гунигт, гунигтай, дүнсгэр.

melas *is.* цардуулын бурам.

melce *is.* орогнох газар, хорогдох байр, нөмөр.

melek, -ği *is.* 1. сахиулсан тэнгэр. 2. *mec.* хүмүүжилтэй, дөлгөөн(хүн). **~ gibi** намуун, дөлгөөн, сайхан сэтгэлтэй, сайхан зантай, сахиулсан тэнгэр шиг.

meleke *is.* чадал, чадвар, чадавхи.

melemek *(nsz)* (хонь, ямаа) майлах.

melez *is.* 1. *biy.* эрлийз. 2. эрлийз хүн.

melik *is. esk.* хаан.

melike *is. esk.* хатан, хааны эхнэр.

melodi *is.* ая.

melodram *is. tiy.* дуутай жүжиг, эмгэнэлийн уянгат жүжиг.

melon *is.* өндөр бүрх малгай.

meltem *is.* зөөлөн бүлээн салхи, эргийн салхи.

melun *s.* 1. хараал идсэн, хараал хүртсэн. 2. *mec.* ой гутмаар зэвүүрхэм, үзэшгүй муухай. 3. *is.* хараал хүртсэн хүн.

melül *s.* 1. уйтгартай, гунигтай, уй гашуутай. 2. хөөрхийлөлтэй, өрөвдөлтэй, ядуу дорой.

memba, -ı *is.* 1. булаг, шанд. 2. эх булаг, эх үүсвэр, эх үндэс. "*Memba suları.*" Булгийн ус.

meme *is.* 1. хөх, хөх дэлэн. 2. зарим зүйлсийн хөхний товч хэлбэртэй хэсэг. 3. чихний унжлага, чихний гэдэс. **~ vermek** хөхүүлэх. **~den kesmek** хөхнөөс гаргах.

memleket *is.* 1. орон, улс. 2. төрсөн нутаг, төрөлх газар, угуул нутаг, нутаг. 3. газар орон, газар нутаг, орон, нутаг, орон нутаг.

memnu, -u *is.* хориотой, цаазтай, цээртэй, хоригтой.

memnun *s.* ханамжтай, сэтгэл дүүрэн, сэтгэл хангалуун, баяртай, таатай. **~ olmak** сэтгэл ханах, сэтгэл ханамжтай байх, сэтгэл хангалуун байх, баяртай байх, баярлах, таатай байх.

memnuniyet *is.* сэтгэл ханамж, хангалуун байдал, ханамжтай байдал, баяр, баяртай байдал. **~ duymak** сэтгэл ханамжтай байх, сэтгэл хангалуун байх, баярлах.

memnuniyetle *zf.* дуртайяа, бахдалтайяа, таатай яа, сэтгэл ханамжтайгаар, сэтгэл хангалуун.

memnuniyetsizlik, -ği *is.* таагүй байдал, дургүйцэл, сэтгэл эс ханасан байдал, чамласан байдал.

memur *is.* 1. (төрийн) ажилтан, албан хаагч. 2. *s.* томилогдсон, үүрэгтэй.

memurluk *is.* албан хаагч.

men, -n'i *is.* хорио, хориул, цааз, цээр.

menajer *is.* 1. удирдагч, зохицуулагч. 2. менежер.

mendebur *s.* өдгүй, болхи, донгио.

menderes *is. coğr.* тохой, тохойрол, нугалаа, нугачаа.

mendil *is.* нусны алчуур, амны алчуур, амны цаас. **~ sallamak** алчуураар даллах, үдэж даллах.

mendirek, -ği *is.* далайн боомт, онгоцны зогсоол.

menekşe *is. bot.* нил цэцэг, нил.

menemen *is.* улаан лооль, чинжүү, өндөгтэй хоол.

menenjit *is. tıp.* менингит, мэнэн өвчин.

menetmek *(-i)* хорих, хориг тавих, хориглох, цээрлэх, цаазлах.

menevişlemek *(nsz)* солонголох, алаглан туяарах, гялганах.

menfaat, -ti *is.* ашиг, завшаан, ашиг хонжоо, ашиг тус, эрх ашиг, ашиг сонирхол, тус. **~ gütmek** ашиг хонжоо эрэлхийлэх, ашиг сонирхол хайх. **~ine** эрх ашгийнхаа төлөө, ашиг тусын төлөө, ашиг сонирхолынхоо төлөө.

menfaatçı *is.* ашиг хонжоо эрэгч, эрх ашиг хайгч, шунахай, хомхой.

menfi *s.* 1. эсрэг, сөрөг, муу. 2. болохгүй талаас нь хардаг, бүтэхгүй талаас нь боддог. 3. *esk.* цөллөгдсөн. хүн 4. *mat.* хасах (тоо). 5. *gr.* үгүйсгэх хэлбэр.

mengene *is.* 1. зуудаг багаж, хавчдаг багаж. 2. шахуур, шахуурга.

meni *is. fizy.* урийн шингэн, ур, дусал, салай.

menkıbe *is.* хүүрнэл, үлгэр(шашны том хүмүүсийн болон түүхэн алдартай хүмүүсийн намтар, гайхамшигт явдлуудыг хүүрнэсэн).

menkul, -lü *is. esk.* 1. тээврийн, зөөврийн. 2. *esk.* амнаас ам дамжсан, ам дамжин ирсэн. 3. *is* ve *s. huk.* хөдлөх (хөрөнгө). **gayri ~** үл хөдлөх (хөрөнгө).

mensubiyet *is.* холбогдох, хамаарах, холбогдол, хамаа, холбоо, барилдлага, холбоо харилцаа, хамаатай байх, хамаарагдах.

mensucat *is.* нэхмэл, бөс, даавуу, бөс бараа.

mensup, -bu *is.* ve *s.* мэдэлд байх, харъ яалагдаж байх, -х, -нх байх, холбоотой. хамаатай, хамааралтай байх, холбогдох, гишүүн. **~ olmak** холбогдох, холбогдолтой байх, хамаарагдах, элсэх, харъяалагдах, -нх болох.

mensur *s. esk.* үргэлжилсэн үгийн, туушчилсан, хүүрнэл.

menşe, -i *is. esk.* гарал, үүсэл, эх үндэс, язгуур, уг сурвалж, эх үүсвэр, учир үндэс, учир шалтгаан.

menteşe *is.* нугас (хаалга г.м).

mentol, -lü *is.* гааны үнэр.

menü *is.* хоолны цэс.

menzil *is. esk.* 1. өртөө, буудал. 2. хоёр буудлын хоорондын зам, хоорондох зай. 3. *ask.* арын алба. 4. сумны тусгалын хол. 5. *tar.* буудал, буурчийн газар. 6. *tar.* нум сумны тусгалын хол.

mera, -sı *is.* бэлчээр, хадлан нуга.

merak *is.* 1. сониуч зан, сонирхол, дур сонирхол, шохоорхол. "*Bahçecilik işine merakı olmak.*" Цэцэрлэгчийн ажилд сонирхолтой байх. 2. их сонирхол, ин, дон, хорхой. 3. санаа зовох, түгшүүр, зовуурь. сэтгэлийн түгшүүр, санаа зоволт, айлт, айх, эмээх. **~ etme!** бүү санаа зов! **~ etmek** 1) сонирхох, сониучирхах, сурахыг хүсэх. 2) санаа зовох, сэтгэл түгших, сэтгэл тавгүйтэх. **~ sarmak** сониурхах, сонирхон орох, дур татагдах.

meraklandırmak *(-i)* санааг нь зовоох, сэтгэлийг нь түгшээх, сэтгэлийг нь тавгүйтүүлэх.

meraklanmak *(-e)* сэтгэл түгших, санаа зовох, сэтгэл зовних, сэтгэл тавгүйтэх.

meraklı *s.* 1. соньч, сониуч. 2. донтой, хорхойтой, сонирхолтой. "*Ava meraklı.*" Анд хорхойтой. 3. *hlk.* түгшдэг, санаа зовдог. 4. *is.* хорхойтон, сонирхогч, дуртай хүн. "*Futbol meraklısı.*" Хөл бөмбөгийн хорхойтон./Хөл бөмбөгт дуртай хүн. 5. *is.* саваагүй, хэрэгт дуртай.

meraksız *s.* 1. сонирхолгүй, сурах мэдэх сонирхолгүй.2.тайван, амгалан, санаа зовохгүй.

meraksızlık, -ğı *is.* сонирхохгүй байх байдал.

meral *is.* марал, эм буга.

meram *is.* хүсэл, эрмэлзэл, санаа, санаа зорилго, зорилго, зорилт. **~ etmek** хүсэл болох, хүсэх, эрмэлзэх, зорих.

merəsim *is.* 1. ёслол, баяр ёслол. 2. *mec.* (албаны ажлын) дүрэм горим.

mercan *is. zool.* 1. шүр (далайн доторхи хад асганд байдаг үл хөдлөх амьтан). 2. шүр (мөнхүү эдээр хийсэн чимэглэл). 3. *s.* шүрэн, шүрээр хийсэн. 4. *zool.* улаан өнгөтэй нэгэн төрлийн загас.

mercanadası *is.* шүрэн арал.

mercek, -ği *is. fiz.* галт шил.

mercimek, -ği *is. bot.* сэвэг, зарам.

merdane (I) *zf.* ve *s. esk.* эрэлхэг, зоригтой, баатарлаг, эрэлхэг зоригтой.

merdane (II) *is.* 1. бортого, целиндр. 2. гурилын бөөрөнхий мод, ганжин, гулууз.

merdiven *is.* шат. **~ dayamak** (өндөр насны хувьд) нас хүрэх, нас шүргэх. "*Onun yaşı doksana merdiven dayadı.*" Тэр ерөн нас шүргэж явна.

merdivenli *s.* шаттай.

meret, -di *s.* ve *is.* 1. өөдгүй амьтан, ягир амьтан. 2. *hlk.* муу ёрын, таагүй.

merhaba *ünl.* Сайн байна уу?

merhabalaşmak *(nsz, -le)* мэндлэлцэх, мэнд усаа мэдэлцэх.

merhale *is.* 1. үе, үе шат, зэрэг. 2. *esk.* буудал, зогсоол, өртөө.

merhamet *is.* нигүүсэл, энэрэл хайр, хайр, энэрэл, өршөөл, өрөвдөх сэтгэл, хөөрхийлөл, өрөвдөх, хайрлах, нигүүлсэх, энэрэх. "*Babasına bile merhameti yoktu.*" Аавыгаа хүртэл өрөвддөггүй байсан.

merhametli *s.* нигүүлсэнгүй, өр нимгэн, өрөвч, энэрэнгүй, өрөвдөх сэтгэлтэй.

merhametsiz *s.* хэрцгий, хатуу сэтгэлтэй, хайрлахгүй, хайр гамгүй, өрөвдөх сэтгэлгүй, өр хатуу.

merhem *is.* 1. эмчилгээний тос, тосон түрхлэг, тосон эм. 2. *mec.* арга чарга, арга зам. **~ olmak** арга зам болох.

merhum *s.* 1. нас нөгчсөн, нас барсан, талийгаач, өөд болсон. 2. *is.* талийгаач (эрэгтэй).

merhume *s.* 1. нас нөгчсөн, нас барсан, талийгаач, өөд болсон 2. *is.* талийгаач (эмэгтэй).

meridyen *is. astr.* голч, уртраг.

Merih *z. is. astr.* Ангараг гариг.

merinos *is.* 1. мирноос хонь, мярнуус хонь. 2. мярнуусан хонины ноос. 3. *s.* мярнуусан хонины ноосоор хийсэн.

merkep, -bi *is.* илжиг.

merkez *is. mat.* 1. төв. 2. төв газар, дээд газар, төв. "*Ankara Türkiyenin merkezidir.*" Анкара Туркийн төв нь мөн билээ. 3. төв. "*Alışveriş merkezi.*" Худалдааны төв. "*Kültür merkezi.*" Соёлын төв. 4. цагдаагийн хэлтэс.

merkezci *s. bk.* merkeziyetçi.

merkezcil *s. fiz.* тев рүү гүйсэн, төв өөд тэмүүлсэн.

merkezcilik, -ği *is.* 1. тевлен захирах үзэл, төвлөн удирдах үзэл, төвлөрөх үзэл. 2. төвлөрөл, төвлөрсөн байдал, нэг гарт төвлөрөх.

merkezî *s.* төвийн, төвд буюу төвийн ойролцоо орших.

merkezîleşmek *(nsz)* төвлөрөх, бөөгнөрөх.

merkezîleştirmek *(-i)* төвлөрүүлэх. бөөгнөрүүлэх.

merkeziyet *is.* 1. төвлөрөх үзэл, төвлөн

захирах үзэл, төвлөн удирдах үзэл. 2. төвлөрөл, төвлөрсөн байдал, нэг гарт төвлөрөх.

merkeziyetçi *is.* төвлөрлийн бодлого баримтлагч.

merkeziyetçilik, -ği *is.* 1. төвлөрөх үзэл, төвлөн захирах үзэл, төвлөн удирдах үзэл. 2. төвлөрөл, төвлөрсөн байдал, нэг гарт төвлөрөх.

merkezkaç *s. fiz.* төвөөс гүйсэн, төвөөс зугтсан.

Merkür *z. is. astr.* Буд гариг.

mermer *is. jeol.* 1. гантиг, цасан дусал чулуу. 2. гантиган, гантигаар хийсэн.

mermerci *is.* гантигаар урлагч, гантиг гарган үйлдвэрлэгч, гантиг худалдагч.

mermi *is.* сум.

merserize *is.* 1. нэг иөрлийн чанартай торго. 2. торгон, торгоор хийсэн.

mersiye *is.* эмгэнэлийн үгс.

mert, -di *s.* 1. эрэлхэг, баатарлаг, зоригтой, зүрхтэй, хатуужилтай. 2. хэлсэн амандаа хүрдэг, эр хүн найдвартай (хүн).

mertçe *zf.* эрэлхэг зоригтойгоор, эрэлхэгээр, баатарлагаар, эр хүний байдлаар.

mertebe *is.* 1. зэрэг, хэмжээ, хир хэмжээ, хир зэрэг, хир. 2. шат, үе шат, түвшин.

mertek, -ği *is.* ялуу, дүнз.

mertlik, -ği *is.* эр зориг, эрэлхэг байдал, эр хүн шиг байх.

mesafe *is.* 1. зай, завсар, хол ойр, хол (зай), ойр (зай). "*Biz beş kilometrelik mesafede yine hiç birşey konuşmadık.*" Бид таван километрийн зайд бас л юу ч ярьсангүй. 2. *mec.* хөндий байдал, албархаг байдал.

mesafeli *s.* 1. зайтай, завсартай, хол зайтай. 2. *mec.* хөндий, хүйтэн харьцаатай, албархаг харьцаатай, ёсорхог.

mesaha *is. esk.* 1. газар хэмжилт. 2. талбай, гадарга, гадаргуу.

mesai *is.* ажил, хөдөлмөр. "*Mesai saatlerinde dışarıya gitmek yasaktır.*" Ажлын цагаар гадагшаа гарах хориотой.

mesaj *is.* 1. албан ёсны илгээлт. 2. *mec.* мэдээ, захиа, зурвас, илгээлт. 3. *mec.* сургаал, санаа.

mesame *is. anat. esk.* арьсны нүх сүв.

mesane *is. anat.* давсаг.

mescit, -di *is.* жижиг мөргөлийн газар, жижиг сүм.

mesel *is. esk.* 1. сургамжтай үгс. 2. зүйр цэцэн үг. 3. сургамжит өгүүлэг, сургамжит домог.

mesela *zf.* жишээлбэл, жишээ хэлвэл, жишээ нь, үлгэрлэвэл.

mesele *is.* 1. асуудал, проблем. 2. *mat. esk.* бодлого, асуулт. 3. хэцүү ажил, явдалтай ажил, явдалтай асуудал. "*Oraya gitmek şimdi bir meseledir.*" Тийшээ явна гэдэг ч одоо явдалтай асуудал даа. ~ **çıkarmak** асуудал бий болгох, асуудал гаргах.

Mesih *z. is.* Есүс.

mesken *is.* орон сууц, орон байр, сууц, орон гэр, оршин суух газар. ~ **tutmak** суурьших, оршин суух.

meskun *s.* хүн олонтой, суурин.

meslek, -ği *is.* 1. мэргэжил, мэргэжсэн ажил. 2. эрхэлсэн ажил, мэргэжил, ажил.

mesleki *s.* мэргэжилийн, мэргэжилтэй холбогдолтой.

mesleksiz *s.* мэргэжилгүй, ажилгүй.

meslektaş *is.* мэргэжил нэгтэн, нэг мэргэжилтэй.

mesnet, -di *is.* үндэслэл, тулгуур.

mesnevi *is. ed.* шүлэглэл дуулал.

mest (I) *s.* согтуу, мансуурсан, ухаанаа алдсан. ~ **etmek** мансууруулах, согтоох. ~ **olmak** согтох, мансуурах.

mest (II) *is.* нэгэн төрлийн гутал (дээрээс нь гутал давхарлаж өмсөхөд зориулсан зөөлөн гутал).

mesul, -lü *s. esk.* хариуцлагатай, хариуцлага хүлээсэн. ~ **olmak** хариуцлагатай байх, хариуцах, хариуцлага хүлээх.

mesuliyet *is. esk.* хариуцлага, үүрсэн хариуцлага. "*Bütün mesuliyeti ona yüklediler.*" Тэд, бүх хариуцлагыг түүнд тохов.

mesuliyetli *s. esk.* 1. хариуцлагатай. 2. хариуцлага шаардсан, хариуцлагатай, чухал.

mesuliyetsiz *s. esk.* 1. хариуцлагагүй. 2. хариуцлага шаардагдахгүй.

mesut, -du *s.* баяр баясгалантай, баяртай, жаргалтай, хувьтай, заяатай, амгалан сайхан. ~ **etmek** баяр баясгалантай байлгах, жаргаах, баярлуулах, гялайлгах, гийгүүлэх.

meşale *is.* бамбар. ~ **çekmek** удирдах, залах.

meşe *is. bot.* 1. царс мод 2. царсан, царсаар хийгдсэн

meşgale *is.* ажил төрөл, эрхэлсэн ажил, мэргэжил

meşgul, -lü *s.* 1. ажилтай, ажиллаж байх. 2. завгүй, зав чөлөөгүй, чөлөөгүй, ажилтай. ~ **etmek** 1) цаг завыг нь авах. 2) завгүй байлгах. 3) саатуулах, зугаацуулах, аргацаах. ~ **olmak** завгүй байх, ямар нэгэн зүйлээр оролдох, юм хийх, хөдөлмөрлөх.

meşguliyet *is.* 1. завгүй байдал, чөлөө завгүй байдал, ажилтай (байх). 2. ажил, эрхэлсэн ажил, мэргэжил.

meşhur *s.* 1. алдартай, цуутай, алдар цуутай, нэртэй. 2. *is.* алдартай хүн, нэртэй хүн. ~ **olmak** алдартай болох, нэрд гарах, цуутай болох.

meşin *is.* 1. идээлсэн арьс. 2. *s.* мөнхүү арьсаар хийсэн, арьсан.

meşk *is.* 1. зөв бичих дасгал. 2. (хөгжмийн, цэвэр бичгийн) дасгал.

meşru, -u *s.* хуулийн, хууль ёсны, хуулиар зөвшөөрөгдсөн.

meşrubat *ç. is.* унд, ундаа.

meşrulaşmak *(nsz)* хууль ёсны дагуу болох, хуулийн дагуу болох, ёсны дагуу болох, хуулиар зөвшөөрөгдсөний дагуу болох.

meşrulaştırmak *(-i)* хууль ёсны дагуу болгох, хуулийн дагуу болгох, хуулиар зөвшөөрөгдсөний дагуу болгох, ёсны дагуу болгох.

meşruten *zf.* хуулинд заасны дагуу. **~ tahliye** *is. huk.* тэнсэн суллах.

meşrutiyet *is.* 1. улс үндэстний үндсэн хуулиар олгогдсон эрх мэдлээ эдэлдэг хаантай улс. хэмжээт эрхт хаан. 2. *tar.* Оттоман гүрний Үндсэн хуулийн үе (1875–1876, 1908–1918).

meşum *s.* азгүй, золгүй, муу, муу ёрын.

met, -ddi *is. coğr.* далайн хөөрөлт, тэнгисийн түлхэл, түрэлт.

meta, -ı *is.* 1. бараа, бараа таваар 2. эд баялаг, хөрөнгө, эд зөөр.

metabolizma *is. biy.* мөтаболизм, бодисын солилцоо.

metafizik, -ği *is.* ve *s. fel.* мөтафизик.

metafizikçi *is.* метафизикч.

metal, -li *is. kim.* 1. төмөрлөг. 2. төмөрлөг, төмөрлөгөөр хийсэн.

metan *is. kim.* намгийн хий.

metanet *is.* тэсвэр, хатуужил, сэтгэлийн хат, бат бөх, бат бэх.

metanetli *s.* тэсвэртэй, хатуужилтай, сэтгэлийн хаттай.

meteor *is. astr.* 1. цаг уур. 2. солир.

meteoroloji *is.* цаг уурын судлал.

meteorolojik *s.* цаг уурын.

meteortaşı *is.* солир.

meth, -thi *is.* магтаал, магтлага, сайшаал.

methetmek *(-i)* магтах, сайшаах.

methiye *is. esk.* 1. магтаал, магтлага, сайшаал. 2. магтаал.

metin, -tni (I) *is.* эх бичиг, уг бичиг, бичиг.

metin (II) *s.* тэсвэртэй, хатуужилтай, тэвчээртэй, сэтгэлийн хаттай. **~ olmak** хатуужилтай байх, тэсвэртэй байх, тэвчээртэй байх, сэтгэлийн хаттай байх.

metodoloji *is. man.* арга судлал.

metodolojik *s.* арга судлалын.

metot, -du *is.* арга зүй, арга, метод, арга метод.

metre *is.* 1. метр. "*Metre kare.*" Метр квадрат. 2. метр хэмжээ.

metres *is.* амраг, нууц амраг.

metris *is.* нуувч, окоп, гуу, шуудуу.

metro *is.* 1. метро (газар дорхи цахилгаан төмөр зам). 2. метро галт тэрэг.

metropol, -lü *is.* нийслэл, том хот, чухал том хот, метрополи.

metruk, -kü *s.* 1. эзэнгүй, зэлүүд, хаягдсан, орхигдсон. 2. хуучирсан, хэрэглэдэггүй.

mevcudiyet *is. esk.* оршин тогтнол, амьдрал, оршин байх.

mevcut, -du *s.* 1. одоо байгаа, бэлэн, бэлэн байгаа, байгаа. 2. *is.* нийт тоо, нийт бүрэлдэхүүн. **~ olmak** байх, байлцах, оролцох.

mevduat *ç. is.* 1. банкинд хадгалуулсан мөнгө, хадгаламжинд хийсэн мөнгө. 2. *esk.* хөрөнгө оруулалт. "*Mevduat defteri.*" Хадгаламжийн дэвтэр.

mevki, -i *is.* 1. байрласан газар, орших газар. 2. алба, албан тушаал, зэрэг тушаал. 3. зэрэг, зэрэглэл. 4. байдал.

Mevla *is.* Бурхан.

mevlit, -di *is. esk.* 1. төрөх, төрөлт. 2. төрсөн нутаг, төрсөн газар. 3. Мухамедийн амьдралыг нь өгүүлсэн шүлэглэл дуулал. 4. энэхүү шүлэглэл дуулалыг уншдаг шашны ёслол.

mevsim *is.* 1. улирал. 2. үе, цаг, улирал.

mevsimlik, -ği *s.* 1. хаврын улиралд өмсдөг, намрын улиралд өмсдөг. 2. *zf.* улирлын чанартай, улирлын.

mevsimsiz *s.* 1. цаг үеээ олоогүй. 2. цаг үеээ олоогүй хийсэн.

mevta *is.* үхдэл, цогцос, хүүр.

mevzi, -i *is.* 1. газар, байрлал, байршил, байр. 2. *ask.* эзэлж авсан газар.

mevzii *s.* 1. нутгийн, газрын, тус газрын. 2. *tıp.* нэг газрын, хэсэгхэн газрын, нэг газарт гарсан, хэсэгхэн газарт хийсэн.

mevzu, -u *is.* юм, сэдэв.

mevzuat *is.* 1. хууль тогтоомж, үйлчилж байгаа бүх хууль дүрэм. 2. (бараа таваар) ороох боох эд, хайрцаг сав.

mey (I) *is. esk.* дарс.

mey (II) *is.* нэгэн төрлийн жижигхэн гуурсан бишгүүр.

meyankökü *is. bot.* амуу соёолж.

meydan *is.* 1. талбай. "*Suhbaatar meydanı.*" Сүхбаатарын талбай (Улаанбаатар хотын төв талбай). 2. дэвжээ, талбар, талмай. 3. орчин тойрон, эргэн тойрон. 4. аятайхан тохиолдол, боломж, сайхан завшаан, сайхан боломж. **~ kalmamak** боломж олж чадахгүй байх, боломж олдохгүй байх. **~ açmak** шалтаг болох, шалтгаан болох. **~ almak** *esk.* дэвжих, тархах, газар авах, түгэх. **~ okumak** айж эмээгүйгээ мэдэгдэх, ирүүл тулалдаанд дуудах, халз тулалдаанд дуудах, тэмцээнд орохыг урих. **~ vermemek** боломж олгохгүй байх, боломжгүй болгох, урьдчилан сэргийлэх. **~a çıkmak** 1) үзэгдэх, илрэх. 2) мэдэгдэх, илрэх, тодорхой болох. **~a gelmek** 1) бий болох, бүрдэх. 2) үүсэх, бий болох, болох, тохиолдох. **~a getirmek** бий болгох, болгох, бүтээх, гаргах.

meyhane *is.* архины гуанз, архины пүүз.

meyhaneci *is.* архины гуанз ажиллуулдаг хүн, архины пүүз ажиллуулдаг хүн.

meyil, -yli *is.* 1. ташуу газар, налуу газар, ташуу, налуу. 2. *mec.* хүсэл, дур, сэтгэл. **~ olmak** дурлах, таалах, таалагдах, дуртай болох.

meyilli *s.* 1. налуу, ташуу, хэлбэгий, хэлбэгэр, хэлтгий, хазгай. 2. дуртай, сонирхолтой, сэтгэлтэй, хайртай.

meyletmek *(-e)* 1. хэлбийх, хэлтийх, хазайх, бөхийх, тонгойх. 2. талтай болох, дуртай байх.

meymenet *is.* зол, аз, хийморь, өлзий, ээл, сайны хувь.

meymenetli *s.* азтай, хийморьтой, өлзийтэй, ээлтэй.

meymenetsiz *s.* 1. азгүй, золгүй. 2. муухай ааштай, булай муухай (хүн).

meyus *s.* 1. гунигтай, уйтгартай. 2. горьдлогогүй, цөхрөнгөө барсан, найдваргүй. **~ etmek** гомдоох, сэтгэл зовоох, гутраах.

meyve *is.* 1. *bot.* жимс. 2. *mec.* бүтээл, үр бүтээл, ашиг, ач тус.

meyvelenmek *(nsz)* жимслэх, жимс нь ургах.

meyveli *s.* 1. жимстэй, жимс өгдөг. 2. жимстэй, жимсээр хийсэн. 3. үр бүтээлч, бүтээлч.

meyvesiz *s.* жимсгүй, жимс өгдөггүй.

mezar *is.* булш, бунхан. "*Mezar taşı.*" Булшны чулуу.

mezarlık, -ğı *is.* оршуулгын газар, оршуулга, оршуулах газар.

mezat, -dı *is.* үнэ хаялцуулах худалдаа. **~a çıkarmak** үнэ хаялцуулах худалдаанд гаргах.

mezatçı *is.* 1. үнэ хаялцуулах худалдаа зохион байгуулагч. 2. үнэ хаялцуулах худалдааг байнга үзэгч.

mezbaha *is.* бойня, мал нядлах газар, нядлах газар.

mezbele *is.* хог буртаг, хог хаягдал угаадасны хонхор, муу усны нүх.

meze *is.* 1. зууш, архины даруулга. 2. *mec.* элэг доог, тоглоом даажин, шоо.

mezgit *is. zool.* нэгэн төрлийн загас.

mezhep, -bi *is.* шашны бүлэглэл, шашны урсгал.

meziyet *is.* сайн тал.

meziyetli *s.* гавьатай, билигтэй, чадалтай, авьяастай.

mezun *is.* ve *s.* 1. амралтаа авсан, чөлөөтэй. 2. (сургууль) төгсгөгч, дүүргэгч. 3. төлөөлөгч, тусгай эрхт, эрх мэдэлтэй, эрх бүхий. **~ olmak** сургууль төгсөх, сургууль дүүргэх.

mezuniyet *is. esk.* 1. чөлөөтэй байх, амралтаа авах, амралт, чөлөө. 2. төгсөлт, төгсөх, төгсөлтийн ажиллагаа. 3. мэдэл, эрх мэдэл, эрх.

mezura *is.* сантиметртэй тууз, сантиметртэй шугам.

mıh *is.* том хадаас, гадас.

mıhlamak *(-i, -e)* 1. хадаас хадах, хадаасаар хадах, гадсаар бэхлэх. 2. *mec.* хадах, наах.

mıhlanmak *(nsz)* 1. хадагдах, бэхлэгдэх. 2. *mec.* байгаа газартаа наалдах, байгаа газартаа хадагдах.

mıknatıs *is.* 1. соронзон, цахилгаан соронзон. 2. соронзон чанартай бүх төрлийн эд зүйлс. 3. *mec.* хүнийг татах увьдастай хүн, сэтгэл булаам.

mıknatıslamak *(-i)* соронзлох, соронзтой болгох.

mıknatıslı *s.* соронзон, соронзтой, соронзот.

mıncıklamak *(-i)* чимхэх, базах.

mıncıklanmak *(nsz)* чимхүүлэх, базуулах.

mıntıka *is.* бүс, бүс хэсэг, бүс газар.

mırıldamak *(-i)* бувтнах, бөвтнөх, үглэх, чимээгүй ярих, ойлгомжгүй ярих.

mırıldanmak *(nsz)* 1. чимээгүй ярих, ээрээ өөртейгөө ярих, аман дотроо бувтнах, бувтнах. 2. аяархан дуу аялах, гингэнэх. 3. бөвтнөх, үглэх, гувтнэх, ойлгомжгүй ярих.

mırıltı *is.* бөвтнөх, аман дотроо ярих, гувтнэх, бувтнаан, гингэнээн, дүнгэнээн, шивнээ.

mısır *is. bot.* эрдэнэ шиш. "*Mısır unu.*" Эрдэнэ шишийн гурил.

Mısırlı *z. is.* Египет хүн, мисир хүн.

mısra, -ı *is.* мөр (шүлэг зохиолын).

mıymıntı *s.* удаан, болхи, залхуу, хойрго.

mızıka *is.* 1. үлээвэр найрал хөгжим. 2. аман хуур.

mızıkçı *is.* ve *s.* луйварчин, булхайч, мэхчин, зальхай гайхал.

mızıkçılık, -ğı *is.* луйвар, булхай. **~ etmek** луйвардах, булхайдах, мэхлэх, зальхайдах.

mızıklanmak *(nsz)* луйвардах, булхайдах, мэхлэх, зальхайдах.

mızmız *s.* 1. өөлөмтгий, голомтгой, өө эрэгч, яншаа. 2. дэндүү залхуу.

mızrak, -ğı *is.* 1. жад. 2. *sp.* хөнгөн атлө тикийн жад.

miço *is.* усан цэрэг, далайчин.

mide *is.* 1. ходоод. 2. *mec.* гэдэс. 3. *mec.* хоол идэх дур. **~ bulandırmak** 1) бөөлжис цутгуулах, дотор муухайруулах. 2) *mec.* сэжиг төрүүлэх. **~si bulanmak** 1) дотор муухайрах, дотор эвгүйрэх, бөөлжис цутгах. 2) *mec.* сэжиг авах, сэжиглэх, хардах. 3) *mec.* ой гутах, жигших, зэвүүцэх. 4) *mec.* дургүй хүрэх, зэвүүн хүрэх, дур гутах. **~si kaldırmamak** 1) ой гутах, бөөлжис хүрэх, дотор муухайрах. 2) зэвүүцэл төрөх, дур гутаах, дургүй хүргэх, зэвүү хүргэх. **~si kazınmak** өлсөх, гэдэс хонхолзох.

midi *s.* дунд зэргийн, дунд зэрэг.

midye *is. zool.* хоёр далавчтай дун, явуу, хоёр далавчтай нальхан хорхой.

miftah *is. esk.* түлхүүр.

migren *is. tıp.* тал толгой өвдөх, толгой таллан өвдөх.

miğfer *is.* дуулга, төмөр малгай.

mihnet *is.* гай, үйл, зовлон, зүдгүүр. **~ çekmek** зовох, зүдрэх.

mihr *is. huk.* инж.

mihrace *is.* махранз (Энэтхэгийн засаг ноёдын дээд зэрэг цол).

mihrak *is. esk.* голлолт, голомтог, тодрох цэг, фокус.

mika *is. min.* гялтгануур.

mikoloji *is. tıp.* мөөг судлал, мөөг зүй.

mikrobiyolog, -ğu *is.* бичил амь судлагч, микробиологч.

mikrobiyoloji *is.* бичил амь судлал, микробиологи.

mikrofon *is.* микрофон (авианы долгионыг цахилгааны долгио болгох багаж).

mikroorganizma *is.* бичил биетэн, микроорганизм.

mikrop, -bu *is.* 1. нян, бичил биетэн, микроп(гагцхүү маш хүчтэй дурангаар харж болох өчүүхэн битэн). 2. *mec.* хор хөнөөлтэй хүн

mikroskop, -bu *is.* микроскоп, бичил дуран авай.

mikser *is.* холигч, хутгагч, холих багаж, хутгагч багаж.

miktar *is.* 1. тоо, тоо хэмжээ, ширхэг. 2. хэмжээ, мөнгөний хэмжээ.

milât, -dı *is.* Есүсийн мэндэлсэн өдөр. **~tan önce (MÖ)** манай эриний өмнө. **~tan sonra (MS)** манай эрин.

miligram *is.* миллиграмм.

milimetre *is.* миллиметр.

milis *is.* 1. ардын журамт цэрэг. 2. цагдаагийн бие бүрэлдэхүүн.

militan *s.* 1. дайчин, тэмцэгч. 2. *is.* ямар нэгэн бүлэглэлийн идвэхтэй гишүүн.

millet *is.* 1. улс, үндэстэн, улс үндэстэн. 2. *hlk.* омог, овог, угсаатан. 3. хүмүүс, улс, зон.

milletlerarası *s.* улс хоорондын, олон улсын.

milletvekili *is.* улсийн их хуралын гишүүн.

millî *s.* үндэсний, улсын, төрийн, улс үндэстэний, ард түмний, бүх ардын, нийт ардын. *"Millî Eğitim Bakanlığı."* Үндэсний Боловсролын Яам, Боловсролын Яам.

millî marş *is.* төрийн дуулал.

millileştirmek *(-i)* 1. үндэсний чанартай болгох, нийт ардын болгох, улсын чанартай болгох. 2. улсын мэдэлд авах, улсад хураах.

milliyet *is.* 1. улс, яс угсаа, яс үндэс, үндэс. 2. үндэстэн, ястан, угсаатан.

milliyetçi *s.* үндсэрхэх үзэлтэн, эх оронч хүн, эх орноо хайрладаг хүн, ардач чанартай хүн.

milliyetçilik, -ği *is.* үндсэрхэх үзэл, ардач чанар, эх орноо хайрлах үзэл, эх оронч үзэл.

milyar *is.* тэр бум, миллиард, арван дүнчүүр.

milyarder *is.* 1. тэрбумтан, тэр бумтай хүн. 2. баян хүн, тэрбумтан, хөрөнгө мөнгөтэй ихтэй хүн.

milyon *is.* ve *s.* сая.

milyoner *is.* ve *s.* 1. саятан, саятай хүн. 2. баян хүн, саятан, хөрөнгө мөнгө ихтэй хүн.

milyonlarca *zf.* сая сая, сая саян.

mimar *is.* архитектор, уран барилгач, барилгын мэргэжилтэн.

mimarlık, -ğı *is.* 1. архитектурын мэргэжил. 2. уран барилга, барилгын урлал, барилгын маяг, барилгын уран хийц.

mimik, -ği *is.* 1. нүүр болон гарын хөдөлгөөнөөр санаа бодлоо илэрхийлэх. 2. нүүрний хөдөлгөөн, мимик (сэтгэл санааг илтгэх).

mimlemek *(-i)* хар дансанд оруулах, хар дансанд тэмдэглэх.

mimoza *is. bot.* сийрсэн мод, гамба цэцэг.

minare *is.* минарет (мусульман шашинтны сүмийн цамхаг).

minder *is.* диваны дэр, суудал, олбог, жинтүү, дэвсгэр. **~ çürütmek** 1) ажил төрөлгүй суух. 2) нэг суудалдаа удаан суух, суудлаа ялзартал суух. 3) олон жил суугаа ажил хийх.

mine *is.* 1. паалан. 2. шүдний цагаан паалан. 3. (цагийн) нүүр, хуваарьт ялтас.

mineral, -li *is. jeol.* 1. эрдэс. 2. эрдсийн, эрдэстэй.

mineralog, -ğu *is.* эрдэс судлаач.

mineraloji эрдэс судлал, эрдэс зүй.

mini *s.* жижиг, өчүүхэн, бяцхан.

minibüs *is.* микро автобус.

minicik, -ği *s.* ve *is.* жижигхэн, бяцхан, өчүүхэн.

minimini *s.* ve *is.* 1. маш өчүүхэн, бяцхан. 2. бяцхан (хүүхэд).

minimum *is.* ve *s.* 1. туйлын бага (хэмжээ), хамгийн бага (тоо) нэн бага, минимум. 2. хамгийн багадаа, доод зах нь, багадаа л.

minnet *is.* 1. талархах, талархах өртэй (байх), ачыг санах, ачийг бодох. 2. талархал, баяр талархал, талархах. **~ duymak** талархах, ачийг санах, ачийг бодох, талархаж явах, талархах өртэй гэж бодох, талархах үүрэгтэй гэж санах.

minnettar *is.* талархах, талархах өртэй (байх), ачыг санах, ачийг бодох. **~ kalmak** талархах сэтгэл төрөх, талархах.

mintan *is.* эрэгтэй хүний цамц.

minüskül *is.* жижиг үсэг.

minyatür *is.* 1. миниатюр (хуучин ном бичгийн будагтай зураг). 2. бяцхан зураг. 3. *mec.* ямарваа нэг зүйлийн бяцхан хэмжээтэй хуулбар.

minyon *s.* нарийн гуалиг, өхөөрдөм, жижигхэн.

miralay *is. ask. esk.* хурандаа.

miras *is.* 1. өв, өв хөрөнгө. 2. өв. *"Kültür mirası."* Соёлын өв. **~ bırakmak** өв хөрөнгө үлдээх, өвлүүлэх. **~ yemek** 1) өв хөрөнгө үлдэх, өвлөгч болох. 2) өв хөрөнгөөр амьдрах.

mirasçı *is.* 1. өвлөгч, өв залгамжлагч, голомт залгамжлагч, угсаа залгамжлагч. 2. залгамжлагч, дууриагч.

mis *is.* сайхан үнэртэн, үнэртэн. **~ gibi** 1) цэнгэг, сайхан үнэртэй. 2) маш сайн, чадварлаг, гарамгай. 3) сайн байна, сайхан зүйл, сайн.

misafir *is.* 1. зочин, гийчин, айлчин. 2. *tıp. esk.* нүдний үүл, нүдний цагаа.

misafirhane *is. esk.* 1. аянчдын буудал. 2. зочины байр, айлчины гэр.

misafirlik, -ği *is.* айлчлал, зочлол.

misafirperver *s.* зочломтгой, зочлох дуртай, зочинд дуртай.

misafirperverlik, -ği *is.* зочломтгой байдал, зочинд дуртай (байх).

misal, -li *is.* 1. жишээ, үлгэр, дууриалал. 2. мэт, шиг, –тай адил, адил.

misil, -sli *is. esk.* 1. төсөө, адил, ижил. 2. тоо, тоо хэмжээ, ширхэг. 3. удаа, дахин.

misilleme *is.* хариу, хариупал, хариу арга хэмжээ, өс хонзон авалт.

misk *is.* заарь, хүдрийн заар.

misket (I) *is.* задийн, задит (анхилам сайхан үнэртэй жимснүүдийн хувьд хэрэглэнэ).

misket (II) *is.* 1. бялтат буу. 2. бугуй.

miskin *s.* ve *is.* 1. хөшүүн хойрго, хойрго, удаан болхи. 2. дүүнгэ, донгио. 3. өрөвдөлтэй, өрөвдөм, дорой, өчүүхэн.

mistik, -ği *is.* агийн ёсыг баримтлагч, сангасваа.

mistisizm *is. fel.* агийн ёс.

misyon *is.* 1. үүрэг, даалгавар, үүрэг даалгавар 2. шашин номлох газар.

misyoner *is.* христосын шашинг дэлгэрүүлэх үүрэгтэй хүн, шашин номлогч.

mit *is.* домог.

miting *is.* цуглаан.

mitoloji *is.* домог зүй, домог судлал.

mitralyöz *is.* пулөмёт, шүршүүр буу.

miyav *is.* (муур) миа миа гэх.

miyavlamak *(nsz)* (муур) миавлах.

miyop, -bu *s.* ve *is.* харалган, алсын хараагүй.

mizaç, -cı *is.* 1. зан, ааш зан, зан авир. 2. *esk.* биеийн байдал, эрүүл мэндийн байдал.

mizaçlı *s.* зантай.

mizaçsız *s.* эрүүл мэндийн байдал тааруу, тавгүй.

mizah *is.* алиа үг, хошин үг, хошин яриа.

mizahçı *is.* хошигногч, алиа хүн, шог зохиолч. хошин зохиолч.

mizan *is.* 1. жинлүүр, жин, пүү, дэнс. 2. *mec.* хэмжүүр, хэмжээ. 3. *tic.* мизан (арилжаа худалдаа эрхлэгчидийн тодорхой хугацаанд нэг гаргадаг тооцооны тайлан).

mizanpaj *is.* үсэг боох, хуудаслах.

mizantrop *is.* хүнийг үзэн ядагч, жожиг.

mobilya *is.* тавилга, гэрийн тавилга.

mobilyacı *is.* 1. тавилга хийдэг хүн, зардаг хүн. 2. тавилгын дэлгүүр.

mobilyalı *s.* тавилгатай, тохижуулсан.

mobilyasız *s.* тавилгагүй, тохижуулаагүй.

moda *is.* 1. моод, маяг, загвар. 2. *s.* шинэ загварын, моодны. **~sı geçmek** моодноос гарах, загвар нь хуучирах, загвар нь хоцрогдох, үе нь өнгөрөх.

modacı *is.* моод хөөгч, загвар хөөцөлдөгч, загвар зохион бүтээгч.

model *is.* 1. үлгэр, загвар. 2. үлгэр жишээ, үлгэр. 3. зургаа авхуулагч хүн, загвар өмсөгч. 4. хэлбэр, хэв загвар, загвар, үлгэр. 5. яг таг хуулбар. 6. үлгэр жишээ, үлгэр дууриалал.

modern *s.* орчин үеийн, орчин цагийн, эдүүгээгийн, шинэ цагийн.

modernleşmek *(nsz)* орчин үеийн болох, шинэтгэгдэх, орчин цагийн болох.

modernleştirmek *(-i)* орчин үеийн болгох, шинэтгэх, орчин цагийн болгох.

Moğol *z. is.* 1. Монгол хүн, монгол үндэстэн. 2. монголын.

Moğolca *z. is.* Монгол хэл.

mola *is.* 1. завсарлагаа, амралт, зогсолт, амсхийх зав, амрах зав. 2. *den.* татлагыг сулруулах. 3. завсарлага (сагсанбөмбөг ба воле йбол). **~ vermek** амрах, бууж амрах, амсхийх, зогсох, үдлэх.

molekül *is. kim.* молекул (бодисын химийн чанарыг агуулсан хамгийн жижигхэн хэсэг).

moleküler *s.* молекулын.

molla *is. tar.* 1. молла, ерөнхий шүүгч (оттоман гүрний танзимат үеийн). 2. (мусульман) шашны сургуулийн сурагч. 3. их эрдэмтэй хүн, мэдлэгтэй хүн.

moloz *is.* 1. чулууны бутархай 2. тусгүй зүйл, тусгүй хүн, дэмий зүйл, дэмий хүн, хэрэггүй зүйл, хэрэггүй хүн.

moment *is. fiz.* агшин, хором

momentum *is. fiz.* 1. хөдлөгч биеийн инерц. 2. хурд.

monarşi *is.* хаант засаг.

monarşizm *is.* хаант төрт ёс.

Mongolist *z. is.* монголч эрдэмтэн.

monitör *is.* 1. зөвлөх, багш, сургагч. 2. монитор, тохируулагч хэрэгсэл. 3. радио долгионы замаас баригч.

monolog, -ğu *is. tiy.* ганцханы үг, ганцаараа ярих.

monopol, -lü *is.* онц эрх, монополи эрх (ямар нэг юм худалдах, үйлдвэрлэх онцгой эрх).

monotip, -bi *is.* монотип, ганц ганц үсгээр өрөгч машин.

monoton *s.* нэг хэвийн, нэг янзын, нэг маягийн, нэг янз, нэг хэв, нэг маяг.

monotonluk, -ğu *is.* нэг янз (байх), нэг хэв (байх), нэг маяг (байх).

mont *is.* богино пальто, хүрэм.

montaj *is.* 1. эвлүүлэг, угсралт, угсрах ажил, монтаж. 2. *sin.* эвлүүлэн зохиох, эвлүүлэг.

montajcı *is.* угсрагч, эвлүүлэгч.

monte etmek *(-i)* эвлүүлэх, угсарах.

mor *is.* 1. хөх ягаан, нил ягаан 2. хөх ягаан өнгийн, нил ягаан өнгийн.

moral, -li *is.* санаа сэтгэл, сэтгэл санаа, сэтгэлийн хүч, дотоод эрч хүч, урам. **~ vermek** сэтгэлийн хүч өгөх, сэтгэлийн дэм үзүүлэх, зоригжуулах, урам өгөх, урам хайрлах, урам зориг нэмэх. **~i bozulmak** санаа сэтгэлээр унах, сэтгэл санаагаар унах, гуниж гутрах, урам хугарах. **~ini bozmak** сэтгэлээр унагаах, сэтгэл санаагаар унагаах, хэн нэгнийг гутаах, урамы нь хугалах.

moralizm *is.* ёс суртахуунч үзэл, ёс журамч үзэл, зан суртахуунч үзэл, хэв заншил.

morarmak *(nsz)* 1. хөх ягаан өнгөтэй болох. 2. хөхрөх, цэлдэн хөх болох.

morartmak *(-i)* хөхрүүлэх, хөх ягаан өнгөтэй болгох.

morfem *is. gr.* бүтээвэр, морфем (үгийн утга бүхий хэсэг, язгуур, угтвар, дагавар, сүүл).

morfin *is. kim.* морфи, мэнэрүүлэх эм, мэдээ алдуулах эм.

morfoloji *is. gr.* 1. үгзүй. 2. хэлбэр бүтцийн зүй.

morfolojik *s.* үгзүйн.

morg *is.* шарил хадгалах газар, морг.

morina *is. zool.* сагамхай загас.

morluk, -ğu *is.* 1. хөх ягаан өнгө. 2. хөхөрсөн газар, хөх няц.

mors (I) *is. zool.* далайн морь.

mors (II) *is.* 1. морз. 2. морзын машин. 3. *mec.* нууц дохио. **~ alfabesi** морзын цагаан толгой, морзын үсэг.

moruk, -ğu *s. arg.* хөгшин эр, хөгширсөн эрэгтэй хүн, аав.

mosmor *s.* бүх тал нь хөх ягаан, нэлэнхүүдээ хөх ягаан. **~ olmak** улайх, ичгүүртэй байдалд орох, хүнд байдалд орох.

motel *is.* зочид буудал.

motif *is.* 1. угалз, хээ, хээ угалз. 2. *müz.* ая, аяг.

motifli *s.* хээтэй, хээ угалзтай, угалзтай.

motivasyon *is.* анхааралаа төвлөрүүлэх, анхаарал төвлөрүүлэлт.

motor *is.* 1. мотор, хөдөлгүүр, хөдөлгөх хүч. 2. хөдөлгүүрт завь, моторт хөлөг онгоц, моторт хөнгөн онгоц. 3. *hlk.* мотоцикл.

motorcu *is.* хөдөлгүүрт завь ажилуулдаг хүн, моторт хөлөг онгоц ажилуулдаг хүн.

motorin *is.* моторын тос, хөдөлгүүрийн түлш.

motorlu *s.* мотортой, хөдөлгүүртэй, мотороор ажилдаг, моторжсон.

motorsuz *s.* моторгүй, мотороор ажилдаггүй, хөдөлгүүргүй.

motosiklet *is.* мотоцикл, моторт дугуй.

mozaik, -ği *is.* шигтгэмэл, мозайк, шигтгэмэл чимэг.

mozak, -ğı *is. hlk.* гахайн тоорой.

muaccel *s. esk.* 1. яаралтай, яаруу, шамдалтай, хойшлуулшгүй. 2. *huk.* урьдчилгаа, яаралтай төлөх хэрэгтэй.

muadil *is. esk.* тэнцүү, ижил, адил.

muaf *s. esk.* 1. уучлагдсан, өршөөгдсөн, хэлтрэгдсэн. 2. чөлөөлөгдсөн, тусгай эрхтэй, чөлөөтэй, тусгай эрх эдэлдэг. 3. чөлөөтэй, сул. **~ tutmak** чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, тусгай эрх эдлүүлэх.

muafiyet *is.* 1. хөнгөлөлт, чөлөөлөлт, тусгай эрх. 2. *biy.* дархлаа, халдашгүй байдал, халдашгүй чанар, дархлал.

muahede *is. esk.* гэрээ, хэлэлцээр.

muakkip, -bi *s. esk.* 1. мөрдөгч, мөшгөгч. 2. (ажил) гүйцэтгэгч, биелүүлэгч.

muallak *s. esk.* 1. дүүжилсэн, өлгөсөн, өлгөөстэй, өлгөөтэй, дүүжлээтэй. 2. *mec.* шийдэгдээгүй, шийдвэрлэгдээгүй, хойш тавигдсан. 3. *mec.* хамаатай, хамааралтай, холбоотой.

muallim *is. esk.* багш.

muamele *is.* 1. ааш, ааш авир, харилцаа, хандлага. 2. арга барил, горим, ёс журам. 3. үйл ажиллагаа. 4. *tic. esk.* арилжаа худалдаа. 5. *kim. esk.* урвал. **~ etmek** аашлах, хандах, харьцах. **~ görmek** аашлах, хандах, харьцах.

muamma *is.* 1. оньсого, таавар. 2. учир битүүлэг, үл ойлгогдох, нууцлаг.

muarız *s.* эсрэг.

muavin *s.* 1. туслагч, туслах. 2. *is.* туслагч, тусалдаг хүн, туслах.

muayene *is. tıp* 1. эмчийн үзлэг, үзлэг. 2. үзлэг, хяналт, шалган үзэлт. "*Gümrük muayenesi.*" Гаалийн үзлэг. **~ etmek** 1) үзэх, өвчтөнийг үзэх. 2) шалгах, шалган үзэх, хянах, хянан шалгах.

muayenehane *is.* эмнэлэг, өвчтөн хүлээн авах газар.

muayyen *s.* тогтсон, тодорхой, магадтай, лавтай.

muazzam *s.* 1. аварга том, аварга, асар том, лут, мундаг, лужир, маш том, лут том. 2. лут, агуу, мундаг, их. 3. *mec.* чухал.

mubah *s.* 1. шашны зүгээс хориотой биш, зөвшөөрч болмоор, байж болмоор. 2. *mec.* байж болмоор, хийхэд аюулгүй.

mucip, -bi *s.* 1. шаардагдах, шаардлагатай. 2. *is.* шалтгаан, учир шалтгаан.

mucit, -di *is.* 1. зохион бүтээгч, бүтээн байгуулагч, үүсгэгч, шинийг санаачлагч. 2. *s.* бүтээгч, бүтээдэг.

mucize *is.* 1. гайхамшигтай явдал, гайхамшигт үйл, гайхалтай явдал. 2. хүний ухаанд багтамгүй явдал, гайхамшиг. 3. *s.* гайхамшигт, гайхалтай, гайхамшигтай.

mucur *is.* 1. нүүрсний бутархай. 2. хаягдал, шаар, хог, орхидос.

muğlak *s.* ойлгомжгүй, ойлгоход бэрх, учир битүүлэг, ээдрээтэй.

rüzgar *is.* салхи. **~ gibi** сум шиг (салхи шиг) хурдан, маш хурдан. **rüzgar altı** *is. den.* (хөлөг онгоцны) нөмөр тал, салхины доод тал. **rüzgar üstü** *is. den.* салхин талын, салхи өөд харсан (онгоцны салхин талын хярхаг, салхины өөдөөс харсан тал)

rüzgarlı *s.* салхитай, салхилсан.

rüzgarsız *s.* салхигүй, салхилаагүй.

S

s, S Түрк цагаан толгойн хорин хоёр дох үсэг. **S** авиа.

saadet *is.* аз жаргал, зол жаргал.

saat, -di *is.* 1. цаг. "*Bir saat geç kalmak.*" Нэг цаг хоцрох. "*Saat kaça geliyor?*" Хэдэн цаг болж байна? "*Öğle yemek saati.*" Үдийн хоолны цаг. 2. цаг, үе. "*O saatlerde orada kimse bulunmaz.*" Тэр үеэр тэнд хэн ч байдаггүй юм. 3. цаг. "*Duvar saati.*" Ханын цаг. "*Kol saati.*" Бугуйн цаг. "*Masa saati.*" Ширээний цаг. 4. заалтуур, заагуур, заагч, тоолуур, метр, хэмжээ. "*Elektrik saati.*" Цахилгаан

тоолуур.

saatçı *is.* 1. цагчин, цагны засварч. 2. цагны худалдаачин.

saatçılık, -ğı *is.* 1. цаг засварын ажил, цагчны ажил, мэргэжил. 2. цагны худалдаа.

sabah *is.* 1. өглөө. "*Bu sabah gitti.*" Өнөө өглөө явсан. "*Hayırlı sabahlar.*" Өглөөний мэнд. 2. *zf.* өглөөгүүр, өглөө. "*Sabah bize geldi.*" Өглөөгүүр манайд ирсэн. **~ın köründe** хар үүрээр, хар өглөөгүүр, гэгээ ороогүй байхад, үүр цүүрээр, үүрийн шөнөөр, нар битүү.

sabahçı *is.* 1. өглөөний ээлж, өглөөний жижүүр. 2. өглөөний ээлж (сургуулийн).

sabahlamak *(nsz)* 1. өглөө болгох, өглөө болтол байх. 2. нойргүй хонох, шөнө турш нойргүй хонох, бүхэл шөнө нойргүй хонох.

sabahleyin *zf.* өглөөгүүр, өглөө, өглө эрт, өглөөний цаг.

sabahlık, -ğı *is.* (эмэгтэй хүний өглөөний) халаад, нөмрөг.

saban *is.* анжис, модон анжис.

sabık *s.* урьдахь, өмнөх, өнгөрсөн, урьдын, агсан, байсан, хуучин.

sabıka *is.* 1. урьдын хэрэг, урьдын явдал, урьд тохиолдсон зүйл. 2. дахин хэрэг үйлдэх, дахин ял хийх, давтан гэмт хэрэг.

sabıkalı *s.* дахин хэрэг үйлдэгч, дахин хэрэг хийгч, давтан гэмт хэрэгтэй.

sabır, -brı *is.* тэсвэр, тэвчээр, хүлцэл, хүлээц, тэсвэрлэх, тэсэх, тэвчих, хүлцэх. **~ etmek** *bk.* **sabretmek. ~ı taşımak (**veya **tükenmek)** тэсэхийн аргагүй болох, тэвчээр нь барагдах, тэсвэр нь барагдах, (зүгээр) өнгөрөөхийн аргагүй болох.

sabırlı *s.* тэсвэртэй, тэвчээртэй, хүлцэнгүй.

sabırsız *s.* тэсвэргүй, тэвчээргүй.

sabırsızlanmak *(nsz)* тэвчээр алдах, тэсэхгүй болох, тэсэхээ байх, тэвчээргүй аашлах.

sabırsızlık, -ğı *is.* тэсвэргүй (байх), тэвчээргүй (байх).

sabit *s.* 1. үл хөдлөх, хөдлөхгүй, хөдөлгөөнгүй. 2. нотлогдсон, лавтай, магадтай. 3. *mec.* өөрчлөгдөшгүй, тогтсон, тогтмол, хувиршгүй. **~ olmak** 1) нотлогдох, тодорхой болох, илэрхий болох, дамжиггүй болох, эргэлзээгүй болох. 2) шургуу зүтгэх, нөр зүтгэх, нөрлөх.

sabotaj *is.* ажил санаатай тасалдуулах, боогдуулах, санаатай тасалдуулах, зориуд саатуулах, хясан боогдуулах.

sabretmek *(nsz)* тэсэх, тэвчих, хүлцэх, тэсэн (хүлцэн, тэвчин) өнгөрүүлэх, тэсвэрлэх, амсаж өнгөрүүлэх, тэсэж өнгөрөөх, давж гарах, давах.

sabun *is.* саван.

sabuncu *is.* саваньч, саван чанагч, савангийн худалдагч.

sabunculuk, -ğu *is.* саван үйлдвэрлэх, саван чанах, савангийн худалдаа.

sabunhane *is.* савангийн үйлдвэр.

sabunlamak *(-i)* савандах, савангаар угаах.

sabunlu *s.* савантай, савангий нь гаргаагүй.

sabunluk, -ğu *is.* 1. савангийн хайрцаг, савангийн гэр. 2. *s.* савангийн, саван хийхэд тохиромжтой.

sac *is.* 1. нимгэн хавтгай төмөр, гөлмөн төмөр, нимгэн төмөр. 2. гөлмөн төмрөөр хийсэн гүдгэр сав.

sacayağı *is.* тулга, хөл, тулгуур.

saç *is.* үс, үс хялгас. **~ı uzun aklı kısa** эмэгтэй хүний үс нь урт, ухаан нь богино.

saçak, -ğı *is.* 1. цацагтай туушин, цацаг, залаа, цацагт эмжээр, эмжээр, хөвөө, хошмог. "*Perdenin saçağı.*" Хөшигний цацаг. 2. хэрдэг (цонх, үүдний дээр хадсан хөшиг татах хөндлөв ч), урагшаа илүү гарсан, төвийсөн, хэрдэг: дээвэр.

saçakbulut *is.* сэмжин үүл, өдөн үүл.

saçaklı *s.* цацагтай туушинтай, цацагтай, залаатай, цацагт эмжээртэй.

saçılmak *(nsz)* 1. saçmak үйлийн үйлдэгдэх хэв. 2. тарах, дэлгэрэх, түгэх, тархах, зайтай байх. 3. (эмэгтэй хүн) шалдан нүцгэн шахам хувцаслаж эхлэх, ёс бус аашилж эхлэх, эвдрэх.

saçkıran *is. tıp.* хяргадаг үлд.

saçlı *s.* үстэй.

saçma *is.* 1. *mec.* утгагүй үг, дэмий балай үг, хоосон яриа, чалчаа үг. 2. шааз, бутархай сум, үрлэн сум. 3. загас барих тор. 4. тэнэг явдал, тэнэг юм, дэмий юм. 5. *s.* тэнэг, мунхаг, мангуу, дэмий, балай (хүн). **~ sapan konuşmak** учир утгагүй ярих, дэмий юм ярих, дэмий чалчих, тэнэг үг хэлэх, дэмийрэх, балайрах, донгосох.

saçmak *(-i)* 1. тархаан хаях, цацах, сандааж хаях, сандаах, тархаах, асгах, гоожуулах, унагах, үйрүүлэх. "*Koku saçmak.*" Үнэр анхилуулах, үнэр ханхлуулах, үнэртүүлэх. 2. (гэрэл, дулаан) тараах, цацруулах. 3. (үзэл, бодлыг) дэлгэрүүлэх, түгээх, тараах.

saçmalamak *(nsz)* чалчих, донгосох, дэмий юм ярих, балайрах, тэнэглэх, дэмийрэх.

saçmalık, -ğı *is. mec.* тэнэг юм, тэнэг явдал, дэмий юм, чалчаа үг, хоосон яриа, дамий балай юм.

saçsız *s.* үсгүй.

sadak, -ğı *is.* саадаг.

sadaka *is.* 1. гуйлгачинд өгөх мөнгө. 2. өглөг.

sadakat, -ti *is.* үнэнч шударга байдал, үнэнч байдал, үнэнч, шударга, чин бат, чин бат нөхөрлөл.

sadakatli *s.* үнэнч, итгэлт, шударга, үнэнч шударга, бат.

sadakatsiz *s.* итгэл эвдсэн, үнэнч бус, ураагч, батгүй, итгэлийг тэсэлсэн, буруу санаатай, уравсан.

sadakatsizlik, -ği *is.* итгэл эвдэх, буруу санаа, урвалт, үнэнч бус байдал.

sade *s.* 1. энгийн, жирийн, эгэл, чимэггүй, гоёлгүй, даруу, төлөв. "*Sade insan.*" Эгэл хүн. "*Sade elbise.*" Даруу даашинз. 2. чихэргүй (кофе). 3. *zf.* дан, зөвхөн, дан ганц. 4. *ed.* эгэл, энгийн, чимэггүй, хялбар. 5. цэвэр, хольцоогүй, нэг төрлийн, дан.

sadece *zf.* гагцхүү, зөвхөн, дөнгөж, –хан(–хэн, –хон, –хөн).

sadeleşmek *(nsz)* энгийн болох, хялбар болох, хялбарших.

sadeleştirmek *(-i)* хялбарчлах, хялбаржуулах, хялбар болгох, хөнгөн болгох, хөнгөвчлөх, энгийн болгох, эгэл болгох.

sadelik, -ği *is.* 1. энгийн байдал, эгэл байдал, ерийн байдал, жирийн байх. 2. цэвэр байдал, хольцоогүй байх. 3. энгийн байх.

sadeyağ *is.* цөцгийн тос.

sadık, -ğı *s. esk.* 1. үнэн, зөв, үнэхээр, үнээр, нээрээ, чухам. 2. үнэнч, итгэлт, үнэнч шударга, бат. ~ **kalmak** үнэнч байх, итгэл даах, шударга байх.

sadist *is.* садист, тарчилган жаргагч.

sadizm *is. psikol.* садизм (хурьцал үйлдэхдээ хүнийг зовоож хүслээ хангадаг завхай явдал).

sadrazam *is.* Оттоман гүрний өрөнхий сайд.

saf (I) *is.* эгнээ, үе, мөр, жагсаал.

saf (II) *s.* 1. цэвэр, хольцоогүй, ёстой, дан. 2. *mec.* гэнэн, хууртахдаа хялбар. 3. *mec.* гэнэн хонгор, цайлган, цагаан санаатай.

safa *is. bk.* sefa.

safha *is.* 1. даваа, үе, үөлэл, шат, үе шат. 2. *fiz.* үе, үөлэл, шат.

safi *s.* 1. ариун, цэвэр, хольцгүй, хольцоогүй. 2. тод, илэрхий. 3. гагцхүү, дан, дан ганц, зөвхөн.

saflık, -ğı *is.* 1. цэвэр (байх), хольцоогүй (байх), ариун. 2. *mec.* гэнэн байдал, хууртахдаа хялбар (байх).

safra (I) *is. den.* 1. тохируулах ачаа дайвар. 2. *mec.* тээр, дарамт, дарамттай хүн.

safra (II) *is.* цөс, сөс. ~ **kesesi** цөсний уут, сөсний уут.

safran *is. bot.* гүргэм (халуун оронд ургадаг улбар шар өнгөтэй ургамал).

sağ (I) *s.* 1. баруун, ич. "*Sağ el.*" Баруун гар. 2. *is.* баруун зүг, баруун тал. 3. *is.* ve *s.* баруунтан.

sağ (II) *s.* 1. эрүүл, эрүүл саруул, мэнд, эсэн, эсэн мэнд, сайн. 2. цэвэр, хольцоогүй. 3. амьд, амьд мэнд, амьтай, голтой. ~ **salim** мэнд амар, амьд мэнд, эсэн мэнд, бүрэн бүтэн.

sağanak, -ğı *is.* аадар, ширүүн бороо, аянгатай бороо, усархаг бороо.

sağbeğeni *is.* юмны ялгааг сайн мэдэх.

sağcı *s.* ve *is.* барууны, баруунтан, барууныг баримтлагч.

sağdıç, -cı *is.* бэргэн (сүйт бүсгүйн, сүйт харцүүгийн).

sağduyu *is.* эрүүл ухаан, зөв бодлого, сайн оюун, хэрсүү ухаан, эрүүл сэтгэлгээ.

sağgörü *is.* нэвтэрхий ухаан, саруул ухаан, мэргэн, цэцэн, алсын хараа, төсөөлөх мэдлэг.

sağgörülü *s.* хэрсүү, нэвтэрхий, гярхай, мэргэн, цэцэн, билгийн нүдэт, алсын хараатай.

sağım *is.* 1. саам. 2. саалийн мал.

sağır *s.* дүлий, чих хатуу (хүн).

sağırlaşmak *(nsz)* дүлийрэх, чих хатуурах.

sağırlık, -ğı *is.* дүлий, чих хатуурах.

sağlam *s.* 1. бат, бөх, бат бөх, тогтвортой. "*Sağlam ayakkabı.*" Бөх гутал. 2. бүтэн, бүрэн бүтэн, тэр хэвээр, гар хүрээгүй, эвдрээгүй, хэмхрээгүй. "*Bütü eşya sağlam.*" Бүх хогшил бүрэн бүтэн байна. 3. эрүүл, эрүүл саруул, эрүүл чийрэг, бие сайтай. "*Kendisi uzun boylu, sağlam, orta yaşlı bir adamdır.*" Тэр өндөр нуруутай, эрүүл чийрэг, дунд хэргэм насны хүн. 4. найдвартай, бат, итгэлтэй. "*Sağlam para.*" Найдвартай мөнгө. 5. ул үндэстэй, ул баримттай, баттай, иш баримттай. "*Sağlam haber.*" Ул баримттай мэдээ.

sağlama *is.* 1. sağlama үйлийн нэр. 2. *mat.* шалгах, шалгалт, шалгаж (туршиж) үзэх.

sağlamak *(-i)* 1. хангах, нийлүүлэх, хангалттай бэлтгэх, олгох, өгөх, бэлтгэж өгөх, бүрдүүлж өгөх. "*Ders çalışacak uygun ortamı sağlamak lazım.*" Хичээл давтах тохиромжтой орчинг бүрдүүлж өгөх хэрэгтэй. 2. олж авах, олох, авах, –тай болох. 3. *mat.* нотлох, шалгаж үзэх, туршиж үзэх.

sağlamlaşmak *(nsz)* бэхжих, батжих, бөхжих, бөх болох, бат бөх болох.

sağlamlık, -ğı *is.* 1. бөх(байх), бат бэх (байх), хөдлөшгүй байдал, бат. 2. эрүүл (байх), эрүүл мэнд сайн (байх), лагшин сайн (байх). 3. найдвартай (байх), үнэн магад нь, лав нь, чухам үнэн нь.

sağlanmak *(nsz)* sağlamak үйлийн үйлдэгдэх хэв.

sağlık, -ğı *is.* бие, эрүүл мэнд, эрүүл, лагшин, бие лагшин. "*Sağlık sigortası.*" Эрүүл мэндийн даатгал.

sağmak, -ar *(-i)* 1. саах. "*İneği sağmaya gitti.*" Үнээ саахаар явсан. 2. (зөгийн балыг) үүрнэс нь салгаж авах, сархигнаас нь салгаж авах. 3. *argo.* авилгалах, шахаж авах, салгаж авах, аажмаар хамаг юмыг нь авах, тонох, цөлмөх, цөлмөн авах.

sağmal *s.* 1. саалийн. 2. *is.* саалийн үнээ, сүү ихтэй үнээ.

sağrı *is.* (амьтны)ууц, хондлой, олон яс нийлэх, асуух нуруу.

saha *is.* талбай, талбар, тавцан.

sahaf *is.* хуучин ховор номны худалдаачин.

sahi *zf.* үнэхээр, нээрээ, үнээр, чухамхан, үнэндээ, чухамдаа, нээрэн, ингэхэд, гарцаагүй бараггүй. "*Siz onu görmediniz mi sahi!*" Та нар түүнийг үнэхээр үзээгүй юм уу! Ингэхэд та нар түүнийг үзээгүй юм уу! ~ **mi** нээрээ үү, үнэн үү.

sahiden *zf. bk.* sahi.

sahil *is.* 1. эрэг, хөвөө, эрэг хавийн газар. 2. *s.* эргийн, эрэг хавийн.

sahip, -bi *is.* 1. эзэн, юмны эзэн, эзэмшигч. "*Ev sahibi şimdi gelir.*" Гэрийн эзэн одоохон ирнэ. 2. –тай (–тэй, –той) хүн, (ямарваа нэг чанар) –тай(–тэй, –той) хүн. "*Namus sahibi.*" Шударга хүн. "*Prensip sahibi.*" Зарчимч хүн, зарчимтай хүн. 3. ивээгч, өмгөөлөгч, хамгаалагч. **~ çıkmak** 1) өөрийгөө эзэн нь гэх, өөрийгөө эзэн нь гэж зарлах, өөрийн юм гэх, гэгдэхийг оролдох. 2) хамгаалах, өмгөөлөх, ивээх. "*Kıza hep sahip çıkmıştır.*" Охиныг үргэлж хамгаалдаг байсан. **~ olmak** эзэмших, –тай (–тэй, –той) болох. "*Akıl sahibi oldu.*" Ухаантай болсон./Ухаажсан. "*Çocuk sahibi oldu.*" Хүүхэдтэй болсон.

sahipsiz *s.* 1. эзэнгүй. 2. *mec.* харах хамгаалах хүнгүй, харч хандах хүнгүй, эзэнгүй.

sahne *is.* 1. тайз, талбай. 2. *tiy.* үзэгдэл, бүлэг. 3. дүр зураг, дүр төрх. 4. театр. **~ye koymak** *tiy.* жүжиг болгох, жүжиг тавих, дэглэх.

sahra *is.* 1. тал газар, тэгш газар, тал, тал хээр, хээр газар. 2. цөл.

sahte *s.* 1. хуурамч, хуурмаг, дуураймал, хиймэл. "*Sahte para basmışlar.*" Хуурамч мөнгө хийжээ. 2. *mec.* худал, хуурмаг, хуурамч, өнгөний. "*Sahte gülümseme.*" Хуурамч инээмсэглэл.

sahtecilik, -ği *is.* хуурмаг, хуурамч, хуурмагаар үйлдэх, хуурмаг үйлдэх, завхруулах, дуурайлгаж хийх, гуйвуулах явдал, булхайлах явдал.

sahtekar *s.* хуурмаг үйлдэгч, хуурамч хүн, мэхч, хууран мэхлэгч, завхруулагч, булхайч, зальт этгээд.

sahtekarlık, -ğı *is.* хуурмаг, хуурамч, хуурмагаар үйлдэх, хуурмаг үйлдэх, завхруулах, дуурайлгаж хийх, гуйвуулах явдал, булхайлах явдал.

sahur *is.* сахур (Мусульманчуудын Рамазан сарын турш үүр цайхаас өмнө мацаг барихдаа бэлдэж иддэг өглөөний хоол).

sakal *is.* сахал, эрүүний сахал.

sakallı *s.* сахалтай.

sakalsız *s.* сахалгүй.

sakar *s.* 1. сар, цагаан толбо. 2. *s.* ve *is.* болхи, будлиун, шаламгай биш, дүйгүй.

sakat *s.* ve *is.* 1. эрэмдэг, зэрэмдэг, тахир дутуу, хөдөлмөрийн чадвар алдсан. 2. *mec.* бүрэн бус, бүтэн биш (юм).

sakatat *is.* цувдай.

sakatlamak *(nsz)* 1. бэртээх, гэмтээх, тахир дутуу болгох, эрэмдэглэх, эрэмдэг зэрэмдэг болгох. 2. *mec.* эвдэх, гэмтээх, эвдлэх, эвдэлж хэмхлэх.

sakatlanmak *(nsz)* 1. гэмтэх, бэртэх, тахир дутуу болох, эрэмдэг болох, эрэмдэг зэрэмдэг болох. 2. *mec.* эвдрэх, гэмтэх, хэмхрэх, эвдэрч хэмхрэх.

sakatlık, -ğı *is.* 1. бэртэх, бэртэнгэ, гэмтэл, эрэмдэг, зэрэмдэг, тахир дутуу. 2. гэмтээх, бэртээх, эвдэх, осол, гэмтэл, гай, үйл, тотгор. "*Elinden bir sakatlık çıkmasın.*" Эвдчихэв ээ./Битгий эвдчихээрэй.

sakın *ünl.* сайхан мэдээрэй, –уузай, –үүзэй, хэрхэвч ... болохгүй, ээ дээ тэгвээ, (тэгэх) вий дээ, битгий, гүй л байгаасай, битгий ...аасай. "*Sakın kimseye söyleme.*" Ээ дээ хүнд хэлэв ээ./Хүнд хэлэвүүзэй./Хүний чихнээс холуур өнгөрөг./Хэрхэвч хэлж болохгүй.

sakınca *is.* 1. савд, бэрхшээл, түвэг, таагүй байдал, аягүй байдал, болохгүй юм, тавгүй байдал, тохигүй байдал. "*Kabul etmekte bir sakınca yoktur.*" Зөвшөөрөхөд болохгүй юм алга.2. харш шалтгаан, харш нөлөө.

sakıncalı *s.* таагүй, аягүй, болохгүй.

sakıngan *s.* болгоомжтой, хянуур, хянамгай.

sakınmak *(-den)* 1. цээрлэх, цаартгалах, түдгэлзэх, биөэ барих, зайлсхийх, тэвчих. "*Günahtan sakınmak.*" Нүглийг тэвчих. Нүглээс зайлсхийх. 2. болгоомжлох, анах, сэрэмжлэх. "*Soğuktan sakınmak.*" Хүйтнээс сэрэмжлэх. 3. *(-i)* хайрлах, арчлах, хамгаалах, сэргийлэх, сахих, сахин хамгаалах.

sakız *is.* давирхай, бах, сайхан үнэртэй цагаан давирхай, зажилдаг давирхай, бохь. **~ çiğnemek** бохь зажлах.

sakin *s.* 1. номхон, дөлгөөн, тогтуун, тайв ан намуун, хөдөлгөөн багатай, хөдлөц муутай. 2. нам гүм, дуугүй, чимээгүй. 3. амгалан, тайв ан, түвшин, төлөв, номхон, ажиггүй. 4. тайван, тайвширсан. 5. *esk.* оршин суугч, хүн. **~ olmak** 1) оршин суух, амьдрах, сууж байх. 2) тайвшрах, тайтгарах, амарлих.

sakinleşmek *(nsz)* амрах, тайвшрах, тайтгарах, санаа амрах, амарлих, уужрах, амсхийх, дуугүй болох, номхрох, дарагдах.

sakinleştirmek *(-i)* амруулах, санааг амраах, тайтгаруулах, тайвшруулах, дуугүй болгох, номхруулах, уужруулах.

saklama *is.* saklamak үйлийн нэр.

saklamak *(-i)* 1. далд хийх, цааш хийх, ил гаргахгүй байх, хадгалах. "*Bana gelen mektupları sakladım.*" Надад ирсэн захидлуудыг далд хийсэн. 2. *(-den, -i)* нуух, нууцлах, далдлах, халхлах, дарах, хаах. "*Ondan bu haberi saklamışlar.*" Түүнээс энэ мэдээг нууцгаасан байна лээ. 3. *(-i, -e)* хадгалах, үлдээх, тусгай тавих, хойш тавих. "*Eti buzdolabında saklamak.*" Махыг хөргөчинд хадгалах. "*Bu kitabı size sakladım.*" Би энэ номыг танд тавьсан юм. 4. *mec.* хамгаалах, хайрлан хадгалах, сахих, сахин хамгаалах. "*Allah saklasın.*" Бурхан өршөөг. Бүү үзэгд.

saklambaç, -cı *is.* нуугдаж тоглох.

saklanmak *(nsz)* 1. нуугдах, хорогдох, далд орох. 2. хадгалагдах.

saklı *s.* 1. нуусан, далдалсан, дарсан. 2. хадгалаастай. 3. нууц, далд, нууц далд, дараастай, хав дарсан.

saksağan *is. zool.* шаазгай.

saksı *is.* ваар, цэцгийн сав.

sal *is.* сал.

salak *s.* тэнэг, мунхаг, мангуу, донгио, ухаан муутай.

salaklaşmak *(nsz)* дүйрэх, дүйнгэтэх, мэнэрэх, тэнэгтэх, мунхрах.

salaklık, -ğı *is.* эргүү тэнэг, дүйрэн.

salam *is.* салам (хиамний нэг төрөл).

salata *is.* салат.

salatalık, -ğı *is.* өргөст хэмх.

salça *is.* 1. томат, улаан лоольны пастэ. 2. амт оруулах зүйл, хольц, хольцоо. сүмс.

saldırgan *is.* ve *s.* түрэмгийлэгч, халдан довтлогч, булимтрагч, довтлогч.

saldırganlık, -ğı *is.* түрэмгийлэл, халдан довтлох.

saldırı *is.* довтлого, халдлага, дайралт, түрэмгийлэл, халдан довтлох, давшилт.

saldırma *is.* 1. довтлого, халдлага, дайралт, атак, довтлох, дайран орох, түрэмгийлэл, халдан довтлох. 2. том хутга.

saldırmak *(-e)* 1. ухасхийх, давхийх, шуурхай давших, довтлох, дайрах, халдах, дайран орох. 2. *mec.* хурц шүүмжлэх, хэл амаар дайрах. 3. *(-den)* дарвуул дэлгэн хөдлөх. 4. *kim.* идэх, үйл ажилгаагаа явуулах, нөлөөлөх, нөлөө үзүүлэх. "*Asitler madenlere saldırır.*" Хүчил металлд үйлчилдэг. Хүчил металлыг иддэг.

saldırmazlık, -ğı *is.* үл довтлолцох. "*Saldırmazlık antlaşması.*" Үл довтлолцох гэрээ.

salep, -bi *is.* 1. *bot.* цахирам. 2. халуун ундаа (цахирамын үндсийг нүдэж бэлддэг).

salgı *is. biy.* ялгарах, шүүрэл, гоождос, ялгадас. **~ bezi** *anat.* шүлсний булчирхай. **~ dokusu** *bot.* ялгаруулах эд.

salgılamak *(-i) biy.* гаргах, ялгаруулах, шүүрүүлэх.

salgın *s.* 1. халдварт, халдвартай, тахалт. "*Salgın hastalık.*" Халдварт өвчин. 2. *is.* тахал, хижиг. 3. *is. esk.* цаг зуурын татвар. 4. *is.* нүүдэл. "*Çekirge salgını.*" Царцааны нүүдэл.

salhane *is.* мал нядлах газар, бойны газар.

salı *is.* мягмар гариг.

salıncak, -ğı *is.* дүүжин, дүүжин ор.

salınım *is. fiz.* хэлбэлзэл, чичиргээ, доргион.

salınmak *(nsz)* 1. найгах, ганхах, хэлбэлзэх, савлах, найгалзах, ганхалзах, гунхалзах, дайв алзах. 2. salmak үйлийн үйлдүүлэх хэв.

salıvermek *(-i)* тавих, гаргаж тавих, суллах, суллан тавих, чөлөөлөх, гаргах. "*Kuşu salıvermek.*" Шувууг суллан тавих.

salim *s. esk.* 1. мэнд сайн, эсэн мэнд, энх мэнд, эрүүл, бүрэн бүтэн. 2. осолгүй, аюулгүй, энх, амар.

salkım *is.* хонгорцог. "*Üzüm salkımı.*" Усан үзэмний хонгорцог.

salkımsöğüt, -dü *is. bot.* унжгар уд.

sallamak *(-i)* 1. бүйвээлэх, савах, ганхуулах, сэгсрэх, савалзуулах, найгалзуулах, хэлбэлзүүлэх, даллах, шарвалзуулах, шарвах. "*Çocuk sallamak.*" Хүүхэд бүүвэйлэх. "*Kuyruğunu sallamak.*" Сүүлээ шарвах. "*El sallamak.*" Гар даллах. 2. (ажил) сунжруулах, унжруулах, удаашруулах, хойш тавих, хойшлуулах, хойш татах, чангаах. "*İşimi bir hafta salladılar.*" Миний ажлыг долоо хоног хойш тавив. 3. *argo.* цохих, алгадах.

sallanmak *(nsz)* 1. хөдлөх, холхих, найгах, ганхах, гуйвах, хэлбэлзэх, найгалзах, саалах, дайвах, дайвалзах. "*Dişi sallanıyor.*" Шүд нь хөдлөж байгаа. 2. санжганах, ганхах, унжганах, хөдлөх. "*Lamba sallandı.*" Чийдэн ганхав. 3. савлах, савах. 4. хий дэмий холхих, сэлгүүцэх. 5. чичрэх, хөдлөх, доргих. "*Son depremde bütün şehir sallandı.*" Сүүлийн газар хөдлөлтөөр хот тэр аяараа доргилоо.

salma *is.* 1. salmak үйлийн нэр. 2. шувууны байр, шувууны хашаа. 3. *s.* эзэнгүй бэлчиж байгаа. "*Salma sığır.*" Эзэнгүй бэлчиж байгаа үхэр. 4. *s.* урсгал (ус).

salmak, -ar *(-i, -e)* 1. суллах, сул тавих, гаргаж тавих, чөлөөлөх, тавих, эрхээр нь байлгах. 2. яаралтай илгээх, нэн даруй явуулах, даруй илгээх. "*Haber salmak.*" Яаралтай дуулгах./Нэн даруй мэдэгдэх. 3. хийх, тавих. "*Ekmeği fırına salmak.*" Талх зууханд тавих. 4. үр жимс өгөх. 5. (татвар) ноогдуулах, хүлээлгэх, татах. "*Ona elli bin lira salmışlar.*" Түүнд тавин мянган лирийн татвар ноогдуулсан гэнэ. 6. оруулах, эрсдүүлэх. "*Başını derde salmak.*" Өөртөө гай удах. /Өөрийгөө хэцүү байдалд оруулах. 7. тухирах, туу гэх, тухиран тавих, туулгах. "*Tazıyı tavşana salmak.*" Нохойгоо туулай руу тухирах. 8. *(-e)* ухасхийх, дайрах, довтлох, халдах. "*Aç kurt, yılana da salar, taşa da! dedi.*" Өлсгөлөн чоно, могойруу ч дайрна, чулуурууч ч тэр, гэлээ. 9. буулгах, доош тавих, унжуулах. 10. *(-i) mec.* тоохгүй байх, үл ойшоох, үл тоомсорлох.

salon *is.* 1. зочдын танхим, зочлох тасалгаа, зочлох өрөө, зочдын өрөө, хүлээх тасалгаа, хүлээн авах тасалгаа, уулзах өрөө. 2. танхим, зал.

salt *zf.* 1. ердөө, зөвхөн, ганц, ганцхан, дан ганц. 2. *s.* дийлэнх, үнэхээр. "*Salt çoğunluk.*" Д ийлэнх олонх.

saltanat *is.* 1. ноёрхол, ноёрхох, ноёлох, хаан байх, хаан төр барих, захирах. 2. *mec.* хээнцэр байдал, хээнцэр тансаг байдал, элбэг сайхан амьдрах, тансаг амьдрал, гойд сайхан амьдрал. **~ sürmek** 1) ноёрхох, ноёлох, хаан байх, хаан төр барих, захирах, удирдах, барих. 2) тансаг сайхан амьдрах, элбэг дэлбэг амьдрах, баян тансаг амьдрах, элбэг сайхан амьдрах.

salya *is.* шүлс.

salyangoz *is. zool.* эмгэн хумс, дун хорхой, хорхойнцог.

saman *is.* сүрэл. **~ kağıdı** гэрэлтүүлэх цаас, гэрэлтүүлэх даавуу.

samanlık, -ğı *is.* сүрэл хадгалах байр, өвсний пин.

Samanyolu *z. is. astr.* тэнгэрийн оёдол, тэнгэрийн заадас.

samimi *s.* 1. үнэн зүрхний, үнэн сэтгэлийн, чин сэтгэлээсээ ярьдаг, цагаан сэтгэлтэй, ний нуугүй, илэн далангүй, дотнын, элэг зүрхний. "*Samimi bir insan.*" Цагаан сэтгэлтэй хүн./Чин сэтгэлээсээ ярьдаг хүн. "*Samimi bir arkadaş.*" Элэг зүрхний найз. 2. *zf.* ёсорхолгүй, эрээгүй. **~ samimi** үнэн сэтгэлээсээ, үнэнээсээ, үнэн голоосоо, чин сэтгэлээсээ, үнэн зүрхнээсээ, ний нуугүй, илэн далангүй, шууд. **~ olmak** ойр дотно болох, дотносох.

samimiyet *is.* 1. үнэн сэтгэл, цагаан сэтгэл, чин үнэн, цагаан санаа, ний нуугүй байх, илэн далангүй байх, элэгсэг байх, дотно байх. "*Onun samimiyeti hoşuma gitmişti.*" Түүний дотно байгаа нь надад таалагдсан. 2. чөлөөтэй (байх), албадлагагүй (байх), хавчигдалгүй (байх), нүүрэмгий зан.

samimiyetsizlik, -ği *is.* хуурамч, хуурмаг, ний нуугүй биш (байх), үнэн сэтгэл үгүй (байх), цагаан сэтгэлгүй(байх).

samur *is. zool.* 1. булга. 2. *s.* булган, булганы.

samyeli *is.* сирокко салхи.

san *is.* 1. алдар, алдар цуу, алдар нэр, нэр алдар, нэр, цуу, нэр төр, нэр хүнд. 2. хүнд, ямба, өргөмж, хүндэтгэх, хүндэтгэл.

sana *zm.* чамд, чамруу. **~ ne** чамд ямар хамаатай юм бэ?

sanal *s. mat.* хуурмаг, тухайлсан, бодит бус, дүрслэгдсэн. **~ sayı** хуурмаг тоо.

sanat *is.* 1. урлаг, уран сайхан. "*Sanat eseri.*" Урлагийн бүтээл. 2. уран бүтээл, зохиол. 3. чадвар, уран чадвар, ур, эрдэм, дүй. 4. дарх, гар ур, ажил, мэргэжил, мэргэшсэн ажил, эрхэлсэн ажил.

sanatçı *is.* ve *s.* 1. уран дархан, гар урлалч, гар урч. 2. уран зураач, жүжигчин, уран сайханч.

sanatoryum *is.* сувиллын газар (ихэвчлэн сүрьеэтэй хүмүүс байдаг).

sanayi, -i *is.* аж үйлдвэр, үйлдвэр. **hafif ~** хөнгөн үйлдвэр. **~ odası**

sanayici *is.* 1. аж үйлдвэрч, үйлдвэрийн эзэн. 2. *s.* аж үйлдвэрийн, үйлдвэрийн.

sanayicilik, -ği *is.* аж үйлдвэржилтийн бодлого.

sanayileşme *is.* үйлдвэржүүлэлт, үйлдвэржих.

sanayileşmek *(nsz)* үйлдвэржих.

sanayileştirme *is.* үйлдвэржүүлэлт, үйлдвэржүүлэх.

sanayileştirmek *(-i)* аж үйлдвэржүүлэх, үйлдвэржүүлэх, аж үйлдвэрийг хөгжүүлэх.

sancak, -ğı *is.* 1. туг, далбаа. 2. ёслолын туг. 3. *den.* хөлөг онгоцны баруун хажуу.

sancı *is.* хурц хатгаж өвдөх, хатгах, базлах, мушгих.

sancılanmak *(nsz)* өвдөх, хатгах, мушгилах.

sancımak *(nsz)* хатгах, өвдөх, янгинах, шархирах, чимчигнэх.

sandal (I) *is.* зандан мод.

sandal (II) *is.* завь, суман онгоц.

sandal (III) *is.* сандааль, сэрүүн шаахай.

sandalet *is. bk.* sandal (III).

sandalye *is.* 1. сандал, суудал. 2. *mec.* алба, албан тушаал. "*Sandalye kavgası.*" Албан тушаалын тэмцэл.

sandık, -ğı *is.* 1. хайрцаг, авдар, чингэлэг. 2. касса, мөнгө төлөх газар. 3. нийгмийн даатгалын газар .

sandıkçı *is.* хайрцагны худалдаачин, авдарны худалдаачин, чингэлэгний худалдаачин, хайрцаг (авдар, чингэлэг) үйлдвэрлэгч.

sandviç *is.* хачиртай талх.

sanı *is.* таавар, таамнал, таамаглал, таамаг, тэгнэ байгаа, тийм байх гэж, таамаглах.

sanık, -ğı *s.* ve *is.* хэрэгтэн, сэжиглэгдэгч, сэжигтэн.

saniye *is.* хором, секунд.

saniyelik, -ği *s.* хоромхон зуурын, хоромын. "*Saniyelik iş.*" Хоромхон зуурын ажил.

sanki *zf.* 1. мэт, шиг, адил, юм шиг, гэж үү? гэнэ, бололтой. "*Sanki gece olmuş gibi.*" Орой болсон юм шиг. 2. асуултын өгүүлбэрт анхаарал татах, сануулах утгаар хэрэглэнэ. "*Ne olur sanki, sen de gelsen?*" Үгүй ингэхэд чи яагаад очихгүй гэж?

sanlı *s.* алдартай, алдар нэртэй, нэртэй, нэртэй алдартай, цуутай.

sanmak *(-i)* бодох, үзэх, тооцох, санах, гэж бодох, гэж санах, шиг байх, шиг санагдах, төсөөлөх, багцаалах, тухайлах, таамаглах. "*Ben onu insan sanmıştım.*" Би түүнийг хүн гэж санасан юм. "*Doktor Sevim, hastaya ilk baktığı an kendinde değil sanmıştı.*" Сэвим эмч, өвчтөнг анх хараад түүнийг ухаангүй байна гэж бодлоо.

sansar *is. zool.* суусар.

sansür *is.* (кино жүжгийн зохиолыг) хянан шалгах, хянан шалгалга.

sansürlü *s.* хянан шалгасан.

santimetre *is. mat.* сантиметр.

santral, -li *is.* 1. (эрчим хүчний) төв станци. 2. утасны станци, утасны хороо, утасны өртөө. 3. утасны ажилтан, цахилгаан мэдээч.

sap *is.* 1. *bot.* иш, шилбэ. "*Çiçek sapı.*" Цэцгийн иш, шилбэ. 2. гар, иш, бариул, сэнж. "*Baltanın sapı.*" Сүхний иш. "*Tavanın sapı.*" Хайруулын тавагны бариул. 3. ороолт. "*Bir sap tire.*" Ороолт утас.

sapan *is.* 1. чавх, харвуур. 2. шидэгч хэрэгсэл.

sapasağlam *s.* бүв бүтэн, бүрэн бүтэн, цоо эрүүл, эв эрүүл.

sapık, -ğı *s.* 1. завхай, завхарсан, гаж донтой, алдагдсан, хэвийн бус, журмаас гажсан, дэг эвдсэн. "*Cinsi sapık.*" Бэлгийн гаж донтой./Зав хай. 2. солиотой, ухаан самуурсан, галзуу, өвчтэй.

sapıklık, -ğı *is.* 1. завхайрах, завхайрал, завхрал, гаж дон, журам гажих, дэг эвдэх. "*Cinsel sapıklık.*" Бэпгийн гаж дон./Завхайрал. 2. солио, ухаан самуурах, буруу үзэгдэл, гаж явдал.

sapıtmak *(nsz)* 1. самуурах, будлих, алдах, төөрөгдөлд орох, төөрөх. 2. *mec.* замаа алдах, буруу замд орох, учраа алдах, яадгаа алдах, хөл толгойгоо алдах. 3. төөрөх, буруу замаар орох. 4. *tkz.* солиорох, солиотой болох, галзууурах, ухаан солиорох, хийтэй болох.

saplamak *(-i, -e)* бүлэх, шаах, хатгах, шигтгэх, чичих, дүрэх, хадаах.

saplanmak *(-e)* 1. бүлэгдэх, шаагдах, хатгагдах, шигдэх, чичигдэх, шааж орох, хатгаж орох, зоогдох. "*Ok bacağına saplandı.*" Сум хөлөнд нь зоогджээ. 2. тээглэх, үлдэх, суух, хацах, хөндөлдөх, хавчуулдах, шигдэх. "*Araba kuma saplandı.*" Машин элсэнд суучихлаа. 3. *mec.* (өөр зүйл, өөр юм) бодохгүй байх, (өөр зүйл, өөр юм) сонирхохгүй байх, сонирхож үзэхгүй байх, гарахгүй байх, салахгүй байх.

saplantı *is. psikol.* улигт бодол, шаналгаа, салахгүй бодол.

saplı *s.* 1. бариултай, иштэй, сэнжтэй. 2. суусан, шигдсэн, зоогдсон, тээглэсэн. 3. *is.* урт бариултай сав.

sapmak, -ar *(-e)* 1. тойрох, эргэх, гарах, хазайх, гажих. 2. (үзэл бодолоос) гажих, хазайх, тийш хандах, өөрчлөгдөх. 3. *mec.* замаа алдах, буруу замд орох.

saptamak *(-i)* тогтоох, тодорхой болгох, тодорхойлох.

saptanmak *(nsz)* тогтох, тодорхой болох, тодорхойлогдох.

saptırmak *(-i, -e) bk.* sapıtmak.

sara *is. tıp.* унадаг өвчин.

saralı *s.* ve *is.* унадаг өвчтэй, унадаг өвчтэй хүн.

sararmak *(nsz)* 1. шарлах, шар болох. "*Sonbaharda yapraklar sararır.*" Намар навч шарладаг. 2. цайх, цонхийх, зэвхийх.

sarartmak *(-i)* шарлуулах, шар болгох.

saray *is.* ордон, орд, харш.

sardalye *is. zool.* сардина загас.

sardırmak *(-i, -e)* sarmak үйлийн үйлдүүлэх хэв.

sardunya *is. bot.* тарлан цэцэг, шимтэглэй.

sarf *is.* 1. зарцуулах, зарах, хэрэглэх, зарлага, гарлага, үрлэг, зардал, зарцуулалт, хэрэглээ. 2. *esk.* хэл зүй, хэлний зүй, хэлбэр зүй, өгүүлбэр зүй. **~ etmek** 1) зарцуулах, зарах, үрэх, гарлага хийх, гарз болгох. 2) хэрэглэх. "*Ağır sözler sarf etti.*" Хүнд үг хэрэглэсэн.

sarfiyat *is.* үрлэг, зарлага, гарлага, зардал, шимтгэл, зарцуулалт, хэрэгцээ.

sargı *is.* 1. бинт, шархны ороолт, боолт, ороолт, жийрэг. 2. ороогуур, ороомог (кабель утасны).

sargılı *s.* боолттой, ороолттой, ороогуур тай.

sarhoş *s.* ve *is.* согтуу, согтуу хүн, согтсон, согтуурсан.

sarhoşluk, -ğu *is.* согтолт.

sarı *is.* 1. шар, шар өнгө. 2. цонхигор, зэвхий, цайвар, бүдэг, цэгээн.

sarık, -ğı *is.* толгойн алчуур, толгойн ороолт, алчуур.

sarıkız *is. argo.* 1. хар тамхи. 2. *hlk.* үнээ.

sarıklı *s.* толгойдоо алчуур зүүсэн, толгойны алчууртай, толгойдоо ороолт ороосон, алчууртай.

sarılgan *s. bot.* ороонго (ургамал).

sarılık, -ğı *is.* 1. шар, шар өнгө. 2. *tıp.* шар өвчин, шарлах.

sarılmak *(nsz)* 1. ороогдох, ороох. 2. бие э ороох, дулаалах, битүүлж дулаалах. 3. ороолдох, тэврэх, ороогдох, хүзүүдэх. 4. *mec.* өөрийгөө зориулах. 5. хийж эхлэх.

sarımsak, -ğı *is. bot.* саримс.

sarınmak *(-e)* биеэ ороох, дулаалах, битүүлж дулаалах, ороох, боох.

sarışın *s.* 1. цайвар, цайвар үстэй, шар, шар царайтай, шар үстэй. 2. шаравтар.

sarkaç, -cı *is. fiz.* дүүжмэг.

sarkık, -ğı *s.* унжуу, санжуу, унжгар, санжгар, холхгор, унжсан, санжсан, холхойсон.

sarkıntılık, -ğı *is.* хоргоох, ээрэх, оролдох.

sarkıtmak *(-i)* унжуулах.

sarkmak, -ar *(-e)* унжих, санжих, унжиж санжих.

sarma *is.* 1. ороох, боох, баглах. 2. хүрээлэх, тойрох, бүслэх, бүслэн хаах, тойрон бүслэх. 3. нэг төрлийн хоол (байцаа, усан үзэмний навчинд ороосон).

sarmak, -ar *(-i)* 1. ороох, боох, баглах, уях, хүлэх, бинтээр боох. "*Yarasını sarmak.*" Шархыг нь боох. 2. хүрээлэх, тойрох, бүслэх, бүслэн хаах, тойрон бүслэх. "*Ordu düşmanı sardı.*" Арми дайсныг бүсэллээ. 3. бүрхэх, автах, бүчих. "*Yangın binayı sardı.*" Түймэр байшинг бүрхэв./ Байшин түймэрт автав. 4. ороох, эвхэх. "*İpliği sarmak.*" Утас ороох. 5. ороох, боох, хуйлах. 6. *(-i, -e)* ороох, боох, ваадагнах, гадарлах. 7. ороох, боох, хучих, бүтээх. 8. *(-e)* ороож бүрхэх, ороож битүүлэх, мушгиран бүрхэх. "*Asma çardağı sardı.*" Усан үзэм цэцэрлэг доторх сүүдрэвчийг бүрхэн ургажээ. 9. *mec.* сэтгэлд таарах, сэтгэлд зохих, сэтгэлд таатай байх, аятайхан санагдах, анхаарал татах, сэтгэл эзлэх, сонирхол татах.

"*Bu ev bizi çok sardı.*" Энэ гэр бидэнд их аятайхан санагдлаа. 10. тэврэх, хүзүүдэх.

sarmal *s. fiz.* эргүүлгэн, мушгиралдсан.

sarmaşık, -ğı *is.* ороонго ургамал.

sarnıç, -cı *is.* 1. газрын хөрсөнд барьсан усны сан, усны сав газар, усан сан, усны уурхай. 2. (усны) том төмөр торх, цистерн.

sarp *s.* 1. эгц, огцом, цавчим, авирашгүй, давшгүй. "*Sarp dağ.*" Эгц уул. 2. *is. mec.* бэрхшээл, хүнд байдал, төвөг, бэрх(байх), саад, тотгор.

sarraf *is.* мөнгө солигч, мөнгө задлагч.

sarraflık, -ğı *is.* мөнгө солих ажил, мөнгө задлах ажил.

sarsak, -ğı *s.* чичирдэг, салганадаг (өтөлж ядарсан, хөгширч сулбайсан, тэнхээ доройтсоноос).

sarsılma *is.* 1. донслох, доргих, ганхах, найгах, хөдлөх, донслолт, доргилт, ганхалт, найгалт, хөдлөлт. 2. цочирдол, цочирдох, доноголзох.

sarsılmak *(nsz)* 1. донслох, доргих, ганхах, найгах, хөдлөх, чичрэх, салганах, дагжих. "*Ev fırtınadan sarsılıyor.*" Байр салхинаас болоод ганхаж байна. 2. *mec.* доройтох, тамирдах. 3. цочирдох, доноголзох.

sarsıntı *is.* 1. доргих, донслох, донслолт, доргилт, хэлбэлзэх, найгалзах, долгих, чичрэх, дагжих, даржигнах, чичигнэх. 2. чичрэлт, чичрэх, дагжих. 3. газар хөдлөлт. 4. хямрал, цочирдол.

sarsmak *(-i)* 1. гүвэх, дугтрах, сэгсрэх, хөдөлгөх, ганхуулах, донсолгох, доргиох, найгуулах, доргиулах. 2. *mec.* донсолгох, түвшин тогтворгүй болгох, доргиулах, доройтуулах, муудуулах, урам хугалах, гуниг төрүүлэх. "*Bu haber beni çok sarstı.*" Энэ мэдээ намайг ихэд донсолголоо. "*Hastalık oğlanı pek sarsmadı.*" Хүү өвчнөөсөө болж нэг их муудаагүй.

sataşkan *s.* түрэмгийлэгч, довтлогч, халдан довтлогч, едөгч.

sataşmak 1. амруулахгүй байх, амраахгүй байх, наалдах, оролдох, салахгүй байх, зовоох, залхуу хүргэх, залхаах, хашраах, улиг болох, саад болох, үймүүлэх, тойв болох. 2. халдах, оролдох, наалдах, өдөх.

saten *is.* 1. пүүсүү, хээгүй торго, атлас. 2. сатин(даавуу).

satıcı *is.* худалдагч, худалдаачин.

satıh, -thı *is.* гадар, гадарга, гадаргуу, хавтгай, хавтаг, талбай.

satılık, -ğı *is.* худалдааны, худалдах, зарах. "*Adamın satılık binası varmış.*" Түүнд худалдах (зарах) байшин байгаа гэнэ. **satılığa çıkarmak** худалдах, зарах, худалдаанд гаргах, худалдаанд гаргаж тавих, худалдахаар тавих.

satılmak *(nsz, -e)* 1. худалдагдах, зарагдах, худалдаалагдаж байх. 2. *mec.* худалдагдах, биөэ худалдах, ашиг хичээн бусдад урвах, урваж орох. "*Düşmana satılmak.*" Дайсанд худалдагдах./Дайсанд урваж орох./Дайсанд биеэ худалдах.

satın *is.* **~ almak** худалдаж авах, авах.

satır *is.* мөр, бичгийн мөр. **~ başı** тэтгэсэн мөр, шинэ мөр, догол мөр, догол.

satış *is.* худалдаа, борлуулах, худалдах, борлуулалт. "*Perakende satış yapmak.*" Жижиглэн худалдаа. "*Toptan satış yapmak.*" Бөөний худалдаа хийх. **~ yapmak** худалдах, зарах.

satmak *(-i, -e)* 1. худалдах, зарах. "*Ayakkabıyı peşin parayla sattım.*" Би гутлыг бэлэн мөнгөөр зарсан. 2. *argo.* салах, мултрах, булталх. "*Yanımdakini satabilirsem size gelirim.*" Хажууд яваа хүнээсээ булталж чадвал би танайд очно. 3. *mec.* бардах, сайрхах, бардамнах, биеэ магтах, гайхуулах, ... хүний дүр үзүүлэх, ... хүний байдал гаргах, мэдэмгийрэх, мэргэмших, үнэд хүргэх. "*Her halde beni satmasını bilmiş olacak ki, ehemmiyetli bir adam gibi karşılandım.*" Сайн магтсаных л байх даа, намайг их л чухал хүн мэт хүлээж авцгаасан. 4. *mec.* худалдах, урваж орох, биеэ худалдах, ашиг хичээн бусдад урвах.

satranç, -cı *is.* шатар.

sattırmak *(-i, -e)* заруулах, худалдуулах.

savaş *is.* 1. дайн, байлдаан, тулалдаан. "*İkinci dünya savaşı.*" Дэлхийн хоёрдугаар дайн. 2. тэмцэх, тэмцэл. "*Veremle savaş.*" Сүрьеэтэй тэмцэх. **~ açmak** (veya **ilan etmek**) дайн зарлах, дайн дэгдээх.

savaşçı *is.* 1. цэрэг, дайчин цэрэг, цэргийн хүн, байлдагч. 2. тэмцэгч. 3. *s.* дайчин, эрэлхэг, цогтой, зоригтой, дайнч.

savaşkan *s.* дайнч, дайчин, эрэлхэг.

savaşmak *(nsz, -le)* 1. дайтах, байлдах, тулалдах, тулах. "*Birinci dünya savaşında savaşan askerler.*" Дэлхийн нэгдүгээр дайнд байлдаж явсан цэргүүд. 2. *mec.* чадлаараа оролдох, үхэн зүтгэх, тэмцэх, чармайх, мэрийх.

savcı *is.* хууль хамгаалагч, хууль сахигч, прокурор. **baş ~** ерөнхий прокурор.

savcılık, -ğı *is.* прокурор(байх), прокурорын ажил үүрэг.

savmak, -ar *(-i)* 1. хөөх, үлдэх, хөөж гаргах, хөөж зайлуулах, үлдэн хөөх, үргээх, халах, огцруулах, чөлөөлөх, чөлөөг олгох. "*Hizmetçiyi savmak.*" Үйлчлэгчийг халах. 2. ангижрах, хагацах, мултрах, гарах, салах. "*Hastalığı savmak.*" Өвчнөөс ангижрах. 3. *(-e, nsz) esk.* дэндүү болох, хорчийх, агшрах, өнгөрүү идээших, хатах, гандах, хагдрах. "*Vazodaki çiçekler savmış, yenilemeli.*" Ваараи дахь цэцэг хатжээ, солих хэрэгтэй.

savruk, -ğı *s.* 1. алмай, хайнга, сэтгэл самуурсан, мартамхай, анхааралгүй, анхаарамжгүй, хичээдэггүй. 2. назгай, салан задгай, эмх замбараагүй, эмх цэгцгүй.

savsak, -ğı *is.* (ажлыг) хааш яаш хийдэг хүн, салан хийдэг хүн, цалгар хийдэг хүн, оролдлогогүй хүн, хичээнгүй бус хүн, цалгар хүн, назгай хүн, хайхрамжгүй хүн, чирэгдүүлэгч, ярвиг татагч.

savsaklamak *(-i)* тоомсорлохгүй байх, эс тоомсорлох, хайхрахгүй байх, үл хэрэгсэх, эс хайхрах, үл тоох, эс ойшоох, хичээнгүй бус байдал гаргах, цалгай назгай байдал гаргах, хойшлуулах, хойш тавих, хойш татах, удах, саатуулах.

savsamak *(-i) bk.* savsaklamak.

savunma *is.* 1. хамгаалалт, батлан хамгаалах хүч. "*Savunma Bakanlığı.*" Батлан хамгаалахын яам. 2. (хэн нэгнийг, үзэл бодлыг) хамгаалах, өмгөөлөн хамгаалах, өмгөөлөх, өмөөрөх, өмгөөлөл, өмгөөлөлт. 3. *sp.* хамгаалалт.

savunmak *(-i)* 1. батлан хамгаалах, сахин хамгаалах, хамгаалах. 2. (үгээр, бичгээр) хамгаалах, хамгаалан өмгөөлөх, өмгөөлөх, өмөөрөх. "*Kendi düşüncesini savunmak.*" Өөрийнхөө үзлийг хамгаалах.

savunmasız *s.* хамгаалалтгүй, биеэ арчилж чадахгүй, арчаагүй, дорой.

savurgan *s.* үрэлгэн, үрэмтгий, үрэмхий, үрлэгч.

savurmak *(-i)* 1. цацах, хийсгэх. 2. (салхи) хийсгэх. 3. шидэх, чулуудах. 4. далайх, цавчих. 5. савлуулах, сарваганууллах. 6. (худал үг, хараал) хэлэх, хашгирах, харааж зүхэх, худлаа сүржигнэх, худлаа сагсуурах. 7. цацах, үрэлгэн байх, үрэх.

savuşmak *(nsz)* 1. сэм гарах, сэм зайлах, сэмхэн алга болох. 2. (өвчин, хэцүү байдлаас) салах, ангижрах, гарах, мултрах, сайжрах, эдгэрэх.

saya *is.* гутлын хэл.

sayaç, -cı *is.* тоолуур.

saydam *s.* 1. тунгалаг. 2. *is.* слайт. 3. *mec.* ойлгомжтой, тодорхой, илт, илэрхий, шууд. ~ **tabaka** *anat.* нүдний эвэр бүрхэвч.

saydırmak 1. тоолуулах, тооцуулах, бодуулах. 2. *(-i, -e)* хүндлүүлэх, тоомсорлуулах, тоолгох, хэрэгсүүлэх.

saye *is. esk.* 1. сүүдэр. 2. *mec.* ивээл, ивээх, хамгаалах, хамгаалал, хамгаалт, өмгөөлөл, өмөөрөл, хайцаалал, дэмжлэг, тусламж.

sayesinde *zf.* ачаар, тусламжаар, туслалцаагаар, шалтгаанаар, учир, учраас, тул, ... хүчинд. "*Dil bilmenin sayesinde her şey güzeldi.*" Хэл мэддэгийн ачаар бүх юм сайхан байсан.

sayfa *is.* хуудас.

sayfiye *is.* зуслангийн байр, зуны байр.

saygı *is.* хүнд, ямба, өргөмж, хүндлэх, хүндэтгэл, хүндэтгэх, тахимдуу, элбэрэл. ~ **duymak** хүндлэх, хүндэтгэх. ~ **göstermek** хүндэтгэх, хүндлэх, бишрэх, тоох, хүндэтгэл үзүүлэх.

saygıdeğer *s.* хүндэт, эрхэмсэг, хүндтэй, эрхэм.

saygılı *s.* хүндэтгэх, элбэрэлтэй, ачлалтай, тахимдуу, халамжтай, хайхрамжтай, эелдэг, найрсаг. "*Annesine ve babasına saygılı bir oğlandı.*" Ээж, аавдаа элбэрэлтэй хүү байсан.

saygın *s.* хүндэт, хүндтэй, эрхэм.

saygınlık, -ğı *is.* хүндлэх, хүндлэл, хүндэтгэл, бишрэх, бишрэл, хүнд, ямба, нэр төр, нэр хүнд, нэр, итгэх, итгэл, итгэмж.

saygısız *s.* хүндэтгэхгүй, тахимдгуу бус, хүндэт биш, эх захгүй, эрээ цээргүй, найрамдуу бус, эвлэг биш, эвч биш, ёсноос гажуу, бүдүүлэг.

saygısızlık, -ğı *is.* хүндэтгэхгүй (байх), тахимдуу бус (байх), найрамдуу бус явдал, эс хүндэтгэх, эс хүндлэх явдал, найралхаг бус (байх), эх захгүй байдал, эрээ цээргүй (байх), бүдүүлэг байдал.

sayı *is. mat.* 1. тоо. 2. (сонин, хэвлэлийн) дугаар. "*Derginin son sayısında...*" Сэтгүүлийн сүүлийн дугаарт... 3. *sp.* оноо.

sayıklama *is.* 1. дэмийрэх, солиорох, зүүдэндээ ярих. "*Sayıklamasını öteki odadan işitiyorduk.*" Бид, түүний зүүдэндээ ярьж байгааг нөгөө өрөөнөөс сонсож байлаа. 2. *mec.* хүслэн болох, бодол болох, санаа болох, сэтгэл зүүдний бодол, мөрөөдөл, хүсэл.

sayıklamak *(nsz, -i)* 1. зүүдэндээ ярих, дэмийрэх, солиорох. 2. *(-i) mec.* хүслэн болох, санаа болох, сэтгэл болох, санагалзах, сэтгэл зүүдэндээ бодох, мөрөөдөх, мун болох, хэнээтэх.

sayılı *s.* 1. тоотой, тоот. "*On sayılı kağıt.*" Арван тоот цаас. 2. тооцоотой, тоотой, тооцоолсон, тоолж дүгнэсэн, бүртгэсэн. "*Sayılı günler.*" Тоотой өдрүүд. 3. цөөхөн, цөөн, хэдхэн, тоотой. 4. *mec.* тоотой, хааяа болдог, ховор тохиолддог, ховор, чухаг. "*Bu gibi olaylar tarihte sayılıdır.*" Иймэрхүү явдлууд түүхэнд ховор тохиолддог.

sayılmak *(nsz)* тооцогддог байх, тоологддог байх, тооцогдох, тоологдох, гэгдэх, хэмээгдэх, гэж хэлцэх, нэртэй байх. "*Balina balıklardan sayılmaz.*" Халим загасанд тооцогддоггүй. "*İstanbul'un en güzel sayılacak yerlerinden birisi olan Dolmabahçe Sarayını gezmiştim.*" Би, Станбулын хамгийн сайхан газруудын нэг гэгддэг Долмабахчэгийн ордноор зугаалж байсан.

sayım *is.* тоо бүртгэл, бүртгэл, тооллого. "*Nüfus sayımı.*" Хүн амын бүртгэл.

sayın *is.* хүндэт, хүндэт, эрхэм, эрхэмсэг.

sayısal *s.* тооны, тооны талын.

sayısız *s.* тоолшгүй, тоо томшгүй, тоолж баршгүй, үй олон, үй түмэн, их олон.

Sayıştay *z. is.* Тооцооны дээд шүүх.

sayma *is.* тоо бүртгэл, бүртгэл, тооллого.

saymaca *s.* болзож тогтсон, болзмол, томъёолсон, нэрийдсэн, дуудсан, дурдсан, нэрийдэл, заасан.

saymak, -ar *(-i)* 1. тоолох, бүртгэх, тооллого хийх, бодож гаргах. "*Bahçedeki ağaçları saymak.*" Цэцэрлэг дэх модыг тоолох. "*Birden ona kadar saymak.*" Нэгээс арав хүртэл тоолох. 2. хүндэтгэх, хүндлэх, бишрэх, тоох, эрхэмлэх. "*Anam babamı nasıl saydı ise ben de kocamı öyle sayacaktım.*" 3. харгалзах, бодолцох, тоонд оруулах, тооцох, анхааралдаа авах, анхаарч үзэх. "*Bundan evvel verdiğimi saymıyor musun?*" Миний, үүнээс өмнө өгснийг бодолцохгүй юм уу? 4. учир холбогдлыг нь ойшоож үзэх, анхааралдаа авах, анхаарч үзэх. "*O, bu gibi âdetleri çok sayardı.*" Тэр, энэ мэтчилэнгийн зан заншилын учир холбогдлыг ихэд ойшоож үздэг байсан. 5. тооцох, тоолох, хэмээх, гэх, бодох, үзэх, гэж бодох, гэж санах. 6. тоочих, жагсаах. "*Onun yaptığı iyilikleri saymakla bitmez.*" Түүний хийсэн сайн үйлсийг тоочоод тоочоод баршгүй. 7. төлөх, тоолж өгөх, бэлнээр төлөх. "*İki bin lira saydı, bana küpe aldı.*" Хоёр мянган лир тоолж өгөөд надад эмэг авч өгсөн. **-ı hiçe ~** үл хэрэгсэх, үл тоох, эс хайхрах, эс ойшоох, үл томсорлох, үл хэрэгшээх, огт тоохгүй (байх), шал тоохгүй (байх), хүн гэж үзэхгүй (байх), юман чинээ бодохгүй (байх), хүний урманд тоохгүй (байх). "*Emeğini hiçe sayınca kız çok kırıldı.*" Хөдөлмөрийг нь юман чинээд бодоогүйд охин маш их гомджээ.

sayman *is.* данс хөтлөгч, нягтлан бодох, ня-бо.

saz (I) *is.* 1. хулс, зэгс, нишингэ. 2. *s.* хулсан, зэгсэн.

saz (II) *is.* саз (нэгэн төрлийн домбортой төстэй хөгжмийн зэмсэг).

sazan *is. zool.* булуу цагаан, салбарс, мөрөг(загас).

sazlık, -ğı *is.* хулс ихтэй газар, зэгс ихтэй газар, хулсан ширэнгэ, шагшуурга (нуур голын дотор ургасан зэгс зэрэг ургамлын бөөн хэсэг).

seans *is.* 1. зураг зуруулах нэг удаагийн хугацаа. 2. үзвэрийн цаг. 3. (ямар нэгэн үйлийн) тасралтгүй зарах хугацаа.

sebat *is.* хатуу, хөдлөшгүй, бат, хэлбэрэлтгүй байх, буцалт няцалтгүй (байх), бөх (байх), тэсвэр, хатуужил, тогтвор, гуйвалтгүй (байх), тогтв оржил, тогтвортой, нэг янз байх, шаргуу, нөр, шургуу зан, цохрөлтгүй оролдлого, няцашгүй зориг. **~ etmek** хэлбэрэлтгүй байх, хатуу байх, тогтвортой байх, тэсвэртэй байх, хатуужилтай байх, биеэ барьж чадах, шургуу зүтгэх, нөр зүтгэх, нөрлөх, үсэд зүтгэх, зүтгэх, зүтгэж бие лүүлэх.

sebatlı *s.* тэсвэртэй, хатуужилтай, тогтв ортой, хатуу, хэлбэршгүй, бат, гуйвалтгүй, хоёргүй, шургуу, цохрөлтгүй, цөхөрдөггүй.

sebatsız *s.* тогтворгүй, хувирамтгай, холив орхой, олон ааштай, урвамхай, зориг муутай, гуйвамтгай.

sebatsızlık, -ğı *is.* тогтворгүй байдал, хувирамтгай зан, олон ааш, хувирамтгай чанар, хувьсамтгай чанар.

sebebiyet *is.* шалтгаан, учир шалтгаан, харилцан шалтгаалах, шүтэн барилдах. **~ vermek** шалтгаан болох, шалтаг гаргах, шалтгаалах, хүргэх.

sebep, -bi *is.* шалтгаан, учир, учир шалтгаан, харгаа, шалтаг. **~ olmak** шалтгаан болох, шалтаг болох, шалтаг гаргах, шалтгаалах, хүргэх. "*Bir ara ne sebep oldu bilmem daha sık gelmeye başladı.*" Нэг хэсэг юунаас шалтгаалсан (юунаас болсон) юм бүү мэд илүү их ирэх болсон. **sebebiyle** учраас, шалтгаанаар, учир, тул.

sebeplenmek *(nsz)* жавших. "*Bu işten biz de sebeplendik.*" Энэ хэргээс бид ч гэсэн жавшаад авсан.

sebepli *s.* шалтгаантай, учир шалтгаантай, шалтагтай, учиртай.

sebepsiz *s.* 1. шалтгаангүй, учир шалтгаангүй, учиргүй, шалтаггүй, санамсаргүй, ухамсаргүй, үндэсгүй, үндэслэлгүй. "*Sebepsiz bir öfke.*" Шалтгаангүй уур. 2. *zf.* учиргүй, тийм ийм гэх юмгүй, шалтгаангүйгээр, зүв зүгээр байтал яасан ч учры нь мэдэхгүй, учир шалтгаангүйгээр, хий, дэмий, хоосон, талаар. "*Sebepsiz gülerdi.*" Учиргүй инээдэг байж билээ.

sebze *is.* ногоо. "*Taze sebze.*" Шинэ ногоо.

seccade *is.* мөргөлийн бяцхан хивс, залбирлын бяцхан хивс.

seçenek, -ği *is.* хоёрын л нэг, хоёрхноос нэгийг шилэх, хувилбар.

seçici *s.* сонгогч, сонгогчийн төлөөлөгч. **~ kurulu** шалгаруулах комисс.

seçik, -ği *is. bk.* açık seçik, ил тод, тод, тодхон, тодорхой.

seçilme *is.* сонгох, шилэх, сонголт, шилэлт.

seçilmek *(nsz)* сонгогдох, шилэгдэх.

seçilmiş *s.* 1. шилмэл, шилдэг, сонгомол, шалгарсан, шалгармал. "*Seçilmiş hikayeler.*" Шилдэг зохиолууд. 2. үлдэгдэл, үлдсэн. "*Bu seçilmiş kumaşların içinde iyisi de var.*" Энэ үлдэгдэл даавууны дотор авах юм бий.

seçim *is.* 1. сонголт, шилэлт, шигшин сайжруулах, сонгон үржүүлэх. 2. *huk.* сонгууль, сонголт. "*Yerel seçim.*" Орон нутгийн сонгууль.

seçkin *is.* сонгомол, шилмэл, сонгодог, шилдэг, шигшээ.

seçme *is.* 1. сонголт, шилэлт, шигшилт, шилэх, шигших. 2. *s.* шилмэл, шилдэг, шигшээ, сонгомол, сонгодог, шалгарсан, шалгармал.

seçmek, -er *(-i)* 1. сонгож авах, шилж авах, ялгах, ялгаж тэмдэглэх. "*Ben bu kitabı seçtim.*" Би энэ номыг сонгож авлаа. 2. шилэх, шилж авах, шигших, сонгох. "*Biz, sizi başkanlığa seçtik.*" Бид, таныг тэргүүнээр сонголоо. 3. ялган мэдэх, ялган таних, ялгаж харах, харах, таних, мэдэх. 4. ялгах, ялгаварлах, ангилах. "*O yemek seçer, öyle her şeyi yemez.*" Тэр хоол ялгана аа, тэгж юм болгоныг идэхгүй.

seçmeli *s.* сонгох эрхтэй, сонгох.

seçmen *is.* сонгогч.

seda *is.* дуу, дуу чимээ, чимээ анир.

sedef *is.* 1. тана, эржин, хясааны хацар. 2. *s.* танын, танан,танаар хийсэн, эржин.

sedef hastalığı *is. tıp.* хайрст үлд, хайрслаг үлд.

sedir (I) *is.* өргөн зөөлөн диваан, бандан, ханз.

sedir (II) *is. bot.* хуш.

sedye *is.* дамнуурга.

sefa *is.* 1. баяр, баясгалан, хөөр, хөөр баяр. 2. амар амгалан (байх), амар тайван (байх).

sefahat, -ti *is.* 1. завхай явдал, садар самуун, садар, ужид, замаа алдалт. 2. үрэмтгий байх, үрлэгч зан, үрлэгч явдал, үрлэг, үрэх.

sefalet *is.* туйлын ядуу байдал, туйлын ядуу зүдүү байдал, гуйлинч байдал, ядуу зүдүү байдал, үгийгүү байдал. **~ çekmek** ядах, зүдэх, дорой амьдрах, ядуу зүдүү байдал туулах, гачаал амсах, зовох.

sefaret *is.* элчин сайдын яам.

sefarethane *is.* элчин сайдын яам.

sefer *is.* 1. богино аялал, аялах, явах, зорчих, жуулчлах, жуулчлал, аян, замд явах, аян зам, замд мордох. "*Uzun bir sefere gidiyor gibi hazırlık yapardık.*" Бид, урт аянд явах гэж буй мэт бэлтгэл хийдэг байж билээ. 2. аян, аян дайн, довтолгоо, (цэргийн)ажиллагаа, явууллага. 3. удаа, дахин. "*Bu sefer gelirim.*" Энэ удаад би очно.

seferber *s.* дайны байдалд орсон, байлдааны байдалд бэлхэн(цэргийн анги).

seferberlik, -ği *is.* 1. дайчилгаа. 2. байлдааны байдалтай болгох, дайны байдалд оруулах, дайчилгаа.

sefih *s.* мөнгөнд үрэлгэн, завхай, садар, садар самуун, ужид, дампуу.

sefil *s.* 1. ядуу, хоосон, хэцүүдсэн, ядуу зүдүү, ядуу хоосон, ягир, хөөрхийлөлтэй, өрөвдөлтэй, ягтаа тулсан, дорой, ядуу дорой. "*Sefil bir ev.*" Ядуу хоосон гэр. 2. өөдгүй, өчүүхэн, шалиагүй, олиггүй, ой гутам, зэвүүцмээр, жигшүүрт.

sefillik, -ği *is.* хоосон, ядуу, тарчиг, гуйланч байдал, ядуу зүдүү байдал, гуйранч байдал, үгийгүү хоосон байдал.

sefir *is.* элчин, элчин сайд.

seğirmek *(nsz)* татвалзах, татганах, чазв алзах. "*Benim gözüm seğiriyor.*" Миний нүд татганаад байна.

seher *is.* үүр, үүр цайх, үүр гийх, үүрийн туяа, гэгээ.

sehpa *is.* 1. тавиур, тавьц. 2. сэтгүүлийн ширээ, явган ширээ. 3. зургийн ширээ, хөл, тулгуур. 4. цаазын дүүжлүүр.

sekiz *is.* 1. найм. 2. найман. "*Sekiz at.*" Найман морь.

sekizgen *is. mat.* найман өнцөгт.

sekizinci *s.* наймдугаар, найм дахь.

sekmek, -er *(nsz)* 1. харайх, дэгдэх, дэвхрэх, дэвхцэх, догонцох, догонцон явах, харайн гүйх, дэвхцэн гүйх, донгоцон гүйх, цовхрох. 2. туулай дэгдүүлэх, чулуу долгоолгох

sekreter *is.* нарийн бичиг, нарийн бичгийн дарга.

sekretlik, -ği *is.* нарийн бичгийн даргын үүрэг.

seksek, -ği *is.* "анги дэвших" хүүхдийн тоглоом.

seksen *is.* 1. ная. 2. наян. "*Dedem seksen yaşındadır.*" Өвөө маань наян настай.

sekseninci *s.* наядугаар.

sekte *is.* 1. зогсох, зогсолт, зогсонги байх, тогтонги байдал. 2. *mec.* хохирол, гарз, хор хомс. 3. *esk.* мэнэн өвчин, саа дайрах, цус харвах.

sektör *is.* салбар.

sel *is.* үер, их ус, хүчтэй ширүүн урсгал, ширүүн үерлэх. **~ basmak** үерлэх.

selâm *is.* мэндлэх, мэндчилэх, мэнд, амрыг эрэх, мэндийг лавлах. **~ etmek** мэнд мэдэх, мэндлэх, мэндчилэх. **~ söylemek** мэнд хүргэх, мэнд дамжуулах, мэнд илгээх, амрыг эрэх. **~ vermek** мэндлэх, мэндчилэх, мэндийг асуух, амрыг эрэх.

selâmet *is.* 1. амар мэнд, эрүүл саруул байх, эрүүл саруул байдал, элбэг дэлбэг, шим, буян, баялаг, хэрэгцээт бүхэн. 2. аюулгүй байдал, аюулгүй, осолгүй, энх, амар, бүрэн бүтэн.

selâmlamak *(-i)* мэндлэх, мэнд мэдэх, мэндчилэх, амрыг эрэх, мэндийг асуух, ёслох. "*Şapkasını çıkararak kadını selâmladı.*" Малгайгаа аван эмэгтэйн амрыг эрлээ.

selâmlaşmak *(nsz, -le)* 1. мэндлэх, мэндчилэх, амарчлах, мэндийг асуух, амрыг эрэх, харилцан мэндлэлцэх. 2. хальт таних, мэндээс цаашгүй байх, зүс таньдаг байх, зүс танихаас цаашгүй байх, нүүр үзсэн төдий байх, мэндийн төдий танил байх, бие биенийгээ бага зэрэг мэдэх. "*Pek ahbap değiliz, selamlaşırız.*" Бид их дотно бишээ, зүс танихаас цаашгүй.

selef *is. esk.* өмнөх зүтгэлтэн, өмнөх хүн, түрүүчийн хүн.

selim *s. esk.* 1. үнэн зөв, шударга, зөв шударга, өөгүй сайхан. 2. хоргүй, аюулгүй (хавдар).

selvi *is. bot. bk.* servi.

sema *is.* тэнгэр, огторгуй. "*Sema bulutsuz, güneşi berrak.*" Тэнгэр нь цэлмэг, нар нь тунгалаг.

semaver *is.* (ус буцалгах) халуун тогоо, самовар.

semavi *s. esk.* тэнгэрийн, огторгуйн.

sembol, -lü *is.* бэлгэ тэмдэг, бэлгэ, тэмдэг, бэлэгдэл. "*Bayrak, o vatanın sebolüdür.*" Далбаа нь уг улсын бэлгэ тэмдэг мөн.

sembolik, -ği *s.* бэлгэ тэмдэг болсон, бэлгэ болгосон, бэлгэтэй.

sembolist *s.* ve *is.* 1. бэлгэ тэмдэг болсон, бэлгэ тэмдэг болгосон, бэлгэтэй. 2. символизмыг баримтлагч.

sembolizm *is.* символизм (үйл явдал, шүтлэгийг бэлэг тэмдэгээр тайлбарлах үзэл).

sembolleşmek *(nsz)* бэлгэ тэмдэг болох.

sembolleştirmek *(-i)* бэлгэ тэмдэг болгох.

semer *is.* шоохой, ачааны эмээл.

semere *is. esk.* 1. идээ унд, жимс. 2. *mec.* үр, дүн, үр дүн, ач, ашиг, тус, ашиг тус.

seminer *is.* семинар.

semiz *s.* 1. тарган, бүдүүн, махлаг, мариатай, лухгар. 2. тарган, өөхтэй, тослог, тостой, хурц, бордмол, бордсон. "*Semiz tavuk.*" Тарган тахиа.

semizlik, -ği *is.* бүдүүн (байх), тарган (байх), мариатай (байх), таргалах, мариалах.

sempati *is.* сэтгэл татам байдал, дур булаам байдал, хайрлам дотно байдал, дотно байдал. ~ **duymak** талтай болох, элэгтэй байх, талтай байх, хайртай дотно байх, элгэмсүү байх, өөриймсүү байх. "*Kendisi okumamış olsa da öğrencilere karşı sempati duyuyordu.*" Тэр, хэдийгээр өөрөө сураагүй ч гэсэн сурагчдад элэгтэй байсан.

sempatik *s.* 1. нөхөрсөг, найзархаг, нийтэч, дур татам, урьхан, нүдэнд дулаахан, сэтгэл татам, дур булаам. 2. аятайхан, аштайхан, гаалamжтай, таатай, сайхан.

semt *is.* 1. нутаг, орон нутаг, хороо, хэсэг, дүүрэг, район. 2. азимут, зовхис, чиг.

sen *is.* чи. ~**ce** чиний бодлоор, чинийхээр бол.

senaryo *is.* кино зохиол, тайзны зохиол, жүжгийн туурвил.

senato *is.* 1. сенат (зарим улсын хууль тогтоох дээд танхим). 2. эрдмийн зөвлөл.

senatör *is.* сенатач, сенатын гишүүн.

sendelemek *(nsz)* 1. бүдрэх, бүдэрч ойчих, тээглэх, тээглэж унах, тээглэлдэх, өлгөгдөх, торох, гуйвах, гуйвганах. "*Ayağı bir taşa takılıp sendeledi.*" Хөл нь чулуунд тээглэн бүдэрлээ. 2. *mec.* самбаа алдах, сандрах, мэгдэх, самгардах. "*Bu haberi alınca fen hâlde sendeledi.*" Тэр, энэ мэдээг аваад бүр самгардлаа.

sendika *is.* үйлдвэрчний эвлэл.

sendikacı *is.* үйлдвэрчний эвлэлийн зүтгэлтэн.

sendikacılık, -ğı *is.* үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн.

sene *is.* жил, он. "*Sene 1946, mevsim sonbahar.*" 1946 оны намар.

senelik, -ği *s.* жилийн, жил тутмын.

senet, -di *is.* өр төлөх баталгаа, нотолгоо, нотлол, баримт.

senetli *s.* өр төлөх баталгаа бүхий, нотолгоотой.

senfoni *is. müz.* симфони, яруу хөгжим. ~ **orkestrası** симфони найрал хөгжим.

senfonik *sf.* симфонийн.

senin *zm.* чиний.

senkron *s.* зэрэг цаг.

senkronik, -ği *s.* зэрэг цагийн, зэрэг цагт, синхрон.

sentetik, -ği *s.* нийлэг, синтезлэж гаргасан.

sentez *is.* нийлэг, синтез.

sepet *is.* 1. сагс, араг, шээзгий. 2. сүлжмэл гувчуур, гүр(загас барих тор). 3. *sp.* сагс.

sepetçi *s.* 1. сагс үйлдвэрлэгч, сагсны худалдаачин. 2. *hlk.* цыган.

sepetlemek *(-i)* 1. сагсанд хийх. 2. *tkz.* гаргаж тавих, хөөж гаргах, хөөж зайлуулах, хөөж явуулах, нүднээс далд оруулах, хөөх, халах (ажлаас). "*Zaten işe yaramaz adamdı, o yüzden onu sepetledim.*" Угийн олиггүй хүн байсан, тиймээс би түүнийг хөөж явуулсан юм.

sepetlenmek *(nsz)* sepetlemek үйлийн үйлдэгдэх хэв.

sepetli *s.* сагстай.

sepi *is.* арьс элдэх, арьс элдэлт, арьс болов сруулах, боловсруулалт.

sepi *is.* ширчин, элдүүрчин.

sepilmek *(-i)* элдэх, боловсруулах.

septik, -ği *is. fel.* үл итгэх үзэлтэн, скептицизмийг баримтлагч, скептик.

septisizm *is. fel.* үл итгэх үзэл, скептицизм.

sera *is.* хүлэмж.

seramik, -ği *s.* 1. шавар, вааран, шаазан. 2. *is.* ваар эдлэл, шаазан эдлэл.

serap, -bı *is.* зэрэглээ.

serbest *s.* 1. чөлөөтэй, чөлөөт. 2. эрх чөлөөтэй, чөлөөт. 3. сул, завтай, чөлөөтэй. "*Geleceksen sabahleyin gelin, o vakitlerde serbestim.*" Ирвэл өглөөгүүр ирээрэй, би тэр үеэр завтай байна. 4. албадлагагүй, чөлөөтэй, эрээгүй, нүүрэмгий, хавчигдалгүй. 5. задгай, хэнэггүй, ичиж зовохгүй (эмэгтэй). 6. чөлөөтэй, чөлөөт, хориулгүй, саадгүй, саад тотгоргүй, торохгүй. 7. *zf.* чөлөөтэй, зоргоороо. "*Serbest tercüme.*" Чөлөөтэй орчуулга, найруулан орчуулах. ~ **bırakmak** суллах, тавих, чөлөөлөх, эрх чөлөөтэй болгох.

serbestçe *s.* ve *zf.* тааваараа, хэнэггүй, чөлөөтэй, албадлагагүй, эрээгүй, нүүрэмгий, хавчигдалгүй.

serbestlik, -ği *is.* 1. эрх чөлөө, эрх, тусгаар тогтнил, биеэ даасан байдал, чөлөөт байдал. 2. эрээгүй(байх), албадлагагүй(байх), нүүрэмгий зан, хавчигдалгүй(байх), чөлөөтэй(байх).

serçe *is. zool.* бор шувуу, богширго, гятруу бялжуухай. ~ **parmak** чигчий хуруу.

serdar *is. esk.* цэргийн тэргүүн, жанжин, командлагч.

sere *is.* сөөм(хэмжээ).

serdümen *is.* усан онгоцны залуурч, залуурчин.

seren *is. den.* 1. хөндлөн мод. 2. хаалганы тотго.

serenat, -dı *is.* хандал дуу, хандал аяз.

sergi *is.* 1. үзэсгэлэн. 2. бүхээг, гудамжны мухлаг.

sergici *is.* хайрцгийн худалдаачин.

sergilemek *(-i)* дэлгэж тавих, үзэсгэлэнд тавих, үзмэр болгох, үзүүлэх, үзүүлэн таниулах, харуулах, танилцуулах.

sergilenmek *(nsz)* sergilemek үйлийн үйлдэгдэх хэв.

serhat, -ddı *is. esk.* хил, хязгаар, хилийн шугам, хил хязгаарын шугам.

seri (I) *is.* 1. цуврал. 2. цуврал, цувралын. "*Seri imalatı.*" Цуврал үйлдвэрлэл, цуврууллан үйлдвэрлэх.

seri (II) *s.* хурдан, түргэн, даруй, бушуу, шамдуу.

serili *s.* дэвссэн, дэлгэсэн.

serilmek *(-e)* 1. дэлгэгдэх, дэлгэсэн байх, дэвссэн байх. 2. сунаж хэвтэх, хэвтэх, тарайн хэвтэх, налайн хэвтэх. "*Kumun üstüne serildi.*" Элсэн дээр тарайн хэвтлээ.

serin *s.* сэрүүн, сэрүүхэн, жихүүн, хүйтэвтэр, хүйтэрхүү, жавартай.

serinkanlı *s.* самбаатай, уужим дотортой, дотор тайван, ажиггүй, амгалан.

serinkanlılık, -ğı *is.* самбаа, уужим дотор, тайван дотор, ажиггүй байдал.

serinlemek *(nsz)* 1. сэрүүн болох, сэрүү орох, сэрүүсэх, жихүүн орох, жихүүрэх, хүйтэв тэр болох. 2. сэрүүцэх. 3. *mec.* сэргэх, уйтгараа гаргах, мартах, (зовнил) арилах, (зовнил) үгүй болох, самуурах, саатах.

serinletmek *(-i)* сэрүүн болгох, сэрүүцүүлэх, салхи оруулах.

serinlik, -ği *is.* 1. хүйтэн, жавар, жихүүн, сэрүүн, сүүдэр. 2. сэрүүн, сэрүү. "*Akşam serinliği.*" Оройн сэрүүн.

serkeş *s.* дагахгүй, мэдэлд орохгүй, дагаар орохгүй, үг дуулахгүй, дуулгаваргүй, үг дагахгүй, үймээн гаргасан.

serkeşlik, -ği *is.* дагахгүй(байх), мэдэлд орохгүй (байх), дагаар орохгүй (байх), үг дуулахгүй (байх), дуулгаваргүй, үг дагахгүй (байх), эс хүлээх.

sermaye *is.* 1. хөрөнгө, капитал. 2. *mec.* хөрөнгө мөнгө, өмч хөрөнгө, бэл бэнчин. 3. *mec.* эмсийн хүрээлэнгийн янхан.

sermayeci *is.* хөрөнгө оруулагч, үндсэн хөрөнгө оруулагч, капиталист.

sermek *(-i, -e)* 1. өлгөх, өлгөж тавих. "*Çamaşırları serip eve girdi.*" Хувцаснуудыг өлгөж тавьчихаад гэрлүүгээ орлоо. 2. дэлгэх, дэлгэж тавих, тархаан тавих, дэвсэж тавих, дэвсэх, хатаахаар дэлгэх. 3. тавих, өрөх, дэвсэх, дэвсгэрлэх. 4. *mec.* (ажил)сунжруулах, унжруулах, удаашруулах, дарах, дарагдуулах.

serpelemek *(nsz)* шиврэх, шивэр шивэр орох.

serpilmek *(nsz)* 1. serpmek үйлийн үйлдэгдэх хэв. 2. өсөх, том болох, томрох, ургах.

serpiştirmek *(-i, -e)* 1. шиврэх, шивэр шивэр орох, будрах, хаялах. 2. түсэргэх, үсэргэх, цацах, цацруулах.

serpmek *(-i, -e)* 1. тархаан хаях, цацах, тархаах, бутаргах, өгөх, асгах, үйрүүлэх. "*Kuşlara yem serpmek.*" Шувуунд идэш цацах. 2. цацах, шүрших, үсэргэх, тургих, сүрших, цавдах. "*Yüzüne su serpti.*" Нүүрлүү нь ус шүршив. 3. *(nsz)* шиврэх, шивэр шивэр орох, дуслах. "*Yağmur serpiyor.*" Бороо шивэрч байна.

sersem *s.* 1. алмай, хайнга, сэтгэл самуурсан, салан задгай. 2. мангуурсан, дүйнгэрсэн. **~ olmak** мангуурах, дүйнгэрэх.

sersemlemek *(nsz)* бэгтрэх, зог тусах, зог хийх, мангуурах, дүйнгэрэх.

sersemlik, -ği *is.* 1. бэгтрэх, мэгдэх, мэдээ алдах, ухаан алдах, манарч ойчих, хиртхийн цочих, цочирдон гайхах, мангуутах, эргүүтэх, тэнэгтэх. "*Uyku sersem-liğiyle ne dediğini hatırlamıyordu.*" Нойрмоглоод юу гэж хэлснээ санахгүй байлаа. 2. мартамхай, алмай, хайнга байх, сэтгэл самуурах.

serseri *s.* ve *is.* 1. тэнүүлч, хэсүүлч, зайгуулч, бадарчин. 2. хэсүүл, тэнэмэл, хэрмэл, золбин, зайгуул, дэмий хэсүүлч, ажилгүй тэнэгч, завхай, замаа алдсан, олхиогүй, завхарсан, ёс алдсан. 3. галзуу, хийтэй, сагсуу. **~ kurşun** тэнэсэн сум.

serserilik, -ği *is.* хэсүүчлэх, тэнүүчлэх

sert *s.* 1. хатуу. 2. хатуу, ширүүн, уян биш, хөшүүн, уян хатан биш. "*Sert kösele.*" Ширүүн шир. 3. хатуу, чанга, ширүүн (улиралтай), эрс тэс, хахир, хүйтэн. 4. хатуу, ширүүн, догшин, эрс хатуу, эрс тэс. "*Sert bir insan.*" Ширүүн хүн. "*Sert cevap verdi.*" Эрс хатуу хариулт өгөв. 5. чанга, хатуу, шаардлагатай. "*Sert bir patron.*" Чанга дарга. 6. ширүүн, хүчтэй, хүчтэй ширүүн. "*Sert adımlarla ilerledi.*" 7. хатуу, чанга, хахуун. "*Sert şarap.*" Хатуу дарс. "*Sert sigara.*" Хатуу тамхи.

sertifika *is.* үнэмлэх, үнэмлэх бичиг, гэрчилгээ, сертификат.

sertifikalı *s.* үнэмлэхтэй, гэрчилгээтэй, сертификаттай.

sertleşmek *(nsz)* 1. хатуурах, хатуу болох. 2. чангарах, ширүүсэх. 3. *mec.* хатуурхах, хатуу зан гаргах, ширүүлэх, ширүүн зан ааш гаргах.

sertlik, -ği *is.* 1. хатуу чанар, хатуу (байх), чанга (байх). 2. ширүүн зан, догшин харьцаа, харгис хэрцгий, хэрцгий явдал, харгис догшин явдал.

serum *is. tıp.* вакцин, халдварыг сэргийлэх тарилга, ийлдэс, (цусны) шар ус, дусал.

serüven *is.* адал явдал.

serüvenci *is.* адал явдалд дуртай, адал явдалч, аз туршсан.

servet *is.* 1. баялаг, элбэг дэлбэг. "*Servet içinde yaşamak.*" Элбэг дэлбэг амьдрах. 2. үнэт (эй) зүйл, баялаг, хөрөнгө, хөрөнгө зөөр, хөрөнгө хогшил, эд зөөр. "*Milli servet.*" Үндэсний баялаг.

servi *is. bot.* агар (мод), майлс.

servis *is.* 1. үйлчлэх, үйлчилгээ. 2. хоолны бүрэн иж хэрэгсэл. 3. алба, хэлтэс, департамент. 4. унаагаар үйлчлэх үйлчтлгээ. 5. *sp.* бөмбөг давуулах, бөмбөг гаргах (теннис, гар бөмбөг). **~ atmak** *sp.* бөмбөг давуулах, бөмбөг гаргах (теннис, гар бөмбөг). **~ yapmak** үйлчлэх, үйлчилгээ хийх.

ses *is.* 1. дуу. "*Alçak ses, yüzkek ses.*" Нам дуу, өндөр (чанга) дуу. 2. дуу, авиа чимээ, анир. 3. *mec.* дуу хоолой, үзэл бодол. "*Gençlerin sesini duyuran başka bir dergide...*" Залуусын дуу хоолойг хүргэж буй өөр нэг сэтгүүлд ... 4. *mec.* сайхан хоолой. "*Sendeki ses kimde var?*" Чинийх шиг сайхан хоолой хэнд байна аа? 5. *müz.* хөг. "*Yarım ses.*" Саармаг хөг, хагас хөг. **~ çıkmamak** сураг чимээгүй байх, сураг чимээ ирэхгүй байх. **~i çıkmamak** юу ч ярихгүй байх, дуугай байх, дуугүй байх. **~ini çıkarmamak** дугай байх, чимээгүй байх. үл татгалзах, саналаа үл хэлэх, (хүнд) хэлэхгүй байх. **~ini yükseltmek** дуугаа чангаруулах.

sesbilimi *is. gr.* авиан зүй.

seslendirme *is. sin.* дуу оруулах, дуутай болгох.

seslendirmek *(-i)* 1. дуу оруулах, дуутай болгох. 2. *müz.* дуулах, дуулж байх.

sesleniş *is.* дуудах, дуудах дуу, дуудах аялга.

seslenmek *(nsz, -e)* 1. дуудах, дуу тавих, хашгирах. "*Birkaç adım yürüdü, seslendi.-Yusuf bey, Yusuf bey.*" Хэд алхаад, Юсуф гуай, Юсуф гуай хэмээн дуудлаа. 2. хариу өгөх, хариулах, чимээ гаргах, аа гэх, хариу дугарах. 3. *mec.* хандах, хандаж хэлэх.

sesli *s.* 1. дуутай, дуу гаргадаг. 2. *zf.* хангинам, дунгинам, жингэнэсэн, цангинасан, чанга, дуутай, чанга дуугаар, чимээтэй, шуугиантай, шаагиантай, дуу шуутай. 3. *s.* ve *is. gr.* эгшиг.

sessiz *s.* 1. хоолой муутай, дуу багатай. 2. чив чимээгүй, аниргүй, дуугүй, чимээгүй, шуугиангүй, нам гүм, анир чимээгүй, дугай. 3. дугай, дуугүй, үг цөөнтэй, үгэнд дургүй, цөөн үгтэй, үг дуугүй. 4. номхон, ноомой, дөлгөөн, түвшин, бүрэг, улиг үггүй, дугай (хүн). 5. *is.* ve *s. gr.* гийгүүлэгч.

sessizce *zf.* нам гүм, чимээгүй, анир чимээгүй, дуугүй, таг чиг, чив чимээгүй, аниргүй, чимээгүйхэн, шуугиангүй. "*Biz eve sessizce girdik.*" Бид байшинд чимээгүй оров.

sessizleşmek *(nsz)* намдах, чимээгүй болох.

sessizlik, -ği *is.* 1. дуугүй(байх), чимээгүй (байх). 2. чив чимээгүй (байх), таг чиг (байх), аниргүй (байх), нам гүм, чимээгүй, анир чимээгүй.

set (I) *is.* 1. далан, хаалт, ус хаах далан. 2. дэнж, дэв, дэвсэг. 3. хэрэм.

set (II) *is. sp.* тоглолт(спорт), тэмцээний хэсэг, өрөг.

sevap, -bı *is.* 1. буянт үйл, сайн үйл, буянтай үйл, ач тус, буян. 2. буян, шан, шагнал. **~ kazanmak** буян үйлдэх, буян хураах, буянт үйл хийх.

sevda *is.* 1. хайр, амрагийн сэтгэл, янаг, хайр дурлал, хайр сэтгэл. 2. хүслэн, мөрөөдөл, хүсэл мөрөөдөл, хүсэл. **~sına düşmek** хүслэн болох, мөрөөдөл болох. "*Babam son zamanlarda roman yazma sevdasına düştü.*" Аав маань сүүлийн үед роман бичихийн хүслэн болоод байгаа.

sevdalanmak *(nsz)* хайртай болох, хүчтэй дурлах, янаг болох, сэтгэлтэй болох, хайр сэтгэлтэй болох.

sevdalı *s.* 1. янаг амраг, дурласан, дуртай. 2. *mec.* тэсгэлгүй дуртай, шуналтай хүсэгч.

sevdirmek *(-i, -e)* хайртай болгох, дуртай болгох, дурлуулах, биедээ татах. "*Çocuklara okulu sevdirmeli.*" Хүүхдүүдээ сургуульд дуртай болгох хэрэгтэй.

sevecen *s. hlk.* нинжин, зөөлөн сэтгэлтэй, өрөвчхөн, энхрий, энхрий зөөлөн, нигүүлсэнгүй, энэрэнгүй, өр нимгэн, өрөвдөх сэтгэлтэй.

sevecenlik, -ği *is.* нигүүлсэнгүй сэтгэл, энэрэнгүй(байх), энхрийлэл, эрхлүүлэх, зөөлөн сэтгэл, өрөвдөх сэтгэл.

sevgi *is.* хайр, амрагийн сэтгэл, энхрийлэл. **~ beslemek** хайрлах.

sevgili *s.* 1. хайртай, хайрт, эрхэм, хүндэт, энхрий. "*Sevgili anneciğim, seni çok özledim.*" Хайрт ээж минь би таныгаа их санаж байна. 2. *is.* янаг, янаг амраг, амраг, хайртай, хайрт хүн, найз, нөхөр.

sevilmek *(nsz)* хайрлагдах, хайрлуулах, таалагдах, хайртай байх, дуртай байх. "*Sevilen şarkılar.*" Дуртай (таалагддаг) дуунууд.

sevimli *s.* ялдамхан, аятайхан, хөөрхөн, дур татам, урьхан, нүдэнд дулаахан, эгдүүтэй. "*Sevimli çocuk.*" Эгдүүтэй хүүхэд.

sevimlilik, -ği *is.* хөөрхөн (байх), эгдүүтэй (байх), аятайхан царай.

sevimsiz *s.* дургүйцмээр, дур гутмаар, ой гутмаар, жигшмээр, бөөдий, их муухай, таалам жгүй, дургүй хүрэх.

sevinç *is.* баяр, баясгалан, хөөр, баяр хөөр, баяр баясгалан, зугаа, цэнгэл, хөөрөх. "*Sevinç gözyaşları döktü yaşlı adam.*" Өвгөн баярын нулимс унагав.

sevinçli *s.* баяртай, баясгалант, баяр хөөртэй, баяр баясгалантай, зугаатай, цэнгэлтэй. "*Sevinçli haber.*" Баяртай мэдээ.

sevindirici *s.* баярлууштай, баяртай, баярламаар, баярлахаар. "*Sevindirici haber geldi.*" Баяртай (баярлууштай) мэдээ ирлээ.

sevindirmek *(-i)* баярлуулах, баясгах, зугаацуулах, цэнгүүлэх, уйтгарыг гаргах, наадуулах, бахыг хангах. "*Bu haber ailemi çok sevindirecek.*" Энэ мэдээ гэрийхнийг маань маш их баярлуулна даа.

sevinmek *(-e)* баярлах, баясах, хөөрөх, хөөр болох, баяр хөөр болох.

sevişmek *(nsz, -le)* 1. бие биенээ хайрлах, бие биеэндээ хайртай байх. 2. хурьцал үйлдэх.

seviye *is.* түвшин, хэмжээ. "*Halkın kültür seviyesi...*" Ард түмний соёлын хэмжээ...

seviyeli *s. mec.* өндөр хэмжээ, эрхэм дээд, ариун сайхан. "*Bütün bir gün süren bu seminer çok seviyeli geçti.*" Бүхэл өдөр үргэлжилсэн энэ семинар их өндөр хэмжээнд болж өнгөрлөө.

seviyesiz *s. mec.* дорой, бага, өдөр тутмын, өрийн, эгэл, энгийн, жирийн, дунд зэргийн.

sevk *is.* 1. илгээх, явуулах, гуйвуулах, зөөж гаргах, илгээлт. 2. санаа, санал, өдүүлбэр, түлхэх, түлхэлт. **~ etmek** 1) илгээх, явуулах, томилох. 2) өдөж байх, өдөөх, түлхэх, оруулах, түлхэн оруулах. "*Beni buna sevk eden sebepler.*" Намайг үүнд түлхсэн шалтгаанууд.

sevkiyat *is.* илгээх, явуулах, зөөх, нүүлгэх, шилжүүлэх, шилжүүлэн аваачих. "*Asker sevkiyatı.*" Цэрэг шилжүүлэн илгээх.

sevmek *(-i)* 1. хайрлах, хайртай (байх), дурлах, амраглах. "*Yurdunu sevmek.*" Эх орноо хайрлах. "*Annesini çok seviyor.*" Ээждээ маш их хайртай. 2. дуртай (байх). 3. энхрийлэх, эрхлүүлэх, таалах. **seyahat** *is.* жуулчлал, жуулчлах, аян, богино аян, аялах, зорчих, сонирхон хэсэх. **~ etmek** сонирхон хэсэх, аялах, аялал хийх, жуулчлах.

seyir, -ri *is.* 1. явц, явалт, явах, ажиллах, эргэх, ажиллагаа, явдал. 2. замд гарах. "*Seyir durumunda gemi.*" Замд гарсан усан онгоц. 3. үзвэр.

seyirci *is.* үзэгч. **~ kalmak** үзэгчийн байр суурьнаас хандах, ажиглах, хараад зогсох.

seyis *is.* ve *s.* адууч, агтач.

seyrek, -ği *s.* 1. таруу, шингэн, сийрэг, сийрэгхэн, оочин тоочин. "*Seyrek saç.*" Шингэн үстэй. 2. ховор, хааяа ирдэг, ховор тохиолддог. 3. *zf.* хааяа, ховор, цөөн.

seyrekleşmek *(nsz)* сийрэгжих, сийрэг болох, тархан байрлах.

seyreklik, -ği *is.* сийрэг (байх), шингэн (байх).

seyretmek *(-i, nsz)* 1. харах, шагаах, үзэх. 2. ажиглах, ажиглан харах, ажиглан суух, харах. "*Onların görüşmesini seyrediyordu.*" Тэдний уулзахыг ажиглаж суулаа. 3. (усан онгоц) явах, хөдлөх, (урагш) давших, рейс хийх.

seyyar *is.* 1. бидэгч, хэсүүл, хэрмэл. "*Seyyar satıcı.*" Ганзагын худалдаачин, үүргийн худалдаачин, хайрцгийн худалдаачин, дамнуурын худалдаачин. 2. нүүдлийн, зөөдөг, зөөврийн. "*Seyyar hastane.*" Нүүдлийн эмнэлэг.

sezaryen *is.* кесаров мэс засал, кесаров огтлол (хүндрэлтэй төрөлтийн үед).

sezdirme *is.* мэдэгдэх, мэдүүлэх, мэдрүүлэх.

sezdirmek *(-i, -e)* мэдэгдэх, мэдүүлэх, мэдрүүлэх, ойлгуулах. "*Doktorlar ona birşey sezdirmediler.*" Эмч нар түүнд юу ч мэдэгдээгүй.

sezgi *is.* 1. зөн билиг, зөгнөл, зөн, ёр, совин, урьдаас мэдэх. 2. мэдрэх чадвартай, урьдаас мэдэх чадалтай, совинтой, зөнтэй, зөнч. 3. *fel.* зөн билгийн онол (юмыг шинжлэх ухааны ёсоор задлан шинжлэхгүй, "шууд бясалгаж" мэдэж болно гэж үздэг үүн ухааны чиглэл).

sezgicilik, -ği *is. fel.* зөн билгийн онол.

sezi *is. bk.* sezgi.

sezgili *s.* зөн билгийн, зөгнөсөн.

sezilmek *(nsz)* мэдэгдэх, харагдах, үзэгдэх, мэдрэгдэх, ажиглагдах.

sezinlemek *(-i)* зөгнөх, ёрлох, совин татах, урьдаас мэдрэх, таамаглах, гадарлах, таав арлах, таах, мэдэх, мэдрэх, ухах, тухайлах.

sezmek, -er *(-i)* 1. зөгнөх, ёрлох, совин татах, урьдаас мэдрэх, таамаглах, гадарлах, таав арлах, таах, мэдрэх, мэдэх. 2. ойлгох, ухах, ажиж харах, ажиж мэдэх, анзаарах.

sezon *is.* улирал.

sıcacık *s.* дулаахан, бүлээхэн.

sıcak, -ğı *s.* 1. халуун, ид халуун, пүү халуун. 2. халуун, дулаан, бүлээн. "*Sıcak çorba getirdi.*" Халуун шөл авчирч өглөө. 3. *mec.* халуун, халуун дотно, чин сэтгэлийн, элэгсэг, нөхөрсөг, дотно. "*Sıcak bir karşılama.*" Нөхөрсөг угталт. 4. *is.* халуун, аагим халуун (агаар). 5. *is.* саун, бие угаах газар, халуун усны газар. **~ bakmak** ойлгох, наашгай хандах, сонирхох.

sıcakkanlı *s.* 1. халуун цустан, бүлээн цустан (амьтан). 2. *mec.* нөхөрсөг, элэгсэг, дотно, сайхан зантай, эелдэг, найртай, эелдэг зантай, нүдэнд дулаахан.

sıcaklık, -ğı *is.* 1. халуун, ид халуун, пүү халуун, бүгчим халуун. 2. дулаан, илч. "*Bugün hava sıcaklığı 16 derece.*" Өнөөдөр 16 хэм дулаан байна. 3. *mec.* эелдэг ааш, найрсаг зан, элэгсэг байдал, хайр, халуун дотно байдал.

sıcakölçer *is.* халуун хүйтний хэмжүүр, халууны шил, термометр.

sıçan *is. zool.* 1. үхэр хулгана, харх. 2. *zool.* хулгана, огтоно.

sıçmak *(nsz) kaba.* 1. өтгөнөө гаргах, өтгөнөөр гадаалах, өтгөн мөр гаргах, баах. 2. *mec.* эвдэх, гэмтээх, гутаах.

sıçramak *(nsz, -e)* 1. харайх, цовхрох, дэвхрэх, дэвхцэх, үсрэх, харайж босох, годхийн босох. "*Çocuk taştan taşa sıçrayarak gitti.*" Хүү чулуу давжин дэвхцэн явлаа. 2. цочих, сочих, чавалзах, татвалзах. "*Çocuk sıçrayarak uyandı.*" Хүүхэд цочин сэрлээ. 3. үсрэх, олгойдох, годхийх, уначих, ойчих. "*Kıvılcım sıçradı.*" Оч

үсрэв. 4. гэнэт шилжих, харайж орох, шилжих, дамжих, тарах. "*Yangın yandaki binaya sıçradı.*" Түймэр дэргэдэх байшинд шилжив.

sıçratmak *(-i, -e)* sıçramak үйлийн үйлдүүлэх хэв.

sıdk, -dkı *is. esk.* 1. зөв, үнэн. 2. үнэнч, шударга, голч, үнэн сэтгэл, чин үнэн, цагаан санаа, цагаан сэтгэл.

sıfat *is.* 1. чанар, шинж, шинж чанар,тэмдэг, тодотгол. 2. *hlk.* царай, дүр, нүүр царай, царай байдал, гадаад байдал. 3. *gr.* тэмдэг нэр.

sıfatfiil *is. gr.* үйлт нэр.

sıfır *is.* тэг.

sıfırlamak *(-i)* 1. тэнцүүлэх. 2. тэглэх.

sığ *s.* 1. гүнзгий биш, гүехэн, нимгэн, намхан. 2. *mec.* мөчид, өнгөцхөн, гүн биш, утга нимгэн. "*Sığ düşünce.*" Мөчид бодол.

sığa *is. fiz.* багтаамж, багтамж (агшаагуур, кондөнсатор).

sığdırmak *(-i, -e)* багтаах, чихэх, чихэж оруулах, шахаж оруулах, багтааж хийх, хийх. "*Kitapları çantaya sığdıramadım.*" Би номуудыг цүнхэнд багтааж чадсангүй.

sığın *is. zool.* хандгай буга.

sığınak, -ğı *is.* 1. нөмөр, орон, орогнох газар, хорогдох газар, орох орон. 2. *ask.* хорогдох газар, хөмгий, нуувч.

sığınık, -ğı *is.* цагаач, дүрвэгч, орогноч, гадаадад суугч, гадаадад дүрвэгч.

sığınma *is.* орогнол, орогнох, хоргодох газар.

sığınmak *(-e)* 1. хоргодох, орогнох, нуугдах, далд үлдэх, нөмөрт байх. 2. хамгаалахыг гуйх, хандах, нөмөрт хорогдох. 3. дүрвэх, цагаачлах, хорогдох. 4. *mec.* найдах, тусламж хүсэх, туслалцаа гуйх.

sığıntı *is.* тэжээвэр хүн, хоолны сав, долдой.

sığır *is.* үхэр, бух, шар.

sığırcık, -ğı *is. zool.* хар тодол (шувуу), шаархай.

sığırtmaç, -cı *is.* мал хариулагч, малчин.

sığışmak *(nsz)* багтах, багтаж суух, суудал олох, чихэлдэн орох, шахалдан орох. "*Biraz daha sıkışırsak hepimiz sığışırız.*" Бага зэрэг шахаад өгвөл бид бүгдээрээ багтана.

sığlık, -ğı *is.* 1. татрах, гүехэн болох. 2. харгиа, хайр, гүехэн газар.

sığmak, -ar *(-e)* 1. багтах. 2. *mec.* таарах, тохирох. "*Akla sığar.*" Ойлгож болмоор, ойлгогдмоор, зүйтэй, зөвшөөрмөөр. "*Mantığa sığmaz.*" авцалдаагүй, зөрөлдөөнтэй.

sıhhat *is.* 1. бие, эрүүл мэнд, бие лагшин, лагшин, эрүүл мэндийн байдал. "*Sıhhatiniz nasıl?*" Таны бие сайн уу?(Таны лагшин тунгалаг уу? Таны эрүүл мэнд сайн уу?). 2. үнэн, зөв, үнэн магад нь, лав нь, чухам үнэн нь. "*Haberin sıhhati...*" Мэдээний үнэн магад нь ... **~ler olsun** (биөэ угааж гарсан хүнд хэлэх ерөөл) Өнгө зүс сайхан байх болтугай.

sık *s.* 1. өтгөн, шигүү, нягт, чигжүү. "*Sık saç.*" Өтгөн үс. 2. олонтоо болдог, байн байн ирдэг, үргэлж тохиолддог. 3. *zf.* олонтоо, ойр ойрхон, байн байн, ахин дахин, байнга, үргэлж. 4. *zf.* зай муутай, зай багатай, ойр ойрхон, ойр ойр, шигүү, зайгүй, давчуу, бачуу, бариу. **~ sık** *zf.* 1) ойр ойрхон, зай багатай. 2) ойр ойрхон, олонтоо, байн байн, ахин дахин, байнга, үргэлж.

sıkı *s.* 1. бариу, бачуу, давчуу, чанга, чангалсан. 2. чигжүү, шигүү, дүүрэн, чигжээстэй, чихээстэй, зай багатай, зай муутай, зайгүй, давчуу, бачуу, бариу. 3. чанга, хатуу, нарийн чанд, хэцүү, шаардлагатай, анхааралтай хийх, нямбай хийх. 4. чанга, хууль дүрэм баримталдаг, дэглэмтэй, чанга байдал. 5. шахуу, маш их. "*Son zamanlarda işlerimiz çok sıkı.*" Сүүлийн үед манай ажил их шахуу байгаа. 6. харамч, нарийн, чанга. 7. тэнцүүхэн, өрсөлдөөнтэй. 8. сайтар, сайн. "*Dersini sıkı çalış.*" Хичээлээ сайн хийгээрэй. "*Sıkı giyinin.*" Сайн хувцаслаарай. 9. шахагдах, хавчигдах, баригдах. "*Sıkıya gelmem.*" Би баригдах дургүй. 10. дотно, янаг, элгэн, дотно сэтгэлийн, халуун зүрхний, ойр.

sıkıcı *s.* уйтгартай, уйтгар төрүүлэх, уйтгар хүргэх, залхуутай, хаширтай, залхуу хүрмээр, ядраах, зүдрээх. "*Sıkıcı bir iş.*" Залхуутай ажил.

sıkılgan *s.* ичимтгий, ичимхий, зовомтгой, эрээлхэг, нэрэлхэг, бүрэг.

sıkılganlık, -ğı *is.* ичимтгий (байх), ичимхий зан, аймтгай, аймхай.

sıkılmak *(-e)* 1. шахах, шавхах, мушгих. "*Çamaşırlar sıkıldı.*" Хувцаснуудаа мушгисан. 2. *(nsz, -den)* уйтгарлах, уйдах, гуних, гуниглах, залхуутай байх, гуних, гунихрах, гиюүрэх, санаа зовох, энэлэх, шаналах, зовох. "*Yalnız oturmaktan sıkıldım.*" Би ганцаар суухаас залхаж байна. 3. *(nsz, -e)* аягүйрхэх, ичих, зовох, нүүр халах, эрээлхэх, нэрэлхэх, ичингүйрэх, эмээх. "*Sıkılma kızım, ye bunlardan.*" Бүү нэрэлх охин минь үүнээс ид. 4. хүнд байдалд орох, хэцүүдэх. "*Sıkılırsam bu parayı harcarım.*" Хүнд байдалд орвол би энэ мөнгийг зарцуулна.

sıkıntı *is.* 1. уйтгар, гуниг, залхуутай байдал, гансрал, гиюүрэх, гиюүрэл, зовлон, шаналгаа, гутрал, сэтгэлийн зовлон. 2. муу совин, зовуур, сэтгэл зовох. 3. бэрхшээлтэй байдал, хэцүүдсэн байдал, зовлон, гачаал, мөнгөний гачаал. 4. *mec.* асуудал, бэрхшээл, проблем. 5. ховор живэр байдал, хомсдол, гачигдал, дутагдал. **~ basmak** бачимдах, залхах. **~ çekmek** зовох, гачигдах (ярианд "махаа зулгаах" гэж хэлдэг). **~ vermek** сэтгэл зовоох, түгшээх, залхаах. **~ya düşmek** гачигдах, дутагдах.

sıkıntılı *s.* 1. бэрхтэй, бэрхшээлтэй, гачигдалтай, хавчигдалтай, хэцүү, хавчлагатай. "*Sıkıntılı şartlarda yaşamak.*" Хавчигдсан нөхцөлд амьдрах. 2. зүдэргээтэй, их ядаргаатай, эцээж туйлдуулах, тамир тэнхэл бардаг. 3. уйтгартай,

уйтгар төрүүлэх, уйтгар хүргэх, зовлонтой, зовнилтой, сэтгэлд эвгүй.

sıkıntısız *s.* дутагдалгүй, хүрэлцээтэй, чинээлэг, амарлингүй, яршигтүй. "*Sıkıntısız bir hayat.*" Чинээлэг амьдрал. "*Sıkıntısız bir iş.*" Яршигтүй ажил.

sıkışık, -ğı *s.* 1. зай багатай, зай муутай, давчуу, бачуу, дүүрэн, **пиг дүүрэн**, шигүү, завсаргүй. 2. хавчигдсан, хэцүү байдалтай, бэрхшээлтэй байдалтай.

sıkışmak *(nsz)* 1. наалдах, шахалдах, шахцалдах, биөэ хумих. 2. хавчих, хавчуулах. "*Parmağı kapıya sıkışmak.*" Хуруугаа хаалганд хавчуулах. 3. шахагдах, хавчигдах, чихэгдэх. 4. хэцүү байдалд орох, хүнд байдалд орох. "*Bu parayı ancak sıkıştığın vakit kullan.*" Энэ **мөнгийг** зөвхөн хэцүү байдалд орсон үедээ хэрэглээрэй. 5. давчдах, бачимдах, бачуурах, амьсгаадах. "*Göğsü sıkışmak.*" Цээж нь давчдах. 6. бие засах хэрэгтэй болох, шээс хүрэх.

sıkıştırmak *(-i)* 1. чихэх, чихэж хийх, чихэж оруулах, шахаж оруулах, хавчуулах, хийх, түлхэж оруулах, чихчих. "*Çamaşırlarını çantaya sıkıştırdı.*" Хувцас хунараа цүнхэнд чихэж хийв. 2. чангалах, дарах, хавчих, нягтруулах, чигжрүүлэх, шахах, шахуу жагсаах, үргэлж болгох, нийлүүлэх. 3. шахан ухруулах, бүслэх, бүслэн хаах. 4. хавчих, шахах, хавчиж нөлөөлөх, хавчилт үзүүлэх, дарамт үзүүлэх. 5. (гарт нь) атгуулах, өгөх, шургуулах, хавчуулах. "*Eline birkaç lira sıkıştırıverin, derhal yapar.*" Гарт нь хэдэн лир (цаас) атгуулчих, дор нь хийгээд өгнө.

sıkıyönetim *is.* бүслэлтийн байдал. дайны хууль.

sıkkın *s.* уйтгартай, уйтгарласан, уйдсан, залхуутай.

sıklaşmak *(nsz)* 1. олонтоо болдог болох, байн байн ирдэг болох, үргэлж тохиолддог болох. 2. олшрох, түргэсэх, хурдсах, байнга ордог болох, ордог болох, үргэлж явдаг болох, байнга ...даг (...дэг, ...дог, ...дөг) болох.

sıklık, -ğı *is. fiz.* 1. үелзэл, давтамж. 2. нягт сийрэг, өтгөн шингэн, нягт, нягтрал, нягт сийрэг, шигүү.

sıkmak, -ar *(-i)* 1. шахах, дарах, атгах, хавчих, зангидах, тэврэх, базах. 2. шавхах, шахах, мушгих, шахаж гаргах. "*Çamaşırları sıkmak.*" Хувцас хунар мушгих. "*Üzüm sıkmak.*" Үзэм шахах. 3. барих, бариу байх. 4. (хоолойгоор) услах, ус хийх, ус асгах, цавдах, шүрших, цацах. 5. буудах. "*Kurşun sıkmak.*" Буудах. 6. шахах, хавчих, хяхах, дарлах, хүчирлэх, хүчлэх, хүч гаргах. "*Kendini hiç sıkmadan...*" Өөрийгөө огтхон хүчлэлгүйгээр... 7. залхуу хүргэх, залхаах, хашраах, улиг болох, саад болох, төвөг болох, төвөг учруулах, яршиг болгох, хашраах, санаа зовоох, сэтгэл түгшүүлэх, тэвдүүлэх.

sınamak *(-i)* 1. сорих, турших, янзы нь үзэх. 2. туршиж үзэх, шалгах, шалгаж үзэх.

sınav *is.* шалгалт, шалгалага, туршлага, сорилго.

sınıf *is.* 1. анги, дамжаа, курс. "*Birinci sınıf öğrencisi.*" Нэгдүгээр ангийн сурагч. "*Üniversite birinci sınıf öğrencisi.*" Их сургуулийн нэгдүгээр дамжааны оюутан. 2. анги, танхим. "*Aydınlık sınıf.*" Саруул анги. 3. *sos.* анги. "*İşçi sınıfı.*" Ажилчин анги. 4. *biy.* анги. "*Memeliler sınıfı.*" Хөхтөний анги. 5. ай, бүлэг, зэрэг, төрөл, зүйл, –дугаар(дүгээр).

sınıflandırma *is.* ангилал.

sınıflandırmak ангилах.

sınır *is.* 1. хил, хязгаар, хил хязгаар, хил зааг. 2. зааг, зах, уулзар. 3. *mec.* туйл, хязгаар **~ dışı etmek** албадан гаргах, албадаж хөөх, тус орны хилээс гаргах.

sınırdaş *is.* хил залгаа, зэрэгцээ.

sınırlamak *(-i)* 1. хязгаарлах, хэмжээлэх, зааглах, хязгаар тогтоох, хил тогтоох. 2. хөвөөлөх, эмжээрлэх, хүрээлэх, хязгаарлах.

sınırlanmak *(nsz)* 1. зааглагдах, хязгаар тогтоогдох, хил тогтоогдох. 2. хязгаарлагдах.

sınırlı *s.* 1. хилтэй, хил хязгаартай, хил заагтай. 2. хязгаартай. 3. хомс, бага хэмжээтэй.

sınırsız *s.* 1. хилгүй, хил хязгааргүй, хил зааггүй. 2. хязгааргүй, маш их, энгүй, зах хязгааргүй, хэмжээгүй, дуусгаргүй, эцэсгүй, хэмжээлшгүй, барагдашгүй.

sıpa *is. zool.* дудран (илжигний унага).

sır, -rrı *is.* 1. нууц. "*Bu sırrı kimseye söylemeyin.*" Энэ нууцыг хэнд ч бүү хэлээрэй. 2. нууц, үл ойлгогдох үзэгдэл. "*Doğanın sırları birer birer açılıyor.*" Байгалийн нууцууд нэг нэгээрээ тайлагдаж байна. 3. нууц, нууц арга, нарийн арга, шалтгаан. "*Başarının sırrı.*" Амжилтын нууц./Амжилтын шалтгаан. **~ tutmak** (veya **saklamak**) нуух, нууц байлгах, нууц хадгалах. **~ vermek** (veya **sızdırmak**) нууц задлах, нууц задруулах.

sıra *is.* 1. эгнээ, үе, цуваа, угсраа, цувраа, хэлхээ. "*Sıra dağlar.*" Угсраа (зэрэгцээ) уулс. 2. эгнээ, цуваа, жагсаал, оочир, дэс дараа. 3. дараа, дараалал, дэс дараа. 4. завшаан, далим, дашрам, цаг, үе, таарамжтай цаг, тохиромжтой үе. "*Sırası gelince söylersin.*" Таарамжтай цаг нь ирэхээр хэлнэ биз дээ. 6. парта, сандалт ширээ, хичээлийн ширээ. 7. ээлж, ээлж дараа, ээлж дугаар, оочир. "*Kimin sırası?*" Хэний ээлж вэ? **~ olmak** жагсах, эгнэх. **~sı gelmek** 1) цаг нь болох, цаг нь ирэх, ээлж нь болох. 2) тохиромжтой цаг нь болох (ирэх). **~sı düşerse** ээлж ирэхэд, цагий нь болоход, цагт нь, чухам цагт нь, тохиолдолд нь, ...хаа хүрвэл, ...хдаа тулбал.

sıradan *s.* энгийн, жирийн, ердийн, эгэл. "*Sıradan biri.*" Эгэл нэгэн.

sıralamak *(-i)* 1. эгнүүлж тавих, эгнүүлж өрөх, жагсаах. 2. ялгах, дугаарлах, журамтай болгох, эмхлэн цэгцлэх, эмхлэх, эмх журамтай болгох. 3. тоочих.

sıralı *s.* 1. журамтай болгосон, эмх цэгцтэй. 2. дэс дараатай.

sırasız *s.* 1. эмхгүй, цэгцгүй, замбараагүй, зуун задгай. 2. цагийг ололгүй, зохимжгүй цагт, тохиромжгүй үед. 3. дугааргүй, оочиргүй.

sırat *is. esk.* зам.

sırdaş *is.* нууц мэдэх хүн.

sırf *zf.* 1. цэвэр, хольцгүй, цул, зөвхөн, ердөө, дан. 2. жинхэнэ, ёстой, үнэн.

sırım *is.* нарийн сур, сур, булигаар.

sırıtmak *(nsz)* 1. шүдээ ярзайлгах, ярзайн инээх, ярзайх, ярзалзах, арсалзан инээх, ярзганах, арсганах, хий хий инээх, хий хий гэх. 2. *mec.* (гажиг, согог, алдаа, дутагдал) илрэх, түрэн гарах.

sırlı *s.* нууц, далд, нууц далд.

sırnaşık, -ğı *s.* ve *is.* залхуутай, залхуу хүрэм, нуршаа үгтэй, яншаа, хаширт, улигт, салж өгдөггүй, наалдамтгай, шаламтгай. "*Ne sırnaşık bir adam, hiç de gitmeye niyeti yok.*" Ямар салж өгдөггүй хүн бэ? огтхон ч явах янзгүй шүү.

sırt *is.* 1. нуруу. 2. (уулын) хяр, хянга. 3. (хутганы) иргүй тал, мохоо тал. 4. (хүний) ар, ар тал. **~ çevirmek** 1) буруу харах, цааш харах, нүүрээ бууруулах, үл тоох. 2) татгалзах, хүлээхгүй байх, цээрлэх, –гүй байх, болих. **~ üstü yatmak** гэдрэг харан хэвтэх, өөдөө харан хэвтэх. **~ sırta vermek** хамтран хийх, бие бие дээ туслалцах, элбэлцэн хийх. **~ı yere gelmek** ялагдалд учрах, ялагдах, дийлэгдэх. **~ına geçirmek** өмсөх, углах. **~ından yaşamak** бусдыг мөлжиж аж төрөх, бусдын гар харж амьдрах.

sırtlamak *(-i)* 1. нуруундаа үүрэх, мөрөн дээрээ тавих. 2. *mec.* (хариуцлагыг) хүлээх, үүрэх.

sırtlan *is. zool.* гиена, чононцор.

sıska *s.* туранхай, эцэнхий, хатангир, эцэнгэр, цонхигор, яс арьс болсон, тэнхээ муутай, туниагүй.

sıtma *is. tıp.* хумхаа, чичрэг өвчин.

sıtmalı *s.* 1. хумхаа өвчтэй. 2. хумхаатай. "*Sıtmalı yer.*" Хумхаатай газар.

sıva *is.* шаваас, элс шохойн зуурмаг.

sıvacı *is.* шаваасчин, шаварчин.

sıvalı (I) *s.* шаваастай, шавартай.

sıvalı (II) *s.* шамласан.

sıvamak (I) *(-i)* шаваслах, шавардах, шавах.

sıvamak (II) *(-i)* шамлах, шуух, сөхөх(ханцуй, шуумаг).

sıvazlamak *(-i)* илэх, илбэх.

sıvı *s.* ve *is. fiz.* шингэн.

sıyırmak *(-i)* 1. шүргэх, хуулах, шалбалах. 2. гаргах, авах, уудалж авах, сугалах, суга татах, мулт татах, хуулах, хуу татах. 3. бүгдийг хамах, шавхах, хусах. 4. *(-den) mec.* аврах, салгах, ангижруулах, хэлтрүүлэх, гэтэлгэх. "*Onu bu bulaşık işten sıyırmak kolay değil.*" Түүнийг энэ аяга угаах ажлаас аврах амар биш.

sıyrık, -ğı *is.* хуурсан газар, шалбарсан газар, шалбархай, шулгархай, зулгархай, дайр, маажинхай.

sıyrılmak *(nsz)* 1. үйлийн үйлдэгдэх хэв, үйлдүүлэх хэв, хуурах, ховхрох, холтрох, шалбарах, хусуулах, үрүүлэх, өвчүүлэх, хальслагдах. 2. *(-den)* мултрах, гарах, булталх, салах, хэлтрэх, гэтлэх.

sızdırmak *(-i)* 1. sızmak үйлийн үйлдүүлэх хэв, гоожих, гоожуулах, нэвчүүлэх, шүүрүүлэх, толгой дүйрүүлэх, мансууруулах. 2. (мэдээ, нууц) мэдэгдэх, мэдэгдүүлэх, задлах, задраах, задруулах, тараах, сонсгох. 3. *mec.* авлигалах, шахаж авах, шалах. 4. шүүх, шүүж тунгаах.

sızı *is.* 1. өвчин, хөндүүр. 2. *is.* зовлон, сэтгэлийн зовлон.

sızıltı *is.* 1. гомдол, үглэх, зовуурь. 2. дургүйцэл, сэтгэл эс ханах, дур гутах, чамлах, голох, тааламжгүй байх.

sızlamak *(nsz)* 1. өвдөх, янгинах, шархирах, чимчигнэх, шимшрэх, шимшрэн өвдөх. 2. гомдох, уйлж үглэх, орилох, гаслан орилох, гасалж гинших, гонгинох, гоншигнох.

sızlanmak *(nsz)* гомдол гаргах, гомдоллох, гонгинох, гоншгинох.

sızmak, -ar *(nsz)* 1. нэвчих, шүүрэх, дуслах, дусах, нэвтрэх, нэвтрэн орох, нэвтрэн гарах. 2. (нууц) задрах, тарах, мэдэгдэх, сонсогдох. 3. зугтах, булталх, мултрах. 4. ухаан алдах, муурч унах (согтуу хүн), унтаад өгөх.

sicil *is.* 1. бүртгэл, данс. 2. биеийн байцаалт, хувийн хэрэг.

sicilli *s.* 1. бүртгэлтэй, бүртгэл бүхий, бүртгэгдсэн. 2. дахин хэрэг үйлдэгч, дахин хэрэг хийгч, давтан хэрэгтэн.

sidik, -ği *is.* шээс. **~ borusu** *is. anat.* шээсний судал, шээс дамжуулагч. **~ torbası** *is. anat.* давсаг.

sifon *is.* 1. сифон (жорлонгийн усны). 2. шингэн дамжуулах хоолой.

sigara *is.* 1. янжуур. 2. тамхи. **~ içmek** тамхи татах.

sigorta *is.* 1. даатгах, даатгал. "*Hayat sigortası.*" Амь биеийн даатгал. Амь биеэ даатгах. 2. даатгалын байгууллага. 3. хамгаалуур, хамгаалагч, гал хамгаалагч, цахилгаан хамгаалуур. **~ atmak** гал хамгаалагч нь буух, гал хамгаалагч нь шатах. **~ etmek** даатгах. **~ olmak** даатгуулах.

sigortacı *is.* даатгагч, даатгалын байгууллага.

sigortacılık, -ğı *is.* даатгагчийн ажил.

siğil *is.* үү, ургацаг.

sihir *is.* илбэ, увдис, шид, ид.

sihirbaz *is.* илбэч, увдисч, шидтэн, идтэн, илбэчин.

sihirbazlık, -ğı *is.* илбэ, увдис, шид.

siklon *is.* циклон, хар салхи, шуурга.

silah *is.* 1. зэр зэвсэг, зэвсэг, буу зэвсэг, буу, зэвсэглэх. 2. *mec.* зэвсэг, хэрэгсэл, хэрэглүүр.

silahlanmak *(nsz)* зэвсэглэх.

silahlı *s.* зэвсэгт, зэвсэглэсэн. **~ kuvvetler** зэвсэгт хүчин.

silecek, -ği *is.* 1. ванны том алчуур. 2. шил арчигч. 3. хөлийн алчуур.

silgi *is.* 1. баллуур. 2. самбарын алчуур.

silik, -ği *is.* 1. мөлийсөн, мөлгөр болсон, элэгдсэн, харагдахгүй болсон. "*Silik para.*" Мөлгөр болсон зоос. 2. *mec.* бий үгүй нь мэдэгдэхгүй, хүний анхаврaлд өртдөггүй, өчүүхэн, үл мэдэгдэм, шалиагүй, эгэл, энгийн, жирийн.

silindir *is. mat.* 1. цилиндр, бортого. 2. булуу, замын индүү.

silinmek *(nsz)* 1. баллагдах, арчигдах, арилах, хасагдах, цэвэрлэгдэх, цэвэрших. 2. биеэ арчих, арчих. 3. *mec.* нүднээс далд орох, алга болох, үгүй болох.

silkelemek *(nsz)* сэгсрэх, гүвэх, сэгсэрээд унагах, сэгсэрч арилгах.

silkinmek *(nsz)* 1. сэгсрэх, гүвэх. 2. цочих, татвалзах, чацвалзах, зог тусах, сэрвэс хийх, догдолс хийх. "*Yanımda bir dal cırtısını duydum. Silkindim.*" Хажууханд маань мөчир чадхийхийг сонсоод цочив. 3. *(-den) mec.* ангижрах, салах, мултрах. "*Tembellikten silkinmek.*" Залхуу байдлаас ангижрах.

silkmek *(nsz)* гүвэх, дугтрах, хөдөлгөх, ганхуулах, сэгсрэх, сэгсчих, сэгсэрч унагах.

silmek *(-i)* 1. арчих, хатаах. 2. угаах, арчих, арилгах, цэвэрлэх, өнгөлөх. 3. баллах, хасах, дарах. 4. *(-i, -dən)* арилгах, баллах, баллуурдах, үгүй болгох. 5. харуулдах, зорох.

sima *is.* 1. нүүр, царай, зүс, дүр. "*Çok tanıdık bir sima.*" Их танил царай байна./Их харсан царай байна. 2. бие, хүн. "*Tanınmış bir insan.*" Олны танил хүн.

simge *is.* бэлэг тэмдэг, бэлэг, тэмдэг, бэлэгдэл. "*Bayrak, o vatanın simgesidir.*" Далбаа нь уг улсын бэлэг тэмдэг мөн.

simgelemek *(-i)* бэлэг тэмдэг болох, бэлэг тэмдэг байх.

simit *is.* 1. цагариг боорцог. 2. аврах цагариг.

sinagog *is.* еврэй сүм.

sincap, -bı *is. zool.* хэрэм.

sindirim *is. biy.* хоол шингээх, хоол болов сруулах, хоол шингээх явц. **~ sistemi (veya aygıtı)** хоол шингээх эрхтэн, хол боловсруулах эрхтэн.

sindirmek *(-i, -e)* 1. нуух, нуугдуулах, дарах, далдлах. 2. *(-i)* хоол шингэх, хоол боловсруулах, шингээх. 3. *mec.* өөртөө тусгаж авах, ойлгож авах, өөрийн болгож авах.

sine *is.* 1. цээж, хэнхдэг. 2. *mec.* сэтгэл, зүрх, сэтгэл зүрх. 3. *mec.* энгэр.

sinek, -ği *is. zool.* 1. ялаа. 2. хөзрийн цэцэг.

sinema *is.* 1. кино. 2. кинотеатөр. 3. кино урлаг.

sinir *is. anat.* 1. мэдрэл, нерв, хий судас. 2. *hlk.* бүлх, шөрмөс, шандас. 3. халдамтгай, эмзэг, эмзэг байх, мэдрэц ихтэй байх. 4. залхуутай, ядаргаатай, яршигтай, уур хүргэмээр. **~leri bozulmak** хийрхэх, хий нь хөдлөх, унтуущах, унтуурхах, цухалдах, цухал нь хүрэх, уур нь хүрэх.

sinirbilimi *is. tıp.* мэдрэл судлал.

sinirce *is. psikol.* мэдрэлийн евчин.

sinirdoku *is. anat.* мэдрэлийн эд.

sinirlendirmek *(-i)* бухимдуулах, унтуурхуулах, хийрхүүлэх, цухал хүргэх, цухалдуулах, уур хүргэх.

sinirlenmek *(nsz, -e)* хийрхэх, хий хөдлөх, унтуущах, унтуурхах, цухал хүрэх, цухалдах, уур хүрэх.

sinirli *s.* 1. шөрмөстэй, шандастай, бүлхэрхэг. "*Sinirli et.*" Бүлхэрхэг мах. 2. бухимдуу, унтуурхуу, хийрхүү, цухалдсан, цухал хүрсэн, тайвангүй, амархан бухимддаг, ууртай.

sinmek *(nsz, -e)* 1. нуугдах, хорогдох, далд үлдэх, чимээгүй явах, буланд нуугдах, үзэгдэхгүй байхыг хичээх. "*Çocuk babasının arkasına sindi.*" Хүү аавынхаа ард орж нуугдлаа. 2. шантрах, айх, бууж өгөх, хулчийх. 3. (үнэр) нэвтрэх, нэвчих, шингэх.

sinsi *s.* битүүлэг, битүү, юмаа нуудаг зантай, муу санаатай, хар санаатай, чимээгүй ажиллаж байгаа, сэм ажиллаж байгаа.

sinsice *s. ve zf.* нууц, сэм, далд, нууцаар, сэмээр, далдуур.

sinyal *is.* дохио.

sipariş *is.* 1. захиалга. 2. захиалсан зүйл. **~ vermek** захиалах, захиалга өгөх. **~ almak** захиалга авах.

sirk *is.* цирк.

sirke (I) *is.* хуурс.

sirke (II) цуу.

sis *is.* униар, хүдэн, будан, манан.

sisli *s.* униартсан, униартай, будантай, манантай, манан татсан.

sistem *is.* 1. тогтолцоо, байгуулал, систөм. 2. журам, эмх журам, эмх цэгц. 3. журам, тогтолцоо. "*Seçim sistemi.*" Сонгуулийн журам. 4. арга барил, арга зам, систем. 5. маяг, хийц.

sistematik, -ği *s.* хатуу эрэмбэтэй, дэс дараалалтай, систөмтэй, журамтай, эмх журамтай, эмхтэй, эмх цэгцтэй.

sistemli *s.* 1. журамтай, эмх журамтай, эмхтэй, эмх цэгцтэй. 2. хатуу эрэмбэтэй, дэс дараалалтай, систөмтэй.

sistemsiz *s.* систөмгүй, эмх цэгцгүй, дараалалгүй, тогтолцоогүй.

site *is.* бага хот, бяцхан хот, хотхон, суурин.

sitem *is.* буруушаах, зэмлэх, зэмлэл, зэмлэх байдал, донгодлого. ~ **etmek** зэмлэх, үглэх, зэмлэх, буруушаах, намжирдах.

sitemkâr *is.* зэмлэх байдалтай, зэмлэх янзтай, гомдомтгой, өөнтөгч, гомдолтой.

sivil *s.* 1. иргэний, ард иргэдийн. 2. энгийн, өрийн (хувцастай). 3. нүцгэн. 4. энгийн хүн. 5. *is.* энгийн хуацастай цагдаа.

sivilce *is.* батга, буглаа, бээрлэсэн газар.

sivri *s.* 1. хурц үзүүртэй, шовх, шовгор, шөнтгөр, шөмбөгөр, хурц, хурц иртэй, хурцалсан, үзүүрлэсэн, шовхолсон.

sivrisinek, -ği *is. zool.* шумуул

siyah *is.* хар, хар өнгө.

siyasa *is.* бодлого, улс төрийн бодлого, улс төр, засаг засаглал.

siyasacı *s.* улс төрийн хүн, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн зүтгэгч, улс төрч, төрийн бодлогоч.

siyasal *s.* улс төрийн, улс төрийн бодлогын, төр бодлогын, бодлогын.

siyaset *is.* улс төр, улс төрийн бодлого.

siyasetçi *is.* улс төрч, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн хүн, улс төрийн зүтгэгч, төрийн бодлогоч.

siyasi *s.* 1. улс төрийн, улс төрийн бодлогын, төр бодлогын, бодлогын. 2. *is.* улс төрч, улс төрийн зүтгэлтэн, улс төрийн хүн, улс төрийн зүтгэгч, төрийн бодлогоч.

siz *zm.* та. **~de** танд. **~den** танаас. **~e** танд. **~i** таныг. **~in** таны.

skandal *is.* шившигт явдал, гутамшиг.

skeç *is.* шог ший.

slogan *is.* уриа, лоозон.

smokin *is.* хүрэм(зоог, үдэшлэгт өмсөх).

soba *is.* зуух, пийшин.

soda *is.* 1. гаазтай ус, хийлсэн ус. 2. буулт (амны хужир).

sodyum *is. kim.* натри.

sofra *is.* 1. хоолны ширээ, зоогийн ширээ. 2. зассан ширээ. 3. явган ширээ, гурил элдэх ширээ.

soğan *is. bot.* 1. сонгино. 2. *bot.* төмс, булцуу.

soğuk, -ğu *s.* 1. хүйтэн. 2. хүйтэн, жихүүн, жавартай, цэв хүйтэн, хүв хүйтэн. "*Soğuk hava.*" Хүйтэн улирал, хүйтэн агаар. 3. *mec.* хүйтэн, хайхрамжгүй. 4. *mec.* хүйтэн, хөндий, цэвдэг, ханшгүй. **~ algınlığı** салхи авах, салхинд цохиулах, хүйт авах, ханиад. **~ almak** салхинд цохигдох, салхинд цохиулах, хүйт авах, ханиад хүрэх.

soğukkanlı *s.* самбаатай, уужим дотортой, дотор тайван, ажиггүй, амгалан.

soğukluk, -ğu *is.* 1. хүйтэн, жихүүн, жавар. 2. *mec.* хүйтэн царай гаргах, хайхрамжгүй байх, хүйтэн, хүйтэн царай, хайхрамжгүй байдал. 3. хүйтэн амттан, компот. 4. халуун усны өмнөх өрөө, банийн наад тасалгаа.

soğumak *(nsz)* 1. хүйтрэх, хүйтэн болох, хөрөх, царцах. 2. *(-den) mec.* сэтгэл хөрөх, хөндийрөх, хөндий болох.

soğutmak *(-i)* 1. хөргөх, царцаах, хөргөөх, зөөгшрүүлэх. 2. *(-den) mec.* (хэн нэг хүнээс, ямар нэг байдлаас) хөргөөх, хүйтэн харьцаатай болгох, хөндий болгох, хөндийрүүлэх.

soğutucu *s.* 1. хөргөх, хөргөдөг. 2. *is.* хөргөгч, хөргүүл. 3. *is.* радиатор (дотоод шаталтын хөдөлгүүрүүдийг хөргөх хэрэгсэл).

sohbet *is.* (нөхөрсөг) яриа, хөөрөө, хөөрөлдөөн, хүүрнэлдээн. **~ etmek** ярилцах, хөөрөлдөх, хүүрнэлдэх.

sokak, -ğı *is.* гудамж, гудам.

sokmak, -ar *(-i)* 1. шургуулах, хийх, чихэх, оруулах, чихэж оруулах, түлхэн оруулах, шахаж оруулах. "*Cebine soktu.*" Халаасандаа хийв. "*Onu içeriye sokmayın.*" Түүнийг битгий дотогшоо оруулаарай. 2. хатгах, чичих, шаах. 3. (хорхой шавж) хатгах, хазах. 4. *mec.* атгуулах, хуурч өгөх, мэхэлж өгөх. 5. *mec.* үгээр хатгах, хорон үг хэлэх.

sokulgan *s.* шургалуур, зальтай, ов живтэй.

sokulmak *(nsz, -e)* 1. sokmak үйлийн үйлдэгдэх хэв. 2. шургах, орох. "*Yorganın altına sokulmak.*" Хөнжил дор шургах. 3. ойртох, дөхөж очих, хажууд нь очих.

sol (I) *is.* 1. зүүн, зүүн тал, буруу тал. "*Solumdaki adam benim babam.*" Миний зүүн талд байгаа хүн миний аав. 2. зүүн, зүүний үзэл.

sol, -lü (II) *is. müz.* соль нот.

solak, -ğı *s.* солгой, солгой хүн.

solcu *is. ve s.* зүүнтэн, зүүний үзлийг баримтлагч.

solgun *s.* цонхигор, цонхийсон, зэвхий, зэвхийсэн, өнгөө алдсан, гандсан.

solist *is. müz.* гоцлон дуулагч, гоцлон хөгжимдөгч.

sollamak *(nsz)* гүйцэж түрүүлэх. "*Köprü üstünde sollamak yasak.*" Гүүрэн дээр гүйцэж түрүүлэх хориотой.

solmak, -ar *(nsz)* 1. гандах, өнгө алдах, цайх, зэвхийх, цонхийх, бүдэгрэх. 2. хатах, муудах, гандах.

solucan *is. zool.* чийгийн хорхой, өт, хорхой.

soluk, -ğu (I) *is.* амьсгал, амьсгаа. **ana ~ borusu** *is. anat.* цагаан хоолой, мөгөөрсөн хоолой. **~ almak** 1) амьсгаалах, дотогш амьсгаалах, амьсгаа авах. 2) амсхийх, амрах. **~ soluğa kalmak** амьсгаадах, аахилах, сүйхлэх, ядрах.

soluk, -ğu (II) *s.* хагдарсан, гандсан, гулжийсан, өнгөө алдсан, цонхигор, зэвхий, цонхийсон, зэвхийсэн.

solumak *(nsz)* 1. амьсгаа авах, амьсгаалах. 2. *(nsz)* аахилах, уухилах, амьсгаадах.

solungaç, -cı *is. zool.* заламгай.

solunum *is.* амьсгаа, амьсгал. **~ sistemleri**

амьсгалын систем.

sombalığı *is. zool.* хульт загас, яргай загас.

somun *is.* бөөрөнхий талх.

somurtkan *s.* яравгар, ихэрхэг, ууртай, дүнсгэр, уруу царайтай, гонсгор, барайсан.

somurtmak *(nsz)* хошуугаа цорвойлгох, гомдож гонсойх, хөмсөг зангидах, хөмсөг атируулах, царай барайх, царайгаа барайлгах.

somut *s.* 1. бодитой, бодит. 2. *is.* бодит (бодитой зүйл.

somutlaşmak *(nsz)* бодит болох, бодитой болох, тодорхой болох.

somutlaştırmak *(-i)* бодит болгох, бодитой болгох, тодорхой болгох.

son *s.* 1. сүүлийн, сүүлчийн. "*Son yağmur ne zaman yağmıştı?*" Хамгийн сүүлд хэзээ бороо орлоо? 2. сүүлийн, төгсгөлийн, эцсийн, хамгийн арын. "*Son tren.*" Хамгийн арын галт тэрэг. 3. сүүлчийн, эцсийн, хэтийн. "*Son ümit.*" Эцсийн найдвар. 4. *is.* эцэс, сүүл, төгсгөл, зах, хязгаар. 5. *is. anat.* хойдох, ихэс, хаг. 6. *mec.* үхэл, насны эцэс. 7. *zf.* байдаг, хамаг байдаг. "*Son hız gidiyordu.*" Байдаг хурдаараа явж байлаа. **~ vermek** дуусгах, төгсгөх, шувтлах. **~ bulmak** дуусах, төгсөх, дүүрэх, шувтрах, төгсгөж байх, дуусаж байх, эцэс болох, төгсгөл болох. **~a erdirmek** төгсгөл болгох, эцэс болгох, дуусгах.

sonbahar *is.* намар.

sonek *is. gr.* үгийн дагавар.

sonra *zf.* 1. дараа, сүүлд, хойно, хожим, аяар, тэгээд, дараа нь, дараагаар нь, сүүлд нь, сүүлээр нь, чингээд. 2. ... (тэгэх) үгүй бол, ... эс тэгвэл, тэгвэл, ингэвэл. "*Dersini çalış yoksa sınavdan geçemezsin.*" Хичээлээ хий, үгүй бол шалгалтаа давж чадахгүй шүү.

sonraki *zf.* дараачийн, дараагийн, удаах, хойтох, бүр сүүлийн, сүүлийн үеийн.

sonsuz *s.* 1. мөнхийн, үүрдийн, цаг үргэлжийн, ямагт, байнгын. 2. эцэс төгсгөлгүй, төгсгөлгүй, тоо томшгүй, хязгааргүй, хэмжээлшгүй. 3. *mat.* хязгааргүй.

sonsuzluk, -ğu *is.* 1. эцэсгүй, дуусгаргүй, барагдахгүй, хязгааргүй. 2. мөнх байдал.

sonuç *is.* 1. үр дүн, үр, дүн, үр дагавар, үршиг. 2. дүн, хариу. "*Sınav sonucu.*" Шалгалтын хариу. 3. дүгнэлт, төгсгөл.

sonuçlandırmak *(-i)* дуусгах, төгсгөх, шуатлах, эцэслэх.

sonuçlanmak *(nsz)* дуусах, төгсөх, шувтрах, шийдэгдэх. "*Bu iş çabuk sonuçlandı.*" Энэ хэрэг хурдан шийдэгдлээ.

sopa *is.* 1. бүдүүн мод, бүдүүн саваа, шийдэм, бороохой, манчуурга. 2. модоор цохих, зодох.

sordurmak *(-i)* асуулгах, сурах, сураглуулах, лавлан асуух, лавлах, асуух, сураглах.

sorgu *is. huk.* байцаалт, байцаан асуух, байцаах, мөрдөн байцаалт, мөрдөлт. **~ya çekmek** байцаах, байцаан асуух, мөрдөн байцаах.

sorgulamak *(-i)* байцаах, байцаан асуух, мөрдөн байцаах.

sormak (I) *(-i, -e, -den)* 1. асуух, сурах, асуулт тавих, асууж мэдэх, асууж сурах, асууж авах. 2. мэддэг байх, хариуцдаг байх. "*Bu işi benden sorarlar.*" Энэ ажлыг би л мэддэг, надаас л асууцгаадаг.

sormak (II) *(-i)* хөхөх, сорох, шимэх.

soru *is.* асуулт. **~ işareti** асуултын тэмдэг.

sorumlu *s.* ve *is.* хариуцлагатай (хүн). **~lu tutmak** хариуцлага ноогдуулах, хариуцлага хүлээлгэх.

sorumluluk, -ğu *is.* хариуцлага, хариуцлагатай (байх).

sorumsuz *s.* хариуцлагагүй. "*Sorumsuz insanlar.*" Хариуцлагагүй хүмүүс.

sorun *is.* 1. асуудал, туйрвах асуудал, проблем. 2. *mec.* зовлон, шаналал.

sorunlu *s.* асуудалтай, туйрвах асуудалтай, проблемтэй.

sorunsuz *s.* асуудалгүй, туйрвах асуудалгүй, проблемгүй.

soruşturma *is.* шүүх, мөрдөх, мөрдөн байцаах, мөрдөн байцаалт, мөрдлөг.

soruşturmak *(-i, -e)* байцаах, мөрдөн байцаах, асуух, шалгах, судлах, сурвалжлах, асууж мэдэх.

sosls *is.* зайдас.

sosyal, -li *s.* нийгмийн, олон нийтийн. "*Sosyal sigorta.*" Нийгмийн даатгал. "*Sosyal yardım.*" Нийгмийн хангамж, тэтгэвэр тэтгэмж.

sosyalist *is. sos.* нийгэм журамтан, социализмыг баримтлагч, социалист.

sosyalizm *is. sos.* социализм, нийгэм журам.

sosyete *is.* язгууртны хүрээ, дээд зиндаа, язгууртны хүрээний хүмүүс, дээд язгууртан.

sosyetik, -ği *s.* язгууртны хүрээний, дээд язгууртны, ихэс ноёдын.

sosyolog *is.* нийгэм судлалч.

sosyoloji *is.* нийгэм судлал.

soy *is.* 1. омог, овог, отог, гэр бүл, гэр, төрөл төрөгсөд, садан төрөл. 2. удам, угсаа, үр угсаа, ач үр. 3. үүлдэр. 4. *s.* сурвалжит, язгууртай, сурв алжтай, угсаат, сайн үүлдрийн, сайн угсааны, үүлдэр сайтай.

soya *is. bot.* таримал буурцгана, шар буурцаг, таримал буурцаг.

soyaçekim *is.* удамшил, удам.

soyadı *is.* овог,овог нэр.

soyağacı *is.* угийн бичиг, гэрийн үеийн бичиг, овог төрлийн цэс.

soygun *is.* дээрэм, тонуул, тонох, дээрэмдэх.

soyguncu *s.* ve *is.* дээрэмчин, тонуулч.

soygunculuk, -ğu *is.* дээрэм, тонуул.

soylu *s. tar.* 1. сурвалжит, язгуурт, угсаат. 2. сурвалжит, язгууртай, сурвалжтай, угсаат, сайн үүлдрийн, сайн угсааны, үүлдэр сайтай.

soyluluk, -ğu *is.* язгуур, сурвалж, угсаа.

soymak, -ar *(-i)* 1. (арьсы нь) хуулах, өвчих, (хальсы нь) арилгах, хальслах. "*Patetes soymak.*" Төмс арилгах (хальслах). 2. хувцасыг нь тайлах, нүцэглэх, шалдлах. 3. дээрэмдэх, тонох, цөлмөх, цөлмөн авах. "*Genci yolda soymuşlar.*" Залууг замд дээрэмджээ.

soysuz *s.* 1. угсаа доройтсон, үүлдэр доройтсон, доожоогүй, дорой. 2. муу нэртэй, өөдгүй, шившигт, шившгийн.

soysuzlaşma *is.* доожоогүй болох, зэрэмдэг болох, угсаа доройтох, алдрах, доройтох, буурч мөхөх, үүлдэр доройтох, зэхийрэх, хувирч гутах, улирч муудах.

soysuzlaşmak *(nsz)* алдрах, доройтох, буурч мөхөх, угсаа доройтох, үүлдэр доройтох, хувирч гутах, улирч муудах.

soytarı *is.* 1. салбадай, алиалагч, алиа салбадай. 2. *mec.* муу зальтай хүн, зальтай этгээд, булхайчин, зальтай гайхал, мэхчин, гөнтэй хүн.

soytarılık, -ğı *is.* 1. алиа салбадайн ажил, алиа зан. 2. мэхлэх, залилах, булхай гаргах, гөн гаргах.

soyunmak *(nsz)* 1. хувцас тайлах, тайчих, нүцэглэх, шалдлах. 2. *(-e) mec.* (өөрийн чадв араа) харуулахыг хичээх, эхлэх. "*Şarkıcılığa soyundu.*" Дуучин болов. Дуулж эхлэв.

soyut *is. fel.* 1. хийсвэр, абстракт. "*Soyut sayı.*" Хийсвэр тоо. 2. *mec.* ойлгоход бэрх, хийсвэр, бодит байдлаас тасархай.

soyutlama *is. fel.* хийсвэрлэх.

soyutlamak *(-i) fel.* хийсвэрлэх.

söğüt *is. bot.* уд. **~ ağacı** удны мод. **salkım ~** унжгар уд.

sökmek *(-i)* 1. ханзлах, ханз татах, задлах, хөвөх. 2. задлах, задлан тавих, салгах, тайлах, ялгах. "*Makinayı sökmek.*" Машин задлах. 3. онгилох, малтаж гаргах, ухах, сугалах, суга татах, тас татах, хуу татах. 4. гатлах, давах, цаана нь гарах, гарах, арай чарай нэвтрэх, арай гэж гарах. "*Araba çamuru s kemedi.*" Машин шавар гаталж чадсангүй. 5. (бичгий нь) гаргах, ойлгох, ойлгож авах, мэдэж авах. 6. ховхлох, гаргах, гоожуулах. "*Balgam sökmek.*" Цэр ховхлох.

sökük, -ğü *is.* ve *s.* ханзалсан, ханз татсан, огло татсан, хүүлсэн, задалсан, хөвөрсөн, цоорхой.

sökülmek *(nsz)* 1. sökmek үйлийн үйлдэгдэх хэв. 2. *(-i) argo.* (ихэвчлэн мөнгийг) дургүй өгөх, дургүй зарцуулах.

sömestr *is.* хагас жил.

sömürge *is.* колони(орон), хараат улс. **~ yapmak** колоничлох.

sömürgeci *s.* 1 колоничлогч. 2. колоничлогчийн, колоничлогч, колоничлох.

sömürgecilik, -ği *is.* колоничлох, колоничлол.

sömürme *is.* мөлжих, мөлжих явдал.

sömürmek *(-i)* 1. мөлжих, шулах. 2. сорж уух. 3. залгих, ховдоглон идэх, гудрах.

sömürü *is.* мөлжих, мөлжих явдал, мөлжлөг.

sömürücü *is.* мөлжигч

söndürmek *(-i)* 1. (гал, гэрэл) унтраах, сөнөөх, бөхөөх. 2. хий гаргах. 3. (сэтгэл) номхруулах, намжуулах, намдаах, тайтгаруулах, дарах.

söndürücü *s.* 1. гал сөнөөгүүр. 2. *s.* гал сөнөөдөг, гал сөнөөх.

sönmek *(nsz)* 1. (гал, гэрэл) унтрах, сөнөх, бөхөх. 2. хий гарах. 3. (галт уул) сөнөх, идэвхгүй болох. 4. номхрох, намжих, намдах, тайтгарах, тайвшрах, дарагдах. 5. доройтох, буурах, сулрах, муудах.

sönük, -ğü *s.* ve *is.* 1. унтарсан, бөхсөн, сөнөсөн, хий нь гарсан. 2. бүдэг, бүүдгэр, сүүмгэр, сулхан, үхээнц, шалигүй, ялихгүй, ялимгүй. 3. *mec.* бий үгүй нь мэдэгдэхгүй, хүний анхааралд өртдөггүй.

sövgü *is.* хараал, хараалын үг, хараал зүхэл.

sövme *is.* 1. хараал, хараалын үг, хараал зүхэл. 2. *huk.* доромжлол, дайрсан хэрэг, басамжилсан үг.

sövmek *(-e)* хараах, хараал тавих, зүхэх, загнах, зэмлэх, үгээр дайрах, доромжлох.

söylemek *(-i, -e)* 1. хэлэх, ярих, гэх, илэрхийлэх, өгүүлэх. 2. хэлэх, санал хэлэх, санал дэвшүүлэх, санал оруулах. 3. хүсэх. 4. дуулах, уран унших, яруу унших, бичих, зохиох. "*Şarkı söylemek.*" Дуу дуулах. 5. хэлэх, хэл хүргэх.

söyleniş *is.* дуудлага, аялга, хэллэг.

söylenmek *(nsz)* 1. хэлэгдэх, яригдах, өгүүлэгдэх, дурдагдах. 2. загнах, шүүмжилж загнах, үглэх, янших, бөвтнөх, аман дотроо үглэх.

söylenti *is.* 1. домог, хууч үг, үлгэр домог. 2. цуу сураг, цуурхал, хов яриа, сураг, яриа, олны яриа.

söyletmek *(-i, -e)* 1. хэлүүлэх. 2. (бурууг нь) хүлээлгэх, (үнэний нь) хэлүүлэх.

söylev *is.* үг, хэлсэн үг, яриа.

s z *is.* 1. үг, үг хэлэх, хэлсэн үг. 2. үг. 3. цуу яриа, хов яриа, яриа, цуу сураг. 4. ам, ам хэл, үг, амлалт, хэлсэн ам. 5. (дууны)үг. **~ almak** 1) үг хэлэх эрх авах, үг хэлэх зөвшөөрөл авах, ярих. 2) ам авах, ам хэл авах, амлалт авах. 3) (эрэгтэйн тал эмэгтэйн талаас) гэрлэх зөвшөөрсөн хариу авах. **~ dinlemek** үг сонсох, үг дуулах. **~ geçirmek** нөлөөлөх, нөлөө үзүүлэх, үйлдэл үзүүлэх. **~ kesmek** сүй тавих. **~ vermek** амлах, ам гарах, ам алдах, ам өгөх. **~ünde durmak** амласандаа хүрэх, хэлсэн амандаа хүрэх, хэлсэндээ хүрэх, хэлсэн үгэндээ хүрэх. **~ünün eri olmak** хэлсэн үгэндээ эзэн болох.

sözbirliği *is.* санал нийлэх, нэг саналтай байх, санал нэгтэй байх, үг нэгдэх, үгсэх, үгээ ололцох.

sözcü *is.* 1. төлөөлөгч, тайлбарлагч. "*Basın*

s zcüsü." Хэвлэлийн төлөөлөгч. 2. илтгэгч.

sözcük, -ğü *is.* үг.

sözdizimi *is. gr.* өгүүлбэр зүй.

sözleşme *is.* хэлэлцээр, гэрээ, гэрээ бичиг.

sözleşmek *(nsz, -le)* хэлэлцэх, хэлэлцэж тохирох, хэлэлцэн тогтох, тохиролцох, болзох, хэлэлцэн тогтох, хэлцэх, тохирох.

sözlü *s.* 1. аман, амаар, амаар авах, амаар хэлсэн. "*Sözlü sınav.*" Аман шалгалт. 2. болзоотой. 3. *is.* ve *s.* хүргэн болох хүн, гэрлэх хүн, сүйлсэн хүүхэн, хадамтай хүүхэн, сүйт.

sözlük, -ğü *is.* толь бичиг.

sözlükbilgisi *is.* үгийн сангийн зүй (хэлний үгсийн бүрэлдэхүүнийг судлах ухаан).

sözlükbilimi *is.* үгийн сангийн зүй (хэлний үгсийн бүрэлдэхүүнийг судлах ухаан).

sözlükçü *is.* толийн зүйч, толь зохиогч.

sözlükçülük, -ğü *is.* толийн зүй (толь зохиох онол, практик).

spiker *is.* диктор, уншигч, радио нэвтрүүлэгч.

spor *is.* 1. биеийн тамир, спорт. 2. *s.* (хэрэглэхэд) эвтэй, эвтэйхэн, спортын. "*Spor ayakkabı.*" Өмсөхөд эвтэй гутал. Спортын гутал.

sporcu *is.* тамирчин, спортчин.

stadyum *is.* цэнгэлдэх хүрээлэн.

staj *is.* 1. дадлагажих хугацаа, дагалдан сурах хугацаа, дагалдан сурах, дадлагажих, дадлагажилт. 2. (ажилласан) хугацаа.

stajyer *is.* дагалдан сурагч, дадлагажигч.

stand *is.* 1. 2. үзмэрийн самбар, үзмэрийн тавиур.

standart, -dı *s.* 1. стандарт, (нэг) загвар, үлгэр, нэг хэв, нэг маяг. 2. *is.* стандарт, үндсэн хэмжээ.

statik, -ği *s.* 1. хөдөлгөөнгүй, өөрчлөлтгүй, нэг хэвийн, статик. 2. *is.* тогтол зүй, статик.

statü *is.* 1. нийгэм дэх байр суурь. 2. албан тушаал. 3. дүрэм, горим. 4. баримал, хөшөө.

steno *is.* таталган бичиг, стенографи.

stok *is.* нөөц, бэлтгэл. **~ etmek** нөөх, нөөцлөх, бэлтгэх, зэхэх, базаах, хураах, хуримтлуулах.

strateji *is.* 1. зорилгодоо хүрэх зам. 2. стратеги, дайныг удирдах чадвар, дайтах ухаан. 2. нийгмийн ба улс төрийн тэмцлийг удирдах чадвар.

stüdyo *is.* 1. (урлагийн) сургууль, танхим. 2. студи, (зураачийн) танхим. 3. төлестуди.

su, -yu *is.* 1. ус. "*Tatlı su.*" Цэнгэг ус. 2. ус (гол, нуур, тэнгис зэрэг усан гадаргуу). 3. шүүс. "*Meyve suyu.*" Жимсний шүүс. 4. зүрхэн охь, эссенци. 5. шөл, усан шөл. **~ almak** 1) ус орох, ус нэвтрүүлэх, ус нэвтрэх. "*Ayakkabılarım su alıyor.*" Миний гутал ус нэвтрүүлээд байна. 2) *den.* (завь, усан онгоцонд) ус нэвтрэх, ус нэвтэрч орох, ус орох, нэвчих, норох. 3) *den.* (усан онгоц) ундны ус авах. **~ basmak** ус авах, усанд автах, усанд авахуулах. **~ gibi akmak** 1) цаг хугацаа ус шиг урсах, хурдан өнгөрөх. 2) (хоол унд, мөнгө) элбэг дэлбэгээр орж ирэх. **~ toplamak** цэвүүүсрэх, ус гүйх.

sual *is.* асуулт. **~ etmek** асуух, асуулт тавих.

sualtı *is.* усан дорх, усны ёроол.

suaygırı *is. zool.* усны үхэр, армана (Африкийн туурайт том амьтан).

subay *is.* офицер.

subaylık, -ğı *is.* офицерийн үүрэг, офицер цол.

subilimci *is.* ус судлалч, гидрологич.

subilimi *is.* ус судлал, гидрологи.

sucu *is.* усчин, ус зөөгч.

sucuk, -ğu *is.* хиам. **~ gibi olmak** нэвт норох, усан хулгана болох.

suç *is.* 1. буруу, ял, гэм, алдал, алдаа, эндэл. 2. буруу хэрэг, гэмт хэрэг, зэм, ял, ялт хэрэг. **~ işlemek** гэмт хэрэг хийх, ялт хэрэг хийх.

suçiçeği *is. tıp.* салхин цэцэг, чонын хөрв өс (өвчин).

suçlama *is.* буруушаал, зэмлэл. **~lar yapmak** буруушаах, зэмлэх, ял тохох.

suçlamak *(-i, -le)* буруушаах, зэмлэх.

suçlanmak *(nsz, -le)* яллагдах, шийтгэгдэх, буруушаагдах.

suçlu *is.* ve *s.* 1. гэмт хэрэгтэн, ялтан, хэрэгтэн. 2. буруутай, буруу, гэмт этгээд, зэмт хүн.

suçluluk, -ğu *is.* 1. буруутай (байх), гэм буруу, гэм зэм. 2. ял, ялт хэрэг, ялт хэрэг үйлдэх явдал, гэмт хэрэг.

suçluluk duygusu *is. psikol.* буруугаа мэдэх, ухаарах, гэмших.

suçüstü *zf.* хэрэг хийж байхад, хэрэг хийж байгаад. **~ yakalamak** хэрэг хийж байхад нь барих. **~ yakalanmak** хэрэг хийж байгаад баригдах.

suflör *is. tiy.* сануулагч.

sugeçirmez *s.* ус нэвтрэхгүй, ус даах.

suiistimal, -li *is.* хортой ашиглах, зүй бус ашиглах, ёсон бус эдлэх, хэтрүүлэн эдлэх, буруу ашиглах. **~ etmek** хортой ашиглах, зүй бус ашиглах, ёсон бус эдлэх, хэтрүүлэн эдлэх, буруу ашиглах.

suikast *is.* 1. халдах, халдлага, хорлохыг оролдох, хөнөөхийг завдах. 2. захиалгат аллага.

suizan *is.* муу санаа, хар санах, муу санах. **~da bulunmak** хардах, сэжиглэх, хар санах.

sukamışı *is. bot.* усны зэгс.

sulama *is.* услах, услалт, усжуулах, усжуулалт.

sulamak *(-i)* 1. (хөрс, ургамал) услах, усжуулах. 2. (амьтан) услах, ус өгөх.

sulandırmak *(-i)* 1. услуулах, ус өгүүлэх. 2. шингэлэх, шингэрүүлэх, ус холих.

sulanmak *(nsz)* 1. усархаг болох, услагдах. 2. шингэрэх. 3. норох, услагдах, чийгтэх, чийг

авах, дэвтэх. 4. нулимс гарах, нулимс гоожих. 5. *(-e) argo.* дур татагдах, хорхойтох, шүлсээ гоожуулах, дуртай байгаагаа илэрхийлэх. 6. *argo.* ээрэх, ороцолдох, хоргоох.

sulh *is.* энх тайван, найрамдал. **~ sözleşmesi** энх тайвны хэлэлцээ. **~ yapmak** найрамдал байгуулах.

sultan *is. tar.* 1. султан, хаан. 2. хатан хаан, гүнж, агь.

sulu *s.* 1. усан, устай. 2. шүүстэй, шимтэй, шүүслэг. "*Sulu limon.*" Шүүслэг нимбэг. 3. шингэрүүлсэн, шингэлсэн, шингэн, усавхи, ус хольсон, усан. 4. *s.* ve *is. mec.* горимгүй, нүүргүй, ичих нүүргүй, залхуутай, хаширтай, улигт, салж өгдөггүй, наалдамхай.

suluboya *is.* усан будаг.

suna *is. zool.* эр нугас.

suni *s.* 1. хиймэл, зохиомол. 2. *mec.* хуурамч, худал.

sunmak *(-i, -e)* барих, өргөн барих, гардуулах, олгох. "*Bu kitabı size sunmak istiyorum.*" Энэхүү номыг би танд өргөн барихыг хүсч байна.

sunta *is.* шахмал хавтан (модон).

sunu *is.* 1. өргөл, барьц. 2. нийлүүлэлт.

sunucu *is.* (радио телевизийн шоуны) хөтлөгч.

sunuş *is.* 1. илтгэмж, илтгэл, өргөх бичиг, рапорт. 2. өмнөх үг.

sur (I) *is.* хэрэмийн туурга, хэрэм, цайзын хана.

sur (II) *is. hlk.* хувь заяа, хувь зохиол, тавилан, үйл, хувь.

surat *is.* 1. царай, нүүр. 2. дургүйцсэн царай, чамласан царай, барайсан царай, хөмсөг зангидах, хүйтэн царай. **~ asmak** барайх, манарах, бүүдийх, гонсойх, гомдож гонсойх, хөмсөг зангидах, хөмсөг атируулах, царайгаа барайлгах. **~ etmek** хошуугаа цорвойлгох, гомдож гонсойх, гоморхох, дүнсийх.

suratsız *s.* 1. барайсан царайтай, муухай царайлсан. 2. царай муутай, муухай. 3. муухай ааштай, ааш муутай, шазруун, ширүүн.

sure *is.* Кураан судрын бүлэг.

suret *is.* 1. хэлбэр, хэв, дүрс, галбир, байдал, төрх. 2. хэлбэр, маяг, янз. 3. хуулбар, бичгийн хуулбар, зургийн хуулбар. 4. *hlk.* зураг.

susam *is. bot.* гүнжид.

susamak *(nsz)* 1. цангах, ундаасах, ангах. 2. *mec.* хүслэн болох, шунал болох, эгээрэл хүсэл болох, эрмэлзэх.

suskun *s.* 1. дуугүй, үг цөөнтэй. 2. *zf.* чив чимээгүй, таг чиг, нам гүм, чимээ аниргүй, дугай, үг дуугүй, чимээгүйхэн.

suskunluk, -ğu *is.* 1. дуугүй байх. 2. анир чимээгүй байх, чимээгүй байх.

susmak, -ar *(nsz)* 1. дуугүй байх, дуугаа хураах, ярихаа болих. 2. анир чимээгүй байх, нам гүм байх, чимээгүй болох.

susturmak *(-i)* 1. дуугүй болгох, ярихыг нь болиулах, чимээгүй болгох. 2. ам таглах, ам бөглөх, гартаах, үгээр давах, амыг нь таглах, амыг нь хаах.

susturucu *s.* 1. дуугүй болгох, дугай болгох, чимээгүй болгох. 2. *is.* чимээ намхруулагч, чимээ дарагч.

susuz *s.* 1. усгүй. 2. шүүсгүй, шимгүй. 3. хуурай, хатсан, гантай. 4. ангасан, цангасан, ундаассан.

susuzluk, -ğu *is.* 1. усгүйдэл, хуурайшил, ган. 2. цангаа, ангаа, амны цангаа, амны ангаа, цангах, ангах, ундаасах.

sutyen *is.* хөхний даруулга.

suvare *is.* үдэшлэг, үдшийн наадам.

süet *is.* илэг.

sükunet *is.* амгалан байдал, тайван байдал, амгалан тайван, амар заяа, нам гүм.

sükut *is.* дугай байх, дуугүй байх, нам гүм байдал, нам гүм байх, анир чимээгүй, чимээгүй байх. **~u bozmak** дугай байхад эхэлэн ярих.

sülale *is.* угсаа, үр ач, үе, язгуур, гарал.

sülfat *is. kim.* хүхэр хүчлийн давснууд, сульфат.

sülfür *is. kim.* хүхэр.

sülük, -ğü *is. zool.* хануур хорхой, цус сорох хорхой (анагаах ухаанд хэрэглэх).

sülün *is. zool.* гургуул шувуу.

sümbül *is. bot.* хэлгий цэцэг.

sümkürmek *(nsz)* нус нийх.

sümük, -ğü *is.* нус, залхаг, салс, зунгаг.

sümüklüböcek *is. zool.* эмгэн хумс, хорхойнцог, дун хорхой.

sünger *is. zool.* далайн хөвөн, губк, сархинцаг.

sünnet *is.* 1. Мусульманчуудын заншил зуршил. 2. тайрах зан үйл, оттлох ёслол.

süpürge *is.* 1. шүүр. 2. тоос сорогч.

süpürmek *(-i)* 1. шүүрдэх, хамах, тоос сорох. 2. *mec.* гаргаж хаях, гаргах, хөөх, хөөж гаргах. 3. *mec.* дуусгах, хэрэглэж дуусгах.

sürahi *is.* галуун хүзүүт усны лонх, бутан.

sürat, -ti *is.* хурд. **~ini arttırmak** хурдаа нэмэх, хурдлах.

sürdürmek *(-i)* 1. түрхүүлэх, нялуулах. 2. цааш нь үргэлжлүүлэх, үргэлжлүүлэх, – саар байх, сунгах, уртасгах, хугацаа сунгах. "*Kitabını okumayı sürdürüyordu.*" Номоо уншсаар байлаа.

süre *is.* хугацаа, үе, мөчлөг, цаг.

süreç *is.* явц, ажиллагаа, хөгжлийн явц.

süreğen *s.* 1. ужиг, ужсан, байнгын, сунжирсан. 2. *tıp.* архаг, ужиг, хуучин, ужсан, удааширсан. "*Süreğen bir hastalık.*" Архаг өвчин, ужиг өвчин.

sürekli *s.* урт, удаан, үргэлжлэх, удаан хугацааны, өнө удаан, тасралтгүй, үргэлжилсэн, байнгын, байнга, үргэлжийн.

süreklilik, -ği *is.* үргэлжлэл, үргэлжлэх хугацаа, хугацаа, урт, удаан түргэн, урт богино.

süreli *s.* үе үе болох, давтагдах, үе дараалан гарах, дараалалт.

sürerlik, -ği *is.* удаан түргэн, урт богино.

süresiz *s.* хугацаагүй, болзоогүй.

sürgün *is.* 1. цөлөгдсөн хүн, хөөгдсөн хүн, цөлөгдөгч. 2. цөллөг. 3. шинэ соёо, найлзуур, мөчир. 4. гүйлгэх, гүйлгээ, дотор аягүйтэх, чацга алдах, улаан суулга, цусан гүйлгээ өвчин, жүсэр. **~e göndermek** цөлөх, нутаг заах.

sürme (I) *is.* 1. sürmek үйлийн нэр. 2. дэгээ, оньс, чагт, хөшүүр, түгжээ, тээг. 3. шургуулга. 4. *s.* автдаг, гүйдэг, сугардаг. "*Sürme kapı.*" Гүйдэг хаалга.

sürme (II) 1. нүдний харандаа, нүд будах будаг. 2. харуу, харуутах, хар түрүү, харанцаг(тарианы өвчин).

sürmek *(-i, -e)* 1. жолоодох. 2. туух, хариулах. "*Koyunları sürmek.*" Хонь хариулах. 3. хүрэх, хүргэх. "*Elini oraya sürmeyin.*" Битгий тэнд гараа хүргээрэй. 4. цөлөх, нутаг заах. 5. түрхэх, нялах. "*Boya sürmek.*" Будаг түрхэх./Будах. 6. хуурамч мөнгө хийх. 7. зах зээлд гаргах, зах зээлд нийлүүлэх. "*Kışlık elbiseleri piyasaya sürdüler.*" Өвлийн хувцаснуудыг зах зээлд нийлүүллээ. 8. (ямар нэг байдалд) байх, амьдрах. "*Dört duvar arasında bir memur hayat sürüyordu.*" Дөрвөн хананы дунд төрийн албан хаагч хийж байв. 9. *(-i)* газар хагалах. 10. *(nsz)* үргэлжлэх. "*Fırtına üç gün sürdü.*" Шуурга гурван хоног үргэлжлэв. 11. *(nsz)* хугацаа өнгөрөх. "*Çok sürmez, her şey güzel olur.*" Тун удахгүй бүх юм сайхан болно. 12. *(nsz)* цаг авах, цаг алдах. "*Bu iş iki saat sürer.*" Энэ ажил хоёр цаг авна.

sürpriz *is.* гэнэтийн сонин, санамсаргүй явдал, гэнэтийн бэлэг.

sürtmek *(-i, -e)* 1. үрэх, зүлгэх. 2. хүргэх, шүргэх, хүрэх. 3. *(nsz) tkz.* тэнэх, хэсэх, хэрэх.

sürtük, -ğü *is.* 1. хэсүүлч, тэнэмэл (эмэгтэй). 2. янхан.

sürtünmek *(nsz)* 1. шүргэх, хүрэх. 2. *mec.* хэрүүл гуйх, хэрүүл өдөх, хэрүүл эрэх.

sürü *is.* 1. сүрэг. 2. бөөн, баахан.

sürücü *is.* 1. (мал) туугч, тууварчин. 2. жолоодогч, жолооч.

sürücülük, -ğü *is.* жолооч, жолоочийн ажил.

sürüklemek *(-i)* 1. чирэх, түлхэх, татах. "*At onu hayli sürükledi.*" Морь түүнийг нилээд чирэв. 2. урсах, урсгах. "*Nehir dalları sürükledi.*" Мөчир голд урсав. 3. *mec.* чирч авчрах, чирч оруулах. "*Niye onu sürükleyip getirdin ki?*" Яах гэж түүнийг чирч авчирсан юм бэ дээ чи? 4. *(-i, -e) mec.* (муу байдалд) татах, татан оруулах, хавчиж оруулах. 5. *mec.* татах, улайрах, салахын аргагүй болгох.

sürükleyici *s.* сэтгэл татсан, сонирхол татсан, сонирхолтой.

sürüm *is.* 1. борлуулах, худалдөх, борлуулалт, худалдаа. "*Sürüm pazarı.*" Борлуулах зах зээл. 2. эргэлт, гүйлгээ. "*Bu para sürümden kaldırıldı.*" Энэ мөнгө гүйлгээнээс гарсан.

sürümek *(-i)* 1. татах, чангаах, чирэх. 2. чирэх. "*Eteğini sürüklemek.*" Хормойгоо чирэх. 3. чирч явах, авч явах, дагуулж явах. 4. үргэлжлэх.

süründürmek *(-i)* 1. мөлхүүлэх. 2. *mec.* зовоох, гачигдалд хүргэх.

sürüngen *is. zool.* хэвлээр явагчид, мөлхөө амьтад, гүвгэнэгчид.

sürünmek *(nsz)* 1. мөлхөх, гулгаж явах, хэвлээр явах. 2. *(-i)* түрхэх, нялах, бялах. "*Bir şişe parfümü süründüm.*" Би, нэг шил үнэртэй ус түрхлээ. 3. шүргэх, хүрэх, дөнгөж хүрэлцэх, аяархан хүрэх. "*Boyaya sürünmek.*" Будагт хүрэх. 4. чирэгдэх, чирүүлэх, чирэгдэн явах. 5. *mec.* улжих, дөнгөж амьдрах, амь улжих, өл залгаж амьдрах, дөнгөж дангаж суух, ядаж аж төрөх. "*Yarı tok sürünmek.*" Ядаж аж төрөх.

süs *is.* 1. чимэх, чимэглэх, гоёх. 2. засал, чимэг засал, тохижол, гоёл. 3. гоёл, гоёлын хувцас, чимэглэл, угалз, хээ, хээ угалз.

süslemek *(-i)* 1. гоёх, чимэх, гоё хувцаслуулах, гоюулах, дэгжин хувцаслуулах. 2. чимэх, чимэглэх.

süslenmek *(nsz)* 1. гоёх, гангалах, гоё хувцаслах, дэгжин хувцаслах. 2. чимэгдэх, чимэглэгдэх.

süslü *s.* 1. чимсэн, чимэглэсэн, гоёсон, гангалсан, гоё хувцасласан, гоё, ганган, гангалсан, дэгжин хувцасласан. 2. чимэх дуртай, гоёх дуртай, гангалах дуртай. "*Süslü bir kadın.*" Гангалах дуртай эмэгтэй.

süt *is.* 1. сүү. 2. *bot.* сүү, сүүхэн. 3. (загасны) цагаан, нялга, эөр.

sütçü *is.* сүү худалдагч.

sütdişi *is.* унаган шүд, сүүн шүд.

sütkardeş *is.* сүүний ах дүүс (нэг ээжийн сүүг хөхсөн).

sütlâç, -cı *is.* сүүтэй чихэртэй будаа.

sütlü *s.* 1. сүүтэй. "*Sütlü kap.*" Сүүтэй сав. 2. саалийн, сүүтэй. "*Sütlü inek.*" Саалийн үнээ.

sütun *is.* 1. *mim.* багана. 2. үе, зурвас (сонин, сэтгүүл, номны).

süvari *is.* морин цэрэг.

süveter *is.* битүү захтай цамц.

süzgeç, -ci *is.* шүүр, шүүлтүүр.

süzgün *s.* үлбэгэр, ядрангуй.

süzme *s.* шүүсэн, шүүж гаргасан. "*Süzme bal.*" Шүүсэн зөгийн бал.

süzmek *(-i)* 1. шүүх, шүүж тунгаах. 2. ширтэх, толгойноос хөл хүртэл харах, шинжих. 3. талмайрч харах.

süzülmek *(nsz)* 1. шүүгдэх. 2. (шувуу) халин нисэх. 3. урсах. "*Gözlerinden yaşlar süzüldü.*" Нүднээс нь нулимс урсав. 4. ихэд турах, яс арьс болох. 5. нүд талмайрах. 6. гунхалзан алхах.

Ş

ş, Ş Түрк цагаан толгойн хорин гурав дахь үсэг.

şad *s.* цэнгэлтэй, зугаатай, баяртай, баяр баясгалантай, баясгалантай, жаргалтай.

şafak, -ğı *is.* үүр, үүр гийх, үүр цайх, гэгээ. **~ sökmek** үүр цайх, үүр гийх, үүр гэгээрэх, гэгээ орох, үүр хаяарах, үүр хяраалах.

şaft *is.* тэнхлэг, гол, бул.

şah (I) *is.* 1. *tar.* хаан.(Ираны, Афганы) 2. шатрын ноён, шаг.

şah (II) морь цоройх, морь цоройсон байдал. **~a kakmak** морь цоройж зогсох, цамнах.

şahadet *is.* 1. гэрч, гэрч баримт, гэрч нотолгоо, нотолгоо, өгүүлсэн зүйл, гэрчлэл, гэрчлэх, нотлох. 2. *is.* ариун үйлийн төлөө, шашин шүтлэгийн төлөө тэмцэж байгаад амь үрэгдэх.

şahadet parmağı *is.* долоовор хуруу.

şahane *is. esk.* 1. хааны, хаант засгийн, хаант. 2. *mec.* тансаг, эрхэм сайхан, гойд сайн, сайхан, гоё, их сайхан, үзэсгэлэнтэй, гайхуулам, сүр жавхлантай.

şahap, -bı *is.* солир, од харвах, нисэх од, харв ах од, харвах солир.

şahdamarı *is.* аорт, гол судас, улаан гол.

şaheser *is.* эрхэм дээж, гарамгай бүтээл, сод бүтээл. "*Herkes bu resmin bir şaheser olduğuna kaniydi.*" Бүгд энэ зургийг сод бүтээл мөн гэж үзэж байлаа.

şahıs, -hsı *is.* хүн, биө, биө хүн. "*Şahsı kimliği.*" Биөийн үнэмлэх.

şahin *is. zool.* начин, шонхор.

şahit, -di *is.* 1. гэрч, нүдээр үзсэн хүн, нүдээр харсан хүн. "*Bu olay gerçekten olmuş olaydır şahidi var.*" Энэ үнэхээр болсон явдал нүдээр үзсэн хүн байгаа. 2. *is. huk.* гэрч, гэрчийн этгээд. **~ olmak** гэрч болох, нүдээр үзэх, нүдээр харах.

şahitli *s.* гэрчтэй.

şahitlik, -ği *is.* гэрч, гэрч баримт, гэрч нотолгоо, нотолгоо, өгүүлсэн зүйл, гэрчлэл, гэрчлэх, нотлох. **~ etmek** гэрчлэх, гэрч болох, өчиг өгөх, мэдүүлэг өгөх.

şahitsiz *s.* гэрчгүй.

şahlanmak *(nsz)* 1. (морь) цоройх, цамнах. 2. *mec.* биеэ барихгүй байх, омог нь бадрах, омог нь шатах, хөөрөх, дээлэндээ багтахгүй болох, тэвчээр алдах, уур нь оволзох. 3. *mec.* урам орох, зоригжих, гялалзах, гэрэлтэх.

şahmerdan *is.* балт, лантуу, том алх, өлгүүр, балбуур, аварга лантуу.

şahsen *zf.* 1. нүүрээрээ, биеэрээ, өөрөө. "*Şahsen işitmedim.*" Би өөрөө сонсоогүй л дээ. 2. зүсээр нь, холоос. "*Onu şahsen tanırım, ahbaplığımız yoktur.*" Би түүнийг зүс танихаас цаашгүй.

şahsî *s.* амины, хувийн, өөрийн, тухайн хүний, тус бүрийн. "*Şahsî düşüncem.*" Миний хувийн бодол.

şahsiyet *zm.* 1. хувийн онцлог, хувийн онцлог шинж, өөрийн онцлог, тус бүрийн онцлог (салангид, бодьгал) . 2. биө, хүн, бие хүн, чухал хүн, нэр хүндтэй хувь хүн.

şaibe *is.* 1. хир, буртаг, толбо, цоохор. 2. өө, өө сэв, гэмтэл, алдаа дутагдал, дутагдал, доголдол.

şair *is.* яруу найрагч, шүлэгч.

şairlik, -ği *is.* яруу найрагч (байх), шүлэгч (байх).

şaka *is.* шог, даажин, тоглоом, наадам, инээдэм наадам, инээдтэй юм, хошин үг. **~ bir yana** инээдэм наадмыг орхиж. **~etmek** тоглох, даажигнах, наадам хийх. **~ya vurmak** тоглоом болгох, тоглоом болгон өнгөрөөх. **~ yapmak** наадам болгож хийх, тоглож хийх, тоглоод хийх, тоглоом хийх.

şakacı *is.* шогч хүн, тоглоомч хүн, хошинч хүн, алиа хошин хүн, шогч хүн

şakadan *zf.* тоглоом болгож, тоглож, тоглоод, наадам болгож. "*Şakadan darılır gibi yaptı.*" Тоглож гомдсон дүр үзүүллээ.

şakak, -ğı *is.* чамархай, санчиг. **~ları ağarmak** санчгийн үс бууралтах, үс цагаарах, цайрах.

şakalaşmak *(nsz, -le)* тоглоом шоглоом хийцгээх, тоглоом хийцгээх, хошигнолцох.

şakasız *s.* тоглоомгүй, төлөв төв, үнэхээр.

şakayık *is. bot.* цээнэ цэцэг.

şakımak *(nsz)* 1. донгодох, жиргэх, шагших, шулганах. 2. (шүлэг, дуу)унших, дуулах.

şakırdamak *(nsz)* шаржигнах, шаржигнуулах, таржигнах, таржигнуулах.

şaki *is.* дээрэмч, дээрэмчин, тонуулчин.

şakirt, -di *is.* шавь, суралцагч, сурагч, дагалдан сурагч.

şakketmek *(-i)* цуулах, ярах, хагалах, хага цохих, цуу татах, бутлах.

şaklaban *s.* 1. алиа, хошин, марзганагч (хүн). 2. салбадай, алиа салбадай.

şaklatmak *(-i)* тас тас хийлгэх, тас няс хийлгэх, түс хийлгэх, пад пад хийлгэх.

şakrak *s.* 1. (дуу чимээний хувьд) баяртай, баяр хөөртэй, хөгжилтэй, баясгалантай, цэнгэлтэй, зугаатай. "*Şakrak bir kahkaha.*" Баяр хөөртэй инээд. 2. хөгжилтэй, сэргэлэн, амьдрал дүүрэн, баясгалантай, наргиантай, цовоо, золбоотой(хүн). "*Şakrak bir kız.*" Хөгжилтэй охин.

şakrakkuşu *is. zool.* зана(шувуу).

şakul, -lü *is. fiz. esk.* эгц хажуу.

şal *is.* 1. кашимөр даавуу. 2. их алчуур, шаль, нөмөрдөг алчуур.

şalgam *is. bot.* сармаг, лууван.

şalter *is.* унтраалга, цахилгаан гүйдэл таслагч.

şalvar *is.* шалбуур өмд, шарваар өмд.

şaman *is.* бөө, зайран.

şamandıra *is.* 1. *den.* усны болгоомжлох тэмдэг, хөвүүр тэмдэг, бакен. 2. дэн, дэнгийн толой, дэнгийн гол, галлуур.

Şamanlık, -ğı *z. is.* Бөөгийн мөргөл, бөөгийн шашин.

şamar *is.* алгадах. **~ atmak (veya indirmek)** алгадах. "*Ahmet onun omzuna kuvvetli bir şamar indirdi.*" Ахмет түүний мөрлүү хүчтэйхэн алгадлаа.

şamarlamak *(-i)* алгадах.

şamata *is.* шуугиан, шаагиан, чимээ, анир, дуу шуу, үймээн шуугиан, бужигнаан, хашгараан. **~ etmek** шуугих, шаагих, дуу шуу болох, чимээлэх, бужигнах, хашгарах.

şamdan *is.* лааны суурь, лааны тосгуур, лааны баг тавиур.

şamfıstığı *is. bk.* antepfıstığı.

şampanya *is.* шампан дарс.

şampiyon *is.* ve *s.* аварга, түрүүлсэн хүн.

şampiyona *is.* 1. аварга булаалцах тэмцээн, аварга шалгаруулах тэмцээн. 2. тэргүүн байр, түрүүлэх, аварга.

şampiyonluk, -ğu *is.* тэргүүн байр, түрүүлэх, аварга. **~u kaybetmek** тэргүүн байраа алдах.

şampuan *is.* толгой угаах шингэн саван, шампунь.

şan (I) *is.* 1. алдар, алдар цуу, алдар нэр, нэр алдар, нэр, цуу, нэр хүнд. 2. эрхэм зэрэг, чанар чансаа, дориун, сайн нэр алдар.

şan (II) *is. müz.* дуулах, дуулал, дуу.

şangırdamak *(nsz)* ханхир жингэр дуугарах, жингэнэх, хангинах.

şangırtı *is.* дуугарах, хангинах, жингэнэх, хангинах чимээ, жингэнэх дуу.

şanlı *s.* 1. алдарт, алдар цуутай, алдартай, цуутай, алдар цуутай. гялалзсан, гайхуулам, гоц. 2. аугаа, аугаа их. 3. хүндэт, эрхэм, эрхэмсэг, хүндтэй, хүндэт, нанс.

şans *is.* 1. хувь заяа, тавилан, төөрөг, хувь зохиол. 2. аз, зол, аз хийморь, аз завшаан. 3. боломж, магадын хувь, магадлал. **~ tanımak** боломж өгөх, боломж олгох. **~ın açık olsun** чамд аз дайрах болтугай, азтай байх болтугай. "*Şansı ona güldü.*" Түүний аз дайрчээ. "*Şansım yok.*" Миний аз харьжээ.

şanslı *s.* азтай, золтой, хийморьтой, зол завшаантай, жавшаантай, урагштай, амжилттай.

şansölye *is.* (Австри, Германы) төрийн тэргүүн, өрөнхий сайд.

şanssız *s.* хувьгүй, заяа муутай, азгүй, золгүй, зол муутай, заяагүй, урагшгүй, бүтэлгүй.

şanssızlık, -ğı *is.* азгүй явдал, бүтэмжгүй хэрэг, азгүй байх, хохь, амжилтгүй болох, урагшгүй явдал, хийморь доройтох, бүтэлгүй байдал, гай, үйл, тотгор.

şantaj *is.* илчлэхээр айлгах. **~ yapmak** илчлэхээр айлгах.

şantajcı *is.* илчлэхээр айлгагч.

şantiye *is.* барилгын талбар.

şantör *is.* эрэгтэй дуучин.

şantöz *is.* эмэгтэй дуучин.

şap *is. kim.* цөр (янз бүрийн хос давсны нэр).

şaphane *is.* цөр гардаг газар, цөрний үйлдвэр.

şapırdamak *(nsz)* тамшаах, шов шов хийлгэх, шов гэтэл үнсэх, шовхийх.

şapırdatmak *(-i)* тамшаах, шов шов хийлгэх, шовхийлгэх.

şapka *is.* 1. малгай, бүрх, эсгий малгай. 2. *gr.* () үсгийн малгай.

şapkacı *is.* малгай хийдэг хүн, малгай худалддаг хүн.

şaplamak (I) *(nsz)* шов шов хийлгэх, алгадах, цохих, гуядах, пад пад хийлгэх, тав тов хийлгэх.

şaplamak (II) *(-i)* цөртэй усаар услах, цөртэй усаар чийглэх.

şaprak, -ğı *is.* гөлөм, тохом, хэжим.

şapşal *s.* 1. мангардуу, тэнэгдүү, эргүү. 2. салан, балиар, бохир, цэвэрч бус хүн. 3. сул болсон, холхисон, хэлхэгэр (хувцас).

şarampol, -lü *is.* замын хажуу дахь суваг.

şarap, -bı *is.* дарс, сархад.

şarapçı *is.* дарсч, сархад нэрэгч.

şarapnel *is.* тэсэрдэг сум.

şarbon *is. tıp.* боом, боом өвчин.

şarıldamak *(nsz)* хоржигнох, шоржигнох, хор хор хийх, шор шор гэх, жир жир урсах. "*Dere şarıldıyor.*" Горхи хоржигнож байна.

şarıltı *is.* шоржигноо, хоржигноо, хоржигнох дуу, шоржигнох дуу. "*Derenin şarıltısı buradan duyuluyor.*" Горхины хоржигноо эндээс сонсогдож байна.

şarj *is. fiz.* цэнэг, цэнэглэх. **~ etmek** цэнэглэх, зай хураалгах.

şarjör *is.* бууны хүхээ (автомат бууны, шүршдэг бууны).

şark *is. esk.* дорно, дорно зүг, дорнод, зүүн, зүүн зүг.

şarkı *is.* дуу, дуулал. **~ söylemek** дуулах, дуу дуулах.

şarkıcı *is.* дууч, дуулаач, дуучин.

şarkıcılık, -ğı *is.* дуучин, дуулаач.

şarkiyat *is. esk.* дорно дахины судлал.

şarkiyatçı *is.* дорно дахины судлагч.

şarküteri *is.* хиамны мухлаг, хиамын зүйл худалддаг дэлгүүр.

şarlatan *is.* мэхч, хуурагч, луйварчин.

şart *is.* болзол, нөхцөл. **~ koşmak** (veya

koymak) болзох, болзол тавих, нөхцөл тавих, болзол тогтоох. **~ olmak** зайлшгүй болох, зохих, ёстой байх. "*Bunu yapmak şart oldu.*" Үүнийг хийхээс зайлшгүй боллоо.

şartlandırmak *(-i)* бэлтгэсэн байх, нөхцөлдүүлэх.

şartlaşmak *(nsz, -le)* болзох, болзоолох, болзож тогтох, зөвшөөрөлцөх, хэлэлцэн тогтох.

şartlı *s.* болзолт, болзолтой, гэрээний, гэрээнд дурдсан, хэлэлцэн тогтсон, хэлэлцсэн.

şartname *is.* гэрээ бичиг, бичсэн болзол, худалдаа арилжааны нөхцөл(мөн түрээсийн).

şartsız *s.* болзолгүй, болзол тавиагүй, үг дуугүй, хэлэлцээнгүй, яриагүй, болзлоор хязгаарлагдаагүй.

şaşakalmak *(-e)* гайхаж хоцрох, нүдээ бүлтийлгэх, нүд нь орой дээрээ гарах, бэгтрэх, зог тусах, зог хийх.

şaşı *s.* 1. хялар. "*Şaşı gözler.*" Хялар нүд. 2. хялар, хялайн. "*Şaşı bakmak.*" Хялар харах./Хялайн харах.

şaşılaşmak *(-i)* хялар харах, хялар байх, хялар болох, хялайх.

şaşılmak *(nsz, -e)* гайхаш төрүүлэх, гайхшралд хүргэх, гайхшруулах.

şaşırmak *(-i)* 1. гайхаш болох, гайхаш тасрах, учраа олохоо болих, яах учраа үл олох, гайхах, гайхшрах, сандрах, мэгдэх, самгардах, тулгамдах. "*Söyleyeceğini şaşırmak.*" Юу хэлэх учраа олохгүй сандрах./Хэлэх үгээ тулгамдаад хэлж чадахгүй байх. 2. будлих, самуурах, төөрөх, зүгээ алдах, андуурах, эндүүрэх, эндүүрэн ташаарах.

şaşırtıcı *s.* гайхалтай, гайхмаар, үнэхээр гайхмаар, мэл гайхмаар, гайхам. "*Biraz çaba harcasaydı şaşırtıcı bir sonuç verebilirdi.*" Бага зэрэг чармайсан бол гайхалтай үр дүн өгч болхоор байсан.

şaşırtmaca *is.* төвөгтэй бодлого, ухааны сорилт.

şaşırtmak *(-i)* 1. гайхахад хүргэх, гайхуулах, хиртхийн цочоох, цочирдон гайхуулах, цочирдуулах, хачирхуулах. "*Aklına geleni yapar, anî kararlarla herkesi şaşırtırdı.*" Санаандаа орсон бүгдийг хийж, гэнэтийн шийдвэр гарган хүн болгоныг гайхахад хүргэдэг байлаа. 2. самууруулах, самгардуулах, төөрөгдөлд оруулах, будлиулах, алдуулах, толгойг нь эргүүлэх, эндүүрүүлэх, төөрөгдүүлэх, тээнэгэлзүүлэх, эргэлзүүлэх, учры нь алдуулах, замы нь алдуулах, будлианы нь хутгах. 3. (ургаман) шилжүүлж суулгах, урслэгчийг шилжүүлж суулгах. 4. *(nsz)* гайхшрах, гайхаш тасрах, гайхаш барагдах.

şaşkın *s.* 1. сандарсан, мэгдсэн, мэгдэнги, сандранги, цөхөрсөн, гайхширсан, гайхсан, будилсан, учраа мэдэхээ больсон, самуурсан. 2. донгио, ухаан муутай, мангуу, алмай амьтан, тэнэг, алмайрагч. **~a dönmek** сандрах, мэгдэх, самгардах, өөрийн(ухаангүй) мэдэлгүй болох.

şaşkınlaşmak *(nsz)* сандрах, мэгдэх, бахардах, самгардах, өөрийн(ухаангүй) мэдэлгүй болох.

şaşkınlık, -ğı *is.* мэгдсэн байдал, сандрал, гайхалт, гайхаш, сандрах, бачимдах, мэгдэх, гайхах.

şaşlık, -ğı *is.* шорлог.

şaşmak, -ar *(-e)* 1. гайхах, хачирхах, цочирдох, гайхах цочирдох. "*Aynı anda nasıl olur da başka bir iş tutabileceğine şaşar kalırdınız.*" 2. *(-den)* (энэ үйл үг нь үгүйсгэх асуулт болсон юм уу эсвэл хойноо үгүйсгэх залгавар авсан тохиолдолд дараах утгыг илэрхийлнэ) хазайх, хэлтийх, гажих, төөрөлдөх. "*O, bildiğinden şaşmaz, boşuna nefes tüketmeyin.*" Тэр өөрийнхөө бодлоос хазайхгүй өөрчлөх гэж оролдоод хэрэггүй. 3. *(-i)* алдаа гаргах, алдах, эндэх, андуурах, эндүүрэх, ташаарах, хольж хутгах, будлих, төөрөх, зүг чигээ алдах. "*Yolunu şaşmak.*" Төөрөх. Замаа алдах. "*Gününü şaşmak.*" Өдөр сарыг хольж хутгах.

şat *is. den.* гатлага онгоц, гүнз, бярвааз.

şatafat *is.* цог жавхлан, сүр жавхлан, үзэсгэлэн төгөлдөр.

şatafatlı *s.* цог жавхлантай, сүр жавхлантай, үзэсгэлэн төгөлдөр.

şato *is.* шилтгээн, цайз, цайз хэрэм, ордон, орд, харш.

şayet *bağ.* хэрэв, хэрвээ, болбол, бол, –бал, –бэл, магад, магадгүй, юуны магад, болзошгүй. "*Şayet gelmeyecek olursanız...*" Хэрв ээ та ирэхээргүй бол... "*Bu parayı şayet sen, ben vermezsek, veren, başkaları olacak.*" Хэрэв энэ мөнгийг чи бид хоёр өгдөггүй юм гэхэд өөр хүмүүс өгөх л болно.

şayia *is.* цуу үг, яриа цуурхал, үг яриа, хов, хов жив.

şeamet *is. esk.* муу ёр.

şebboy *is. bot.* манжхуй цэцэг.

şebek, -ği *is. zool.* бабуин(Африкт уулархаг газар амьдардвг нохой шиг хошуутай, богино сүүлтэй сармагчин).

şebeke *is.* 1. сүлжээ. "*İstihbarat şebekesi.*" Тагнуулын сүлжээ. "*Telsiz şebekesi*" Радио сүлжээ. 2. бүлэг, нууц бүлэглэл. (бүлэг хулгай, дээрэмчид, зандалчид) "*Hırsız şebekesi.*" Хулгайн бүлэг. 3. оюутны үнэмлэх.

şebiyelda *is.* жилийн хамгийн урт шөнө.

şebnem *is. esk.* шүүдэр.

şecere *is.* гэрийн үеийн бичиг, угийн бичиг, овог төрлийн цэс.

şecereli *s.* сурвалжит, язгууртай, алдартай.

şef *is.* 1. дарга, тэргүүн, удирдагч, эрхлэгч, толгойлогч, толгой. 2. *s.* гол, ерөнхий, ахлах. "*Şef garson şarabı övünce aldım.*" Ахлах үйлчлэгч дарсыг магтахаар нь би авлаа.

şefaat, -ti *is.* зуучлал (гэм зэмийг нь өршөөхийг хүссэн), өмгөөлөл, өмөөрөл, хаацайлал. ~ **etmek** өмөглөх, өмгөөлөх, өмөөрөх, хаацайлах.

şefaatçi *is.* зуучлагч, өмгөөлөгч, хамгаалагч, өмөөрөгч, хаацайлагч. "*Gülsüm'ün şefaatçileri günden güne çoğalıyordu.*" Гүлсүмийг өмөөрөгчид өдөр ирэх тусам нэмэгдэж байлаа.

şeffaf *s.* тунгалаг.

şeffaflık, -ğı *is.* тунгалаг.

şefkat, -ti *is.* өрөвдөх, хөөрхийлөх, хайрлах, өрөвч сэтгэл, нигүүлсэх, энэрэх, өрөвдөх, нигүүлсэл, энэрэл, өрөвдөх сэтгэл, хөөрхийлөл, хайр, энхрийлэл, уян зөөлөн сэтгэл. "*Anne şefkati.*" Эхийн энхрийлэл.

şefkatli *s.* нигүүлсэнгүй, энэрэнгүй, өр нимгэн, өрөвч, өрөвдөх сэтгэлтэй, энхрий.

şefkatsiz *s.* өрөвдөхгүй, өрөвдөх сэтгэлгүй, өрөвсөлгүй, хайргүй, хайрлахгүй, хвйр гамгүй, хэрцгий, хүний шинжгүй, хүний үнэргүй, энэрэлгүй, харгис, ширүүн.

şefkatsızlık, -ğı *is.* өршөөлгүй байх, өрөвдөх сэтгэлгүй, хүний үнэргүй, энэрэлгүй, хэрцгий, харгис хэрцгий, хэрцгий явдал, харгис догшин хэрэг.

şeftali *is. bot.* 1. тоорын мод. 2. тоор (жимс), бүглэс, бимба.

şehir, -hri *is.* хот. "*Güzel İstanbul, bu dünyada senden güzel bir şehir yoktur diye düşünürüm.*" Үзэсгэлэнт Станбул, энэ дэлхий дээр чамаас сайхан хот байхгүй гэж би боддог.

şehirler arası *s.* хот хоорондын. "*Şehirler arası otobüsüne bindi.*" Хот хоорондын автобусанд суусан.

şehirleşme *is. sos.* хотын өсөлт хөгжилт, хот руу хүн ам олноор шилжих.

şehirli *s.* хотын хүн, хотын оршин суугч.

şehit, -di *is.* шэхит (ариун үйлийн төлөө, шажин шүтлэгийн төлөө тэмцэж байгаад амь үрэгдсэн хүн). ~ **düşmek** шэхит болох (ариун үйлийн төлөө, шажин шүтлэгийн төлөө тэмцэж бвйгаад амь үрэгдэх).

şehitlik, -ği 1. шэхит болох, ариун үйлийн төлөө, шашин шүтлэгийн төлөө тэмцэж байгаад амь үрэгдэх. 2. энэхүү амь үрэгдэгсэдийн булш, бунхан.

şehriye *is.* мянтууз, нарийн гоймон.

şehvet *is.* 1. шунахайрал, хурьцал, хуял тачаал, тачаал, тачаадал, хурьцал тачаал, тэчьяадал. 2. *mec.* шунал, тэмүүлэл, дэндүү их хүсэл.

şehvetli *s.* 1. тачаангуй, хурьцангуй, хуялтай, тачаатай, тачаасан, твчаалтай, тэчьяадалтай. 2. *mec.* шуналтай, шунал болсон, тэсгэлгүй, тэсгэлгүй дуртай.

şehzade *is.* хаан хүү, хунтайж, (хааны агь), жонон, агь, хаан ширээнд суух агь.

şeker *is.* 1. чихэр. **toz** ~ элсэн чихэр. 2. чихэр, амттан, цаастай чихэр. 3. чихрийн шижин өвчин, чихэр шээрэн, шээрэн өвчин, шижин. 4. саахар. 5. *s. mec.* ялдамхан, аятайхан, хөөрхөн.

Şeker Bayramı *is.* Чихрийн баяр(Рамазан сар дууссаны дараа болдог мусульман шашны баяр).

şekerci *is.* 1. амттан үйлдвэрлэгч, амттаны худалдаачин. 2. чихрийн дэлгүүр, амттаны дэлгүүр.

şeker hastalığı *is. tıp.* саахарын өвчин, чихрийн шижин, чихрийн шижин өвчин, чихэр шээрэн, шээрэн өвчин, шижин.

şeker kamışı *is. bot.* чихрийн нишингэ.

şekerleme *is.* 1. şekerlemek үйлийн нэр. 2. чихэрлэсэн жимс, чихрээр бүрсэн жимс, чихэр. 3. *mec.* үүрэглэх, зүүрмэглэх. ~ **kestirmek** үүрэглэх, дуг хийх.

şekerlemek *(-i)* чихэрлэх, дотор нь чихэр хийх, чихэртэй болгох.

şekerlenmek *(nsz)* чихэртэх, чихэр болох. "*Reçel şekerlenmiş.*" Жимсний чанамал чихэртжээ.

şekerli *s.* 1. чихэртэй. "*Şekerli çay.*" Чихэртэй цай. "*Çok şekerli olmuş.*" Их нялуун болсон байна. 2. саахарын өвчтэй.

şekerlik, -ği *is.* 1. чихрийн сав. 2. *s.* чихрийн.

şeker pancarı *is. bot.* чихрийн манжин.

şekil, -kli *is.* 1. хэлбэр, дүрс, хэлбэр дүрс, хэв. "*Yuvarlak şeklinde bir tabak.*" Бөөрөнхий хэлбэртэй таваг. 2. бүдүүвч, бүдүүвчилсэн зураг, зураг, диаграмм, жишиг зураг, харьцангуй жишиг. "*Bu kitapta birçok şekil var.*" Энэ номонд их хэмжээний жишиг зураг бий. 3. байдал, янз, төрх, арга, арга маяг. "*Bu şekilde hareket etmek doğru değildir.*" Иймэрхүү янзаар хийх нь буруу. 4. янз, төрөл, хэлбэр. "*Yalnızlığın şekilleri vardır, kimsesiz bir yerde yalnızlık, kalabalık yerde yalnızlık.*" Ганцаардал янз янз байдаг, хүнгүй газар ганцаардах, олон хүнтэй орчинд ганцаардах. 5. хэлбэр. "*Yönetim şekli.*" Удирдах хэлбэр. 6. байдал, хэлбэр, янз. 7. *mat.* дүрс, хэлбэр. 8. ярих арга, тайлбарлах арга барил. 9. *ed.* хэлбэр. үг бүтэх хэлбэр. ~ **almak** хэлбэржих, хэлбэрших, хэлбэртэй болох, хэлбэржин тогтох. ~ **ve şemail** гадаад байдал, үзэмж. ~ **vermek** хэлбэржүүлэх, хэлбэртэй болгох, хэлбэржүүлэн тогтоох, хэлбэршүүлэх.

şekil bilgisi *is. gr.* үгзүй.

şekilci *s.* хэлбэрдэгч, ёсорхогч.

şekilcilik, -ği *is.* хэлбэрдэх, хэлбэрдэх ёс, хэлбэрдэл, ёсорхох явдал, ёсорхол, формализм.

şekil değiştirme *is.* хувьсгах, хувиргах, хувилгах.

şekillendirmek *(-i)* хэлбэржүүлэх, хэлбэршүүлэх, хэлбэртэй болгох, хэлбэрт оруулах, хэлбэржүүлэн тогтоох.

şekillenmek *(nsz)* хэлбэржих, хэлбэрших, хэлбэртэй болох, хэлбэржин тогтох.

şekilli *s.* хэлбэртэй, дүрстэй.

şekilsiz *s.* 1. хэлбэргүй, төлөвгүй, хэлбэржээгүй, хэлбэр дүрсгүй. 2. үзэмжгүй, эв хавгүй, уран дүргүй, дүрслэлгүй, зүйрлэмжгүй, муухай. "*İyi terzi dedin ama bu diktiği pantolona baksana, şekilsiz bir şey olmuş.*" Чи сайн оёдолчин л гээд байсан энэ оёсон өмдийг нь хар л даа, муухай юм болсон байна.

şelale *is.* усан хүрхрээ, хөрхрөө.

şelf *is. coğr.* харгиа, гүехэн газар(эх газрын, тивийн).

şema *is.* 1. бүдүүвч, бүдүүвчилсэн зураг, диаграмм, зураг, жишиг зураг, харьцангуй жишиг. 2. зохиолын ноорог.

şempanze *is. zool.* хүн мич.

şems *is. esk.* нар.

şemsiye *is.* шүхэр, халх, халхавч, нарны халхавч, нарны хаалт.

şemsiyeci *is.* шүхэр үйлдвэрлэгч, шүхрийн худалдаачин.

şemsiyecilik, -ği *is.* шүхрийн үйлдвэрлэл.

şemsiyelik, -ği *is.* 1. шүхэр тавих газар. 2. *s.* шүхэр хийхэд тохиромжтой (бөс даавуу).

şen *s.* 1. цэнгэлтэй, зугаатай, баяртай, баяр хөөртэй, баясгалант, баясгалантай, жаргалтай. "*Seren hanım, şen görünmeye çalışıyordu.*" Хатагтай Сэрэн, баяр хөөртэй харагдах гэж хичээж байлаа. 2. хөгжөөнтэй, хөгжилтэй, зугаатай, наргиантай. "*Şen şarkılar.*" Хөгжилтэй дуунууд.

şenlendirmek *(-i)* 1. баярлуулах, баясгах, цэнгүүлэх, зугаацуулах, хөгжөөх, сэргээх, идэвх оруулах. 2. хөгжүүлэх, цэцэглүүлэх, дэвжүүлэх.

şenlenmek *(nsz)* 1. баясах, хөгжиж цэнгэх, хөгжих, цэнгэх, зугаацах. "*Sare gelince hepimiz şenleniriz.*" Сарэг ирэхээр бүгдээрээ хөгжиж цэнгэнэ. 2. хөгжих, цэцэглэх, цэцэглэн хөгжих, дэвжих, мандан хөгжих. "*Bu şehir kısa bir zamanda çok şenlendi.*" Энэ хот богинохон хугацаанд маш их хөгжсөн. 3. *mec.* сэргэх, идэвх орох.

şenlik, -ği *is.* 1. баяр, баясгалан, хөөр, баяр хөөр, баяр баясгалан, зугаа, цэнгэл, наргиан, хөгжүүн (байх), сэргэг(байх), урамтай(байх). 2. баяр, ёслол, баяр ёслол, наадам, баяр наадам (тодорхой өдрүүдэд тэмдэглэдэг). "*Bahar şenliği.*" Хаврын баяр. 3. фестиваль, үзлэгт наадам, их наадам.

şer, -rri *is.* хорлогчин явдал, хар үйл, хорлол, хорон үйл, муу явдал, муу юм. "*Tanrım, sen beni kötü insanların şerrinden koru.*" Бурхан минь намайг муу хүмүүсийн хорлолоос хамгаал.

şerbet *is.* 1. нэгэн төрлийн ундаа (жимсний шүүсийг чихэртэй устай хольж чанасан). 2. уусмал, зуурмаг. "*Kireç şerbeti.*" Шохойн зуурмаг.

şerbetçi otu *is. bot.* зөрөг цэцэг.

şeref *is.* 1. нэр төр, нэр хүнд, хүнд. "*Yurdun şerefi.*" Эх орны нэр төр. "*İnsanın şerefi.*" Хүний нэр төр. 2. хүнд, өргөмж, хүндэтгэх, хүндэтгэл. **~ vermek** хүндлэн үзэх, хүндлэх, хүндэтгэх, хүндэтгэл үзүүлэх, тоох. "*Düğünümüze gelip bize şeref verdiniz. Teşekkürederiz.*" Та бидний хуриманд ирж биднийг хүндэтгэлээ. Баярлалаа. **~e** (veya **şerefinize**) Эрүүл мэнд сайн сайхны (тань) төлөө!

şereflendirmek *(-i)* хүндлэн үзэх, хүндлэх, хүндэтгэх, хүндэтгэл үзүүлэх, тоох.

şereflenmek *(nsz)* бахархах, бахархах сэтгэл төрөх, сэтгэл ханах, ханамжтай байх, баясах.

şerefli *s.* 1. нэрээ их хичээдэг, нэр төрөө их эрхэмлэдэг, нэрэлхүү, нэрэлхэг, ихэрхэг, ихэрхүү. 2. хүндтэй, хүндэт. "*Şerefli bir görev.*" Хүндтэй үүрэг./Хүндэт үүрэг. 3. хөгжилтэй, цэцэглэсэн, цэцэглэн хөгжсөн, мандан хөгжсөн. "*Şerefli bir yer.*" Цэцэглэн хөгжсөн газар.

şerefsiz *s.* ёс журамгүй, шударга бус, шудрага ёсноос гажих, нэр гутах, муу нэртэй, хүндгүй, гутамшигтай.

şerefsizlik, -ği *is.* нэр гутах, муу нэр, хүндгүй байх.

şerh *is. esk.* тайлбар, таниулга, тайлбарлах, тайлбарлан таниулах. **~ etmek** тайлбарлах, тайлбар хийх, тайлбарлан хэлэх, тайлбарлан ойлгуулах.

şerif *is. esk.* 1. ариун, нандин, ариун нандин, дархан, эрхэм, хүндтэй. 2. сурвалжит, угсаат, язгуурт, сурвалжтай, угсаатай, язгууртай.

şerik *is. esk.* хамтрагч, түнш, хамт эзэмшигч, эздийн нэг, хамтран зүтгэгч, хувь нийлүүлэгч.

şerit, -di *is.* 1. тууз, тасам, лөнт, хиаз. 2. хөвөө, зах. 3. зурвас, судал. 4. замын урсгал. 5. *zool.* гуш хорхой. 6. *anat.* шөрмөс, шандас.

ses şeridi *is.* дууны хөвч.

şeritlemek *(-i)* тууз хадах, туузаар эмжээрлэх, тууз хөвөх.

şeritli *s.* туузтай, туузаар чимсэн, туузаар гоёсон.

şevk *is. esk.* 1. хүсэл эрмэлзэл, идэвх хичээл, оролдлого зүтгэл, урам зориг, идэвх зориг, сэтгэл зориг хөгжих, урам хөгжих, урамшил, зоригжил, дур хүсэл. "*Hiç yılmadan büyük bir şevkle çalışırdı.*" Огтхон ч шантралгүй их урам зоригтой ажилладаг байсан. 2. баяр, хөөр, баясгалан, баяр баясгалан, баяр хөөр, хэт хөөрөх, онго орох. **~ vermek** урам зориг өгөх, урам өгөх, урам оруулах. **~e gelmek** онго орох, урам зориг орох, хүсэл эрмэлзэл төрөх, идэвх зориг орох, сэтгэл зориг хөгжих, хэт хөөрөх. **~i kırılmak** урам зориг хугарах, дур хүсэлгүй болох.

şey *is.* 1. үйл, явдал, юм, зүйл. 2. мартсан үгийн оронд хэрэглэнэ. хэн гэдэг билээ, юу билээ, өө биш, үгүй бишээ, нөгөө юу билээ, нөгөө хэн билээ. **bir ~** 1) нэг юм, юм, ямар нэг юм, бага сага юм, юүхэн хээхэн, энэхэн тэрхэн. "*Bir şey eksik.*" Нэг юм дутаад байна. "*Bir şeyler konuştu.*" Энэхэн тэрхэнийг ярьсан. 2) юу ч, нэг ч юм, юу ч, огт, ямар ч юм. "*Bir şey kalmamış.*" Юу ч үлдээгүй байна. "*Bir şey söyleme.*" Нэг ч юм хэлж болохгүй

шүү. **her ~** бүгд, бүх юм, цөм. **bir ~ değil** зүгээр, хамаагүй, яах вэ, гайгүй.

şeyh *is.* 1. мусульман шашны бүлэглэл байгуулагч, шашны тэргүүн. 2. шейх, овгийн ахлагч (арабчуудын).

şeytan *is.* чөтгөр, буг чөтгөр, шулам, шулмас, рагшис. **~ dürtmek** бодлогогүй хэрэг хийх, тэнэг хэрэг хийх, бодлогогүй явдал гаргах, учраа алдах, будилж гүйцэх, эргүүтэж гүйцэх, самуурах. "*Bizim Nuri'yi şeytan dürttü galiba.*" Манай Нури эргүүтэж гүйцжээ. **~ gibi** маш их авхаалжтай мэхтэй, маш их зальтай, маш их овтой. **~ görsün yüzünü** чөтгөрлүүгээ тонилог. **~ tüyü (olmak)** бусдыг өөртөө татах онцлог (-той байх), бусдыг өөртөө дурлуулах онцлог (-той байх), дур булаах зан авиртай байх, сэтгэл татам ааш зантай байх, бусдыг өөртөө татах увдистай. **~a pabucu ters giydirmek** маш их адтай, маш их зальтай, маш их ов мэхтэй(байх).

şezlong *is.* наран шаралгын сандал.

şık (I) *s.* 1. гял цал болсон, тансаг сайхан, аштайхан, ганган, дэгжин ганган, чамин, ганган хээнцэр. "*Şık bir elbise.*" Дэгжин ганган хувцас. 2. ганган, ганган дэгжин, тансаг сайхан хувцасласан, чамин хувцасласан, ганган хээнцэр. "*Şık kadınlar vardı.*" Ганган хээнцэр хүүхнүүд байсан. 3. зохистой, таарамжтай. "*Şık bir cevap.*" Зохистой (оновчтой) хариулт.

şık, -kkı (II) хоёрын л нэг, хоёрхноос нэгийг шилэх, олон сонголтоос нэгийг шилэх, хувилбар.

şıkırdamak *(nsz)* дуугарах, хангинах, жингэнэх, цангинах.

şıkırtı *is.* хангинах чимээ, цангинах чимээ, таржигнаан, шажигнаан.

şıklık, -ğı *is.* ганган хээнцэр байдал, тансаг сайхан байдал, аштайхан байдал, аятайхан байдал, ганган (байх), дэгжин ганган (байх), чамин байдал.

şımarık, -ğı *is. ve s.* эрх, танхи, танхил, овилгогүй, увайгүй, хэт нүүрэмгий, дураараа аашилдаг, дураараа, задарсан, задгай, дэггүй, ах захгүй, зоргоороо.

şımarmak *(nsz)* задрах, ах захгүй болох, танхилах, эрх болох, эрх танхи болох, дураараа загнах.

şımartılmak *(nsz)* задрах, ах захаа алдах, дэггүй болох, танхилах, эрх болох, эрх танхи болох.

şımartmak *(-i)* задраах, дэг алдуулах, ах захгүй болгох, эрхлүүлэх, танхилуулах.

şıngırdamak *(nsz)* хангир жингэр хийх, дуугарах, хангинах, жингэнэх, цангинах.

şıp *is.* дуслах чимээ, дуслах дуу.

şıpırdamak *(nsz)* цалгих.

şıpırtı *is.* цалгиа.

şıppadak *zf.* гэнэт, гэнэтхэн, гэнэтэд, санамсаргүй. "*Şıppadak çıkageldi.*" Гэнэтхэн гараад ирсэн.

şıpsevdi *is.* амархан дурладаг хүн, дурлахдаа хялбар хүн, дурламтгай хүн. "*O şıpsevdinin biridir, herkese aşık olur.*" Тэр дурламтгай хүн, хүн болгонд л дурлаж байдаг.

şıra *is.* 1. үзэмний шүүс. 2. *argo.* хар тамхи.

şıralı *s.* шүүстэй, шүүслэг, шимтэй. "*Şıralı elma.*" Шүүслэг алим.

şırfıntı *is. ve s. tkz.* банзал хүүхэн.

şırıldamak *(nsz)* хоржигнох, шоржигнох, шорчигнох, шор шор гэх, жир жир урсах.

şırıltı *is.* хоржигноо, шоржигноо, шорчигноо.

şırınga *is.* 1. шахуурга. 2. тариур.

şiddet *is.* 1. хүчтэй (байх), чанга (байх), ширүүн (байх), чанга зан, хатуу(байх), ширүүн догшин (байх), догшин(байх), чанга байдал, догшин зан, хэрцгий явдал, ширүүн зан, харгис догшин хэрэг, харгис хэрцгий. 2. хурд. "*Rüzgarın şiddeti.*" Салхины хурд. 3. *mec.* туйлшрал, хэтрэл, хэтэрсэн явдал, хэтрүүлэг. 4. хүч хэрэглэх, хүчдэх. **~e başvurmak** хүч хэрэглэх, хүчирхийлэх. **~le** хүчтэй, чанга, ширүүн.

şiddetlendirmek *(-i)* хүчтэй болгох, ширүүн болгох, чангаруулах.

şiddetlenmek *(nsz)* ширүүсэх, хүчжих, хүчтэй болох, чангарах, нэмэгдэх, гаарах. "*Rüzgar şiddetlendi.*" Салхи хүчтэй болох. Салхи ширүүслээ.

şiddetli *s.* 1. хэцүү, бэрх, хүнд бэрх, ширүүн, хүнд. "*Şiddetli bir romatizmaya tutulmuştu.*" Тэр хүнд хэрэх өвчин туссан юм. 2. ширүүн, чанга, хүчтэй, тасхийм, их, хатуу, догшин, аймшигт, гаарсан, хахир. "*Şiddetli rüzgar.*" Хүчтэй салхи. Ширүүн салхи. 3. хэт, дэндүү, хэтэрхий их, хурц.

şifa *is.* эдгэрэх, эдгэх, анах, эрүүл болох, илаар, илаарших. **~ bulmak** эдгэрэх, эдгэх, анах, бие зүгээр болох, эрүүл болох, сайжрах, илаарших. **~ vermek** эдгэрүүлэх, эдгээх, ангаах, эрүүл болгох, иларшуулах. "*Allah şifa versin.*" Хурдан эдгэх болтугай. **~yı kapmak** өвдөж эхлэх, бие эвгүйрэх. "*Çok hapşırıyor acaba şifayı kapıyor mu?*" Их найтайлгаж байх чинь арай ханиад хүрч байгаа юм биш байгаа.

şifalı *s.* анагаах, эмнэх, эдгэрүүлэх, эдгээх, биед сайн, эрүүл мэндэд тустай, эмд ордог, эм болох, эмийн, ач тустай. "*Şifalı otlar.*" Эмийн өвснүүд.

şifasız *s.* эдгэршгүй, эдгэшгүй, анагаашгүй, аргалшгүй.

şifon *is.* 1. сиймгэр эд. 2. *s.* сиймгэр, энэхүү эдээр хийсэн.

şifoniyer *is.* хувцасны шүүгээ, шүүгээ.

şifre *is.* нууц түлхүүр, шифр. **~ çözmek** (нууц түлхүүрт бичгийг) тайлах, шифрийг тайлах.

şifrelemek *(-i)* нууц түлхүүртэй бичих, нууц түлхүүрээр бичих, шифрлэх.

şifreli *s.* 1. нууц түлхүүртэй бичсэн, нууц түлхүүрээр бичсэн. 2. нууц түлхүүртэй, шифртэй. "*Şifreli kilit.*" Нууц түлхүүртэй цоож. "*Şifreli telgraf.*" Нууц түлхүүртэй цахилгаан мэдээ.

şiir *is.* яруу найраг, шүлэг, шүлэглэл. **~ okumak** шүлэг унших, **~ söylemek** (шүлэг) уран унших, яруу унших, шүлэг унших. **~ yazmak** шүлэг бичих, шүлэг зохиох, шүлэглэх.

şikayet *is.* гомдол, зарга. **~ etmek** 1) гомдол мэдүүлэх, гомдох, гашуудах, гаслах, гомдоллох. "*Kaderinden şikayet etmek.*" Хувь заяандаа гомдох. 2) гомдол мэдүүлэх, зарга мэдүүлэх, заалдах, зарга барих. **~te bulunmak** гомдол мэдүүлэх, заалдах, зарга барих, зарга мэдүүүлэх.

şikayetçi *s.* ve *is.* гомдол гаргагч, гомдол мэдүүлэгч, гомдогч, зарга мэдүүлэгч, заалдагч этгээд.

şikayetname *is.* гомдол, зарга (бичгээр илэрхийлсэн).

şilep, -bi *is.* ачааны усан онгоц, тээврийн усан онгоц.

şilte *is.* дэвсгэр, ширдэг, олбог.

şimal, -li *is.* хойт зүг, умард зүг, хойно, умар.

şimdi *is.* 1. одоо, яг одоо. "*Şimdi size en güzel haberi vereceğim.*" Одоо би та бүхэнд хамгийн сайхан мэдээг дуулгая. 2. одоохон, даруйхан. "*Annen şimdi gelir, ağlama sus.*" Ээж чинь одоохон ирнэ, битгий уйл дуугай бай. 3. саяхан, тун саяхан, тун сая, эгээ саяхан, дөнгөж саяхан, бүр саяхан. "*Otobüs şimdi gitti.*" Автобус дөнгөж саяхан яваад *еглөө.* 4. *zf.* үүнээс цаадахыг нь, одоо, үүнээс цаашихыг нь. **~ye kadar** (veya **şimdiye dek**) эдүгээ болтол, өдгөө хүртэл, өдий болтол, сая л, саяхныг хүртэл. "*Kız, şimdiye kadar hiç duymadığım bir ülkeden gelmiş.*" Охин, миний өдгөөг хүртэл огт сонсож байгаагүй улсаас ирсэн гэнэ.

şimdiden *zf.* өнөөгөөс эхлэн, одооноос эхлэн, одоогоос хойш, үүнээс хойш, энэ цаг мөчөөс хойш.

şimdiki *s.* одоогийн, өнөөгийн, одоо үе ийн, өнөө үеийн, өнөө цагийн, одоо цагийн, одоо, эдүгээ, өнөө, эдүгээ үеийн, орчин цагийн, эдүгээгийн. "*Şimdiki gençler hiç kitap okumuyorlar.*" Өнөөгийн залуучууд огт ном уншдаггүй болж./Өнөөгийн залуучууд огт ном уншихаа больжээ.

şimdilik *zf.* түр зуур, одоохондоо, өнөөхөндөө, мөнөө дээрээ, энэ зуураа, одоо хир нь, хараахан, тэгээгүй, ингээгүй, түрхэн зуурдаа, энэ удаа, энэ удаадаа, эдүүгээ, одоо цагт, мөнөө цагт, одоо хир. "*Şimdilik bu kadar yeter.*" Энэ удаад энэ зэрэг хангалттай./Одоохондоо энэ зэрэг хангалттай.

şimendifer *is.* 1. төмөр зам. 2. төмөр замын бүрэлдэхүүн, галт тэрэг.

şimşek, -ği *is.* цахилгаан, аянга. "*Şimşek çaktı.*" Цахилгаан цахив. **~ gibi** цахилгаан мэт түргэн, агшин зуурын, нүд ирмэх зуур.

şimşekli *s.* цахилгаан цахисан, цахилгаантай.

şimşir *is. bot.* нягт шар.

şipşak *zf.* тэр даруй, даруй, тэр дороо, дороо, дор нь, агшин зуур, хоромхон зуур, дорхноо.

şipşakçı *is.* гудамжны зураг авагч, гудамжны зурагч, гудамжны фото зурагч.

şirin *s.* аятайхан, аштайхан, таатай, сайхан, ялдамхан, хөөрхөн, дур татам, урьхан, нүдэнд дулаахан, үзэсгэлэн. "*Ne şirin bir elbise.*" Ямар аятайхан хувцас вэ? "*Ne şirin bir çoçuk.*" Ямар хөөрхөн хүүхэд вэ?

şirinlik, -ği *is.* хөөрхөн(байх), аятайхан(байх), дур татам(байх), нүдэнд дулаахан байдал.

şirk *is.* олон бурханд итгэх.

şirket *is.* нөхөрлөл, компани, пүүс, нийгэмлэг, түншлэл, хамтрагч, түнш, хамт эзэмшигч, эздийн нэг, хамтран зүтгэгч, хувь нийлүүлэгч. "*İtalya'da büyük bir şirkette çalışıyorum.*" Би Италид нэгэн том пүүст ажиллаж байгаа.

şirpençe *tıp.* шоргоолжин хатиг, мундас.

şirret *s.* зожиг зантай, хүнтэй нийцгүй, муухай ааштай, хэрүүл өдөөгч, агсан хүн, солго, хэрүүл цуугианд дуртай, хэрүүлч хүн, ярдаг хүн, шартай хүн.

şirretlik, -ği *is.* дуулгаваргүй (байх), үг дагахгүй(байх), үг дуулахгүй (байх), зожиг зантай (байх), хүнтэй нийцгүй (байх), хэрүүлч зан, ярдаг зан, муухай ааштай(байх).

şist *is. jeol.* занар (чулуу).

şiş (I) *s.* 1. хавдартай, хавдсан, хаван болсон. 2. *is.* хавдар булдруу.

şiş (II) *is.* 1. шор. 2. зүү. "*Örgü şişi.*" Нэхмэлийн зүү. 3. *is* ve *s.* шорлог, шорлон, шарсан мах.

şişe (I) *is.* 1. гожгор шил, лонх, шил. "*Bir şişe süt alabilir miyim?*" Нэг шил сүү авч болох уу?. 2. дэнгийн шил.

şişe (II) *is.* бяцхан гадас.

şişirme *is.* үлээх, хийлэх, хий оруулах, үлээлт, хий оруулалт, хий дүүргэх.

şişirmek *(-i)* 1. үлээх, хийлэх, хий оруулах, үлээж хүнхийлгэх, хий дүүргэх, хөөлгөх. 2. *mec.* гоёж ярих, чимэглэн бичих, дэврүүлж ярих, хөөргөж ярих, дэгслэх, давуулж ярих, дөвийлгөх. 3. *mec.* хийсэн болох, халтуурдах. 4. *hlk.* хэтрүүлэх.

şişkin *s.* үлээсэн, хийлсэн, хөөсөн, хавдартай, хавдсан, хавантай.

şişko *s. alay.* тарган, бүдүүн, махлаг, мариатай.

şişlemek *(-i)* шорлох, шороор хатгах, шордох, шороор хатгах сүлбэх.

şişman *is.* ve *s.* тарган, бүдүүн, махлаг, мариатай, лухгар (хүн).

şişmanlamak *(nsz)* таргалах, махлах, мариажих, мариалах, бүдүүрэх, тарган болох, бүдүүн болох.

şişmanlatmak şişmanlamak үйлийн үйлдүүлэх хэв.

şişmanlık, -ğı *is.* тарган байдал, тарган (байх), махлаг байдал, махлаг (байх), бүдүүн (байх).

şişmek *(nsz)* 1. хийлэх, хийлэгдэх, үлээгдэх, хий дүүрэх, хөөх. "*Balon şişti.*" Бөмбөлөг хийлэв. 2. хөөх, сэвсийх, бөмбийх, булцайх. 3. хавдах, хөөх, хаваглах, сэлхрэх, хавантай болох, хаван суух, хаван гүйх. "*Ağlamaktan gözleri şişmişti.*" Уйлсанаас болоод нүд нь хавдсан байлаа. 4. хэт их идэх, цатгалдталаа идэх. 5. *sp.* бахардах. 6. *hlk.* онгирох, хөөрөх, бах болох, бахархах. 7. *argo.* эдгээд гаж үгээс ичих, сэтгэл зовох.

şive *is.* аялга, хэллэг, дуудлага, дуудахуй. "*İstanbul şivesi.*" Станбулын аялга (дуудлага).

şivesiz *s.* буруу, хазгай, хазгай хэлэх, хазгай дуудах.

şizofren *is. tıp.* ухаан балайрсан хүн, элий балай хүн.

şizofreni *is. tıp.* ухаан балайрах өвчин, элий балай өвчин.

şofben *is.* домбогор зуух (газ, цахилгаанаар ажиллаж ус халаах хэрэгсэл).

şoför *is.* жолооч.

şok *is.* шок, үхэдхийн унах, дайрлага, цочрол. **~ tedavisi** өндөр дозоор эм өгч эмчлэх, цахилгаанаар цочроон эмчлэх.

şort *is.* богино өмд, шорт.

şose *is.* засмал зам.

şoset *is.* богинохон оймс.

şoson *is.* нэгэн төрлийн гутал (даавуу юм уу нимгэн арьсаар хийдэг шулуун ултай).

şoven *is.* (үндэсний) дээрэнгүй үзэлтэн, шовинист.

şovenizm *is.* (үндэсний) дээрэнгүй үзэл, шовинизм.

şöhret *is.* 1. нэр, алдар, алдар нэр, цуу, алдар цуу. 2. нэртэй хүн, алдартай хүн, алдар нэртэй хүн, цуутай хүн, алдар цуутай хүн. "*Bu salonda benim ilk defa gördüğüm altı şöhret var.*" Энэ танхимд миний анх удаа харж байгаа зургаан алдартай хүн байна. **~ bulmak** (**vəya kazanmak**) нэртэй болох, алдартай болох, алдар нэртэй болох, цуутай болох, алдар цуутай болох.

şöhretli *s.* нэртэй, нэрт, алдартай, алдарт, алдар нэртэй, цуутай, алдар цуутай, олны танил болсон. "*İstanbul'un en güzel, en şöhretli kadınlarından biriydi.*" Станбулын хамгийн сайхан, хамгийн нэртэй эмэгтэйчүүдийн нэг нь байсан юм.

şölen *is.* 1. будаалга, дайллага, зоог, гүнцэг, зочиллого, зочинд зориулсан зоог, цайллага, хүлээн авалт. 2. *mec.* үзүүлбэр, үзмэр.

şömine *is.* задгай зуух, камин зуух.

şövalye *is. tar.* 1. цэрэг, тайж, баатар (Д ундад үеийн Евро ын цэрэг тайж угсааны хүн). 2. хүндэт жуух ба одон (Өдгөө Францын төр засгийн олгодог).

şövalyelik, -ği *is.* 1. баатарууд, цэрэг тайж нар. 2. *mec.* баатарлаг явдал, уудам сэтгэлтний үйл.

şöyle *s.* və *zf.* ингэж, тэгж, ийн, тийн, ийнхүү, тийнхүү, энэ мэтээр, үүнчлэн, түүнчлэн, чингэж, үүн шиг, энүүн шиг, иймэрхүү, тиймэрхүү, үүнэрхүү, түүнэрхүү, энэрхүү. **~ bir bakmak** халти харах, халти хараад авах, өнгөцхөн харах. **~ bir** 1) ингэс тэгэс гээд, халти, халти мөлт, өнгөц, өнгөцхөн, хуумгай. "*Bardakları şöyle bir yıkadı.*" Аяга шаазанг ингэс тэгэс гээд угаасан боллоо. 2) жаахан, бага, түр, жаал, халти. "*Şöyle bir dolaşıp geleyim.*" Би жаал зугаалчихаад ирье. **~ böyle** 1) дунд зэргийн, дунд хэмийн, хир тааруу, дунд, жирийн. "*Almancayı şöyle böyle bilir.*" Тэр Герман хэлийг дунд зэргийн мэддэг. 2) бараг, шахам, шахуу, орчим, хир, хиртэй, ойролцоогоор, –аад (–ээд, –оод, –өөд). "*Şöyle böyle üç yıl oldu.*" Бараг гурван жил боллоо.

şu 1. энэ, тэр, наад, энэ юм, энэ хүн. 2. хойно гарах, дараахь, дор дурдсан. **şuna bak!** үгүй ер энийг хараач ээ! **~ bu** энэ тэр, нэгэн, нэг хүн, ямар нэгэн, аль нэгэн. **şu halde** тийм бол, чингэв эл, өө тийм юм бол, тэгж байгаа бол, тэгэх дээрээ хүрвэл, тэгдэг бол, иймийн тул, тиймээс, учир иймд, ингэхлээр, тэгвэл, тэгэхлээр.

şubat *is.* хоёрдугаар сар.

şube *is.* салбар, тасаг, хэсэг, анги.

şuh *s.* və *is.* алиа томоогүй, цэнгэлтэй зугаатай, сээтэгнүүр, сээтэн зантай (эмэгтэй).

şule *is. esk.* гал, дөл.

şunca *s.* төдий, төдий чинээ, төчнөөн, өчнөөн.

şunda *zm.* тэрэнд, түүнд.

şundan *zm.* тэрнээс, түүнээс.

şunu *zm.* тэрийг, энийг, үүнийг.

şunun *zm.* тэрний, энэний, үүний.

şura *zm.* энэ/тэр хавь, энэ/тэр газар. **~ya** тийшээ.

şûra *is.* зөвлөл, зөвлөгөөн.

şuracıkta *zf.* энүүхэнд, энэ хавьд.

şurada *zm.* 1. энд, тэнд, энэ хавьд, ойр, хавьд, дөт. 2. үүнд.

şurası *zm.* 1. энэ газар. 2. энэ хэсэг.

şurup, -bu *is.* 1. чихэрлэг шүүс, шүүс. 2. чихэрлэг шингэн эм, шингэн эм, усан эм.

şuur *is.* ухамсар, мэдээ, мэдрэл, ухаан.

şuuraltı *is.* сэгээ, дотоод ухамсар.

şuurlu *s.* ухаантай, ухамсартай, ойлгож хийдэг, ухаарч хийдэг, ухаж хийх, ухамсарлах.

şuursuz *s.* бодлогогүй, ухаангүй, ухамсаргүй, ухаан мэдрэлгүй, санаатайгаар биш, ухвар мөчид, учир мэдэхгүй.

şükran *is.* талархал, ачийг санах, ачийг бодох, талархан ачийг санах.

şükretmek *(-e)* 1. Бурханд талархах, бурханд талархалаа илэрхийлэх. 2. талархах, гялайх, талархалаа илэрхийлэх, баярлах, баярлалаа гэх, ачийг хариулах, талархаж явах, ач санаж явах.

şükür, -krü *is.* 1. Бурханд талархлаа илэрхийлэх, талархал. 2. талархал, ачийг санах, ачийг бодох. **~ etmek** талархах, гялайх, ачийг санах, талархлаа илэрхийлэх, баярлах, баярлалаа гэх, ачийг хариулах, талархаж явах, ач санаж явах. **Hele şükür!** Ингэдэг (тэгдэг) юмаа бас, Арай гэж нэг (**тийм**) **юм** тэглээ, за яамай тэглээ, За нэг тэгж гялайлаа, ингэж тэгэхийг үздэг юмаа бас! "*Hele şükür, geldin.*" Чи ингэж нэг ирдэг юмаа бас! (За яамай чи нэг ирлээ. Чиний ирэхийг үздэг юм аа бас. Ашгүй чи минь ирлээ.) **şükürler olsun** Ээ гялай! Яамай даа, Ашгүй дээ.

şüphe *is.* сэжиг, хар сэжиг, дамжиг, тээнэглэлзэл, эргэлзээл, хардлага, хар. **~ etmek (şüpheye düşmek)** сэжиглэх, сэжиг төрөх, сэжиг санах, сэжигдэх, хардах, дамжиг санах, эргэлзэх, тээнэгэлзэх. "*Benden şüphe etme.*" Намайг бүү сэжиглэ. Надад бүү дамжиг сана.

yığın *is.* 1. овоо, бөөн, бөөм. "*Ot yığını.*" Цомог өвс, өвсний цогц, бухал өвс, нуруу өвс. 2. тоо томшгүй олон, ханархуй олон, сүрэг, бөөн, олон, үй олон, учиргүй их, учиргүй олон, оворолдоон, цуглаан.

yığıntı *is.* сүрэг, оворолдоон, багшралдаан, цуглаан.

yığmak, -ar *(-i, -e)* 1. овоолох, дээр дээрээс нь тавих, бархайлган сэрхийлгэх. 2. хуримтлуулах, хураах, цуглуулах, нөөцлөх, нөөх, дарах, бөөгнөрүүлэх, хуралдуулах. "*Herkes kışlık kömürünü yığdılar.*" Бүгд өвөл хэрэглэх нүүрсээ нөөцөллөө. 3. хуралдуулах, цуглуулах, бөөгнөрүүлэх.

yıkama *is.* угаах, усанд орох, угаалга.

yıkamak *(-i)* угаах, угааж цэвэрлэх, усанд оруулах.

yıkanma *is.* угаал, угаалга, угаах.

yıkanmak *(nsz)* 1. угаагдах. 2. нүүр гараа угаах, усанд орох, биеэ угаах.

yıkatmak *(-i, -e)* угаалгах.

yıkayıcı *is.* угаалч, угаагч.

yıkı *is. hlk.* балгас, эвдэрхий балгас.

yıkıcı *s.* 1. эвдэгч, сүйтгэгч, сүйтгэл ихтэй, хенөөлтэй. 2. *is.* сүйтгэгч, нураагч.

yıkık *s.* эвдэрсэн, нурсан, эвдрэн унасан, эвдэрхий, балгас.

yıkılma *is.* yıkılmak үйлийн нэр.

yıkılış *is.* уналт.

yıkılmak *(nsz)* 1. yıkmak үйлийн үйлдэгдэх хэв. 2. нурах, нурж унах, нурж ойчих, эвдрэх, эвдэн унах. 3. унах, ойчих. "*Yere yıkıldı.*" Газар пидхийтэл уналаа. 4. *mec.* тонилох. "*Yıkıl buradan.*" Эндээс тонил. 5. *mec.* үгүй болох, балрах, сүйрэх. 6. *mec.* тохогдох, нуруун дээр үлдэх.

yıkım *is.* 1. yıkmak үйлийн нэр. 2. сүйдэл, сүйрэл, их хэмжээний хохирол, аюул, гай.

yıkıntı *is.* 1. эвдрэл, сүйдэл, сүйрэл, нурал, аюул, аюул болох, сүйдэх, сүйрэх. 2. үлдэгдэл, хэмхэрхий, эвдэрхий, эвдэрхий балгас, балгас, нурсан сүйрсэн зүйлс.

yıkmak, -ar *(-i)* 1. эвдэх, хэмхлэх, нураах, нурааж унагах, буулгах, сүйтгэх. 2. түлхэн унагаах, унагах, унагаах. 3. хазайлгах, (нэг) тийш болгох. 4. *mec.* үгүй болгох, сүйрүүлэх, сүйтгэх, үгүйрүүлэх, хоосруулах, гутаах, шившиглэх. 5. тохох, түлхэх. "*Suçu bana yıktı.*" Буруугаа надруу түлхэв.

yıktırmak *(-i, -e)* yıkmak үйлийн үйлдүүлэх хэв.

yıl *is.* 1. жил. "*Bir yıl önce gitti.*" Нэг жилийн өмнө явсан. 2. он. "*1917 yılın yazı.*" 1917 оны зун.

yılan *is. zool.* 1. могой. 2. *mec.* хорон санаатай хүн, зальхай, муу санаатай, хөнөөлтэй хүн. **~ gibi** хүйтэн хүн, жигшмээр, зэвүүн, дургүй хүргэм, могой шиг.

yılanbalığı *is. zool.* могой загас.

yılankavi *s.* могой хэлбэртэй, эргүүлгэн, мушгиа, нугалаатай, мурилзсан.

yılbaşı *is.* Шинэ жил, Нэгдүгээр сарын нэгэн. "*Yıl başınızı kutlarım.*" Шинэ жилийн мэнд хүргэе!

yıldırım *is.* аянга, цахилгаан. **~ gibi** цахилгаан мэт хурдан, маш хурдан, үтэр түргэн, агшин зуур. **~ düşmek** аянга буух. **~ siperi** аянгын сарниул.

yıldırımsavar *is.* аянгын сарниул, аянгын хориул, аянга хорилт.

yıldırma *is.* сүрдүүлэг.

yıldırmak *(-i)* айлгах, айлган сүрдүүлэх, сүрдүүлэх, эмээлгэх, шантраах.

yıldız *is.* 1. од. 2. цуутай жүжигчин, кино од, од болсон жүжигчин, од болсон дуучин, од. 3. шилдэг (хүн). "*Matematikte, geometride sınıfımızın yıldızı idim.*" Математик, геометртээ би ангийнхаа шилдэг нь байсан. 4. *den.* хойд зүг, умард. 5. *mec.* аз, од, хийморь, цог. 6. таван хошуу, од. **~ kaymak** (veya **akmak**) од харвах. **~ı** (veya **yıldızları**) **barışmak** эвтэй байх, эв нийцтэй байх, тааpах, аясыг олох, нийлэх. "*Küçükken de hep Ayşe ile oynardı, yıldızı hiç barışmazdı seninkiyle.*" Тэр жаахан байхдаа ч гэсэн дандаа л Аешэтэй тоглодог байсан, чамтай ер таардаггүй байж билээ. **~ı parlamak** алдар цуу нь өсөх, нэртэй болох, нэр цуутай болох.

yıldızlı *s.* 1. одтой. 2. од түгсэн, одтой, үүлгүй.

yıldönümü *is.* ой, ойн өдөр. "*Evlilik yıldönümü.*" Хуримын ой , гэрлэсэний ой.

yılgı *is.* айдас, айх, эмээх.

yılışık *s.* залхуутай, хашраадаг, хаширтай, наалдуур, наалдамтгай. **yılışıklık, -ğı** *is.* хашрал, хаширтай зан, залхуутай байх, залхмаар зан, улиг.

yılışmak *(nsz)* залхуутай байх, зулгуйдах, долдогонох, цврайчлах, зулгуйдан инээмсэглэх, саймсран инээмсэглэх, хуурмаг инээмсэглэх.

yıllanmak *(nsz)* 1. нэг жил болох, нэг жил өнгөрөх. 2. өвгөрөх, өтлөх, хөгшрөх. 3. олон жил болох, олон жил өнгөрөх. "*Yıllanmış şarap.*" Хуучны дарс, олон жил хадгалсан дарс.

yıllık, -ğı *s.* 1. нэг настай, ойндоо хүрсэн, ... жилийн настай. "*On yıllık ağaç.*" Арван жилийн настай мод. 2. жилийн хугацаатай, нэг жилээр. 3. жилийн, нэг жилийн, жил тутмын. 4. жилийн хөлс. 5. *is.* жил бүр нэг удаа гардаг хэвлэл, жил тутмын хэвлэл.

yılmak, -ar *(-den)* 1. шантрах, айх, сүрдэх, эмээх. 2. залхах.

yılmaz *s.* шантаршгүй, айхгүй, аймшиггүй, зүрхтэй, зоригтой.

yıpranma *is.* элэгдэл, хорогдол, элц.

yıpranmak *(nsz)* 1. урагдах, элэгдэх, элэх, цоорох, хуучрах. 2. элэгдэх, хуучрах, элэх. "*Dikiş makinesi iyice yıpranmış.*" Оёдлын машин бүр элэгджээ. 3. *mec.* сулдах, доройтох, тамирдах, тэнхээдэх, тэнхэл барагдчихах, мохох, муудах. "*Onun zekası hiç yıpranmamış.*" Түүний ухаан огтхон ч муудаагүй (мохоогүй) байна шүү.

yıpratıcı *s.* зүдрээсэн, эцээж туйлдуулсан, тэнхэл тамир барсан, доройтуулсан, тэнхээгүй болгосон.

yıpratmak *(-i)* 1. элээх, элэгдүүлэх, хуучруулах. 2. *mec.* зүдрээх, эцээж туйлдуулах, тэнхэл тамир барах, тэнхээгүй болгох, доройтуулах.

yır *is. hlk.* 1. дуу, дуулал. 2. шүлэг.

yırtıcı *s.* 1. махчин, араатан. "*Yırtıcı hayvan ve yırtıvı kuşlar.*" Араатан амьтан ба махчин шувууд. 2. *mec.* цусанд дуртай, алах талах дуртай, хэрцгий харгис (хүн). 3. *mec.* чанга, хүчтэй (дуу, хоолой). "*Yırtıcı çığlıklarıyla uyandı.*" Чанга хашгирах дуунаар сэрлээ.

yırtıcılık, -ğı *is.* махчин байх, махчин байдал.

yırtık, -ğı *s.* 1. уранхай, тасархай, урагдсан, тасар тасдуулсан. 2. *mec.* ичгүүргүй, ичгүүрээ алдсан. 3. хуучирсан, уранхай, нооронхой, салбархай, навтархай. **yırtık-pırtık** элэгдсэн, уранхай, нооронхой.

yırtılmak *(nsz)* 1. урагдах, тасрах, яз үсрэх, хүүрэх. 2. *mec.* ичимхий зангаасаа мултрах, ичимтгий зангаасаа ангижрах.

yırtınmak *(nsz)* 1. бархирах, хашгирах, чарлах, тэнхээ мэдэн хашгарах, байдаг хүчээрээ чарлах. 2. өөрийгөө зовоох, хамаг байдгаараа мэрийх.

yırtmaç *is.* оноо (хувцасны). "*Ablam yırtmaçlı etek diktirmiş.*" Эгч оноотой юпка оёулжээ.

yırtmak, -ar *(-i)* 1. урах, тасар татах, таслах, цуу татах, ханз татах, хуу татах, тас татах. 2. урах, маажих, маажиж шалбалах, савардах. 3. *zf. mec.* хүчлэх, байдаг хүчээ шавхах. 4. морь сургах, эмнэг сургах, даравчдан эмнэг сургах.

yiğit, -di *s.* 1. зүрхтэй хүн, зоригтой хүн, баатар, сайн эр, чин зоригт, эрэлхэг баатар. 2. *is.* залуу хүн, залуу эр, эр(хүн), хүү. 3. шулуун үгтэй, шударга зантай, шулуун зантай. "*O yiğit adamdır, gerçeği söylemekten çekinmez.*" Тэр шударга зантай хүн, үнэнийг хэлэхээс айхгүй.

yiğitlik, -ği *is.* зүрх, зориг, зүрх зориг, аймшиггүй зориг, аймшиггүй (байх), эрэмгий зориг, эрэмгий байдал, идэрхэг явдал, чин зориг, шулуун зан.

yine *zf. bk.* гөнө.

yineleme *is.* давтах, дахих.

yinelemek *(-i)* давтах, дахих.

yinelenmek *(nsz)* давтах, давтагдах, дахих.

yirmi *s.* ve *is.* хорь, хорин.

yirminci *s.* хорьдугаар.

yitik, -ği *s.* 1. гээгдсэн, гээсэн, хаягдсан, алдагдсан, алдсан, үгүй болсон, алга болсон. 2. хаягдал, алдал, алга болсон юм, гээсэн юм, алдсан юм.

yitirmek *(-i)* 1. гээх, хаях, алдах, алга болгох. "*Bütün malını yitirdi.*" Бүх хөрөнгөө алдсан. 2. алдах, –хаа (–хээ, –хоо, –хөө) болих, –гүй болох. 3. алдах, үхүүлэх. "*Kocasını savaşta yitirdi.*" Нөхрөө дайнд алдсан. 4. замаа алдах, төөрөх.

yitmek, -er *(nsz)* 1. үгүй болох, алга болох. 2. харагдахгүй болох, далдрах. 3. үрэгдэх, дэмий хаягдах, дэмий өнгөрөх.

yiv *is.* 1. сэтэрхий. 2. ухаадас, ухмай, ховил, гурви, иргүүл. 3. (үсний)заадас, хагалбар.

yiyecek, -ği *is.* 1. хоол хүнс, хоол, хүнс, идээ, идэх уух юм. 2. *s.* идэж болох, идэж болмоор.

yiyici *s.* 1. иддэг. "*Et yiyici hayvan.*" Мах иддэг амьтан. 2. *mec.* авилгал авагч, хахууль авагч. 3. *hlk.* ховдог.

yobaz *is.* ve *s.* 1. шашинд дэндүү туйлширан бусдыг дарамтлах сонирхолтой нэгэн. 2. *mec.* дэндүү туйлширагч, хэт шүтэгч, улайран шүтэгч, хэт шүтсэн, улайран биширсэн. 3. *hlk.* бүдүүлэг, молхи бүдүүлэг, болхи бүдүүлэг(хүн).

yobazlık, -ğı *is.* дэндүү туйлширах байдал, хэт шүтэх байдал, улайран шүтсэн байдал, болхи бүдүүлэг зан, болхи бүдүүлэг байдал.

yoga *is.* йог, бясалгал.

yoğaltmak *(-i)* хэрэглэх, эдлэх.

yoğrulmak *(nsz)* 1. yoğurmak үйлийн үйлдэгдэх хэв. 2. *mec.* холилдон орох. 3. махийх, матийх, муруйх, хонхойх (мөтал сав). 4. *mec.* туршлагажих, туршлагатай болох, туршлага суух, дадлагажих, боловсрогдох.

yoğun *s. fiz.* 1. өтгөн, нягт, шигүү. 2. зузаан, өтгөн, битүү, шигүү, чигжүү, их. "*Yoğun sis.*" Өтгөн манан./Битүү манан. "*O bölgede nüfus yoğundur.*" Тэр хэсэгт хүн зон шигүү байдаг. 3. (үнэр, амт) аагтай, хурц, богшсон, их хурц, хүнд. 4. *mec.* эрчимт, эрчимтэй. **~ bakım** *is. tıp.* эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах. 5. *mec.* бүдүүн, тарган, бадриун.

yoğunlaşma *is. fiz.* конденсаци, өтгөрөл (уур, шингэн бодис, шингэн зүйл).

yoğunlaşmak *(nsz)* өтгөрөх, өтгөн болох, агших, зузаарах, бөөгнөрөх, хуралдах, хуримтлах, нягтрах, хавчигдах, шахагдах.

yoğunlaştırmak *(-i)* авчих, шахах, хуримтлуулах, өтгөрүүлэх, өтгөн болгох, нягтруулах, чигжрүүлэх.

yoğunluk, -ğu *is.* 1. өтгөн. 2. *is. fiz.* нягт, нягтрал.

yoğurmak *(-i)* 1. зуурах, нухах, хутгах. "*Hamur yoğurmak.*" Гурил зуурах. 2. *mec.* авьяасыг хөгжүүлэх, сурган хөгжүүлэх.

yoğurt, -du *is.* тараг. **~ çalmak** тараг бүрэх.

yok, -ku, -ğu *is.* 1. үгүй, үгүй (байх), байхгүй (байх), алга (байх) –гүй (байх). "*Üstünde bir av bıçağından başka silahı yoktu.*" Биед нь ангийн хутганаас өөр зэвсэг байхгүй байлаа. "*Burda kimse yok.*" Энд хэн ч алга байна. 2. хориотой зүйл, болохгүй зүйл, хориотой, болохгүй. "*İçki, sigara yok.*" Архи, тамхи хориотой. 3. *zf.* Үгүй, үгүй ээ. "*Geldiler mi? -Yok, daha gelmediler.*" Тэд нар ирсэн үү? –Үгүй ээ, хараахан ирээгүй л байна. 4. *bağ.* хэн нэгний хэлсэн үгэнд итгээгүй эсвэл басамжилах үед хэрэглэдэг холбоос үг. "*Yok kağıdı kalmamış, yok mürekkebi iyi değilmiş, hepsi yalan bahane.*" Цаас дууссан л гэнэ, бэх нь сайн биш л гэнэ, бүгд худлаа шалтаг. 5. *zf.* зөв гэсэн бодлыг илэрхийлэхэд өгүүлбэрийн эхэнд хэлж хэрэглэнэ. "*Yok, doğrusu iyi adam, kim ne derse desin.*" Хэн юу ч гэж байсан тэр, үнэндээ, сайн хүн. **yok canım** 1) үгүй ээ, тийм юм байхгүй ээ, яалаа гэж дээ, бүү итгээрэй. 2) тийм үү? үнэн үү? **~ etmek** устгах, үгүй хийх, зайлуулах, арилгах, сөнөөх. **~ olmak** устах, үгүй болох, сөнөх, мөхөх, үхэх, алга болох. **~ pahasına** *zf.* маш хямд, үнэгүй шахуу, зүгээр шахуу, асар хямд. **~ yere** хий, дэмий, хоосон, ямар ч хэрэггүй, ямар ч ашиггүй, тийм ийм гэх юмгүй, учир шалтгаангүйгээр. **~**

yok 1) байхгүй юм алга, хүссэн бүхэн байна. "*Bu mağazada yok yok.*" Энэ дэлгүүрт ч байхгүй юм алга. 2) үгүй үгүй! "*Yok yok geç oldu, biz gidelim.*" Үгүй үгүй орой болчихлоо, бид явъя.

yoklama *is.* 1. шалгалт, хяналт, асуулт, байцаалт. 2. нэр дуудлага, тооллого, бүртгэл. "*Sınıf yoklaması.*" Ангийн бүртгэл, үдшийн тооллого.

yoklamak *(-i)* 1. тэмтрэх, тэмтчих, тэмтрэн үзэх, тэмтрэн мэдрэх, тэмтчин үзэх. 2. үзэх, харах, хянах, хянан шалгах, магадлах, шалгах. 3. мэдэж авахыг хичээх, олж мэдэхийг хичээх, мэдэж авахыг оролдох, тандах, мэдэхийг хичээх, ойлгохыг оролдох. "*Bir yokla bakalım belki razı olur.*" Сураглаж мэдэх гээд үз дээ, зөвшөөрч юуны магад. 4. лавлах, лавлан үзэх, асуух, үзэх, эргэх, эргэж тойрох, уулзаад гарах. "*Hastayı yokladınız mı?*" Өвчтөнг эргэж тойрсон уу? 5. дунших. 6. эрэх, эрж үзэх, нэгжих, нэгжиж үзэх, хайх, шалгах.

yoklatmak *(-i, -e)* yoklamak үйлийн үйлдүүлэх хэв.

yokluk, -ğu *is.* 1. үгүй байх, байхгүй байх, эзгүй байх. "*Onun yokluğunda..*" Түүний эзгүй байхад..., түүний эзгүй хооронд... 2. *mec.* ядуурал, хоосон ядуу байдал, үгээгүү байдал, гачигдал, гачаал.

yoksa *bağ.* 1. үгүй бол, эсвэл, -гүй бол, эс тэгвэл. "*Sus, yoksa babana söylerim.*" Дуугай бай эс тэгвэл аавд чинь хэлчихнэ шүү. 2. уу, уу эсхүл ...уу, үү эсхүл... үү.

yoksul *s.* ve *is.* 1. ядуу, ядуу хоосон, ядуу зүдүү. 2. *s. mec.* дулимаг, дутмаг, хомсхон. "*Bilgice onu biraz yoksul buldum.*" Тэр надад мэдлэгээр жаахан дулимаг санагдлаа.

yoksullaşmak *(nsz)* ядуурах, ядуу зүдүү болох, үгүйрэх, ядуу хоосон болох.

yoksulluk, -ğu *is.* 1. гуйланч байдал, ядуу зүдүү байдал, ядуу хоосон байдал, үгийгүү байдал, гачигдал, гачаал, хоосон, ядуу, тарчиг. 2. *mec.* хангалтгүй байдал. **~ çekmek** гачигдах, дутагдах, ядуу зүдүү байх, ядуу зүдүүг амсах, ядуу зүдүүг үзэх.

yoksun *s.* гачигдсан, дутагдсан, дутмаг, гачигдалтай. **~ bırakmak** гачигдуулах, дутаах. **~ kalmak** гачигдах, дутагдах.

yoksunluk, -ğu *is.* гачигдал, гачаал, гчигдал дутагдал, гачигдалтай байдал, ядуу зүдүү байдал.

yokuş *is.* 1. өгсүүр, өгсүүр газар, өөд газар, өдөрлөг гүдгэр газар. 2. уруу газар, уруу. **~ aşağı** *zf.* 1) уруудан, урууга, доошоо. 2) уруудах, ажил үйлс бүтэхгүй, доошлох. **~ yukarı** *zf.* өгсөн, өөдөө.

yol *is.* 1. зам, харгуй. 2. аян зам, аян, замд гарах. "*Yol parasını almamışım.*" Би замын зардлаа аваагүй байна. "*Baba, sen ne zaman yola çıkacaksın?*" Аваа, та хэзээ замд гарах гэж байна? 3. явалт, хурд. "*Bu trenin yolu az.*" Энэ галт тэрэгний хурд бага. 4. *mec.* зам, арга, сүв, арга зам, арга барил, арга, барил, маяг. 5. ховил, говил. 6. журам, ёс, ёс журам, дүрэм горим, систем. 7. *mec.* зорилго. 8. зурвас, судал. 9. *hkl.* удаа, дахин. **~ kavşağı** уулзвар, бэлчир, зөрөлт. **~ yordam** харьцааны болон биеэ зөв авч явах дүрэм горим. **~ aramak** арга зам хайх, арга чарга хайх, арга хайх. **~ çizmek** төлөвлөгөө хийх, төлөвлөгөө зохиох. **~ göstermek** 1) зам заах, замчлах. 2) зааварлах, удирдах, чиглүүлэх. **~ kesmek** 1) зам хаах, замд саатуулах, зогсоох. 2) зам тосох, зам отож булаан дээрэмдэх, тонох. **~a düşmek** явах, одох, хөдлөх, замд гарах, замд мордох. **~a koyulmak** явах, одох, хөдлөх, замд гарах, замд мордох. **~a gelmek** сэхээрэх, сэхээ орох, ухаарах, томоожих, засрах. **~a getirmek** ухаруулах, засах. **~dan çıkmak** 1) зам гажих, замаасаа гарах, шугамнаас гарах. 2) *mec.* зөв замаас гарах, замаа алдах. **~una girmek** засрах, сайжрах, эмхрэх, жигдрэх, эмхтэй болох, бүтэх, болох, сайхан болох. **~unda gitmek** санасанчлан бүтэх, сэтгэлчлэн бүтэх. **~unu kaybetmek** төөрөх, замаа будлих. **~unu yapmak** нөхцөл боломжийг бүрдүүлэх, таатай орчныг бүрдүүлэх, бүтэх боломжтой болгох. "*Yolun açık olsun.*" Замдаа саадгүй сайн яваарай.

yolcu *is.* 1. зорчин явагч, зорчигч, аялагч, жуулчин, замын хүн. 2. замд гарах хүн, зорчих хүн. 3. *mec.* төрөх хүүхэд, гэдсэнд байгаа хүүхэд 4. *mec.* горьдлогогүй өвчтөн, найдваргүй өвчтөн. **~ etmek** үдэх, гаргаж өгөх, үдэж гаргах, үдэж мордуулах.

yolculuk, -ğu *is.* аялал, жуулчлал, аян, аялах, зорчих, явах, жуулчлах. "*Otobüs yolculuğu tramvay yolculuğundan daha rahattır.*" Автобусаар аялах нь трамвайгаар аялахаас илүү тухтай. **~ etmek** аялах, жуулчлах, зорчих. **İyi (veya hayırlı)yolculuklar!** Аян замдаа сайн яваарай, саадгүй сайн яваарай(алтан шар зам чинь өлзийтэй болтугай!).

yoldaş *is.* 1. замын хань, замын найз. 2. найз, нөхөр, анд нөхөр, хань. 3. *mec.* үзэл бодол нэгтэн.

yoldurmak *(-i, -e)* зулгаалгах, зумлуулах, сугалуулах.

yollamak *(-i, -e)* явуулах, илгээх.

yollanmak *(nsz)* 1. илгээгдэх, илгээх. 2. явах, одох, хөдлөх.

yollu *s.* 1. замтай. "*Güzel yollu bir mahalle.*" Сайхан замтай хороолол. 2. судалтай. 3. хурдан, хурдан явдаг. "*Yollu araba.*" Хурдан явдаг машин.

yolluk, -ğu *is.* 1. замд идэх хоол хүнс, замын хүнс. 2. замд гарах хүнд өгдөг бэлэг. 3. нарийн урт хивс. 4. томилолтын зардал, томилолтын мөнгө, замын зардал.

yolmak, -ar *(-i)* 1. зулгаах, зумлах, зулгааж авах, сугалах, сэмлэх. 2. *mec.* залилан мөнгий нь авах, тонох, цөлмөх, цөлмөн авах.

yolsuz *s.* 1. замгүй, зам муутай. 2. удаан явагч, алгуур явагч (тээврийн хэрэгсэл). 3. *mec.* зохисгүй, тохиромжгүй, таарамжгүй, байж болшгүй, зөвшөөршгүй, зохимжгүй, аягүй, ёс бус, зүй бус. 4. ёс жаягүй.

yolsuzluk, -ğu *is.* 1. замгүй байх, зам муутай байх. "*Köy yolsuzluktan kurtuldu.*" Тосгон замтай болсон. 2. *mec.* (албан тушаал, эрх мэдлээ) хортой ашиглах, зүй бус ашиглах, ёсон бус эдлэх, хэтрүүлэн эдлэх, буруу ашиглах, хуул зүйгүй байдал, ёс бус байдал.

yoluk *s.* зулгаалгасан, зумлуулсан.

yolunmak *(nsz)* 1. зумлуулах, зулгаалгах. 2. *mec.* гасалж гинших, гаслан орилох, гасалж зовох.

yoluyla *zf.* 1. дамжин, дайран, дундуур, -аар(-ээр, -оор, -өөр) нэвт. "*Ulaanbaatır yoluyla...*" Улаанбаатараар дайран... 2. аргаар, тусламжаар, зуучлуулж, хэрэглэж.

yom *is. hlk.* зол, аз, аз хийморь, завшаан.

yonca *is. bot.* гэрийн хошингор.

yontma *is.* 1. yontmak үйлийн нэр. 2. *s.* харуулдсан, зормол, өөлөн зассан. ~ **Taş Devri** эртний чулуун зэвсгийн үе.

yontmak, -ar *(-i)* 1. харуулдах, зорох, цавчих, цавчин өөлөх, өөлөн засах, үзүүрлэх. 2. *mec.* бага багаар мөнгө татах, бага багаар мөнгө салгах.

yontu *is.* баримал, хөшөө.

yontucu *is.* барималч, цутгамалч.

yontulmak *(nsz)* 1. yontmak үйлийн үйлдэгдэх хэв. 2. *mec.* бүдүүлэг байдлаас ангижрах, ёс жаягүй байдлаасаа ангижрах.

yorgan *is.* хөнжил, хучлага.

yorgancı *is.* хөнжилийн оёдолчин, хөнжилийн худалдаачин.

yorgun *s.* ядарсан, ядрангуй, эцсэн, зүдэрсэн, цуцсан, туйлдсан. ~ **düşmek** ядрах, эцэх, туйлдах. ~ **argın** *zf.* эцэж ядарсан, туйлдаа хүртэл ядарсан.

yorgunluk, -ğu *is.* ядаргаа, ядрах. ~ **çıkarmak** амрах, ядаргаагаа тайлах. **yorgunluğunu almak** 1) амрах, ядаргаа тайлагдах. 2) амраах, ядаргааг нь тайлах.

yormak, -ar (I) *(-i)* 1. ядраах, зүдрээх, чилээх. 2. төвөг учруулах, яршиг болох, ярвиг татах, зовоох, шаналгах, гомдоох.

yormak, -ar (II) *(-i, -e)* –нх гэх, –ийнх гэх, тайлбарлах, тайлах, тооцох. "*Rüyayı hep hayra yormak lazım derdi, anaannem.*" Эмээ маань, зүүдийг үргэлж сайнаар тайлбарлах хэрэгтэй гэдэг байж билээ.

yortu *is.* Христосын баяр.

yorucu *s.* ядраах, зүдрээх, эцээх, тэнхэл тамир барчихих, ядраадаг.

yorulmak (I) *(nsz)* ядрах, туйлдах, эцэх, зүдрэх, чилэх.

yorulmak (II) *(nsz)* гэгдэх, -ийнх гэгдэх, тайлбарлагдах, тооцогдох.

yorum *is.* 1. тайлбар. 2. тойм. 3. таамаг, тайлал, тайлах, тайлбарлах, тойм. 4. *müz. ve tiy.* дуулах ба тоглох (дуу ба жүжгийг өөрийн гэсэн техникээр, өвөрмөц хэлбэрээр).

yorumcu *is.* тайлбарлагч, тоймч.

yorumlamak *(-i)* 1. тайлбарлах. 2. *müz. ve tiy.* дуулах ба тоглох (дуу ба жүжгийг өөрийн гэсэн техникээр, өвөрмөц хэлбэрээр).

yosma *s.* 1. цэнгэлтэй, зугаатай, сайхан, гуа сайхан, үзэсгэлэнтэй, залуу(эмэгтэй). 2. *is.* ааль гүй, гангалах гоёх дуртай эмэгтэй.

yosun *is. bot.* хөвд, хөвх, замаг, хиг, хигдэр. ~ **bağlamak** хөвд ургах, замагтах. **su ~ları** замаг, хиг, хигдэр.

yosunlu *s.* хөвдтэй, хөвхтэй, хигтэй, замагтай, хигдэртэй.

yoz *s.* 1. боловсруулаагүй, атар, зэрлэг. "*Yoz bitki.*" Зэрлэг ургамал. "*Yoz toprak.*" Атар газар. 2. *mec.* боловсон бус, соёлгүй, соёл боловсролгүй, бүдүүлэг.

yozlaşma *is.* алдрах, доройтох, буурч мөхөх, мөн чанар нь муудах, үүлдэр доройтох, муудах, зэхийрэх.

yozlaşmak *(nsz)* алдрах, доройтох, буурч мөхөх, үүлдэр доройтох, муудах, зэхийрэх, угсаа доройтох, үндэс угсаа доройтох, мөн чанар нь муудах, мөн чанараа алдах.

yozlaştırmak *(-i)* yozlaşmak үйлийн үйлдүүлэх хэв.

yön *is.* 1. зүг чиг, зүг, тал, этгээд. 2. чиглэл. "*Bursa yönüne.*" Бурсагийн чиглэл рүү. 3. *s.* баримтлах. ~ **vermek** хандуулах, чиглүүлэх, зүглүүлэх, залах, заах. **~den** ...ийн үүднээс, ...ийн үзлийн үүднээс.

yönelmek *(-e)* 1. чиглэх, зүглэх, эргэх, харах, хандах, чиг хийж явах, чиглүүр болгож явах, чиглэн явах, зүглэн явах. 2. *mec.* чиглэх, чиг барих, тал баримтлах, хандлагатай болох, хандах.

yöneltilmek yöneltmek үйлийн үйлдэгдэх хэв.

yöneltme *is.* yöneltmek үйлийн нэр.

yöneltmek *(-i, -e)* 1. чиглүүлэх, зүглүүлэх, эргүүлэх, чиг бариулах, харуулах, хандуулах, (мөрөөр) оруулах, чиг бариулах, жолоодох, залах, тал баримтлуулах. 2. ...ний зүг харах, чиглэн харах, зүглэн харах. 3. хандаж хэлэх, хандуулах.

yönetici *is.* удирдагч, эрхлэгч, захирал, зохион байгуулагч.

yöneticilik, -ği *is.* удирдах, удирдлага.

yönetilmek *(nsz)* yönetmek үйлийн үйлдэгдэх хэв.

yönetim *is.* 1. удирдах, удирдлага. 2. *mec.* жолоо. ~ **kurulu** удирдлагын зөвлөл, өрөнхий хороо.

yönetme *is.* yönetmek үйлийн нэр.

yönetmek *(-i)* 1. удирдах, захирах, барих, эрхлэх. 2. жолоодох, залах, удирдах. 3. *sin.* ve *tiy.* найруулах, удирдах. "*Film yönetmek.*" Кино найруулах.

yönetmelik, -ği *is.* заавар.

yönetmen *is.* 1. удирдагч, захирал, эрхлэгч. 2. *sin.* ve *tiy.* найруулагч.

yönetmenlik, -ği *is.* удирдлага, захиргаа, газар, удирдах газар, байгууллага.

yönlendirmek *(-i)* чиглүүлэх, зүглүүлэх, залах. "*Beni doğru yola yönlendiren kişi.*" Намайг зөв зам руу залсан хүн.

yönlü *s.* талтай. "*Çok yönlü...*" Олон янзын, зүйл зүйлийн, олон талын, тал бүрийн, олон талтай.

yönsüz *s.* 1. зүг чиггүй, зүггүй, чиггүй. 2. *mec.* зорилгогүй.

yöntem *is.* арга, арга барил, арга метод, метод.

yöntembilimi *is.* арга зүй, арга судлал.

yöre *is.* газар, нутаг, дүүрэг, дэргэдэх тосгон, орчин, орчин тойрон, ойр хавь, хавь.

yöresel *s.* нутгийн, орон нутгийн, бүс нутгийн.

yörünge *is. mat.* 1. тойрог, тойрог зам. 2. *astr.* зам, траектори.

yudum *is.* балга.

yudumlamak *(-i)* балгах, оочих.

yudumluk, -ğu *is.* балга, нэг балга.

yufka *is.* 1. нимгэхэн элдсэн гурил, нимгэхэн хавтгайлсан гурил. 2. *s. mec.* нарийн, хэврэг, эмзэг, хугармтгай. **~ açmak** гурил элдэх, гурил хавтгайлах. **~ yürekli** өр нимгэнтэй, зөөлөн сэтгэлтэй, өрөвч сэтгэлтэй, өр зөөлөн, өр нимгэн, өрөвч зөөлөн.

yuh *ünl. tkz.* зэмлэлээ, дургүйцлээ, бухимдлаа, болон уураа илэрхийлэх аялга; түй, аа, ээ, болиёоо.

yuhalamak *(-i)* зэмлэлээ, дургүйцлээ, бухимдлаа, болон уураа илэрхийлэх, "yuh" гэж хашгирах.

yukarı *is.* 1. дээд хэсэг, дээд тал. 2. эрх бүхий хүн, эрх мэдэлтэй хүн, дээд тушаалт хүн. 3. *s.* дээд, дээрх. 4. *zf.* дээшээ, өөдөө, дээд талруу, дээш, өөдөө. "*Yukarı tükürsem bıyık, aşağı tükürsem sakal.*" Дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу, ацан шалаанд орох, хаашаа харж үхэх вэ бүү мэд.

yukarıda *zf.* дээр, дээр нь, дээд талд нь.

yukarıdan *zf.* дээрээс, өндөр дээрээс, дээд талаас.

yulaf *is. bot.* овъёос.

yular *is.* ногт, жолоо, цулбуур, бурантаг.

yumak (I) *(-i) hlk.* угаах.

yumak, -ğı (II) *is.* 1. бөөрөнхий утас, бөөрөнхий ноос, бөөрөнхий ноолуур. 2. *s.* бөөрөнхий, бөөрөнхийлж ороосон.

yumaklamak *(-i)* бөөрөнхийлөх, бөөрөнхийлөн ороох.

yummak, -ar *(-i)* хаах, таглах, хамхих, аних, жимийх. **ağızını ~** амаа хамхих, амаа жимийх. **gözünü ~** нүдээ аних.

yumru *is.* 1. товруу, бэсрүү, товон, булдруу, булуу, хавдар. 2. *s.* булцгар, бондгор. 3. *bot.* төмс, болцуу.

yumruk, -ğu *is.* 1. нударга, зангидсан гар. 2. нударган цохилт, гараа зангидаж шаах. 3. *mec.* дарамт, шахалт. **~ atmak** гараа зангидан цохих, нударгадан цохих, нударгадах.

yumruklamak *(-i)* нударгадах, гараа зангидаж шаах.

yumuk *s.* 1. аниатай, аниастай, аниастай байгаа. "*Yumuk gözlerini açtı.*" Аниастай нүдээ нээлээ. 2. тарган, махлаг.

yumulmak *(nsz)* 1. хаагдах, таглагдах, халхлагдах, халхлах, бүрхэгдэх, хучигдах, аних. 2. *(-e)* дайрах, ухас хийх, шамдан хийх, шүүрэн хийх. 3. цавчлах, цавчигнах, анивалзах.

yumurta *is. biy.* 1. түрс, өндөг. 2. тахианы өндөг.

yumurtacı *is.* өндөгний мухлаг, өндөгний худалдаачин.

yumurtalık, -ğı *is. anat.* ve *biy.* 1. өндгөвч. 2. өндөгний жүнз (өндгөө босоогоор нь хийх зориулттай).

yumurtlamak *(-i)* 1. өндөглөх, өндөг гаргах. 2. *mec.* зохиогоод хэлэх, зохиох, санаагаараа зохиох, худлаа чалчих, далан худал хэлэх. 3. *mec.* үг алдах, нууц задлах.

yumuşak, -ğı *s.* 1. зөөлөн, зөөлхөн. 2. уян, зөөлөн. "*Yaş dallar yumuşak olur.*" Нойтон мөчир уян байдаг. 3. зөөлөн, хазахад амар, зүсэхэд амар. "*Yumuşak ekmek.*" Зөөлөн талх. 4. зөөлөн, дулаан, урин дулаан. "*Yumuşak hava.*" Урин дулаан агаар. 5. *mec.* номхон, дөлгөөн, зөөлөн, эелдэг. 6. таатай, аятайхан, эелдэг.

yumuşaklık, -ğı *is.* 1. зөөлөн (байх), зөөлөн байдал. "*Göğsünde ilk defa bir kadın vücudunun sıcaklığını, yumuşaklığını ilk defa hissediyordu.*" Цээжиндээ анх удаа л эмэгтэй хүний биеийн халуун, зөөлөн булбарай байдлыг мэдэрлээ. 2. уян зөөлөн аашлах, эелдэг зөөлөн (байх), дөлгөөн (байх).

yumuşama *is.* 1. зөөлрөх, зөөлөн болох. 2. хурцадмал байдлыг сулруулах. 3. *gr.* зөөлрөх, гийгүүлэгч зөөлрөх.

yumuşamak *(nsz)* 1. зөөлрөх, зөөлөн болох. 2. *mec.* зөөлрөх, номхрох, намдах, дарагдах. "*Abim yumuşadı.*" Ахын маань хилэн дарагдав. 3. *gr.* зөөлрөх, гийгүүлэгч зөөлрөх.

yumuşatıcı *is.* 1. зөөлрүүлэгч, зөөллөгч. 2. *mec.* намдаагч, дарагч.

yumuşatmak *(-i)* 1. зөөлрүүлэх, зөөллөх, зөөлтгөх. 2. *mec.* зөөлрүүлэх, номхотгох.

Yunanistan *z. is.* Грек улс.

Yunan *z. is.* 1. Грек хүн, грек, грек үндэстэн. 2. *s.* грекийн, грек үндэсний, грек.

yunus balığı *is. zool.* далайн гахай, дельфин.

yurt, -du *is.* 1. нутаг, орон, орон нутаг, улс. 2. эх орон, эх нутаг, төрсөн нутаг. 3. *mec.* газар нутаг, газар орон, газар, нутаг. "*Bu köy pehlivanlılar yurdudur.*" Энэ тосгон бөхчүүдийн нутаг. 4. *mec.* анх гарсан орон, анх үүссэн орон, эх орон, их байдаг орон, их байдаг газар. 5. байр, дотуур байр, орон байр, гэр, асрах газар, асрах гэр.

yurtsever *s. ve is.* эх оронч, эх орноо хайрлагч.

yurtseverlik, -ği *is.* эх орноо хайрлах үзэл, эх оронч үзэл.

yurttaş *is.* нэгэн нутгийн хүн, иргэн, харъяат.

yurttaşlık, -ğı *is.* харъяат, иргэн.

yutak, -ğı *is.* хоолой, багалзуур, залгиур.

yutkunmak *(nsz)* 1. шүлсээ залгих. 2. *mec.* дүгдрэх.

yutmak, -ar *(-i)* 1. залгих, залгилах. 2. *tkz.* тэвчээрлэх, тэсэх, хүлцэх, дугай өнгөрүүлэх. "*Ben bu ağır sözü yutamam.*" Би энэ хүнд үгийг дугай өнгөрүүлж чадахгүй. 3. *tkz.* хууртагдах, үнэмших, хууртах, итгэх. "*Bu yalanı kimse yutmaz.*" Энэнд чинь хэн ч хууртахгүй. 4. (хонжв орт тоглоомноос)хожих, хонжих. 5. *tkz.* мэргэших, сайтар сурах, сайтар эзэмших, тоть болох, толгойдоо хийх, (мэдлэгийг) өөрийн болгох. "*Kimyayı yutmuş insan.*" Тэр химид тоть болсон хүн./Тэр химид мэргэжсэн хүн. 6. аман дээр гараад буцах, буцаан залгих, хэлэх гэсэн үгээ залгих. 7. алгасах, буруу дутуу хэлэх.

yutturmak *(-i, -e)* yutmak үйлийн үйлдүүлэх хэв.

yutulmak *(nsz)* yutmak үйлийн үйлдэгдэх хэв.

yuva *is.* 1. шувууны үүр, амьтаны үүр, нүх, ичээ, үүр. "*Karınca yuvası.*" Шоргоолжны үүр. 2. орон гэр, гэр. 3. хүүхдийн цэцэрлэг, ясли. 4. асрах газар, халамжийн газар. 5. дээрэмчний үүр, гэмт хэрэгтний орогнодог газар. 6. нүх, ухархай, хонхорхой. **~ kurmak** гэрлэх, хүнтэй суух, айл гэр болох, өрх гэр болох, өрх тусгаарлах. **~ yapmak** 1) үүр засах, үүр бэлдэх, үүр хийх. 2) гэрлэх, хүнтэй суух, өрх гэр болох, айл гэр болох.

yuvalamak *(nsz)* үүр хийх, үүр барих.

yuvarlak, -ğı *s.* 1. дугуй, дүгрэг, дугариг, бөөрөнхий, бөмбөрцөг. "*Yuvarlak masa.*" Д угуй ширээ. 2. *is.* бөөрөнхий зүйл, дугуй юм, бөмбөрцөг хэлбэртэй зүйл. **~ konuşmak** утга балар ярих, бүрхэг ярих, учир дутмаг ярих, тодорхой бус ярих. **~ hesap** *is. mat.* ойролцоо утга, тоо.

yuvarlamak *(-i)* 1. өнхрүүлэх. "*Taşı yuvarlamak.*" Чулуу өнхрүүлэх. 2. хуйлах, хуйлж эвхэх, ороож эвхэх, ороох. "*Muşambayı yuvarlayarak kaldırdılar.*" Хулдаасыг хуйлж хураалаа. 3. унагаах, онхолдуулан унагаах, онхолдуулах. 4. *tkz.* хөнтрөх, хөмрүүлэх. 5. (үгийг) утга балар хэлэх, учир дутмаг хэлэх.

yuvarlanmak *(nsz)* 1. эргэлдэх, өнхрөх. 2. бөмбөрөх, бөмбөрөн унах. 3. унах, өнхрөн унах, ойчих. 4. *mec.* зуурдаар өнгөрөх, гэнэт нас барах. **yuvarlanıp gitmek** 1) байгаа боломжоороо амь зуух. 2) гэнэт нас барах, зуурдаар өнгөрөх, зуурдаар нөгчих.

yuvarlatmak *(-i, -e)* yuvarlamak үйлийн үйлдүүлэх хэв.

yüce *s.* 1. аугаа, их, дээд, эрхэм. 2. эрхэм дээд, ариун сайхан, сүр жавхлантай, цогтой сүрлэг. **~ ruhlu** ариун сэтгэлтэй, уужим санаатай, өршөөлтэй.

yücelmek *(nsz)* дэвших, дээшлэх, хүндтэй болох, өсөх, сүндэрлэх.

yücetilmek *(nsz)* yüceltmek үйлийн үйлдэгдэх хэв.

yüceltmek *(-i)* өргөх, өргөмжлөх, дээшлүүлэх.

yük *is.* 1. ачаа, тээш, ачаа тээш, тэгнээ. 2. тэрэг, тээвэр (зөөж болох ачааны хэмжээ). "*Bir araba yükü odun.*" Тэрэг түлээ. 3. эд хогшил, эд зүйлс. "*Bütün yükü bu bavul.*" Бүх эд хогшил нь энэ чемодон. 4. *mec.* дарамт, дарлал, тээр, тээр дараа. "*Hangi insan bu yükün altında yaşar?*" Ямар хүн энэ дарамтанд амьдардаг юм бэ? 5. *fiz.* хуримтлагдсан цэнэг, цэнэг. 6. *esk.* хенжил гудасны шүүгээ. **(birine) ~ olmak** 1) (хүнд) дараа болох, төвөг удах, дарамт учруулах, тээр болох. 2) зардал чирэгдэл учруулах. **~ vurmak** ачаа ачих, тэгнэх. **~ünü çekmek** хамаг хүндий нь үүрэх, хүнд бэрхийг үүрэх, хатуу хүтүүг үүрэх. **~ gemisi** ачааны усан онгоц.

yükçü *is.* ачигч, ачаа зөөгч, дамнуурч.

yüklem *is. gr.* өгүүлэхүүн, учир зүйн өгүүлэхүүн.

yükleme *is.* 1. ачилт, ачаалалт, тэгнэлт. 2. *fiz.* цэнэглэх.

yüklemek *(-i, -e)* 1. ачих, ачаалах, тэгнэх. 2. *mec.* даалгах, үүрүүлэх, шилжүүлэх, үүрэг ноогдуулах, хариуцуулах. 3. *mec.* –нх, гэх, –ийнх гэх, бурууг тохох, бурууг чихэх, бурууг түлхэх, бухах. 4. *(-i) fiz.* цэнэглэх.

yüklenmek *(-i)* 1. yüklemek үйлийн үйлдэгдэх хэв. 2. *(-e)* налах, түших. 3. үүрэх, зөөх. 4. *(-e) mec.* дайрах, давшлах, довтлох, довтлон орох. 5. *mec.* хариуцаж авах, дааж авах.

yükletmek *(-i, -e)* yüklemek үйлийн үйлдүүлэх хэв.

yüklü *s.* 1. ачаатай, тээштэй, ачаалсан, ачсан, тэгнэсэн. 2. ажилтай, ачаалалтай, завгүй, чөлөөгүй, дарагдсан, даруулсан. "*O çok yüklü, bu işi başkasına verelim.*" Тэр маш их ажилтай байгаа, энэ ажилыг өөр хүнд өгье. "*Bu yılki ders programı çok yüklü.*" Энэ жилийнх нь хичээлийн программ их ачаалалтай. 3. маш их, тун их. 4. агуулсан, дүүрэн. 5. *hlk.* жирэмсэн, хээлтэй. 6. *argo.* мөнгөтэй, хөрөнгөтэй, бэл бэнчинтэй.

yüklük, -ğü *is.* хөнжил гудасны шүүгээ.

yüksek, -ği *s.* 1. өндөр, хүчтэй, их. "*Yüksek dağ.*" Өндөр уул. "*Yüksek ücretli.*" Их цалинтай. "*Yüksek ihtisaslı.*" Мэргэшил ихтэй, их чадвартай. "*Yüksek frekans.*" Өндөр үелзэл, өндөр давтамж. 2. өндөр, дээр, дээгүүр. "*Yükseklerde uçan kuşu g rdü.*" Өндөрт нисэж байгаа шувууг харлаа. 3. өндөр, чанга. **~ perdeden** чанга дуугаар, өндөр дуугаар. 4. *mec.* өндөр, дээд. "*Yüksek tahsilli adam.*" Дээд (өндөр) боловсролтой хүн. "*Yüksek sosyete.*" дээд зиндаа. "*Yüksek mahkeme.*" Д ээд шүүх. "*Yüksek makamlar.*" Дээд шатны байгуулгууд. 5. *mec.* буянтай, ач тустай, буяны, сайн үйлийн, төгс (сайн), төгөлдөр (сайн), эрхэм (сайн). 6. *zf.* их мөнгөөр. "*Yüksek oynamak.*" Их мөнгөөр тоглох. **~lerde dolaşmak** *mec.* хүрэхэд бэрх зүйл горилох, хүрэхэд бэрх зүйлд эрмэлзэх, бүтэхэд бэрх зүйл хүсэх. **~ten atmak** бардамнах, сайрхах. **(birine) ~ten bakmak** ихэрхэн харах, дээрэлхэн харах.

yükseklik, -ği *is.* 1. өндөр. 2. *mat.* өндөр. 3. *coğr.* өндөр газар, өндөрлөг, өндөрлөг газар.

yükseliş *is.* дэвшилт, өсөлт, хөгжил.

yükselme *is.* 1. дэвшилт, өсөлт, хөгжилт, дэгжилт, нэмэгдэл, өсөлт. 2. (тушаал) ахих, дэвших. 3. *jeol.* эргэлт, гэнэтийн эргэлт, эрс эргэлт. 4. *coğr.* үерлэх, сайрам, уруй, ус ундрах.

yükselmek *(nsz)* 1. дээшлэх, хөөрөх, өөд гарах, ургах, сүндэрлэх 2. чангарах, ихсэх, ширүүсэх. 3. нэмэгдэх, өсөх, ихсэх, арвижих. 4. дээшлэх, сайжрах, дэвших, ахих. 5. *mec.* хүндтэй болох, дээшлэх. "*Benim gözümde bu davranışıyla yükseldi.*" Энэ зан авираараа надад их хүндтэй болсон доо.

yükselteç *is. fiz.* чангаруулагч, хүч нэмэгдүүлэгч.

yükseltgeme *is. kim.* металл хийцийн гадаргууг исэлдүүлэх.

yükselti *is.* далайн төвшнээс дээш өндөр.

yükseltilmek *(nsz)* yükseltmek үйлийн үйлдэгдэх хэв.

yükseltmek *(-i)* 1. өргөх. 2. өндөр болгох, чангаруулах, ихэсгэх. 3. *mec.* хэт магтах, хэт өргөх, дөвийлгөж хэлэх, даврууллж ярих. 4. боловсруулах, хөгжүүлэх, өргөтгөх, сайжруулах, дээшлүүлэх. 5. ахиулах, дэвшүүлэх. 6. *mat.* зэрэг дэвшүүлэх.

yüksük, -ğü *is.* хуруувч. **~ kadar** жаахан, маш жаахан, хуруувчин чинээ.

yüküm *is.* алба, үүрэг, үүрэгт алба, албан үүрэг.

yükümlü *s.* үүрэгтэй, ёстой.

yükümlülük, -ğü *is.* үүрэгтэй (байх).

yün *is.* 1. хонины ахар ноос. 2. ноос, ноолуур. 3. *s.* ноосон, ноолууран, ноосоор хийсэн юм, ноолуураар хийсэн эд эдлэл.

yünlü *s.* 1. ноостой, ноолууртай. 2. *is.* ноосон юм, ноосон даавуу, ноолууран эд эдлэл.

yürek, -ği *is. anat.* 1. зүрх. 2. *mec.* зүрх, зориг, эр зориг, эрэлхэг зориг, аймшиггүй байдал. 3. *mec.* өр, өр зүрх, өрөвч сэтгэл. 4. чин зүрх, чин сэтгэл, үнэн сэтгэл, үнэн зүрх. 5. зүрх, сэтгэл, сэтгэл зүрх. 6. *hlk.* дотор, гэдэс. 7. хөзрийн бунд. **~ vermek** зүрх зориг өгөх, зоригжуулах. **yüreği ağızına gelmek** зүрх амаар гарчих чахчихих, зүрх амаар гартал айх, догдлох, түгших. **yüreği bayılmak** гэдэс маш их өлсөх. **yüreği burkulmak** ихэд гашуудах, харуусах, гуниглах. **yüreği cız etmek** зүрх зүсэгдэх, өр өвдөх. **yüreği çarpmak** 1) зүрх цохилох, зүрх лугших. 2) (догдолсноос)зүрх хүчтэй цохилох, зүрх хүчтэй лугших. **yüreği daralmak** дотор бачуурах, бачимдах, бачуудах, дотор давчдах, дотор давчрах. **yüreği kabarmak** 1) санаа алдах. 2) дотор муухайрах, бөөлжис хүрэх. **yüreği kan ağlamak** гүнээ харуусах, ихэд гашуудах, гансран гашуудах. **yüreğine kurt düşmek** сэжиглэх, сэжиг төрөх, хардах, хар буух. **yüreğini boşaltmak** ярьж дотроо онгойлгох, зовлонгоо ярьж тайтгарах. **yüreği temiz** цагаан сэтгэлтэй, цайлган цагаан, муу санаагүй. **yüreği yufka** өр нимгэн, өрөвч сэтгэлтэй, өрөвч зөөлөн, зөөлөн сэтгэлтэй. **yürekten** чин сэтгэлээсээ, чин зүрхнээсээ, сэтгэлээсээ, зүрх сэтгэлээсээ.

yüreklendirmek *(-i)* зоригжуулах, зориг оруулах, зүрх өгөх, зориг өгөх.

yürekli *s.* зүрхтэй, зоригтой, эр зоригтой, аймшиггүй, эрэлхэг зоригтой.

yüreklilik, -ği *is.* зүрх, зориг, зүрх зориг, аймшиггүй зориг, аймшиггүй (байх), эрэмгий зориг, эрэмгий байдал, идэрхэг явдал, чин зориг, шулуун зан.

yüreksiz *s.* аймхай, хулчгар, зоригүй, зүрхгүй, эр зоригүй.

yürük *s.* 1. хурдан явагч. 2. нүүдэлчин, нүүдэлч.

yürüme *is.* явах, явалт, явдал.

yürümek *(nsz)* 1. явах, явган явах, алхах. 2. нүүх. 3. (хүүхэд) алхаж эхлэх, алхаж сурах, хөлд орох. 4. явгаар явах, алхах, явгаар зугаалах, зугаалах. 5. яарах, яаравчлах, адгах. 6. *mec.* урагштай байх, бүтэх, бүтэмжтэй байх. "*İşler iyi yürüyor.*" Ажил төрөл сайн бүтэмжтэй байна. 7. өнгөрөх, явах, өөрчлөгдөх. 8. *(-e)* дайрах, давшлах, довтлох. "*Askerler kaleye yürüdüler.*" Цэргүүд цайз руу дайрлаа. 9. *(nsz)* (хүү) оногдуулах, бодох, тооцоолох. "*Bu paranın faizi yüzde beşten mi yürüyor?*" Энэ мөнгөний хүүг таван хувиар бодож байгаа юм уу? 10. *(nsz) argo.* үхэх, өнгөрөх. 11. *(-e)* хүрэх, очих, явж хүрэх, тулах.

yürürlük, -ğü *is.* хүчин төгөлдөр байх. **yürürlüğe girmek** хүчин төгөлдөр болох, хүчинтэй байх, хэрэглэгдэж байх, хүчинтэй болох, мөрдөгдөж эхлэх. **~te olmak** хүчинтэй байх, мөрдөгдөж байх, хүчин төгөлдөр байх. **~ten kaldırmak** хүчингүй болгох, цуцлах. **~ten kalkmak** хүчингүй болох, цуцлагдах.

yürütme *is.* 1. yürütmək үйлийн нэр. 2. гүйцэтгэл, гүйцэтгэх, биелүүлэх.

yürütmek *(-i, -e)* 1. алхуулах, явуулах, алхлуулах. 2. гүйцэтгэх, биелүүлэх, хэрэгжүүлэх, хийх, удирдах, жолоодох, явуулах, эрхлэх. 3. хэлэх, илэрхийлэх, дэвшүүлэх. "*Muhakeme yürütmek.*" Эргэцүүлэн бодсоноо хэлэх. "*Fikir yürütmek.*" Өөрийн бодсоныг тулган хүлээлгэх. 4. *mec.* və *tkz.* халах, огцруулах, чөлөөлөх, чөлөөг олгох, **хөөх**. 5. *argo.* хулгайлах, хулгай хийх, хулгайлж **аваачих**, хумслах, хэлэлгүй авах.

yürüyüş *is.* 1. явах, явалт, явдал, алхаа; ажиллагаа, эргэлт. 2. алхах. 3. хөдөлгөөн, жагсаал, эсэргүүцлийн жагсаал. 4. *ask.* аян, аялал. **~ düzenlemek** жагсах, жасаал хийх, жагсаал зохион байгуулах, эсэргүүцлийн жагсаал хийх. **~ yapmak** 1) алхах, явган алхах, салхилах. 2) жагсаал хийх, эсэргүүцлийн жагсаал хийх.

yüz (I) *is.* 1. зуу. 2. *s.* зуун.

yüz (II) *is.* 1. нүүр, царай, зүс. 2. гадар, гадарга, гадаргуу, хавтгай, хавтаг, талбай, талс. 3. ир. 4. нүүр, нүүр царай, дүр төрх. 5. дэрний уут, дэрний гэр, хөнжлийн бүрээс, хөнжлийн уут, бүрээс, гадар. 6. нүүрэн тал, өвөр тал, урд. 7. гадар өнгө, гадна, өнгө, өнгөн тал, зөв тал. "*Bu kumaşın yüzü hangisi?*" Энэ бөсний өнгөн тал нь аль вэ? 8. *mec.* ичгүүр, ичих, зовох, аягүйрхэх, эрээлэх, нэрэлхэх, санаа зовох, сэтгэл зовомтгой зан, ичих нүүр. "*Adamda yüz yok ki.*" Тэрэнд ямар ичих нүүр байх юм биш. 9. нүүр, тал. "*Arka yüzü.*" Арын нүүр. 10. учраас, аас болж, ээс болж. "*Bu yüzden Fuat kızmıştır.*" Иймээс учраас Фуат уурласан байх. **~ çevirmek** нүүр бууруулах, үл ойшоох. **~ kere** хэдэн зуу дахин, дахин дахин, олон удаа. **~ tutmak** 1) чиглэх, хандах. 2) эхлэх. "*Dağ karları erimeğe yüz tutmuş.*" Уулын цас хайлж эхэлжээ. **~ vermek** нүүр өгөх, давраах, эелдэг ааш гаргах, эрхлүүлэх. **~e çıkmak** 1) хөвөх. 2) илрэх, илэрхий болох, ил гарах, мэдэгдэх. **~ü görmemek** –ээр гачигдах, –ээр дутагдах, үзээгүй байх, хол байх, огт үзээгүй байх, өр хараагүй байх, юу гэгчийг мэдэхгүй байх. **~ü kalmamak** гуйх нүүргүй болох. **~üne karşı** нүүрэн дээр нь.

yüzbaşı, -yı *is. ask.* ахмад.

yüzde *is.* 1. шимтгэл, хувь. 2. *s.* хувь, зууны хувь. "*Yüzde yirmi.*" Хорин хувь, зууны хорин хувь.

yüzdelik, -ği *is.* 1. шимтгэл. 2. хувь, зууны хувь.

yüzdürmek (I) *(-i, -e)* 1. сэлүүлэх, усанд оруулах. 2. *(-i)* хөвүүлэх, усны гадаргуу дээр өргөж гаргах.

yüzdürmek (II) *(-i)* өвчүүлэх, арьсыг нь хуулуулах, арьслуулах.

yüzey *is. mat.* гадар, гадаргуу, хавтгай, хавтаг, талбай.

yüzeysel *s.* 1. дээрх, өнгөн талын, өнгөн. 2. *mec.* өнгөц, өнгөцхөн, хуумгай.

yüzgeç, -ci *is.* 1. сэрвээ, загасны сэрвээ, живэр. 2. *s. hlk.* усч, усчилагч, сэлэгч, самрагч.

yüzkarası *is.* гутамшиг, ичгүүр, нэр нүүр барсан явдал, нэр гутаасан зүйл, гутамшигт явдал, ичгүүрт байдал.

yüzlemek *(-i)* зэмлэх, зэмлэн ичээх, дутагдлыг нь хэлэх.

yüzleşme *is.* нүүрэлдлэг.

yüzleşmek *(nsz, -le)* 1. нүүрэлдэх, нүүр тулах, нүүр тулж гэрчлэх, нүүрдэх. 2. нүүр тулах, нүүр учрах, дайралдах, биеэр учрах, уулзах.

yüzleştirmek *(-i)* нүүрэлдүүлэх, нүүрдүүлэх, нүүр тулгах.

yüzlü *s.* нүүртэй, царайтай. **iki ~** хоёр нүүртэй, зусарч, бялдууч.

yüzlük 1. зуутын дэвсгэрт, зуун төгрөг 2. зуутын орон 3. зуун

yüzme *is.* (I, II) yüzmək үйлийн нэр.

yüzmek, -er (I) *(nsz)* 1. сэлэх, самрах, усчлах. 2. хөвөх. 3. умбах. "*Para içinde yüzmek.*" Мөнгөнд умбах. 4. хучигдах, бүрхэгдэх, болох. "*Kitaplar toz içinde yüzüyor.*" Номууд тоосонд дарагдсан байна. 5. *mec.* намирах.

yüzmek, -er (II) *(-i)* 1. өвчих, арьсыг нь хуулах, арьслах, арьсыг нь өвчих. 2. *hlk.* их хэмжээний мөнгө хүсэх.

yüzölçümü *is.* 1. талбайн хэмжилт. 2. талбай, талбайн хэмжээ.

yüzsüz *s.* 1. нүүргүй, царайгүй. 2. *s. mec.* ичгүүргүй, ичгүүр сонжоргүй, ичих нүүргүй, ичгүүрээ алдсан, ичих нүүрээ барсан.

yüzsüzleşmek *(nsz)* ичих нүүрээ барах, ичих нүүрээ гээх, ичгүүр сонжууруаа алдах, ичгүүргүй аашлах.

yüzsüzlük, -ğü *is.* уйвайгүй зан, ичгүүргүй ааш, ичгүүр сонжуургүй явдал.

yüzücü *s.* 1. усч, сэлэгч, самрагч. 2. мэргэжлийн сэлэгч, мэргэжлийн усч. 3. малын арьс өвчдөг хүн.

yüzük, -ğü *is.* бөгж. **~ takmak** сүй тавих.

yüzkoyun *zf.* түргүлгээ, элгээрээ, нүүрээрээ доош харж. **~ yatmak** түргүлгээ харж хэвтэх, элгээрээ хэвтэх.

yüzülmek 1. сэлэх. 2. өвчигдөх, арьс нь хуулагдах.

yüzünden *zf.* -ээс болж, -ээс, шалтгаалж, учраас, тул.

yüzüstü *zf.* 1. нүүрээрээ доош харж, түргүлгээ, элгээрээ. 2. эхлүүлээд хаясан, дутуу орхигдсон, дутуу, орхигдсон. **~ bırakmak** 1) хайхрахгүй орхих, хайхрах хүнгүй хаях, хүнд байдалд орхих. 2) хаях, орхих, хайхрахгүй орхих, хайхрахгүй хүндрүүлэх.

Z

z, Z Турк цагаан толгойн хорин ес дүгээр буюу сүүлийн үсэг. **Z** авиа.

zaaf *is.* 1. сул дорой байдал, сул байдал, буурай(байх), тэнхэл дорой(байх), дутагдал, дутагдалтай тал, сул тал, тэсэж чадахгүй(байх), тэсвэрлэж чадахгүй(байх), хүлцэж чадахгүй (байх), тэвчиж чадахгүй (байх). 2. биеэ барих чадваргүй (байх), өөрийгөө захирах чадвар сул (байх), биеэ жолоодох чадвар муу(байх).

zabıt -ptı *is.* 1. байлдан авах, булаан авах, эзлэн авах, эзэрхэн авах, байлдан дагуулах, эрхшээлдээ оруулах. 2. хурлын тэмдэглэл, тогтоол, дэлгэрэнгүй тогтоол, протокол, тогтоолд оруулах, тогтоол бичих, тогтоолд тэмдэглэх. **~ tutmak** протокол хөтлөх, тогтоол бичих.

zabıta *is.* цагдан сэргийлэх.

zabıtname *is. esk.* хурлын тэмдэглэл, тогтоол, дэлгэрэнгүй тогтоол, протокол, тогтоолд оруулах, тогтоол бичих, тогтоолд тэмдэглэх.

zabit *is. esk.* 1. офицер, дарга, занги 2. *s. mec.* шаргуу, нөр, шургуу, хичээлтэй, цохрөлтгүй, цохердөггүй, ноёрхог, эзэрхэг, захирангуй.

zaç *is. kim.* байван(хүхэр хүчлийн давсан талст).

zaçyağı *is. kim.* хүхрийн хүчил.

zade *is.* 1. хүү, хөвгүүн, нуган. 2. *s.* төрсөн, төрөн гарсан.

zadegân *is. esk.* сурвалжит, сурвалжтан, язгууртан, угсаатан.

zafer *is.* 1. ялалт, гайхамшигт ялалт, ялгуусан баяр. 2. хожил, амжилт. **~ kazanmak** 1) ялалт байгуулах, ялах 2) дийлэх, түрүүлэх, амжилтыг олох.

zafiyet *is.* 1. туралт, эцэлт, туранхай байдал, яс арьс болсон байдал, тэнхэл дорой байдал, бие сул байх. 2. эцэж ядарсан байдал, сульдсан байдал, туйлдсан тамирдсан байдал, тэнхэлгүй байдал, хүчгүй байдал.

zağanos *is. zool.* начин, шонхор.

zağar *is. zool.* тайга нохой.

zağara *is. esk.* ангийн арьсан зах, ангийн үсээр хийсэн зах заам, ангийн үсэн зах.

zağcı *is. hlk.* билүүдэгч, гуранздагч.

zağlamak *(-i)* ирлэх, хурцлах, билүүдэх, засах.

zahir (I) *s.* 1. ил, ил тод, илт, илэрхий, яах аргагүй, тодорхой, ойлгомжтой, лавтай, маргаангүй. 2. *is.* царай, зүс, гадаад үзэгдэл, өнгө зүс, царай зүс, гадаад төрх, гадаад байдал, үзэгдэх, харагдах. 3. *zf. hlk.* илт, илэрхий, тодорхой, ойлгомжтой, байх, байлгүй, лав...байлгүй, дамжиггүй, эргэлзээгүй, сэжиггүй магад, мэдээж, гарцаагүй. 4. *zf.* үзтэл...бололтой, тэгтэл, гэтэл, харин. "*Ben yanlış biliyormuşum zahir.*" Би харин буруу мэддэг байсан юм байна.

zahir (II) *s. esk.* дэмжин туслагч, туслагч, дэмжигч, ар тал, түшиг тулгуур, хамгаалагч.

zahire *is.* нөөцөөлсөн үр тариа (хоол хүнс, идэшний зүйл, идэх зүйл)

zahirən *zf. esk.* харваас, харах өнгөнөөсөө, харах царайнаасаа, гаднаас нь харахад л, байдлаас харахад, байдал төрх нь, янз нь, байр байц нь, гаднаа, өнгөндөө, наанаа, нүд хуурахын тулд, нүүрэн дээрээ, хүн харахад, хүний нүдэнд, санагдавч

zahmet *is.* бэрхшээл, төвөг, хүндрэл, бэрх(байдал), хүнд байдал, яршиг, чирэгдэл, төвөг татах, яршиг болох, зовнил, сэтгэл зовох, санаа зовох, оролдлого. **~ çekmek** зовох, бэрхшээл үүрэх, бэрхшээл туулах, чилэх, бэрх байдал амсаж өнгөрүүлэх, зовлон амсаж өнгөрүүлэх, хүнд байдал туулах. "*Kızım yolda çok zahmet çekmiş.*" Охин маань замдаа их зовсон байсан. **~ etmek (zahmete girmek** veya **zahmete katlanmak)** 1) ядрах, зүдрэх, ядарч зүдрэх, зарлага гаргах, зардал гаргах, зарлагад орох, төвөг удах, (өөртөө) төвөг удах, төвөг тарих, (өөртөө) чирэгдэл учруулах, (өөртөө) ажил гаргах, биедээ дааж авах, бие дээ хүлээж авах, өөрийгөө чилээх, (өөртөө) төвөг учруулах, (өөртөө) ярвиг татах, (өөртөө) хүндрэл учруулах. "*Benim için yine yorulacaksınız, zahmete katlanacaksınız.*" Та миний төлөө дахиад л ядарч зүдрэн, өөртөө төвөг тарих нь байна даа. 2) оролдох, хөөцөлдөх, хичээл зүтгэл гаргах, өөрийгөө дайчлах, хичээл гаргах, зүтгэл гаргах, мэрийх. "*Hiç zahmet edip enine boyuna okumazlardı.*" Тэд өрдөөсөө хичээл зүтгэл гаргаад сайтар нарийвчилж уншдаггүй байлаа. **(birine) ~ olmak** (хэн нэгэнд) бэрхтэй байх, (хэн нэгэнд) төвөгтэй байх, (хэн нэгэнд) бэрхшээлтэй байх, төвөгшөөх, бэрхшээх. **~ vermek** төвөг удах, төвөг болох, дараа болох, яршиг удах, дараас болох, тээр болох, тойв болох, чирэгдэл болох, хүндрэл удах, хүндрэл учруулах. "*Size zahmet vermek istemiyorum.*" Би танд төвөг болохыг хүсэхгүй байна. **~e sokmak** амруулахгүй, амраахгүй, зовоох, ядраах, зүдрээх, чилээх, төвөг учруулах, хашраах, яршиг болох, ярвиг татах, гарзанд гаргах, зардал гаргуулах, зардалд унагах.

zahmetli *s.* 1. бэрхшээлтэй, бэрхтэй, төвөгтэй, хэцүү, бэрх, хүнд, хүчир, хүч хөдөлмөр шаардах. "*Zahmetli iş.*" Бэрх ажил. 2. бэрхшээлтэй, төвөгтэй, яршигтай, ярвигтай, залхуутай, залхуу хүрмээр, ядраах, зүдрээх, дараастай, дараатай, дарамт болсон, дарамттай. "*Bu tarafta zahmetli yollar çoktur.*" Энэ зүгрүү ядраах зам ихтэй.

zahmetsiz *s.* бэрхшээлгүй, саадгүй, төвеггүй, бэрхгүй, хүч шаардахгүй, хөдөлмөр шаардахгүй, хүч хөдөлмөр оролгүй, хөдөлмөр гаргалгүй, хөнгөн, хялбар, амархан, ярвигүй.

zail *s. esk.* алга болсон, үгүй болсон, зуурдын, түр зуурын, богино хугацааны. **~ olmak** зогсох, болих, байх, тасрах, арилах, алга болох, үгүй болох, байхгүй болох, устах.

zakkum *is. bot.* хулслаг улаан цэгцүүхий.

zalim *s.* харгис, хэрцгий, догшин, шударга бус, эзэрхэг, дарангуйлагч, хатуу сэтгэлтэй, дарлагч, зовоогч.

zalimce *s. ve zf.* харгис, хэрцгий, догшин, дарангуйлан, шударга бусаар, өрөвдөх сэтгэлгүй, хайргүй, өрөвсөлгүй.

zalimlik, -ği *is.* харгислал, хэрцгий, дарлал, үнэн шударга бус явдал, харгис хэрцгий, хэрцгий явдал, харгис догшин хэрэг, ширүүн зан, дарангуйлах, хатуу сэтгэлтэй байх.

zam, -mmı *is.* (үнийн) нэмэгдэл, нэмэлт, өсөлт. **~ gelmek** үнэ нэмэгдэх, үнэ өсөх. "*Herşeye zam gelmiş.*" Бүх юмны үнэ өссөн байна. "*Maaşıma zam gelmiş.*" Миний цалин нэмэгдсэн байна лээ.

zaman *is.* 1. цаг хугацаа. "*Zaman çok çabuk geçmiş.*" Цаг хугацаа маш хурдан өнгөрчээ. 2. цаг. "*Az konuşup çok çalışma zamanı geldi.*" Бага ярьж их ажиллах цаг ирлээ. 3. хугацаа(үйл ажилд өдөр хоног цаг болзож хэмжээлсэн хэмжээ). 4. үе, цаг, улирал. "*Bahar zamanı.*" Хавар цаг. "*Gül zamanı.*" Сарнайн урирал. "*Çocukluk zamanı.*" Хүүхэд үе/цаг. 5. үе, цаг үе. "*Devrim zamanında.*" Хувьсгалын үед. 6. *gr.* цаг, цаг заах үйл үг (уул үйлийн өнгөрсөн, одоо, ирээдүйн чухамхүү алинд болсон буюу болохыг заах үйл үг). "*Gelecek zaman.*" Ирээдүй цаг. 7. *jeol.* үе, судал, зурвас, давхарга. **~ almak** үргэлжлэх, цаг авах. **~ kazanmak** цаг хожих. **~ kollamak** 1) цагийг хүлээх, хүлгэлзэх, хүлээх, азнах, байзнах 2) таарамжтай цагийг хүлээх, тохиромжтой цагийг хүлээх. **~ı dolmak** хугацаа нь гүйцэх.

zaman aşımı *is.* удах, хугацаа улирах, он удах, хугацаа удах.

zamane *is. hlk.* 1. үе, цаг үе, одоогийн байдал, орчин цаг, эдүгээ үе. 2. (халагласан байдалтай эсвэл тоож үзэхгүй байгаа байдлаар)өнөө цагийн, өнөөгийн, орчин цагийн, эдүгээгийн, одоо үеийн. "*Zamane gençleri, büyüklerin sözünü hiç dinlemiyor.*" Өнөөгийн залуус ч, ахмад хүмүүсийн үгийг өрөөсөө авахаа больж дээ.

zamanında *zf.* 1. яг цагтаа, яг хугацаандаа, цаг тухайд нь, зохих цагт нь, цагаа олж. "*Zamanında söylemiş olsaydı böyle olaylar çıkmayacaktı.*" Цаг тухайд нь хэлсэн бол ийм явдал гарахгүй байх байсан. 2. дээх нь, хуучин, өмнө, дээр үед. "*Zamanında bizim memlekette çok zeki bir adam varmış.*" Дээр үед манай нутагт маш их ухаантай хүн байжээ.

zamanla *zf.* яваандаа, аажимдаа, цаашдаа, дараа, хожим, хожим сүүлд.

zamanlama *is.* zamanlamak үйлийн нэр, цаг хугацааны сонголт.

zamanlamak *(-i)* 1. хамгийн тохиромжтой цагийг тодорхойлох, цаг хугацаа сонгох. 2. цаг хугацаа төлөвлөх, хугацаа тогтоох.

zamanlı *s.* ve *zf.* цагаа олсон. **~ zamansız** ямар ч цагт, ямар ч хамаагүй цагт, хамаагүй.

zamansız *s.* ve *zf.* цагаа олоогүй, цаг үеэ олоогүй, цагаа буруу тооцоолсон, цагийг нь олоогүй, тухайн цагт тохироогүй.

zaman zaman *zf.* үе үе, хааяа, заримдаа, хааяа хааяа.

zambak, -ğı *is. bot.* сараана, сараанын цэцэг.

zamir *is. esk.* 1. мөн чанар, уг чанар. "*Bu sözüyle zamirini dışa vurmuş oldu.*" Энэ үгээрээ мөн чанараа харууллаа. 2. *gr.* төлөөний нэр.

zamk *is. bot. esk.* цавуу.

zamlanmak *(nsz)* үнэ нь өсөх, үнэ нь нэмэгдэх.

zampara *is.* хүүхэмсэг эр, хүүхэнд дуртай эр, хөнгөмсөг эр, шалиг эр, сээтэн эр.

zamparalık, -ğı *is.* завхай явдал, садар самуун, садар, ужид, ужид самуун. **~ etmek** садарлах, садар самуун явах, завхайрах, ужидлах.

zan, -nnı *is.* бодол, үзэл, таамаглал, төсөөлөл, таамаг, сэжиг таамаг, гэж бодох, тийм байх гэх, таамаглах. "*Elimi tutucak zannıyla kalbim gümbür gümbür attı.*" Гарыг минь барих нь гэж бодоод зүрх минь түг түг хийтэл цохиллоо. **~ altında bulunmak** хэрэгт сэжиглэгдэх, хардагдах, сэрдэгдэх, хадаж сэрдэх. **~nına düşmek** бодох, үзэх, таамаглах, гэж бодох, төсөөлөх. "*Elimi uzatsam dokunabilirim zannına düşmüştüm.*" Би, гараа сунгавал хүрч чадна гэж бодсон.

zanaat *is.* 1. ажил, мэргэжил. 2. гар ур, дарх.

zanaatçı *is.* гар урч, гар урлалч, уран дархан.

zangırdamak *(nsz)* тачигнан чичрэх, тас няс дуугаран чичрэх, бөмбөгнөтөл чичрэх, дагжтал чичрэх, пажигнан хүчтэй чичрэх, дагжих, салганах, салганан чичрэх. "*Gevşemiş çerçeveler dışarıdan yumrukla vuruluyormuş gibi zangırdıyordu.*" Суларсан хүрээнүүдийг, гаднаас нь нударгаар нүдэж буй мэт пажигнан хүчтэй чичирч байлаа.

zangırdatmak *(-i)* zangırdamak үйлийн үйлдүүлэх хэв.

zanka *is.* хос морь хөлөлдөг чарга.

zanlı *s.* сэжиглэгдэгч, сэжигтэн, сэжиг бүхий, сэжигтэй.

zannetmek *(-i)* бодох, санах, гэж бодох, гэж санах, үзэх, тооцох, төсөөлөх, багцаалах, тоймлох, тухайлах. "*Onlar benim de yalancı olduğumu zannetmişler.*" Тэд, намайг ч бас худалч гэж бодсон байна.

zapt *is.* 1. эзлэн авах, булаан авах, булаан эзэмших, эзэрхэн авах. 2. барих, хорих, дарах 3. bk. zabıt. **~ etmek** 1) булаан авах, эзэрхэн авах, эзэлж авах, хүчээр авах, хүчээр эзлэх, булаан эзэмших, түрэмгийлэн эзлэх, хураан авах. 2) барих, хорих, дарах, татах, зогсоох, тогтоох, тэвчих. 3) номхотгох, номхуулах 4) тэмдэглэж авах, бичиж авах, тэмдэглэх. 5) цээжлэх, тогтоох, таньж авах. 6) ойлгох, ухаж ойлгох, учрыг нь мэдэх, нарийн сайн ойлгох, гүнзгий ойлгох.

zaptiye *is. tar.* 1. Оттоман гүрний үвд нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цэрэг цагдаагийн байгуулга, цагдан сэргийлэх, цагдаагийн газар. 2. энэ байгуулгад ажилладаг цэрэг, цагдаа.

zar (I) *is. esk.* 1. нимгэхэн хөшиг, нимгэхэн бүтээлэг 2. *anat.* хальс, хальс налхи. "*Kulak zarı.*" Чихний хэнгэрэг, хэнгэргэн хальс. 3. *bot.* нимгэн хальс, мембран сарьс, хальс, өрөм, хөрс, нимгэн бүрхэвч, нарийн бүрхүүл.

zar (II) *is.* шоо. **~ atmak** 1) шоо хаях. 2) хувь заяагаараа тоглох, ирээдүйнхээ төлөө төлөв лөгөө зохиох.

zarafet *is.* гуалиг байдал, уран, нарийн сайхан байдал, эелдэг байдал, уян нарийн байдал, чамин тансаг байдал, дэгжин, гоё ганган байдал, уян налархай байдал.

zarar *is.* хор, хөнөөл, хохирол, гарз, хор хомс, гарлага, алдагдал. **~ etmek** алдагдалд орох, хохирол амсах. **~ gelmek** хор хенөөл хүргэх, хор хүргэх. **~ görmek** хохиролд орох, хохиролд учрах, хохирол амсах, алдагдал гарах, гарз учрах. **~ vermek** хорлох, хорлон сүйтгэх, хор хүргэх, гэмтээх. **~a uğramak** хохирол амсах. **~ı dokunmak** хохироох, хохирол амсуулах, хохирол учруулах.

zararlı *s.* 1. хортой, хөнөөлтэй, хор хөнөөлтэй, их хортой, хор хүргэх, хорон. "*Sağlığa zararlı.*" Эрүүл мэндэд хортой. 2. гарзтай, алдаатай, хохиролтой, гарлагатай. **~ çıkmak** алдах, алдаа болох, хохирох. "*Bizimle gitmemekle zararlı çıktınız.*" Таны бидэнтэй яваагүй чинь алдаа болсон доо.

